

ШИХИХУТУГ ИХ СУРГУУЛЬ



**Хууль бүтээх үйл ажиллагааны  
шинжилэх ухааны үндэс, хууль  
тогтоомжийг боловсронгуй болгох  
үндсэн чиглэл**

(ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БАГА ХУРЛЫН МАТЕРИАЛ)

2016 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР

Улаанбаатар хот  
2016 он

DDC 340  
ННА 67  
Х - 758

Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх  
ухааны үндэс, хууль тогтоомжийг  
боловсронгуй болгох үндсэн чиглэл

Редактор: Ч.Даваадаш  
Д.Отгонтуяа  
Эмхэтгэсэн: Э.Анхбаяр  
Хэвлэлд бэлтгэсэн: Б.Энхжин  
Хавтасны дизайн: Б.Энхжин  
Цаасны хэмжээ: 148x210  
Хэвлэлийн хуудас: 16,5 х.х  
ISBN: 978-99973-51-16-6



"Соёмбо принтинг" ХХК-д  
хэвлэв,

## ГАРЧИГ

### БАГА ХҮРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

Шихихутуг Их сургуулийн дэд захирал, доктор /Ph.D/, профессор Ч.Даваадаа..... 9

## ҮНДСЭН ИЛТГЭЛ

### ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖЛЭХ

УХААНЫ ҮНДЭСЛЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч, хууль зүйн

инженерийн ухааны доктор, профессор

Д.Лунзагжиган..... 11

## ИЛТГЭЛ

### ХУУДАЙН АМИН СУНСИЙГ ЧИНГИС ХААНЫ ӨВД ТУЛГУУРЛАН СУДАЛСАН НЬ

Академич, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, Шихихутуг Их сургуулийн хүндэт доктор

С.Нарангерэл..... 32

### ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА: ТҮҮХЭН СУРГАМЖ

Үдириллагын академийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

Ч.Энхбаатар..... 56

### ХУУЛЬЧДАД ХУНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ НЬ ӨНӨӨГИЙН ХЭРЭГЦЭЭ,

#### ШААРДЛАГА МӨН

Хүний эрхийн үндэстний комиссын дарга, доктор /Ph.D/, профессор Ж.Бямбадорж..... 74

### ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

АНУ-ын Тринити хуулийн сургуулийн профессор

Кристофер Калл ..... 81

<b>ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛЬ БҮТЭЭХ, ХЭРЭГЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУДЫГ БАРИМТЛАХ НЬ</b>	
<i>Шихижутг <i>Их түргүүчин зүүгийн эрх зүйн тэнхийн эрхлэгч, доктор /Ph.D/, профессор Ж.Бамба.</i></i>	163
<b>ЯНЗ БУРИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛҮҮДИЙН УЛС ОРНУУД ДАХЬ УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМҮҮД</b>	
<i>Эрхуугийн УИС-ийн хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн тэнхмийн профессор, доктор /Ph.D/ М.Г.Тирских.</i>	118
<b>АРДЧИЛЛЫН ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ</b>	
<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлох, доктор /Ph.D/ Ч.Өнөрбаатар.</i>	126
<b>АНУ-ЫН ХОЛБООНЫ ХУУЛЬ ТАЙЛБАРАХ АРГАЧИЛГААНЫ СТАНДАРТЧИЛАЛ БА ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД</b>	
<i>БНСУ-ын Хандуны Олон Улсын хууль зүйн сургуулийн профессор Дэвид Коллиер</i>	144
<b>ОЛОН УЛСЫН БОЛОН ОРОСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИГЧ ГОРИМ ЖУРМУУДЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД</b>	
<i>Эрхуугийн УИС-ийн хууль зүйн сургуулийн дэд профессор, доктор /Ph.D/ О.А.Шабаева.</i>	157
<b>ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ОНОЛ АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>	
<i>Шихижутг <i>Их сургуулийн багши, гавьямат хуульч, доктор /Ph.D/ Р.Оюунбадам.</i></i>	166
<b>МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖООС ЯЛГАМЖТАЙ МОНГОЛ УЛСЫН</b>	

**ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН  
ЗАРЧИМД ҮНДЭСЛЭН ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ  
АСУУДАЛ**

*Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн  
захирал, доктор /Ph.D/ Ц.Мандах.....* 191

**ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ОНОЛЫН ҮНДЭС, ХУУЛЬ ЗҮЙН ПОЗИТИВИЗМЫН  
ХОЦРОГДОЛ**

*/Эрүүгийн эрх зүйн хүрээнд/  
Шихихутуг Их сургуулийн ахлах багши, докторант  
П.Баянбаатар, ахлах багши, докторант  
Б.Гантуурэв.....* 209

**БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮН  
ШИНЖИЛГЭЭ**

*Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багши,  
доктор /Ph.D/ М.Сувд.....* 236

**ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖЛЭХ  
УХЛАНЫ ҮНДЭС ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА/УЗЭЛ  
СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ/**

*Шихихутуг Их сургуулийн багши, магистр  
Ц.Амарсанаа.....* 249

**БАГА ХУРЛЫГ ХААЖ ХЭЛСЭН ҮГ**

*Шихихутуг Их сургуулийн захирал, профессор  
Д.Оюунцэг.....* 263

## **CONTENT**

### **OPENING ADDRESS BY MR. CH.DAVAADASH**

Ph.D. Prof. Vice-director of the Shiihutug University

### **ISSUES OF IMPROVEMENT OF THE SCIENTIFIC BASIS FOR LAW MAKING PROCESS**

#### **Sc.D. Prof. D.LUNDEEJANTSAN**

Member of State Great Hural /Parliament/, Honorary  
lawyer

### **STUDYING ESSENTIALS OF THE LAW BASED ON HERI- TAGES OF GENGHIS KHAN**

#### **Sc.D. Prof. S.NARANGEREL**

Academician, State Emeritus of Science, Honorary doctor of the  
Shiihutug University

### **LAW MAKING PROCESS: HISTORICAL ADMONITION**

#### **Sc.D. Prof. CH.ENKHBAATAR**

Head, Department of Law, Government Agency of Mongolia-Academy of Management

### **THE MODERN DEMAND AND REQUIREMENT OF ALLOWING KNOWLEDGE OF HUMAN RIGHT FOR LAW- YERS**

#### **Ph.D. J.Byambadorj**

Chief of National Human Rights Commission of Mongolia

### **CONTEMPORARY TRENDS INFLUENCING DOMESTIC LAW MAKING**

#### **Prof. CHRISTOPHER A.KALL**

Trinity Law School, California, The United States of America ...

### **ADHERING TO LEGAL PRINCIPLES FOR CREATION AND ENFORCEMENT OF LAWS**

#### **Ph.D. Prof J.BYAMBAA**

Head, Department of Criminal Law, the Shiihutug University

## **POLITICAL REGIMES OF LEGAL FAMILY IN THE COUNTRIES**

**Ph.D. Prof. TIRSKIH.M.G**

Department of International and Comparative law, the Irkutsk State University

## **ROLE OF RULE OF LAW IN OVERCOMING A CRISIS OF DEMOCRACY: FROM THE PERSPECTIVE OF COMPARATIVE LAW**

**Ph.D. CH.UNURBAYAR**

Legal advisor of President of Mongolia

## **STANDARDIZATION OF THE FEDERAL STATUTORY INTERPRETATION RULES**

**Prof. DAVID W. COLLIER**

The Handong International Law School, Pohang, Korea

## **MPROVING MAIN STREAMS OF SUPPORTIVE RULES IN THE INTERNATIONAL AND RUSSIAN LEGISLATION**

**Ph.D. Prof. O.A.SHABAEVA**

Law School of the Irkutsk State University

## **AMENDED CRIMINAL CODE OF MONGOLIA AND ITS CHALLENGES OF IMPLEMENTATION IN CONTEMPORARY CONFLICTS**

**Ph.D. R.OYUNBADAM**

Lecturer of the Shihihutug University, Honorary lawyer

## **SOME ISSUES WITH THE INTERPRETATION AND THE APPLICATION OF INTERNATIONAL TREATIES RATIFIED BY MONGOLIA WHICH ARE INCOMPATIBLE WITH MONGOLIA'S DOMESTIC LAWS, BASED ON COMMONLY RECOGNIZED INTERNATIONAL LAW PRINCIPLES**

**LL.D. TS.MANDAKH**

Director of the Judicial Research, Information and Training Institute under the Judicial General Council of Mongolia

**THEOROTICAL BASIS OF APPLYING LAW PROCESS AND  
LAG OF LEGAL POSITIVISM**

**Ph.D candidate P.BAYANBAATAR**

Senior lecturer, Department of Criminal law, the Shihihutug University,  
**Ph.D candidate B.GANPUREV**

Senior lecturer, Department of State and Administrative law, the Shihi-  
hutug University

**LEGAL ANALYSIS OF LAW DRAFT ABOUT PASTURE UTI-  
LIZATION IN MONGOLIA**

**Ph.D. M.SUVD**

Lecturer, Law School of the Otgontenger University

**A PERSPECTIVE AND SCIENTIFIC STUDIES OF LAW MAK-  
ING PROCESS**

**LL.M. TS.AMARSANAA**

Lecturer, Department of State and Administrative law, the Shihihutug  
University

**ALLOCUTION AT CLOSING CEREMONY OF INTERNA-  
TIONAL ACADEMIC CONFERENCE**

**Prof. D.OYUNTSETSEG**

Rector of the Shihihutug University

**“Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”**  
**сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг**  
**иээж Шихихутуг Их сургуулийн дэд захирал, доктор,**  
**профессор Ч.Даваадашийн хэлсэн үт**

*Эрхэм хүндэт эрдэмтэн профессор багий наараа*

*Эрхэм хүндэт зочид толооалжчид оо*

*Эрдэмид шамлан суралцаач хүндэт аюутан наараа*

*Энд хурган цргласан эрхэм похойд оо*

Та бүхнийхээ энэ одрийн амар амгаланг айлтган мэндчилье. Юуны омни ТА бүхэндээ эрдмийн гэгээн уурхай Шихихутуг сургууль үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье. Шихихутутгчууд сургуулийнхаа 25 жилийн ойг ихээхэн нэр тортэй, ололт амжилт дүүрэн утгацааж байна. Ойн босгон дээрээ Шихихутуг ХЗДС маань их сургуулийн статустай боллоо. Энэ бол эзэн Чингис хааны Их Заргачийн изэрээр овоглосон Шихихутуг сургууль Монгол Улсын дэд боловсролын тогтолцоондөөрийн баттай байр суурь, нэр хүндтэй орон зайгаа зээлсний, эх орондоо болон гадаадал хүлээн зөвшөөрөгдсөний бодит нотолгоо билээ.

Шихихутуг ХЗДС сургалт-судалгааны тов болох стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйлстээ томоохон алхам хийсний ачаар их сургууль болох нохцлоо бүрдүүлсэн юм. Нэг үгээр их сургуулийн шаардлагыг бүрээ хангасан хэрэг юм. Энэ эрхэм үйлст сүүлийн 10 жил дараалан Монголын тэр, эрх зүйн тулгамдсан асуудлуудаар жил бүр зохион байгуулж ирсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болон гадаадын нэр хүндтэй эрдэм шинжилгээний байгууллагатай цөөнгүй жил хамтарсан судалгаа шинжилгээний төсөл хотолбер хэрэгжүүлж байсан явдал үнэтэй хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Сургууль үүсч байгуулагдсаны 25 жилийн ойн цогц арга хэмжээний хүрээнд багтаж буй онцодрийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал маань сонгож авсан сэдвийнхээ хувьд ч, илтгэл тавин оролцож буй дотоод, гадаад эрдэмтэн судлаачдын

бүрэлдхүүнийхээ чанар чансаагаараа ч үнэхээр онцлог бегоод ихээхэн жин дарах үйл явдал болж байна.

Чөлөөт арчилсан шинэ нийгмийн тогтолцоог тогс тоголдор болгоход, ёс суртахууныг амин сүнсээ болгосон хууль эрх зүйт торийг жинхэнэ утгаар байгуулахад хууль бүтээх үйл ажиллагаа амин чухал ач холбогдолтой нь тодорхой. Чухамхүү энэ үйл ажиллагааны шинжлэх ухааны үндсийг эрс дээшилүүлэх явдал оноодрийн Монголын нийгмийн омни тулгамдсан зорилт яах аргагүй болоод байна. Энэ түүхэн зорилтыг амжилттай хээргжүүлэх үйлст Шихихутуг их сургуулиас санаачлан зохион байгуулж буй оноодрийн “Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал ини чухал, үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Манай оноодрийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаанд бидний илэвхитэй хамтран ажилладаг түнш сургууль болох БНСУ-ын Хандоны их сургуулийн төлөөлөгчид, ОХУ-ын Эрхүүгийн их сургуулийн төлөөлөгчид оролцож байгааг баяртайгаар уламжлай.

Ингээд “Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаа нээснийг мэдэгдье.

# ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Д.Лундээжсүнцэн

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч,  
хууль зүйн шинжлэх ухааны доктор, Профессор

Монгол Улсын Их Сургуулийн хуулийн салбарын V курст 1979 оны өвлийн шалгалт дуусаад амралт эхлэх гэж байхад Э.Авирамд багш (Монгол улсын гавьяат хуульч) маань тэнхимд дуудаад “Совершенствование законодательства (хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал) гэж мэргэших тусгай курсын хичээлийн лекц бэлтгэж байх хэрэгтэй. Хавар доод ангийн мэргэших курсынхаанд заалгана. Цоо шинэ хичээл. Май энэ номыг ашигла гэж хатуу ногоон хавтастай орос ном огов. Энхуу ном нь хууль тогтоомжийг бүтээх, системчилэх техникийн тухай бичсэн ном байж билээ.

Энэ мэргэших курсыг хуулийн одөр, орой, энээс ангид 3 жил хиртэй орсон юмдаг. Одоо лекц нь ч алга болжээ. Гэхдээ сэтгэлд маш тод дурсамж үлдэж хоцорсон. Сэтгэлийн гунд нэг тод оч үлдсэн нь хууль бүтээх ажилд гуч шахам жил зүтгэхэд шинжлэх ухаанчаар хандах ёстой гэсэн итгэл үзүүмшлийг бий болгож өгсөн явдал юм. Энэ хичээлд бэлтгэх гэж тэр үсийн Шүүх яаман дзор байнга очдог байж билээ. Учир нь хууль боловсруулах ажиллагааг эрхэздэг Шүүх яамиы сайд нь Б.Чимид багш, Сайд Нарын Зөвлөлийн Хэрэг Эрхэлэх газрын хуулийн хэлтсийг О.Амархүү багш, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газрын хуулийн хэлтсийг Г.Совд багш нар маань удирдлаг байсан юм шүү дээ.

Хуулийн төсөл боловсруулах ажил бол хатан хааны титэм, зэмэг, богжийг урлахтай адил нарийн, адармаатай, инжээний ажил юм. Би бээр Б.Чимид, О.Жамбаалдорж, О.Амархүү, С.Цэрэндорж, Ж.Амарсангаа, Н.Лувсанжав, Д.Дэмбэрэлцэрэн, С.Нарангэрэл, Ц.Нямдорж, Ч.Энхбаатар гээд үе үсийн хууль бүтээх ажилд зүтгэж

ирсэн хүмүүсийн хууль зүйн техник, арга зүйгээс л суралцахыг хичээж ирсэн хүний нэгэн нь болой.

Эдүгээ хууль тогтоох нь зөвхөн улс төрд л хамаатай зүйл гэсэн сэтгэлгээ орхигдож энэ бол хүмүүнлэгийн олон ухааны уулзвар багаад шинжлэх ухаан бүрийн судалгааны онцгоос нь харах учиртай шинжлэх ухааны судалгааны зүйл гэдэг нь тодорхой болж байна. Энэ бүхнийг нохцолдүүлэгч гол хүчин зүйл нь **өөрийн амьдралын зүй тогтлоос уламжлан гарсан харилцаа**, хүн төрөлхтний хэмжээнд хууль тогтоох үйл ажиллагааны хүзээн зовшоорогдсон чиэт зүйлс **хөёрыг** оновчтой хослуулснаас хамаарна. Энэ хослолын зөв зохицол дээр орчин үеийн хууль тогтоох үйл ажиллагаа хийгээд эрх зүйн хэм хэмжээ бүтээх технологи хууль зүйн техник тулгуурлаж байна.

**1.Хууль тогтоох үйл ажиллагаанд орчин үеийн сонгодог онол, дэлхийн жишгийг харгалзаж үзэх хандлага бий боллоо.** Энэ хандлагыг хэн нэгэн сэтгэгч зохногоогүй. Харин хууль тогтоох үйл ажиллагааны хөгжлийн нэгэн хандлага, бодит амьдралын тусгал юм. Тэгэхээр, Монголын хууль тогтоох үйл ажиллагааг хөгжүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалж шинжлэхэд хууль тогтоох онол, арга зүйг ашиглах нь хууль тогтоох үйл ажиллагааны зүй тогтол, онцлог, уламжлал, шинэчлэлийг тодорхойлох гол цэг, арга зүйн чухал үндэслэл болох төдийгүй ногое талаас улс орны эрх зүйн тогтолцоог сонгодог хэлбэрт ойртуулах, оруулах, түүний хөгжлийг товчлох, тосож хөгжих нэг чухал механизм болж огно гэж хэлж болмоор санагдана. Монголын хууль тогтоох үйл ажиллагаанд хууль тогтоох онол, арга зүй аажим алгуур боловч извтэрч эхэлсэн гэж хэлж болно. Хууль тогтоох онол нь олон салбарыг хамарсан шинжлэх ухаан юм. Үүнтэй холбоотойгоор мөн хууль тогтоох онол, арга зүй нь эхлэл төдий байгаагаас хамаарч энэхүү салбарын тогтолцоо одоогоор байхгүй байгаагийн шалтгаан оршино. Тийм ч учраас энэ

удаад хууль тогтоох процедурын хүрээнд зөвхөн хамгийн чухал сэдвэв ба асуудлыг изрэх боломжтой байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** Оршихуй ба байх ёстой зүйл (хууль) харилцан нөхцөлдсөн энэхүү хууль тогтоох арга зүйн шинж чанарын дагуу бодит байдалд дун шинжилгээ хийх ба үнзэлэмжийн чиг баримжааг тодорхойлох нь шийдвэрлэх ач холбогдолтой юм.

**Хоёрдугаарт:** хууль тогтоох арга хийгээд техникт хамаардаг хуулбарлан шилжүүлэх, хүлээн авах (рецепции) ба хүчингүй болгох асуудлыг судлах шаардлага тавигдаж байна.

Хууль тогтоох үйл ажиллагаа нь эрх зүйг зэмдэн хэрэглэх, уламжлан шилжүүлэх (рецепции), нэг талын болон хоёр талын сонирхлын дагуу экспортлох, импортлох арга замаар явагдаж байна. Өдгөө “эрх зүйн рецепци” хэмээх ойлголтоор тэмдэглэсэн үзэгдэл, үйл ажиллагаа дэлхий дахинаа түгээмэл үйтчилдэг болсон хэдий ч харин түүнд хууль тогтоогчид хэрхэн хандах арга, ухаан, эрх зүйн соёл, ухамсар харилцан адилгүй байна. Үүзээс хамаарч хууль тогтоох үйл ажиллагаа, түүний эцсийн үр дүн, үүрэг, зорилго харилцан адилгүй үр дагаварыг авчирсаар байна. Гэтэл уг ойлголт манай ороонд шинжүүх ухааны хувьд нэг мөр тайлбарлаж, тодорхойлсон зүйл одоогоор ховор бөгөөд харин олон улс гурэнд өргөн тархсан хэлний толь бичгүүдэл “нэг улсын эрх зүйн тогтолцооны элементийг нөгөө улс нь зээлдэн авч нутагшуулах, шилжүүлэн хэрэглэхийг илэрхийлдэг ойлголт” гэсэн нийтлэг утгаар тодорхойлсон нь харагдана.

Хууль тогтоох үйл ажиллагаанд “эрх зүйн рецепци” хийхийн омно хуулийн төсөл боловсруулагч, хууль санаачлагч нар дараах дорвон үндсэн нөхцлийг тооцож судалсан байх ёстой. Үүнд:

- Рецепцээн авах гэж буй хууль нь өөрийн эх орондоо тухайн эрх зүйн харилцаагаа бүрэн дүүрэн зохицуулж байгаа эсэх нь хангалттай үндэслэлээр батлагдсан эсэх. Тодруулбал, зохицуулах ёстой эрх зүйн харилцааг анх батлагдсан газраа ч зохицуулж чадахгүй байгаа эрх зүйн шийдлийг өөр бусад орон рецепцилэхээс татгалзах хэрэгтэй.

цааш хэтэрч чадахгүй, өөрийн гол үүргээ сонгодог утгаар нь хэрэгжүүлж чадахгүй байна гэж хэлж болно. Зарим улс оронд нийм төрлийн үүргэг гүйцэтгэдэг байгууллагыг хууль зүйн шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ-судалгааны гол төв гэдэг утгаар нэр хүнд бүхий Хууль зүйн сургуулиудад байгуулан ажилшуулж байна. Энэ байгууллага нь одгоо дэлхийн олон улс оронд байгуулагдаж байгаа нь үр дүнтэй байна гэсэн баталгаа болж байгаа учраас манай улс ч байгуулан ажиллахад илүүдэх юун. Мен "Хууль тогтоох онол, арга зүй" гэсэн изртэй хичээлийг хууль зүйн сургуулиудийн сургалтын төлөвлөгөөндөө оруулсан бие даасан хичээл<sup>2</sup> болгон үзэхийн сацуу энэ асуудлыг "Эрх зүйн онол" хичээлийн судлах зүйлийн нэг гэж үзж байна.

#### 4. Парламентийн чадавхийг сайжруулах (сайн парламент бол сайн л хууль батлан гаргана, муу парламент бол муу хууль л батлан гаргана гэсэн үг)

Хууль бол улс төрийн бодлогын томъёолсон илэрхийлэл, хэрэглүүр<sup>3</sup> учраас улс төрийн бодлого хууль тогтоомжийн үялдаа хамаарлыг нарийн судалж, хуулийг улс төрийн бодлогын алдаа гажуудлаас хамгаалах, улс төрчдийн аминчхан, явцуурсан үзлийн түр зуурын хэрэгсэл болохгүй байх хууль зүйн болон бусад арга, хэрэгслийг шинжлэх ухааны үүдлийс судалж боловсруулах шаардлага улам хурцаар тавигдаж байна. Энэ нь ийнгийн харилцааг хүний сайн сайхан нийтлэг эрх ашгийн төлөө зохицуулж буй хууль улс төрчдийн бүрэн эрхийн хугацааны хүсэл зориг болчих вий гэсэн болгоомжлолыг торуулж байна. Ногоо талаас нь авч үзвэл, Улсын Их Хурлаас батлагдан гарч буй хуулиудад хуулийн чанар, агуулга, үр дүн, тогтвортой үйлчилж

<sup>2</sup> Christopher, E. Legal technique NSW., 2002. болон Кашманова Т.В. Юридическая техника М., 2011.

<sup>3</sup> Б.Чимэд. Зохицтой тогтолцоог барилжсанах нь эрх зүйн шинжилгээний үр дүнтэй хэрэгжүүлэх гуджээ болох нь (Олон улсын сийлээшиуд төвсэн ижтээ). Төрийн захиргаа сонс угз. УБ., 2002. 252 дахь тал.

шинж буюу "амин сүнктэй хууль" чамлалттай байна. Энэ нь юуны омно хуулийн төслийн боловсруулалт муу байгаагас буюу хууль тогтоох үйл ажиллагааны техниктэй холбоотой юм.

**5. Хууль тогтоох үйл ажиллагаанд түгээмэл болон танийн мэдэхүйн аргуудыг зохицой ашиглах.** Хууль тогтоох үйл ажиллагаанд судалгааны зов арга, гүн ухаарал, бүтээлч хандлага шийдвэрлэх үүрэгтэй. Өнеодөр хууль тогтоох үйл ажиллагааны үе шатанд судалгааны аргыг буруу хэрэглэснээс олон орны хууль тогтоомжийг харьцуулан дүгнэхэд алдаа гарах магадлал их байна. Тийм учраас ялангуяа ерөнхий танийн мэдэхүйн үүдлийн дүгнэлт хийхэд алдаа гарлаг хэдэн тохиолдол байдгийг Б.Чимид багшилтийн томъёолсноор ". . . объектыг буруу сонгон авах; улс орныхоо бодит нохцел байдлыг зов харгалзан үзлгүй хуулбарлах; эрх зүйн шинжлэх ухааны тодорхой үзсл баримтлалыгoeffийн орны нохцол байдалд тохиорох эсэхийг үл харгалзах; эрх зүйн бүл, аймаг, салбар, дэд салбар, төрөл хэсэг (институт) гэх зэргийн "ойлголт", оороөр хэлбэл эрх зүйн тогтолцооныoeffoeff бүтцийг харгалзахгүй,oeffийн болгох; хууль, эрх зүйн шинжлэх ухаан, мэргэжлийн хэвшсэн нийтлэг ойлголт, зарчим, иэр томъёо, загварыг тоомсорлохгүй буюу буруу дутуу ухаарах; эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд, түүний дотор хууль тогтоомжийн болон хууль зүйн бусад арга хэрэглүүрийн хоорондын уялдаа, тэнцлийг үл харгалзах<sup>4</sup> гэсэн асуудлуудал юун түрүүнд анхаарлаа хууль тогтоогч нар хийгээд төсөл боловсруулагчид хандуулах ёстой юм. Ийм алдаа гаргахгүйн тулд харьцуулсан эрх зүйн онол сургаалц үндэслэн шинжлэх ухааны арга зүй, аргачлалаар нарийн нягт судлах хэрэгтэй байна.<sup>5</sup>

<sup>4</sup> Н.Лүнээсдорж. Төр, эрх зүйн сэргээлээний хөгжлийн хандлага. УБ., 2002. 252 дэхь тал.

<sup>5</sup> Мон нам. 253 дэхь тал.

Эрх зүйн шинжлэх ухаан нь аль иэг улсын эрх зүйн системийн зарчмууд, журам заалтууд болон стандартуудыг тайлбарлах техникийг агуулаад зогсохгүй нийгмийн элдэв зорчилдоөнийг saatuuлах буюу зохицуулах арга замыг иээж олохыг мөн өөртөө багтаадаг гэж үзвэл эрх зүйн харьцуулалтын арга барил аль иэг ганц улсын дотоод эрх зүйн өгч чадахаас хамаагүй илүү баялаг зохицуулах арга замуудын хувилбар, сонгох боломж өгч чадах нь тодорхой. Учир нь гагшүү өөрийн орны эрх зүйн тогтолцооны дотор бүгсэн ямар ч сэтгэлийн сайтай хуульчийн бүх наасараа бодож олиж чадах бүх арга замуудаас дэлхийн олон янзын эрх зүйн системүүд нь зохицуулах арга замуудыг хавьгүй илүүтэй олон хувилбараар өгч чадна. Эрх зүйн харьцуулалтын практик ач холбогдол бүхий 4 гол үүргийн иж нь эрх зүйн харьцуулалт бөгөөд энэ арга нь хууль тогтоогчид тусlamж болох явдал юм<sup>6</sup>. Учир нь өөрийн орны хууль, эрх зүйг илүүд үзэж, дотроо асуудлыг шийдвэхийг чармайх нь түгээмэл боловч илүү оргөн хүрээгээр тухайн асуудлыг харах боломжоор хангадаг тул онөө үсийн хууль тогтоогч (Улсын Их Хурлын гишүүн) нар өөртөө хэрэгтэй шийдвийг "эрх зүйн харьцуулалт"-аар тодруулбал, өөр орны хууль тогтоомжийг анхаарч судлах замаар олж авах нь зөв юм.

Харьцуулалт бол аливаа юмс үзэгдлийн адил төсөөтэй ба ялгаатай тал, шинжүүдийг тогтоодог. Шинжлэх ухааны харьцуулалтыг үр дүнтэй болгоход хоёр үндсэн шаардлага тавигдаж байдаг байна. Эхний гол шаардлага бол харьцуулах гэж буй хоёр буюу түүнээс дээш олон объектод ямар иж илэрхий бодит нийтлэг шинж байх явдал юм. Хэрэв иж объектын гол шинжийг өөр иж объектын гол биш шинжлэхүүн байх тухайн мэдэхүйн үр дүн худал буюу хоосон байх болно. Тодруулбал, эрх зүйн харьцуулалтын бүрэлдэхүүн:

- харьцуулалтанд хамруулсан зүйл (comparatum)

<sup>6</sup> Б.Чимидж. Үндсэн хуульн үзэж баримтлагч тийтийг асуудал. УБ, 250-253 дэхь тал

- харьцуулах зүйл (comparandum)
- холбогч (ter ium comparationis) Энэ нь дээрх хоёр зүйлийн дундаж онцлог, хоёуланд нь байх шинж чанар бөгөөд энэ шинж чанар дээр уг хоёр зүйл тохирч, үүний дунд харьцуулалт хийх боломж огогддог.

**Нэгдүгээрт:** Хууль тогтоогч (хуулийн төсөл боловсруулагч) нь хамгийн түрүүн ямар эрх зүйн бүлийгoeffийн хийх гэж буй харьцуулалтад хамруулах вэ гэдгийг шийдвэр хэрэгтэй. Бүх эрх зүйн тогтолцоог "эх" болон түүнд нэгдсэн "гишүүн" гэсэн хоёр том бүлэгт хувааж болно. "Эх" эрх зүйн систем нарийн бодож боловсргэдсон байдаг богоод бусад системүүд тогтмол түүнийг хуулбарлан авах буюу дуурайdag.

**Хоёрдугаарт:** судалгааныхаа хүрээг хaa хүртэл тэлж болох тухай асуудал юм. Энэ талаар срөнхий чиглэл огоход хэцүү байдаг ба энэ нь тухайн судалгааны тодорхой сэдвээс хамаарна. Хэрэв, олон янзын эрх зүйн систем түүний хэв маяг, загварыг харьцуулж байгаа бол судалгааныхаа хүрээг ерөнхийдоо эрх зүйн бүлүүдийн эх системүүдээр хязгаарлаж болно. Харин тодорхой ямар нэгэн асуудлаар дагнан харьцуулалт хийж байгаа бол дараах журмыг мөрдож болно. Иргэний эрх зүйд, ялангуяа гэрээний, омчийн эрх зүйд "сонгодог" асуудлууд байдаг. Эдгээр болон Америкийн эрх зүйг, Ромын бүлээс Франц, Италийн эрх зүйг, Германы эрх зүйн бүлээс Герман, Швейцарийн эрх зүйг судлахад хангалттай. Мөн онолын шинэчлэл ховорхон хийгддэг тул Скандинав системүүдээс Швед, Данийн эрх зүйг судалгаанд хамруулбал зохицктой. Эдгээр эрх зүйн асуудлуудаас гадна бүх орны хууль тогтоогчид адилхан зууралдаж буй чухал асуудлууд байдаг. Ийм үед бүр жижиг системийн бодож боловсруулсан шийдвэлийг ч анхааралдаа авах шаардлагатай болох нь олонтоо. Жишээ нь, Израйль гэрээний стандарт-хэлбэртэй холбоотой асуудлыг шийдвэр тал дээр илүү амжилттай байна. Ослын нийгмийн даатгалын арга замаар автозамын ослоос үүдмэгтэй хохирлыг барагдуулах талаар Канаадын Саскатчеван муж, Польш, Финляндын хамт дэлхийг тэргүүлж

байна. Мөн гэр бүлийн салбарт Скандинавын улсуудын системээс суралцах зүйт ишгээд их. Тухайн орны эрх зүйн системд шинэчлэг, өөрчлөлт хийхэд уг системд хамгийн их нөлоотэй системийг эрх зүйн харьцуулалтад хамруулах шаардлагатай байдаг байна.

**Гуравдугаарт:** Хууль тогтоогч (хуулийн тесэл боловсруулагч) харьцуулахаар сонгосон гадаад орны хууль тогтоомжийг өөрийн орны системд дассан нүдээр хардаг, өөреөр хэлбэл, хэрэгтэй шийдэл, арга замыг харийн эрх зүй дотор хайхдаа өөрийн системд олж сурсан газраа эрдэг тохиолдол олон. Ингэж буруу газар хайснаас гадаадын эрх зүйн систем тухайн асуудлыг зохицуулаагүй, гадаадын системээс авах юм байхгүй гэсэн дүгнэлтэд хүрнэ. Гэтэл эрх зүйн системүүдийн өөр хоорондоо ялгагдах гол ялгаа нь тухайн асуудлыг өөр өөр замаар шийддэгт байх болоод үүний улмаас уг асуудалд өгсөн шийдэл тухайн эрх зүйн системийн хаа ч, мөн системээс гадуур ч одож болно гэдгийг санах хэрэгтэй юм.

**Доровдүгээрт:** Эрх зүйн нэр томъёоны сан бүрдүүлэх хэрэгтэй. Судалгааны явцал судалгва, харьцуулалт хийж байгаа иэгжийг хэрхэн нэрлэх, юу гэж ойлгох талаар хүндрэл гардаг. Ямар нэгэн үг буюу хэлтэг харьцуулалтад хамруулсан бүх системийн хувьд яг тэр утгыг илэрхийлж адилхан асуудлыг хамрах тохиолдол бараг үгүй. Иймд эрх зүйн харьцуулалтын үйл явцын дараагийн алхам болох "эрх зүйн нэр томъёоны сан" байх шаардлагатай. Үүний тулд тусгай огүүлбэр зүй болон угсийн сан боловсруулах хэрэгтэй. Энэ нэр томъёоны сан нь маш уян хатан байх шаардлагатай бөгөөд өөр хоорондоо зоруутай боловч гүйцэтгэх үүргээрээ харьцуулж болох институциудыг оортөө багтаахын тулд ойлголтуудыг хангалттай өргөн хүрээгээр авсан байвал зохино. Сүүлийн жилийнд хууль зүйн нэр томъёоны толь хэд хэд гарсан нь олзуурхууштай юм.

Хууль бүтээх (тогтоох) үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг дээшилүүлэхэд шууд нолоо үзүүлэх эрх зүйн гол хоёр эх сурвалж бол Хууль тогтоомжийн тухай хууль, Улсын Их

**Хурлын хуралдааны дэгийн тухай хууль хоёр юм.** Энгэрсон онд баталсан, ирэх оноос хэрэгжиж эхлэх Хууль тогтоомжийн тухай хууль нь хуулийн тосол боловсруулах, санаачлах ажилд ахиц давшил авчирна гэж найдаж байгаа юм. Айх 1993 онд Улсын Их Хурлын даргын захирамжаар “хууль тогтоомжийн тосол боловсруулах аргачлал”-ыг баталсан байдаг богоод энд аргачлалын дагуу 1997 он хүргэл хууль тогтоомжийн тослийг боловсруулж хэлэлцэн баталдаг байсан. Хууль тогтоомжийн тухай хууль нь улс орны бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжийг санаачлахаас эхлээд хэрэгжилтийг хангах хүртэлх бүхий л асуудлыг нэг дор, цогц байдлаар зохицуулж, агуулгыг тодорхойлсон нь одоогийн эрх зүйн орчиниг илүү давшилтгэй болгож, сайжруулсан гэж үзэхээр байгаа юм. Тухайлбал хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дараах зохицуулалтууд ишмэгдсэн.

1. Хуулийн тосол боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаяар хангах үүднээс Засгийн газар б 6 аргачлалыг баталж, мөрдүүлж;
2. Хууль санаачлагч хууль тогтоомжийн тослийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийх;
3. Хуулийн тосол боловсруулахын омно түүний хэрэгцээ шаардлагыг холбогдох аргачлалын дагуу урьдчилан тандан судлах;
4. Хэрэгцээ шаардлагыг судалсны үндсэн дээр хуулийн тослийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулах;
5. Хуулийн тослийн үзэл баримтлалд тулгуурлаж хуулийн тослийг холбогдох аргачлалын дагуу боловсруулах;
6. Хууль санаачлагч хуулийн тослийн үр нөлөөг холбогдох аргачлалын дагуу үзүүлж;
7. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг аргачлалын дагуу тооцоюлох;
8. Хууль тогтоомжийн тосолд эрх зүйн дүтийн хийх эрх бүхий этгээдээс санал, дүтийн авсан байх;

9. Хууль тогтоомжийн төсөлд санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэшүүлэх;
  - а. Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах
  - б. Ерөнхийлогч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах
10. Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангадаг байхаар шинэ тогтолцоог бий болгосон;
11. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлснээ тохиолдолд эрх зүйн дүгнэлт гаргуулж хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Улсын Их Хуралд оргон мэдүүлэх тогтолцоог бий болгосон;
12. Парламент, УИХ ворийнхөө баталсан хуулиа олон нийтэд хүргэх үүргийнхээ дагуу яаж ажиллахыг тодорхой болгосон зохицуулалтыг оруулсан;
13. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах нийтлэг журмыг хуульчилсан;
14. УИХ ЗГ хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинэжилгээ үзэлгээ хийх ажлыг хийхээс гадна хөндлөнгийн байгууллагаар үзэлгээ хийлгэх зэргээр хамтарч ажиллаж болохоор зохицуулсан.

1) Хуулийн тосол боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүдлийн Засгийн газар б аргачлалыг баталж, мөрдүүлэх Хуулийн тосол боловсруулах арга зүйн асуудлаар зөвлөмж, аргачлал гаргах, хууль зүйн нэр томьёог нэг мөр болгон жигдлэх арга хэмжээ авах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”, “Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд үзэлгээ хийх аргачлал”, “Хуулийн төслийн зардлыг тооцох аргачлал”, “Хууль тогтоомжийн тосол боловсруулах аргачлал” гэсэн 5 аргачлалыг 2009-2011 онд баталсан байдаг бөгөөд энэ нь зөвлөмж, арга зүйн шинжлэхүүний байсан

тул хуулийн төсөл боловсруулахад төдийлон хэрэглэгддэгтүй байсан. Үүнийг сайн дагаж мордсон бол тослийн шинжлэх ухааны үндэслэл нэмэгдэх байсныг хэлэх хэрэгтэй.

**2) Хууль санаачлагч хууль тогтоомжийн тослийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийх;**

Хууль тогтоомжийн тослийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийхийг хуульчилж огсон. Үүнд:

- > хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;
- > хууль тогтоомжийн тослийн үзэл баримтлалын тослийг боловсруулж, батлах;
- > хууль тогтоомжийн тослийг боловсруулах;
- > хууль тогтоомжийн тослийн үр нолооний үзүүлэлтэй, зардлын тооцоог хийх;
- > эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн толоолол, олон нийтээр хууль тогтоомжийн тослийг хэлэлчүүлж, санал авах;
- > хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагыг, мэргжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;
- > хууль тогтоомжийн тосолд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авах;
- > хууль тогтоомжийн тослийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлчүүлэх;
- > хууль тогтоомжийн тослийн бүрдүүлбэрнийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

**3) Хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах**

Хууль тогтоомжийн тослийн үр нолоог урьдчилан тандаж судлах нь аливаа асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлон, тухайн асуудлыг шийдвэрлэх

зохицуулалтын хувилбаруудыг илрүүлж, тэдгээрийн эрэг болон серөг талуудыг харьцуулан судалж, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг шийдвэр гаргагчид санал болгоход оршино.

#### **4) Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;**

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахын омно тухайн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах нь хуулийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэгжих баталааг хангах чухал нохцол болох ба энэ нь ирээдүйд батлагдан гарах хуулийн гол агуулга, үзэл санааг тодорхойлж байгаа хэрэг юм.

Хууль санаачлагч /Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар/ хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох ба хууль санаачлагчийн өгсөн удирдамж, чиглэлийн дагуу тухайн төслийг хариуцан боловсруулах мэргэшсэн хуульч, шинжээч, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг ажиллах нь илүү тохиромжтой.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулах бөгөөд хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хууль тогтоомжийн зорилго, сронхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хууль тогтоомж батлагдсаны дараа үүсж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал болон хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, верчлолт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал зэргийг тусган үзэл баримтлалын төслийн боловсруулана.

## **5) Хууль тогтоомжийн төсөл боловсруулах**

Хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа холбогдох аргачлалын дагуу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тухайн харилцааг хуулиар зохицуулахаар шууд заасан, эсхүл хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тухайн хуулийн хэрэгцэг тодорхойлох нь чухал бөгөөд хэрэгцэг тодорхойлоход хэд хэдэн асуудлыг судлан үзэж тогтооно. Үүнд:

- Нийгмийн тодорхой харилцааг үүсгэх, оорчлох, дуусгавар болгоход чиглэх эсэх;
- Тухайн зохицуулалт нь Монгол Улсын газар нутгийг бүхэлд нь хамрах эсэх;
- Иргэн, хуулийн этгээд, торийн байгууллагад эрх олгох буюу үүрэг хүлээнгэх эсэх;
- Тухайн харилцааг зохицуулах өөр бусад арга зам байгаа эсэх;
  - ✓ Цаашид үүсэж болох сорог үр дагавар болон нийгэм тухайн зохицуулалтыг хүлээн авахад бэлэн эсэх, тодорхой хэмжэний хүлээнт бий эсэх;
  - ✓ Тухайн асуудлаар хууль батлах ажлыг хүлээнгэх боломжгүй байгаа нохцол шаардлага, түүнчлэн тухайн асуудлыг хэсэгчлэн, эсхүл цогцоор нь зохицуулах шаардлагатай байгаа эсэх.
- Тухайн харилцааг хуулиар зохицуулснаар бий болох үр дагавар нь түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зөвтгэж байгаа эсэх;
  - ✓ Тухайн зохицуулалт нь нийгэм, здийн засаг, шинжүүх ухаан, техник, хууль зүйн хувьд бий болох үр дагавар, ач холбогдол нь зөрөг талыг бий болгох бол;
  - ✓ Тухайн зохицуулалт бий болсноор нийгэмд үзүүлэх здийн засгийн зардал нь нийгэмд эргээд илүү сайнаар нөлоолох бол.

Хуулийн төсөл боловсруулахад төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна:

- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;
- Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зорчилгүй байх;
- Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжктэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;
- Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн иэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нохцел байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;
- Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зорчсон этгээдэд хүлэолгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдор болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдох журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;
- Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагаадах хуулийн төслийг боловсруулсан байх;
- Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох

богоод зорилгод тус хуулиар хангахаар зориж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. Эдгээр шаардлагуудаас гадна хуулийн төсөл боловсруулахад нэр томьёо, хуулийн төслийн хэл зүй, наиргуулга зүй, товчлол, ишилэл зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

Эрх зүй, хууль тогтоомжийн системчлэлийг шинэ түвшинд гаргах шаардлага буй болоод удахж байна. Хууль тогтоомжийн системчлэлийн үндсэн гурван аргын аль алийг нь хэрэглэж ирсэн туршлага бидэнд бий. Гэхдээ төрөлжүүлэн хуульчлах (Кодификаци) үйл явц удаашралтай, нийгмийн харилцааг зохицуулагч хуулийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч тэдгээр хуулиудын давхардал бий болж нэг төрөл харилцаанд олон жижиг хуультай болсон нь кодификаци хийн төрөлжүүлэн хуульчлах хэрэгтэйг харуулж байна.

2002 онд Иргэний хуулийг шинэчлен баталсныг эс тооцвол манайд төрөлжсон хууль гарч чадахгүй явж ирсэн. Харин 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдан гарч 2017 оны 7 дугаар сарын 1 нээс эхлэн дагаж мордохоор болсон нь том ахиц дэвшил болсон гэж үзэж байна. Нийт 224 хууль тогтоомжуудад байсан захириааны зөрчил, хариуцлагын арга хэмжээнүүдийг нэягтгэн улмаар эрүүийн хуультай нийцүүлэн хуульчилснаар зөрчлийн тухай хууль гарч байгаа юм.

Байгаль орчны тухай хуулиуд, нийгмийн халамж, даатгалын тухай хууль тогтоомж, газрын тухай хууль тогтоомж гэх мэтээр төрөлжүүлэн хуульчлах шаардлагатай салбарууд байна. Манай улс онгөрсөн онд ОХУ-ыг дууриаж сонгуулийн кодекс хуультай болох оролцлого хийлээ. Гэхдээ энэ нь зохицуулж буй харилцааны онцлогоос хамаарч үр нөлоөтэй байх эсэхийг цаг хугацаа харуулна.

Хууль олиоор төрж байгаатай холбоотойгоор Хууль зүйн яамнаас өргөтгесөн ажлын хэсэг гарч хуулиудын давхардлыг арилгах кампанит ажлыг хийснээр 2009-2011 оны хооронд 298 хуульд эрх зүйн цвэрлэгээ хийсэн байна. Үүнээс хойш 5, 6 шахам

жил өнгөрөхөд дээрх цэвэрлэгээг дахин хийх шаардлагага мөн л гарч ирж байна.

Багц хууль гэдэг ухагдахуун бий болоод удаж байна. 1990 ээд оны эхэнд Татварын тухай багц хууль, Боловсролын тухай хууль гээд л эхэлсэн түүхтэй. Ямарч л байсан Багц хуулийн хувьд өөр хоорондын уялдаа холбоо (бүлэг, зүйл заалтууд төдийгүй зохицуулж буй асуудал хүрээний хувьд тухайлбал, батлан хамгаалах салбарын хууль тогтоомж шүүхийн багц хууль гм) -той байхыг хууль тогтоомжийн тухай хуульд бэхжүүлж өгөх шаардлагага тавигдсан юм.

Багц хуулийн төсөл гэсэн зүйлийг бий болгож Хууль тогтоомжийн тухай хуулийн 26 -р зүйлд заахдаа:

26.1 Засгийн газар тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлчүүлэхээр багц хуулийн төслийг боловсруулж, оргон мэдүүлж болно. Энэ тохиолдолд хууль тус бүрийн үзэл баримтлалыг тодорхойлно гэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг Улсын Дээд Шүүх тайлбарлах эрх, үүргэгтэй. Энэ эрх, үүргийг яаж хэрэгжүүлэх вэ? Гэдэг асуудал нийтэн маргаан дагуулж буй юм. Шинэ Үндсэн хууль мөрдөгдсөнөөс хойшхи нийтэд хугацаанд (2012 он хүргэлих) Улсын Дээд Шүүх норматив тайлбар буюу хуулийн зүйл заалтыг тогтоолын хэлбэрээр тайлбарлаж ирсэн. Улсын Дээд Шүүхийн тайлбар нь Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэл рүү халдсан шинжтэй гэсэн шүүмжлэл удаа дараа гарсантай холбогдуулан шүүхийн тухай хуулиар казуальний буюу шүүх хэрэг маргааныг шийдвэрлэсэн жишиг нь тайлбар болох агуулга бүхий заалт орсон. Энэ нь бас л хяналтын шатны шүүхийн шүүгчийн шийдвэр Улсын Дээд Шүүхийн тайлбар болж чадах уу гэдэг асуулт тавигдаад хүрч байна. Гэсэн ч урьдах тогтоолууд ч, хэрэг маргаан таслан шийдвэрлэх практик ч аль аль нь албан ёсны тайлбарт багтана. Энд нэг зүйл тэмдэглэхэд сүүлийн жилүүдэд

Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарлах үйл ажиллагаа зогсонги байдалд орсныг хэлэх байна.

Шүүхийн тухай багц хуульд энэ мэт үзэл баримтлалын шинжтэй маргааны асуудлууд байгаань хууль бүтээх (тогтоох) -д нарийн бодож тооцсон, шинжлэх ухаанч хандлага үгүйлжээзор байгааг харуулж байна.

## **АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ**

1. Б.Чимид. Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэлгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болох нь (Олон улсын симпозиумд тавьсан илтгэл). Төрийн захиргаа сэтгүүл. УБ., 2002. 252 дахь тал.
2. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал. УБ., 250-253 дахь тал
3. Д.Лүндээжанцан. Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005.
4. Кашанина Т.В. Юридическая техника М., 2011.
5. Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 252 дахь тал.
6. С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 74 дэх тал.
7. Christopher. E. Legal technique NSW., 2002.

## **THESIS: ISSUES OF IMPROVEMENT OF THE SCIENTIFIC BASIS FOR LAW MAKING PROCESS**

Law making process is in intersection of many humanitarian disciplines and it is a relation inherited from the nation's social life patterns, which should be viewed from a different perspective of each discipline. Also, it is an independent issue of the science mixed with legislative values among the human history.

This comprehensive activity which can be similar to creation of a queen's crown includes: *First*, legislative tradition of the nation mixed with modern classic theories considering worldwide standards; *Second*, study of the nature and evolution of the relations that require legislative regulations; *Third*, to study social mind and academic organizations' proposals; *Fourth*, improve the capabilities of the Parliament which is the main subject to law making process; *Fifth*, the main requirement to rationally apply the scientific cognition methods in a rational basis.

The above requirements are the main conditions to improve scientific justifications of the legislation the following activities in all levels of legislation:

- Initiate law drafts and submit to the State Great Khural;
- Discuss and approve the laws (Standing Committees and Plenary Sessions);
- Verify and publish the laws.

Therefore, the presentation highlights that the above main requirements must be as important as the investigation of the real needs of the legal regulation, development of the concepts of the draft laws, and implementation of the draft laws likewise the development of the draft laws.

We consider that the presentation has new and practical significance by mentioning all the methods to create laws, using the comparative study in it, and aiming to determine the improvement methods.

газар аж төрөхийг л эрмэлзэн хүсч ажтуу"<sup>13</sup> гэсэн дүгнэлтээ "...монголчуудын дайсан Мэргэдийг Половчууд өмгөөлж байсан аж. Онон мөрноос Днепр хүрэх хийгээд Днепрээс Онон хүрэх тал хээрийн зам нэг бөгөөд хил хязгаараа дайсан этгээдэд нээж үлдээх нь учир утгагүй хэрэг байв. Монголчууд Половецчуудтай дайсан шалтгаан чухам үүнд орших бөгөөд тэднийг Карпатын чанац руу хөөн гаргах зорилгоор монголчууд Русийн гүн рүү довтолсон юм"<sup>14</sup> гэж баталсан байдаг. Оросууд половец гэж Каспийн тэнгис, Кавказ, Хар тэнгисийн хойд хэсгийн бус нутаг, баруун тийш Дунай мөрний эхэнд тулах асар уудам баруун хойд Евразийн их талд эртиээс амьдарч ирсэн түрэг угсааны нүүдэлчдийн олон аймгуудыг кинчак гэж иэрлэдэг байжээ. Европт болохлоор куман буюу коман<sup>15</sup> гэж иэрлэдэг ажээ. Энэ үед Русь нь олон тооны вант улсад хуваагдан задран бутарч, өөр хоорондоо дайсагналааж байв. Ийм байдал нь Русийг монголын эзэнт гүрэнд дагаар ороход хургэсэн гэдэг. Монголчуудын нөлоонд байх үедээ Русийн олон хот суурин ямар ч хохирол амсаагүй бөгөөд хүчирхэг Алтан орд улсын үед хөгжил цэцэглэлт зогсолтгүй явагдсаныг Оросын түүхчид өөрсдөө баталсан байна.

Хятадын түүхчдийн өөрсдийных нь иотолсноор Хятад гүрэн Монголчуудын эрхшээл байхдаа тархай бутархай нэгдмэл бус байдал нь эцслэгдэж, нэгэн цаг үеийн турш чинхэлэг хангалуун амьдарч, ср бусын хөгжил цэцэглэлтэд хүрч, худалдаа үйлдвэрлэл оргожин хөгжжээ. Ойрхи дорнод, дундад Ази монголчуудын ачаар худалдаа арилжаанд нолоо бүхий үүрэг гүйцэтгэх болжээ.

Монголчууд Евразийн их худалдааны бүсийг хөгжүүлж, Газрын дундад тэнгисийн Венеци, Генуягаас Монголын эзэнт гүрний дундуур дайрч, Хятад хүрэх замын нутаг дэвсгэрийн

<sup>13</sup> Н.С. Түрбецкий, дүрдсан бүтээл, 69 дэх тал.

<sup>14</sup> Лев Гумилев, дүрдсан бүтээл, 69 дэх тал.

<sup>15</sup> Сүгимма Масалык Монголын эзэнт гүрний мандал буурах, Улаанбаатар, 2015, 69 дэх талас тодруулж үзнэ уу.

аюулгүй, найдвартай байцлыг хангаж өгчээ. Үүний үр шимийг Европчууд, төв Азийн лалынхан, Еврейчүүд, Хятадууд, Азийн бусад улс түмэн хүртэж байжээ.

140 жилийн туршид монголчууд нэгэн үсийн амар амгалан буюу Pax Mongolica-г дэлхий дахинд авчирсан билээ. Ингэхээр Ш.Монтеськогийн Монголчууд түүний дотор Чингис хааныг Энэтхэгээс Газар дундын тэнгис хүртэл Азийг түйвээн сүйтгэж, Персээс дорнод зүгт орших бүх улсыг устган элсэн цөл болгосон гэсэн үндэслэгээ түүхэн бодит үзүүд огт нийцэхгүй байна.

### **Ш.Монтеськогоос 450 жилийн омнох**

#### **тэс өөр үзэл баримтлал**

Чингис хаан багшдаа бичсэн захидалдаа “Өдгөө миний бис эрдэмтэн мэргэдийг залж, авьяастан чадвартныг түшихийг хүсж буй нь дэлхий дахыныг амарлиулахын төлөө болой”<sup>18</sup> гэсэн байdag. Чингис хааны энэ эрхэм чанарыг түүний хүүхдүүд, ач гуч нар нь нэр төргэй үргэлжлүүлжээ. Түүний нэг жишээ нь их эзний отгон хөвүүн Толуйгийн гуравдугаар хөвүүн Хүлэгү Ил хаант улсыг цогцлоож, түүнийг залгамжлагчдын санаачилгаар 1301-1311 оны хооронд СУДАРЫН ЧУУЛГАН хэмээх Монгол териин албан ёсны түүхийг Персийн язгууртан Рашид-ад-диний удирдлагаар Монгол териин нэрт зүтгэлтийн Болод чинсан, хятад эрдэмтэл, энэтхэг санваартан нарыг оролцуулсан баг бүтээсэн. Эл бүтээл Персийн Рашид-ад-Диний нэрээр алдаршсан бөгөөд Ш.Монтеськогоос 450 жилийн омно бичигджээ. Тэр бүтээлд “Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч нарт хорвоод торж, хаан тор барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэж болохуйц Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг оорчлохгүйгээр сахивал Мөнх тэнгэр хишигээ хүртээж, тэд маань өнө мөнхөд гэр хотлоороо энх амар,

<sup>18</sup> Ли Жичан Чанчунь болбын орто энээсээд зорчсон тэмдэгээ... орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 18 дэхь тал.

жаргалтай байх болмуй заа<sup>19</sup> хэмээсэн байдаг билээ. Энэ бүтээлд эхлээд ёс суртахуун, дараа нь Засаг хууль гэсн байна. Чухам яагаад хуулийн омни ёс суртахууныг оруулах болов?

Өнеөдөр Монгол улсад дээр дооргүй ёс суртахуун ярьж, ёс суртахуунгүй байгаа учраас ийм байдалд орчихлоо гэж халаглах болжээ.

Тэгвэл ёс суртахуун гэж юу юм бол? Аливаа юутай ч зүйрлэшгүй хамгийн үнэ цэнэтэй зүйл нь мөнгө, эд хөрөнгө, албан тушаалд бус харин түүний ёс суртахуунд<sup>20</sup> байдаг ажээ. Үүний дэлхийн суут ухаантнууд нэгэнт нотолж чадсан байна<sup>21</sup>.

Агуу Аристотель одоогоос 2500 жилийн омнио “Хууль тогтоогчид болбоос дадал зуришлынхаа дунд сайн тал руу нэгэнт хэлбийн одчихсон хүмүүс дагана хэмээн ойлгосны үндсэн дээр үзэмж сайны нэрийн омноос тэднийг сайн үйл рүү уриалан шахах хэрэгтэй, харин дуулгаваргүй бөгөөд нуруу муутай хүмүүсийг залхааж, цэргүүлж байвал зохино”<sup>22</sup> гэсэн санааг дэвшүүлж байжээ. Аристотель ийнхүү хуулийн амин сүнсийг “сайн үйлгэй”, ёс суртахуунтай шууд холбон үзэж байжээ.

Ёс суртахуун бол аливаа хүмүүнийг хүмүүн хэвээр байлгах дотоод сэтгэл, хүний уураг тархинд мөнхөд орших олдмол бус төрөлх огогдол буюу энерги юм. Хүмүүн гээч бодгаль өөртөө ямагт сэтгэлийн сайн инстиктийг тээж явдаг. Шударга ёс, ичих ба эмээх сэтгэл, эр зориг, үүрэг ба хариуцлага, жудаг, нинжин өрөвч сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, найрсаг зэлдэг зан, тэсвэр тэвчээр, өгөөмөр сэтгэл, үл хомхойрох, ёс хонзон, атая жетоо эс

<sup>19</sup> Рашид-ад-дин Сүдрын чуулган..., I боть..., орос хэлээс эх хэлээх хорхуулжши Ц.Сүрэнхордоо..., Улаанбаатар., 2002, 404 дэх тал; Рашидаддин Шандырын чуулган хэмээх монголчуудын түүх ориший..., дэд боть..., Альзи хэлээс орчуулж, уялга уг бичиж, тайзбар зуулж үзэжши Г.Аким..., хөйрдэх хэлээл..., Улаанбаатар., 2015, 448 дэх талыг үзэ үү.

<sup>20</sup> Ёс суртахууныг англи хэлээс *moral*, орос хэлээс мораль хэмээн ишигжсан байдал.

<sup>21</sup> Альберт Эйнштейн..., Улаанбаатар., 2015, 79 дэх талас тодруулж үзэ үү.

<sup>22</sup> Аристотель Никомахын ёс түү..., орос хэлээс орчуулжсан Б.Даш-Эндон..., Улаанбаатар., 2007, 319 дэх тал.

өвөрлөх зэрэг хүмүүний эрхэм нандин зан чанарын цогц угтаа ёс суртахуун юм.

Аливаа хүний уураг тархи, мэдрэлийн систем нь 80 мянган тэрбум эсээс бүрддэг байна. Эрдэмтэд 80 их наяд (80 000 000 000) цахилгаан элементийг хүний уураг тархи агуулдаг болохыг тогтоожээ<sup>23</sup>. Хүний уураг тархинд 10 тэрбум гаруй үүр байдгийг мөн ишэжээ<sup>24</sup>. Тэдгээр үүр ёс суртахууны энерги үйлдвэрлэж, хүлээн авч, бүртгэн тэмдэглэж, дамжуулдаг аж. Эдгээрийн үр дүнд хүний оюун ухаан хэвийн ажилладаг байна. Тэрхүү ёс суртахууны энерги нь бусад хүмүүнд үйлчлэн харилцан таталцах хүчин чадлыг оортоо агуулдаг. Ийм болохлоор кванттын физикчид дэлхий өртөнц бүхэлдээ оюун бодлюос үүсэлтэй хэмээн үзжээ<sup>25</sup>.

Хүний оюун ухааны нэг хэсгийг ердийн ухамсар, нөгөө хэсгийг нь дотоод ухамсар бүрдүүлж, эдгээр нь бие бистэйгээ шууд хамааралтай харилцан ажилладаг байна. Хүний дотоод ухамсырын үл мэдгэдэх орон зайг орчин үеийн шинжлэх ухаан судалж эхэлсэнээс хойш хүн төрөлхтөн срдэө 100-аад жилийн нүүр үзэж байна. Дотоод ухамсырын өргөн уудам талбарт хүний ёс суртахууны өгөгдлийн орон зай байдаг. Энэ учраас ёс суртахууныг хэн нэгэн тогтоодогтүй, харин төрөлх эсээс бүрдэнэ.

Хүн эхийнхээ умайгаас тасрахад түүний уураг тархинд ёс суртахууны эс энерги унгаа байдалтай байх боловч цаашидын осолт бойжилтын явцад удам судар, гэр бүлийн болон оорийн хүмүүжил, боловсрол ба орчны олон талт нөлөөлөл зэргээс шалтгаалан ёс суртахуунлаг буюу эсхүл ёс суртахуунлаг алдах төловшилээ олно. Суут Кант ёс суртахууны зүй тогтол хүний сэтгэл дотор байдгийг нотлоод хүн сайн явахыг хичээж чадах тул сайн байх учиртай гэж үзжээ. Германы гүн ухаанч Прехт

<sup>23</sup> Наполон Хилл, Кларенс Стоун Эрэг сэтгэгэээнд тулгуурлан амжилтад хүрэх нь..., оруулсан Д.Донгийн..., Улаанбаатар., 2014, 55 дахь талыг узин үү.

<sup>24</sup> Мон тэнд, 56 дахь тал.

<sup>25</sup> Ронда Берн Нууц..., Монсудар..., Улаанбаатар., 2011, 15 дахь талыг узин үү.

хүний ёс суртахууны чадвар төрөлхийн. Бидний приматаас гаралтай тархи бусдын сэтгэлийг ойлгох боломж олгосон ба мөн “сайн үйл” хийснийхээ төлөө нейро химиин урамшуулал авахаа ч мэддэг. Иймд ёс зүйтэй зан төрх бол маш нарийн төвөгтэй альруизм богоод сэтгэл болон эргэцүүлэн бодохоос бүтиз... Ёс суртахуунаа ямар түвшинд хэрэглэх нь хүн өөрийгөө хүндлэх хүндлэл болон хүмүүжлээс хамаардаг<sup>26</sup> хэмээн бичсэн.

Хүмүүс жигд ёс суртахуулаг байх үед тэдэнд хуулийн хэрэг огт байхгүй байжээ. Гэтэл нэг хэсэг нь мөнгө, эд хөрөнгө, албан тушаал, тансаглалц улайран, ёс суртахуунаасаа дээгүүр тавих болсон нь хүн төрөлхтөнд их гай зовлон авчиржээ. Чингис хааны багш хутаат арш Чанчууль бомбо “Ёсыг (ёс суртахууныг) чин сэтгэлээр үнэнхүү бясалгахуйд хад чулууг туулан ондөр уулнаа авирах мэт болох агаад дээшилэх тутам бэрх болох тул хэрэв алхамын төдийд алдваас урьдын бүх зүтгэл талаар болох бий. Иймийн тул ёсыг (ёс суртахууныг) туйлын чандаар сахиж чадах нь үнэхээр бэрх агаад өртонцийн эгэл хүмүүс тийн явж үл чадах нь даанич их ажгуу. Ёсноос “(ёс суртахуунаас) тэрслэгсэд, шунагсад болбоос уулнаас онхрох чулуу лугаа адил хоромхон зуурт үлдэх мөргүй талиймуй”<sup>27</sup> хэмээсэн сургаал айлдаж байжээ. Их Монгол улсын үед түгэн дэлгэрэн “Эрдэний эрхи Субашид”-д “муу юм өртонцод олон бий боловч, муу хүнтэй адил аюулт юм ер үгүй”<sup>28</sup> хэмээн бичсэн байdag.

Хүчирхийлэл, ёс хонгzon, атаархал, хорон муу санаа, луйвар, дур зоргын авиралалаас ёс суртахуулаг хүмүүсийг хамгаалах нь ганц нэг хүний хувьд бараг боломжгүй зүйл юм. Иймд ёс суртахуулаг хүмүүсийг хамгаалахын тулд эзэн хаан дангаараа

<sup>26</sup> Мөн тэнд.

<sup>27</sup> Ли Жичан Чанчууль болбыйн орно эхээсээд горчсон тэмдэхэн..., орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 98-99 дэх тал.

<sup>28</sup> Сажса Бандид Гунгнажсан Эрдэнийн сан Субашид..., Монсудар..., Улаанбаатар., 2009, 52 дэх тал.

эсхүл иргэдийн дундаас сонгогдсон төлөөлөгчид хуран чуулж, ёс суртахуунлаг бус хүмүүсийн хорон муу үйлийг гэсгээх, тэдний учруулсан хохирлыг арилгахын тулд албадлага хэрэглэх зайлшигүй шаардлага үүссэн. Энэ шаардлага хууль, түүний биселзтийг тусгай зохион байгуулалт-торт ёсыг буй болгов. Ёс суртахуунлаг иргэд татвар гувчуур сайн дураараа төлж, түүгээрээ торийн түшмэдүүдийн цалин пүнлүүг тавьж олгон, хариуд нь оөрсдийгөө ивээл хамгаалалтдаа байлгахыг шаардах болов. Төр, түүний нүсэр аппаратыг ёс суртахууныг хамгаалагч байх ёстой хэмээн үзж иржэ. Монголчууд торийн судландаа залбирч ирсний учир нийм юм.

### Харийн сурвалж бичижт хийсэн эрэлхийлэл

XIII зууны үед ёс суртахууныг амин сүнс болгосон хууль нь Монголчуудыг дэлхийн эзэнт гүрэн болгосныг юуны омно гадаадын элч, эрдэмтэн мэргэд, санваартан, худалдаачин, аялагчдын бичиж үлдээсэн сурвалжуудаас эрэлхийж мэдэж авсан юм. Энэ талын буюу оөрөөр хэлбэл, Чингис хааныг эих тунх байх үсийн хоёр аян замын тэмдэглэл нь здүгээ үлдсэн байна. Эхнийх нь Чингис хааны багш, хутагт<sup>29</sup> арш<sup>30</sup> Чанчунь бомбын<sup>31</sup> орно этгээдэд зорчсон тэмдэглэл юм. Чингис хаан хутагт аршийг олон удаа урин залж, түүнд бүр хувийн захидал хэдэнтээ бичиж байжээ.<sup>32</sup> Захидыг хүлээж аваад нас сүүдэр 70

<sup>29</sup> Хутагт гээдээ бол хувилгаадад алгодог цэд.

<sup>30</sup> Ариш бол хүний дэлтэй хөдөлгөөнөөс запидуу, бүйдлийн газар ном баясалгал уйзджэж буй даяанч хүн.

<sup>31</sup> Бомбо бол манай эршиний эсм үед Энэтхэг. Түүд улмаар Хятаад дэлгэрэндээсэйн шашин.

<sup>32</sup> Чингис Хаан захидалдаа “Одгоо линий билээ зэргийн эзэнтэй мэргэжийг залж, аялагчадаан чадвартныг түүнчлийг хүсэж буй нь дэлхий дахьтыг алмиршуулжин тозоюү болгой. Гэх линий хаан сууринд сууринд сүсээн цагасаас ялангу чин сэргээсээр төр засагт түүхээсээр омоог хүрээдээ үүнд шийцэх хүнийг хараахан эс алгасан анам. Харин одгоо сонсохуз благийн Тагийн болибын үнэн биеийг алгод ёсыг журагчлан шийжүүлж үзжээ, уламжийг лэдэн дээдэйг үзжад ёс зүйд ижигүүрээн зэдээ чадаа тогс бүрдэжээ хэмжээ улс дамаргаан алдарчиж, эртний болд

гарсан ч их хааны урилга заллагасаа цааргалж чадсангүй. Чингис хаан Хорезм руу хөдөлгүүхсөн байсан учир арш Чанчунь бомбо түүнтэй уулзахын тулд хойноос нь иэн их бартаат замыг 2 жилийн туршид туулж, Самарканц орчимд их хаанд бараалхжээ. Чингис хаан түүнийг гүн хүндлэлтэй хүлээн авч, багшаа гэж дээдлэн, дэргэдээ 2 жил орчим байлгаж, хутагт аршийн ном сургаалыг хичээнгүйлэн сонижээ.<sup>33</sup>

Негеө нь Хятадын элч Мэдэв Бэй-лутийн “Полное описание монголо-татар” /Монгол-татарын бүрэн тэмдэглэл/ юм. Хятадын энэ элч 1221 онд Чингис хаантай уулзахыг зорысон боловч тэрбээр алсад дайлаар мордсон учир Яныцзинд (Эдүгээгийн Бээжин хот) Монголын цэргийн их жанжны

---

мергэдийн сургаалыг оворлон, эрдэмийн хүмүүний сайн ёсоор азагаа улстай баясгалгас хийн удьшал сууж буй гэмэг. Овог дээдсийнхээ улдээснээ эрдэм ундаасыг онгон узмыжжээ, уншижуу эрдэмийт арийн болсон эрхэм таныг Бомбын ёсны замд орсон сүсөнэнд оюун уулэн мэн хурган хүрээлж сэдгийг мөхөс би салвартарган алж лэдэгэй. Хаан миний бие алсын яянд мордсон хойшиноо сай, эрхэм Таныг хялгаар нутастаан буйе сонсодон таныг ихэд бишрэн санаагзахаа сэргээгээ лишь өр үз дараагдас болзов. Бас таны тухай үзүүр дөмөг болсон яриа ховорог сонсон энэхүү бахархах болзооч ул гол хэмжэхийн хол тут энэ удаад хүрж учран залгоожээ эс чадавай. Иймийн тут мөхөс би алс газраас боломж суудлаасаа босч, бие мэдийн Танд ёсохж, шадар тушимэээ шалжон. Таныг мянган газрын чатадаас уринг затж байнаан. Эрхэм арийн бишиг түр түүрээж, эзэн цэлийг эзчилжүй алс хэмжээн эс төвөгжинож, эзэж бүлэглүүсээр морилон црэж, түүэн олын төвөн эрдүүрүүрүйг ариялжам, дэхийн дахиных засах үйт эрдмийг мөхөс наадад зөхөн хэлж, эсч бас миний биед настыг уртасгаж, алзий хүтгийг бататгах ундаас эрдмийг зааж хайрлах болон уу? Тэр цагт мөхөс би багийн Таныг оврийн бишр хүндээн асрангагаа мэргээн уг, ишидээ сургаалыг сонсөн хэмжээн ихэд хичээнгүйгэн хүснэг. Эрхэм багийн Таны эрдэм сургаалыг түр ч атугай хүртмээс наадад бүүн замшиш болох буйз заа” - Ли Жичан Чанчунь бомбын орно энэхүүдэд зорчсон тэмдэглээ..., орчуулж тайэлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 19-20 дахь таныг үзсөн уу.

<sup>33</sup> Ли Жичан Чанчунь бомбын орно энэхүүдэд зорчсон тэмдэглээ..., орчуулж тайэлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 18 дахь таныг үзсөн уу.

өргөөнд зочилж, илгээд хугацаагаар Их Монгол улсад байж, монголчуудын ёс суртахууныг судалжээ.

Плано Карпина,<sup>34</sup> Жувейни,<sup>35</sup> Рубрук,<sup>36</sup> Рональд Лейтхэм,<sup>37</sup> Рашид-ад-Дин<sup>38</sup> нарын XIII-XIV зууны үед бичсэн ном, аян замын тэмдэглэл нь өнөө үед хадгалагдан үлдсэн нь Чингис хааны үсийн ёс суртахууныг судлахад баттай, хөдлошгүй эх сурвалж болсон юм. Дорно дахини судлаач, эрдэмтэн П.Рачневский “Монголчуудын ёс суртахуунд Чингис хааны хууль тогтоомжийн авчирсан гайхалтай оөрчлөлтийг сударчид болон аялалчдын баримтууд тогтоох боломжийг бидэнд олгож байгаа билээ”<sup>39</sup> хэмсэн бичсэн нь эдгэр болон гадаадын эрдэмтэд, судлаачдын бусад бүтээлийг хэлсэн хэрэг юм. Персийн түүхч Жувейни “Чингис хаан ноёрхсоныхоо эхээр аймгуудын дотор зөвшөөрөгдсөн буюу явагдаж байсан болхи

<sup>34</sup> Ромын папын эзчэр томилогдон 1245-1247 онд Их Монгол улсад амьдарсан шаталыг үндэстэн Плано Карпина чутагтаа бүлэгээ очаод, аян замын тэмдэглэлээ Монголчуудын түүх (*Historia Mongolorum quos post Tartaros appellatissim*) хэмээснээрээ зөвхөн гаргасжээ.

<sup>35</sup> Из хааны узсын нолоо бүхий сурвалжийн түүнчлэл, персийн түүхч Жувейни Хархорумд хоёр ч удаа хүрээлж ирснэйн болгоод 1252-1253 онд “Дэхийн байхдан дагуулагчийн түүх” номдоо бичсэн.

<sup>36</sup> Францын IX Людовик хааны эзчэр 1253-1254 онд Их Монгол улсад хүрээлж ирж, аян замын тэмдэглэлээ Дорно эзээдэд зарчсон тэмдэгээз (*Pinciarium fratris Willielmi de Rubruquis de ordine fratrum Minorum*) хэмээх ирээр гаргасан юм.

<sup>37</sup> Итальян алдарт аялагч, худагдаачин Марко Поло оворийн худалдаачин юрэ, авга албан хамт 15. настай байхдаа 1260-аад оны үед Хубилай хаанд бараагахж танилцаад улмаар түүний итгэлийн олжээ. Тэрбээр 1272-1289 оны хооронд Хубилай хааны дэргэд 17 жилийн алба хааж, түүний эзчэр олон газар зарагдаж байжээ. Их Монгол улсад алба хааж байхдаа үзүүж харсан ба сонссон зүйлээ Рүстикээлю хэмээх дунд хэлээ бичүүлсэн нь Орчонгийн элдэж сонин (*Livres des merveilles de monde*) хэмээх ном болсон гарчээ.

<sup>38</sup> Персийн Рашид-ад-Диний удирдлагагаар түүрүүсэн “Сударын чуулган” нь дундад түүны үеийн Ази, Европын аль ч улс түүмэнд байжгүй түүхийн хосгүй ижтээрхийн толшийн хэмжээний бүтэээд үзүүлэхдээ.

<sup>39</sup> Пауль Рачневский Чингис хаан түүний амьдрал ба ...,, англи хэлээс орчуулсан Л.Монх-Эрдэнэ,, Улаанбаатар,, 2006, 142 дарь тал.

бүдүүлэг заншлыг эвдэж, онолын талаар үзсэн ч сайгууштай хууль тогтоомжийг тогтоожээ”<sup>40</sup> гэж бичсэн байна.

Чингис хаан “Хуучин үгийг хууль болго”<sup>41</sup> хэмээн айлдсан нь олон түмний одор тутмын амьдралаар бичигдээгүй хууль болсон ёс суртахууны хэм хэмжээнд тулгуурлан хууль гарга гэсэн нэн гайхамшигт санааг дэвшүүлсэн байна. Ийнхүү тэрбээр ёс суртахууныхаа ачаар Жувейний бичсэнчлэн “тэр бараг ганцаархнаа, зэр зэвсэгтүүг гэмээр цөөн цэрэгтэй байж өдий тодий хүчирхэг дайснууд дундаас, тэр үсийнхээ сайтар зэвсэглэсэн фахтур (богд хаад) мэтийн хүчирхэг хаадын дундаас цойлон гараад дорноос орно хязгаар хүртлэх эрх мэдэлтийг бараг тулалцалгүйгээр эрхэндээ оруулж чадсан”<sup>42</sup> юм. Марко Поло “Чингис хааны засаглал шулуун шударга, хүн арддаа ээлгэй энэрэнгүйг үзсэн бусад орны хүн ард ч түүнтэй өөрсдөө ирж ийилэн изгдээр байв. Нэг мэдэхэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар дэлхийг хучин бүрхсэн үй түмэн болсон”<sup>43</sup> гэж бичсэн байдал билээ.

Ёс суртахууныг амин сүнс болгосон Чингис хааны хууль олон үсийн туршид монголчуудын оюун санааны ой санамжид хадгалагдаж ирснийг Оросын алдарт аялагч, байгаль судлаач, газар зүйч Н.М.Прижевальский,<sup>44</sup> Монголд 1893-1938 он хүртэл 35 жил амьдарсан, швед Ф.А.Ларсон,<sup>45</sup> Орос-зөвлөлийн иэрт

<sup>40</sup> Жүйшийн Дэлхийг байждан дагуулзагчийн түүх..., тэркүүн боть..., Мизра Мухаммед Казвииний эзихтэжсэн номыг перс хэлээс англи хэлээр орчуулсан Ж.Э.Байд, орос хэлээс орчуулсан М.Бодданиям., Улаанбаатар., 2006, 28 дахь тал.

<sup>41</sup> Монголын нууц товчоо.. Ц.Дамдинсүрэн, Улаанбаатар., 2009, 181 дахь тал.

<sup>42</sup> Жүйшийн, дурдсан бутээл, 18 дахь тал.

<sup>43</sup> Романъд Лейтхэм Марко Поло аялаг.., англи хэлээс орчуулсан О.Бурэнжаргал, Улаанбаатар., 2012, 147 дахь тал.

<sup>44</sup> Н.М.Прижевальский Монгол, Ташгад нутгаар.., Орос хэлээс орчуулсан Ж.Нэрэгүй, Улаанбаатар, 2011.

<sup>45</sup> үз. Ф.А. Ларсон Монгол орон, Монголчуудын дунд онгоруулсан он эсэл..., Герман хэлээс орчуулсан А.Цэрэнчүүлийн.., шимчэгэн орчуулсан хөөрн үдаагийн хэлэл, Улаанбаатар, 2015.

эрдэмтэн И.И.Майский,<sup>46</sup> Монголын Данийн ирт аялагч, угсаатан судлаач Хеннинг Хаслунд-Кристенсен,<sup>47</sup> Швейцарийн иргэн, гэрэл зургийн сурвалжлагч Вальтер Боссхард<sup>48</sup>, Унгарын иргэн, Монголд 9 жил амьдарсан Гелета Иосеф,<sup>49</sup> монгол судлаач, орос-германний Николас Поппе<sup>50</sup> нарын зэрэг хүмүүсийн өмнөх зуунд бичсэн судалгаа шинжилгээний бүтээл, аян замын тэмдэглэлд өгүүлсэн байна. Тухайлбал, Шведийн Ф.А.Ларсон Чингис хааныг ямар их ухаалаг хууль дэлхийд бий болгосныг мартсан байна<sup>51</sup> гэж бичижээ.

Гадаадынхны хийсэн сүүлийн үеийн судалгааны дүгнэлт сонирхол ихээхэн татах боллоо. Оросын судлаач, Еврази сургаалыг үндэслэгч Н.С.Трубецкой одоогоос 100 шахам жилийн өмнө Чингис хааны төр ёсон иэн ёс суртахуунлаг<sup>52</sup> байсан гэсэн дүгнэлт хийжээ. Германы Монгол судлаач эрдэмтэн Удо Баркмани “Чингис хаан судлал, Монголын их эзэнт гүрний түүхийн судалгаа Баруунд хол урагшилжээ. Эдгээр судалгааны дунд Барууны өртөнцийд Чингис хааны талаар олж авсан бидний ойлголт төсөөлөл бүрмөсөн өөрчлөгдсөн юм. Бид Чингис хааныг “харгис хэрэгий”, “яргачин” гэхээ болив. Бид түүний суу билиг, гэрээс бошгын<sup>53</sup> талаар мэдэж авахыг хичээх болов”<sup>54</sup> гэсэн дүгнэлтэд хүрсэн

<sup>46</sup> уз. И.И.Майский *Современная Монголия...*. Иркутское отделение., 1921 (Орчин үеийн Монгол, Улаанбаатар, орчуулга)

<sup>47</sup> уз. Хеннинг Хаслунд Монгол хүн, Монгол бурхад.., Битпресс хэвлэлийн газар, Улаанбаатар, 2011; Хеннинг Хаслунд-Кристенсен Явсаа яв!, Герман хэлийн орчуулсан Б.Баяртайхан, Улаанбаатар, 2014.

<sup>48</sup> уз. Вальтер Боссхард Сэтгэл булагам Монгол орон мину... Герман хэлийн орчуулсан Б.Баяртайхан, Улаанбаатар, 2014.

<sup>49</sup> уз. Лайстру Фурбат Монголд сэргээл хоргодсон есон жил.., Унгар хэлийн орчуулсан Д.Баш, Улаанбаатар, 2015.

<sup>50</sup> уз. Поппе Дурнагат., NEPKO publishing., Улаанбаатар, 2007.

<sup>51</sup> Ф.А. Ларсон, дүрдсан бүтээл, 50 дэх тал.

<sup>52</sup> Түрбецкий И.С. дүрдсан бүтээл, 64 дэх талыг үзэх уу.

<sup>53</sup> Бодныг эхэн үе нь монгол хамсын зарчмын, соёлхол, алдзах, суршах, сурсамж, суртал гэсэн угтгатай ажээ.

<sup>54</sup> Удо Б.Баркмани Монголын түүх, улс төрийн асуудлын тухай осуултуурүүд.., Улаанбаатар., 2013. 229 дэх тал.

байна. Эдгээр дүгнэлт бас Чингис хааны хуулийн амин сүнс ёс суртахуун байсныг нотолно.

## Харийн элдэв бусын үзэл баримтлалын туршилтын талбар байхаа хэзээ болих юм вэ?

Их эзэн Чингис хааны "... бус сэтгэлтийн үгэнд орж, мөхөсдүүлэн сэтгэвээс, мөн зарлиг засаг<sup>55</sup> мөхөсдөнө шүү"<sup>56</sup> хэмээсэн захиас байдаг. Үүгээрээ Чингис хаан үндэсний өв уламжлалаа умартаж, бусдыг хуулбарлан дууриах сэтгэлгээнд автагдвал хүчирхэг торт ёс, хууль цааз чинь мөхнө шүү гэсэн санааг илэрхийлжээ. Тэрбээр бас "Миний сургаалыг мянган онц хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлалтугай"<sup>57</sup> хэмээн захьсан гэдэг.

Монголын хүчирхэг эзэнт гүрний хойч үсийн удирдагчид өвог дээдсийнхээ гэрээс захиасыг умартаж, эв зээ алдсаны улмаас XVI зууны үед сарини бугарч, доройглын хар ангал руу гулсан орсон билээ. Хоёр том гүриэр хүрээлгэдэх болж, тэдний хэн нэгний нь дэмжлэг туслацааг авахаас өөр аргагүйд хүрэв. Энэ удаад Манжийн хаанд хандаж, түүний дэмжлэгээр цус асгаруулсан аймшигт талцаа арайхийж зогсоов. Өөрт нь аянидаа орж ирсэн монголыг монхийн хараат байлгахын тулд Манжийн хаан хуулиа тулган хүлээлгэх бодлогыг тууштай, чадамгай явуулав. 200 гаруй жилийн туршид Монгол улсын нутаг дэвсгэрт ийнхүү Манжийн хууль хүчтэй нөлөөлев. Газар нутгаа харийнханд улам бүр алдсаар байв. Улс төр, хууль зүй,

<sup>55</sup> "Засаг" гэсэн уг эртний монгол хэзинэ "цэрхэ, ардыг наён ташижуудах хуулийн нэр" эсвэл ойзогчдог байжээ. – Монгол хэзиний дээдээрээгүй тайлбар төль (таван боть)... II боть. Д.-Л. Улаанбаатар, 2008, 989 дахь талын үзүүлүү.

<sup>56</sup> Мэргэн гэсэн Лувсандамбийжаплан Аштан төвч – Монгол түүхэн эх сурваажийн цурагт... 12 дугаар боть, Улаанбаатар, 2006, 165 дахь тал.

<sup>57</sup> Сайншал Чингис хааны тоочоом... тэрэгүүр дэвтэр, кирил үсүүт хорхруулсан Ш.Чоймаа, М.Баярсайхан, С.Батхиниг... Улаанбаатар, 2003, 397-398 тал.

эдийн засаг, үндэсний тусгаар тогтийн зугуухандаа бүдгэрсээр. Ийм нөхцөлд умард гүрний дэмжлэг туслалцааг авахад хурэв.

Тусалсан хэдий ч коминтерн Марксист-Ленинист онолыг Монголд тулган хүлээнгэв. Энэ онол ёсоор омнох тогтолцооны оюуны тэргүүлэх хүч болсон засаг ноёд, хутагт хувилгаад тэдний ойр дотнын хүмүүсийг ангийн эвлэригүй дайсан мэтээр үзэн ядаж, тэднийг хүйс тэмтрэх бодлогыг баримтлав. Монголд 35 жил амьдарсан шведийн А.Ф.Ларсон “Би орнөөс дорно, омноөс умардыг хүртэл аялж, газар бүрийн эрхэм дээдсээр зочлуулж үзсэн. Олон аймаг хошууг аавынх нь үесэх эхлээд хүүгийнх нь ноён суух үеийг хүргэл мэдэх билээ. Бас ирээдүйд ноён суух жаал хүүг нь ч танина. Бүх орон, аймаг хошуугаар явах зуураа би амин хувийнхаа сонирхлыг ард түмнийхээс дээгүүрт тавьсан гуравхан ноёнтой дайралдах байлаа. Засаглахаар заясан тоотой хэдхэн жилийнхээ хугацаанд ухаалаг, сайн ажиллах явдал Монголын ноёдын гэр булийн мах цусанд шингэсэн чанар”<sup>58</sup> байлаа гэж бичижээ. Ингэхлээр монголын нийгмийн хамгийн ёс суртахуулаг, оюунлаг хэсэг устгагджээ. Үндэснийхээ овормоц онцлогийг огт хайрхахаа болж, зөвхөн зовлюлтийн гэсэн болгоныг зөв хэмээн дууриан хуулбарласан. Ардын хувьсгалын омнө Монгол улс мөхөж зүйл дууссан мэт “домог” зохион. Гэвч төр нь болохоор нэг анги ногеөгөө дарангуйлах зэвсэг, хууль нь болохоор ажилчин, малчин ангийн хүсэл зоригийн илэрхийлэл хэмээсэн үзэл баримтлал монголын хорсонд нутагшиж чадсангүй.

1990-ээд оны үесэх хуулийн тухай барууны онолыг шууд хуулбарлан хэрэглэв. Энэ нь юуны омно эрх зүйт төрийн тухай үзэл баримтлал юм. Энэ онол ёсоор хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрч, хүний эрхийг дээд зэргийн өндөрт гаргаж, үүрэгт нь ач холбогдол өгөлгүй, дур зоргын авирлал газар авснаар монголын уламжлалт ёс суртахууныг хоцрогдол хэмээн хөсөр хаяж, монголчуудын соёл иргэншилийн олгий болсон

<sup>58</sup> Ларсон Ф.А. дүрдсан бүтээг. 17 дахь тал.

бэлчээрийн газар руугаа улангасан дайрч, онгичон байгаль орчноо сүйтгэв. Ашигт малтмалаар улс орноо өөд татах хүсэл эрмэлзгэл Монгол улсад дааж давахын аргагүй ор ширийг авчрав. Ийнхүү Монгол улс XVI зуунаас хойш харийн эдэв бусын онол, үзэл баримтлалыг туршилаар өдий хүрэв. Гэтэл монголчууд бидэнд хууль, торт ёсны өөрийн гэсэн дэлхий дахинд шагшин гайхагдаж ирсэн хосгүй уламжлал байсан байна.

### ТӨГСГӨЛИЙН ОРОНД

Өмнө дурдсаныг ияягээн дүгнэвэл хуулийн амин сүнс нь аливаа хүмүүний уураг тархини тормол огогдол болох ёс суртахуун ажээ.

Чингис хаан “Хөвүүн нь эцгийн сургаалыг үл авагсад, дүү нар нь ахмадын ятгалгыг үл сонсогсад, эр нь гэргийгээ сэжиглэж, гэргий нь эрээ эсэргүүцгэсд, эрэ нь гэрлэсэн гэргийгээ доромжилж, охин нь ураглаагүй эрээ гадуурхагсад, ахас захас нь багачууд хүүхдээ үл хамааран, хүүхэд багачууд нь ахас захсынхаа хамаарлыг үл дагагсад, эрхэм ноёд ураг төрлюө дотночилж, үл таних хүмүүсийг гадуурхагсад, баян эрхэм хувийн хөрөнгөө нарийлж, албаны эдийг хонжигсод эрх биш худал хуурмагын замд орж, хулгай дээрэм болох бөгөөд орх гэр доройтоож, тор улс мөхөн, дайсны өмнө ялагдах болмуй. Эдгэр муу зүйлийг хориглотугай хэмээн би чангса сээрэмжлүүлсүгэй”<sup>59</sup> хэмээсн хууль зарлиг буулгасан байдал. Үүнээс үзэхэд тэрбээр ёс суртахуунлаг бус үйлийг хуулиар хориглож, албадлага тогтоож байсныг харуулна. “Өөрийн бие шударгуу байваас зарлиг эс буулгасан хэрэг бүтүюү, өөрийн бие шударгуу бус байваас зарлиг хэдий буулгавч эгэл ард эс дагаюу”<sup>60</sup> гэсэн гүн ухаанд Чингис хаан сүсэглэж байжээ. Жувейни “...тэр мэргэн ухаан, сүр хүчээрээ дэлхийн хамаг хаадын орой нь байж,

<sup>59</sup> үз. “Юань сүрний түүхийн нийтвэр орчуулга...”, I боть; Сайшалг Чингис хааны тохиочон..., дээд дэвшир..., Улаанбаатар, 2010, 397-398 дэх таз.

<sup>60</sup> Күнц Шүүмжээс огцузээ..., хятад хэчинэс орчуулсан М.Чимэдэрээ..., Улаанбаатар, 2013, 124 дэх таз.

хүчирхэг Хосровчуудын тухай бичигдсэн болгоныг, Фараонууд, Кесариудын тухай он дарааллын бичиг, эртний сурвалж бичгүүдийг судлах гэж зүдрэлгүй ёөрийн хар толгойгоор хууль дүрэм тогтоосон болгөө”<sup>61</sup> гэж бичсэн нь үүнийг нотолж байна.

Чингис хааны хуулийг эх бичвэрээр нь олох гэсэн судлаачдын эрэл олон зууны туршид үргэлжилсээр өнөөдрийг хүрэв. Дийлэнхи судлаачид Чингис хааны хуулийг орчин цагийн бичмэл нэгдмэл хууль шиг байсан мэтээр төсөөлж байна.

“Засаг” буюу “Yassa; Yasa; Yasaq; Jazag; Zasag” хэмээсэн нэр томъёо Монголын итууц товчоонд тэмдэглэгдсэн. Тухайлбал, Чингис хаан зарлиг болгон “Засаг хөндвөөс”<sup>62</sup> надад хэлзгүүн гэсэн гэж Монголын итууц товчооны 227 дугаар зүйлд бичигджээ. “Засаг” гэсэн нэр томъёо нь монгол хэчинц “хууль цааз”<sup>63</sup> гэсэн уттыг агуулдаг. Түүничлэн ихэвчлэн перс, араб хэлний эх сурвалжид энэ нэр томъёог хэрэглэжээ. Тухайлбал, Жувейнийн бичсэн “Дэлхийг байдан дагуулагчийн түүх” (1260 оны орчим), Рашид-ад-диний “Судрын чуулган” (1306 он) зэрэг бутээлийг ирлэж болно. Эдгээрээс үзэхэд Чингис хааны хууль энэ хорвоо ертонцэд байсан нь одоо нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ. Надтай зөвлөж, Шихихутугийн шийтгээд цагаан цаасанд хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн ураг хүртэл үүрд хэн ч бүү юорчилтугэй<sup>64</sup> хэмээсэн Чингис хааны зарлигийг Монголын итууц товчоонд тэмдэглэн үлдээсэн юм. Эдгэр нь ёс суртахууныг иоцтой гажуудуулсан тохиолдолд тогтоосон хориг, албадлагын арга хэмжээ байв. Ийм учраас хуулийн амин сүнс нь ёс суртахуун богоод энэ онцгогоос авч үзвэл хууль тогтоогчид ёс суртахуулаг бус, үүний улмаас

<sup>61</sup> Жувейни, дурдсан бүтээл, 18-19 дэх тал.

<sup>62</sup> Монголын итууц тоочоо...., эртний уг хэлэхийн түгээмээ тайлбартай шинэ хореографи...., шинээр хориуулж, тайлбар үйлдсэн Ш. Чоймал., Улаанбаатар, 2011, 187 дарь тал.

<sup>63</sup> Монгол хэчинд дэлжэрээгүй тайлбар толь, 989 дэх тал.

<sup>64</sup> МНТ-ны 203 дугаар зүйлийн үзүүлүү.

хууль нь ёс суртахуунлаг бус, хуулийг хэрэглэгчид (хуульчид) нь ёс суртахуунлаг бус, хүн ард нь ёс суртахуунлаг бус болсон байвал “судрын чуулган”-д бичсэнчлэн “өнө мөнхөд гэр хотлоороо энх амар, жаргалтай байх”<sup>65</sup> иөхцөл хангагдахгүй юм байна.

Чингис хаанаас багшдаа бичсэн захицлын “Хаан миний бие умар зүгийн их хээр талд аж төрөн сууж, чин сэтгэлээр чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, сүйтгэн бүрэлгэхийг хориглон зогсоож, омсах хувцас, илэх хоолоон адуучин үхэрчинтэй хуваалцаан, ард иргэдийг хүүхэдтэйгээн адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгэн мэт хүндэлж, эв зэйг эрхэмлэн, энэрэл хишигийг түгээмүй”<sup>66</sup> хэмээсэн ганцхан өгүүлбэр хуулийн амин сүнс ёс суртахуун болохыг хэн ч маргахын аргагүй харуулж байгаа юм биш үү?

Хаана ёс суртахуун ба хуулиас монгө, эд хөрөнгө, албан тушаал, тансаглалыг дэргүүр тавина, тэнд юу болдгийг 800 жилийн өмнө персийн түүхч Жувейни хэрхэн бичсэнээр энэхүү илтгэлээ өндөрлөө. Тэрбээр элдэв үл бүтэх амьтдаас болж, дэлхий дахин далайн шуурга мэт оволzon бүхийд, ойр дөтийн хаад ноёдын бисээ тоосон ихэмсэг зан хэрээс хэтрээд ирох цагт оройн дээд Бурхан Чингис хаанд сүр хүчийг соёрхон олгож, ялалтын эзэн болгосон юм<sup>67</sup> хэмээжээ.

<sup>65</sup> Рашид-ад-дин Судрын чуулган..., I боть..., орос хэлээс эх хэлээс хоригуулсан Ц.Сүрэнхорхозоо..., Улаанбаатар., 2002, 404 дэх тал; Рашидаддин Шандирин чуулган хэмээх монголчуудын түүх оризовай..., дэд боть..., Англи хэлээс орчуулж, уялга уг бичиж, тайзбар түүхи рийзэм Г.Аким..., хөфрдээх хэмээ..., Улаанбаатар., 2015, 448 дахь талыг үзүүлүү.

<sup>66</sup> Ли Жичан Чончунь бомбын орно энгээдэд зарчсон тэмдээгээ..., орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 18 дахь талыг үзүүлүү.

<sup>67</sup> Жувейни, дурдсан бүтээл, 18-19 дэх шамыг үзүүлүү.

## **STUDYING ESSENTIALS OF THE LAW BASED ON HERITAGES OF GENGHIS KHAN**

Mongolia has been adopting many laws intensively from the beginning of 1990's while having established a legislative body which cost higher. In the last 25 years, Mongolia has adopted over 500 laws and almost every state organization has its own law at the moment. However, these laws did not bring the development and growth we have been expecting to our country. Therefore, this presentation analyzed what are the essentials for the laws from a scientific perspective. The presentation has been developed based on the past decade studies done by Academician S. Narangerel and comprises of over 60 quotes and 5 main parts. His 13-page presentation is briefed in 3-page document.

### **Leading concepts regarding essentials of the laws**

The researchers consider that worldwide-accepted concepts regarding the essentials of the laws were mentioned by Ch. Montesquieu, prominent thinker and the French enlightener, in his book titled *The Spirit of Laws* (1748) 250 years ago. He concluded that the essentials of the laws lie in the balancing of the power in legislative, executive and judiciary sections. Ch. Montesquieu's concept on independence of the laws from the ethics had been inherited by the post-period thinkers. Hans Kelsen, the best delegate of the modern lawyers maintaining Montesquieu's concepts, wrote that "measures of the ethics is independent from the laws, maintain its nature and cannot convert into laws". This quote determines the modern-day laws.

Ch. Montesquieu described Mongols as "strangest nation in the world" in his famous book titled *the Spirit of the Laws* while he proposed concepts on essentials of the laws. He continued that the geographical location and climate have converted Mongols invaders. However, Lev Gumilev confirmed his facts which stated that "Mongols did not have an attempt to invade settled nations but they wanted to strengthen their border areas and protect their native land

from strong external invaders in order to live peacefully" by historical documents. Historians also proved that Russia and Chia did not have any losses during the Mongol empire era. There is a proof that there was development and flourishing for Golden Horde era. Also, Mongols developed trading zones to a greater extent and ensured their security. In doing so, many nations benefited from that. Therefore, Ch. Montesquieu's conclusion that "Mongols or Genghis Khan destroyed Asian nations extending from India to Mediterranean, and conquered all the nations located in the east of Persian Empire" is baseless in comparison with historical facts.

### **Completely different concept 450 years ago before ch. Montesquieu era**

Genghis Khan stated in his letter to his master "Currently, the fact that I invited all the scientists and academicians in order to rely on the talents is to make the world peaceful". This important value of Genghis Khan was inherited by his children and grandchildren with honor. For example, COLLECTION OF SUTRAS was created by the initiative of Khulegu, the third son of Tolui, youngest son of Genghis Khan between 1301 and 1311. The book states that "if the nations and empires that will be created along with his latter generations follow and do not change the Genghis Khan's ethics and laws in 500 hundred or a thousand, or ten thousand years later, eternal sky will give them endowment and they will live altogether peacefully ever after." The book prioritizes first ethics then laws. Why the ethics come before the laws?

Most important things for any man are not money, properties or titles, but his ethics. Great Aristotle considered the essentials of the laws as good deed and ethics directly 2500 years ago.

Ethics can help any person to stay as a human and is a native data or energy which exists forever in their internal mind or brains. Mankind keeps good instincts in his body all the time. Fairness, shame and fear, braveness, obligation and responsibilities, individuality, benevolent compassion, fame, reality, trust, friendly

and polite behavior, patience, generosity, not having greedy heart, malice and envy are complexity of the most important characters of the mankind. Ethics cannot be decided by anybody but it comprises of the native characters according to the many thinkers, scientists and nature science disciplines.

When people have similar ethics, they did not need any laws at all. However, some people wanted to flush for money, properties or titles and preferred them over the ethics. This caused a trouble to the mankind. Therefore, the kings or representatives chosen from the people convened a meeting and considered there needed to be punishment or compulsion for people without ethics in order to protect people with ethics and repair the losses. And the people considered the state as a "protector of ethics". The reason why Mongolians pray for the symbol of the state is the reason.

### **Findings from the foreign literature**

Mongols' law with ethical spirit in the 13<sup>th</sup> century made Mongols as the world's strongest empire according to the facts written by foreign messengers, scientists, pastors, traders and tourists. Books and travel notes written by Plano Carpini, Juvaini, Rubruk, Ronald Latham and Rashid-Ad-Din during the 13-14<sup>th</sup> centuries are conserved until now which allows us to study the ethics of Genghis Khan on a firm and unmovable basis. Oriental scholar and scientist P. Rachnevsky wrote that "utra writers and travelers' evidence gave us an opportunity to study the wonderful changes that the Genghis Khan ethics brought to the Mongols" which meant the above and other books created by foreign scientists and researchers.

Recent studies conducted by foreigners have a lot of interests from our side and if we mention one of them, N. S. Trubetskoi, Russian researcher and founder of Eurasian Study, concluded that the Genghis khan state was very ethical about 100 years ago. German Mongolist Udo Barkmann concluded that "Genghis Khan study and historical study of the Great Mongol Empire have advanced well in the west. As a result of these studies, our understanding regarding

the Genghis Khan changed substantially. We will no longer call Genghis Khan as "cruel" and "butcher". We would like to know more about his smartness and testament". This conclusion proves that the essentials of the Genghis Khan laws were based on the ethics.

### **When are we going to stop to be a test field for various foreign concepts?**

Great Genghis Khan said to us that "if you think in a limited way following others then our laws and state will be destroyed". Genghis Khan showed by this word that not to forget own traditions and follow other traditions then the strong state and laws will be destroyed. Also, he said "Please follow my words in a thousand years or a ten thousand years without any changes by generation by generation".

However, the peace between the kingdoms of Mongol empire was destroyed and Mongols went to bad times during 16<sup>th</sup> century. After that, Mongolian laws followed Manchu or Komintern political, legislation and economic policies. Then, pastors and higher state people are ignored or killed thus vanishing the most ethical and smart parts of the Mongolian society. The law theory was following the western theories during 1990's which is about the legislative state. According to the theory, everything that are not prohibited by the laws will be permitted and human rights are considered as vital. But we did not highlight the obligations then freedom became limitless causing the traditional ethics of Mongolia was considered as old, pasture land was exploited and environment was polluted.. Therefore, Mongolia has been undergone in a different foreign theories and concepts since 16<sup>th</sup> century. However, we have had a unique tradition of laws and state which is considered very good in the worldwide.

## **ENDING**

If we conclude the above, the spirit of the laws lies in ethics of anybody which is given from his birth. Genghis Khan prohibited unethical things by laws and used punishment. He prays for the philosophy which states that "if you are fair then your order will be implemented or if you are not fair, then your order will not be followed by the people" and he punished any acts against ethics. Therefore, the spirit of the laws is ethics and the law makers should not follow unethical actions then the laws will be unethical and law users will become unethical causing whole population as unethical according to the Collection of Sutras.

Genghis Khan's letter to his master stated that "I, King, lives in the north steppe and prefers the fairness, stops the destroying acts, shares food and clothing with my people, considers my people as my children, adores soldiers and academicians as my brothers, prefers peaceful and benefits the poor". This one sentence shows where the spirit of the law lies in.

Where the ethics is appreciated over money, properties and titles you will see what happens there from the Juvaini's book written 800 years ago. He said that because of bad people, wars are abundant over the world and kings prefer bad habits then Genghis Khan got all the victories over them.

## ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА: ТҮҮХЭН СУРГАМЖ

Ч.Энхбаатар

Удирдлагын академийн эрх зүйн тэсцэнийн эрхтэгч,  
хууль зүйн ишиижлэх ухааны доктор, профессор

Монголын нийгмийг бүхэлд нь арчилах, төрийн тогтолцоог шинэчлэх, төрийн эрх мэдлийг тэнцвэртэйгээр хуваарилах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үндсэн хуулийн хяналтыг нэвтрүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн шинэ Үндсэн хуулийг дагаж мөрдсөн он жилүүдэд Монгол Улс арчилсан хөгжлийн замаар тууштай замнаж, нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд зарчмын шинэтгэл хийсэн билээ. 1992 оны Үндсэн хуулиар тус улсын төрийн тогтолцоог төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын үндсэн дээр тогтоосон нь дэлхийн нийтийн жишигт нийцсэн шийдвэр болсон юм. Үүний үр дунд Монгол Улсад хууль тогтоох эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх бүрэн эрхтэй орчин цагийн парламент- Улсын Их Хурал- 1992 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн.

Төрийн шинэ тогтолцоо төловшин бэхжих явц үргэлж дардан замаар яваагүй бөгөөд ололт амжилтын зэрэгцээ эрх зүйн орчин тогс бүрдээгүй, тогтолцооны дархлаа гүйцэл суугаагүй зэрэгээс үүдсэн зарим бэрхшээл, ээдрээгүй асуудал оршсоор байгаа. Энэ талаар манай бусад илтгэгчид тодорхой баримттай ярих байх гэж бодож байна. Харин энэ илтгэлд гарцааны цэг буюу Монгол Улсад парламенттад ёс хэрхэн нэвтэрсэн, улмаар хууль тогтоох институциүүд хэрхэн хөгжиж ирснийг авч үзэхийг чухалчилсан юм. Учир нь онгорсноо дэнислэж, түүнээс түүхэн сургамж авч байх нь одоогийн хүрсэн өндөрлогтөө бодит үнэлгээ өгөхөд тустай байх болов уу.

Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагааны практикт түүхийн үүднээс дун шинжилгээ хийхээс омно тухайн үсийн Монгол Улсын удирдлагын хэлбэр болон төрийн тогтолцооны онцлог, үндсэн шинж, төрийн тогтолцоонд хууль тогтоох

субъектын эзлэх байр суурийг тодруулах нь зүйтгэй болов уу. Үүнийг иш үндэс болгох, төрийн эрх барих байгууллагуудын хууль тогтоох бүрэн эрхийн эрх зүйн зохицуулалтыг тоймлож, эцэст нь хууль тогтоох ажиллагааны практикийг шинжлэн судалж, зохих дүгнэлт хийх болно.

### Нэг. Монгол Улсын удирдлагын хэлбэр

Ардын хувьсгал ялсны үр дүнд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар төрийн удирдлагын хаант хэлбэрийг халж, илүү дэвшилгэй бүгд найрамдах ёсиг тогтоон бэхжүүлсн боловч түүгээр тогтоосон удирдлагын хэлбэр нь дэлхийд зонхилдог парламентын, сронхийлогчийн буюу холимог бүгд найрамдах улсын хэлбэрийн аль нь ч биш, зөвлөлүүдийн бүгд найрамдах улс гэж томъёологддог удирдлагын овормөц хэлбэр байв.<sup>1</sup> Үүний үндсэн шинжүүд нь: төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг үүгүйсгэж, засгийн бүх эрх нэгдмэл байх зарчимд суурилдаг, төлөөлох байгууллагууд нь захирах, захирагдах зарчмын дагуу зохион байгуулгасан нэгдмэл тогтолцоог бүрдүүлдэг; орон нутагт оороо удирдах ёс хэрэгждэггүй, төрийн бүх байгууллага тухайн түвшний Хурлуудаас байгуулгаждаж, тэдээд ажлаа хариуцан тайллагнадаг, бүх шатны толоооллийн байгууллагууд нь жинхэнэ ажиллагч байгууллага биш, зөвхөн гүйшэтгэн захирамжлах байгууллагаас гаргасан шийдвэрийг батламжлах үүрэг хүлээдэг, толооолийн дээд байгууллагын бүрэн эрхийг үнэн хэрэгтээ түүнээс сонгогдсон цоон хүнтэй тэргүүлгчид түүний нэрийн өмнөөс

<sup>1</sup> 1917 оны 4 дүгээр сард эх оролдоо буцаж ирсний дараа бичсэн "Дороваджээр сарын сэдүүрд" бүтээлдээ В.И.Ленин: ажлычны дэлгүүтээсийн Зөвлөлтүүд нь хувьсгалт засгийн цор ганц байж болох хэлбэр мөн..., үүнээс парламентын бүгд найрамдах улсын хэлбэр дэгээрээ орох нь ухарсан албан болно..., шийдвэртээ улсын хэмжээнд дорогосоо байгуулгасан ажлычны, шарнаачны Зөвлөлтүүдийн бүгд найрамдах улс байх ёстой гэсэн санаануудыг дэшигүүжээ. В.И.Ленин. Пол. Собр.соч., 5 изд., Т.31, с.113-118-аас үзнэ уу.

гүйцэтгэдэг байсан юм.<sup>2</sup> Түүчинэл засаглалыг үзэн хэрэгтээ намын шат шатны удирдах аппарат хэрэгжүүлдэг намын засаглалын хэлбэр буюу *партократи* тогтсон байв. Өөрөөр хэлбэл тэр үсийн төрийн байгуулалтын гол шинж нь төрийн бүх байгууллага МАХН-ын удирдлагага, хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг байсанд оршино.<sup>3</sup>

Энэхүү тогтолцоо нь 1960 оны Үндсэн хуульд 1990 оны 3 дугаар сарын 23-нд томоохон ишмэлт, өөрчлөлт оруулж, МАХН-ын онц эрхтэй холбогдсоон заалтуудыг хассанаар улс төрийн харилцааг шинэчлэн, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг эрс өөрчлох хүртэл 70 шахам жил хадгалагдсан юм.

### **Хоёр. Хууль тогтоох субъект (парламент)**

Нийтийн жишгээр хууль тогтоох байгууллага буюу парламент нь хэд хэдэн үндсэн шинжийг агуулдаг. Иэгдүгээрт, парламент нь төлөөллийн байгууллагын хувьд бүх ард түмнээс сонгогдож, тэдний хүсэл зориг, ашиг сонирхлыг бүрэн илрэхийдэг. Хоёрдугаарт, парламент нь хууль тогтоох бүрэн эрхийг төрийн өөр ямар ч байгууллагатай хуваалцахгүйгээр, дангаар хэрэгжүүлдэг юм. Гуравдугаарт, байнгын үйл ажиллагаа явуулах учиртай. Эдгэр шинжүүдийг цогцоор агуулж гэмээнэ жижэнэ утгаар парламентад тооцогдоно.

<sup>2</sup> Г.Н. Андреева. Конституционное право зарубежных стран. М., "Эксмо", 2004, с. 177; А.М. Осавенок. Конституционное право зарубежных стран. М., "Юстицизм и право", 2010, с.122-123.

<sup>3</sup> БНМАУ-ын омнох үндсэн хуудаанд МАХН-ын удирдан чиглүүлж үргэшн тухай тодорхой заадаг байжээ. Тухайзбаг, 1940 оны үндсэн хуудын "БНМАУ-ын ходолгоорчиг (ажелччи, мазчин, оюутан) ардын доптоос аль шилдэг иджээгээ болгоод учраа мэдэгээд нь улс тайгийнг хөгжүүлэхийн төлөөг тээвэрээд ходолгоорчиг ардын тэрэгүүнд явсан хэсэг болгоод улс тайгийн байгууллагыг удирдах хувьг бозох МАНН-д эхлэдэг иждээс" (82 дугаар зүйл), 1960 оны Үндсэн хуудын: бүрнийг ялагч заржсан заминийн оюулор эзэссээж МАХН нь улс тайгийнг удирдан чиглүүлж хүч мөн гэж тус тус зассан байдал.

Монгол Улсад эрт үеэж төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэгч хэмээн томъёолж болох Их хуралдай, “Хорин дөрвийн зовлол”, мянганы ноёдын хуралдай, аймгийн ноёдын чуулган, хожмоо Богд хаант Монгол Улсын Олноо өргөгдсөний 3 дугаар онд (1914) байгуулагдсан Улсын Дээд, Доод Хурал хэмээх олон байгууллага уйл ажиллагаа явуулдаг байсан боловч бүгд төлөөллийн бус байгууллага байсны дээр гагихүү хаанд зөвлөх эрхтэй байжээ. Тухайлбал, Улсын Доод хурал нь засгийн олон яамдаас оруулсан аливаа асуудлыг хянан хэлэлцэж Улсын Дээд хурал уг асуудлаар Богд эзэнд айлтгаж эцсийн шийдвэрийг гаргуулдаг байсан.<sup>4</sup> Түүничлэн 1921 оны 9 дүгээр сард байгуулагдсан Улсын түр цагийн Хурал ч Ардын Засгийн газарт зөвлөх эрхтэй байснаараа өмнөхтэй тостэй байв.<sup>5</sup> Иймд анхдуугаар Үндсэн хууль, батлагдах хүртэл Монгол Улсад төрийн дээд эрх барих, үүнийг дотор хууль, дүрэм батлах, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах бүх эрхийг үзэн

<sup>4</sup> Монгол Улс дахь парламенттам ёсны түүхийг судлаачид Монгол улсад парламенттад ёс хэдийнээс хэрэгжсэн эхэлж талаар оор оор үзэл бодлагийн байдгийг мэдний бүтээлүүдээс харж болно. Судлаачидын мэдээд бүтээд “парламенттам ёс” нь Хамаг Монголын хаант төрийн үеэж эхэлжээгээс түүхийн түүхийн үе дэх “Ноёдны хуралдай”-той холбон тайвбарздааг бол оор хэсэг судлаачид Чингис хааны байгуулсан Их Монгол Улсын үе дэх “Их хуралдай” нь төрийн дээд байгууллагын шинжийн изүү агуулж байсан гээж түүхийг парламенттам ёсны овоо гэж үзүүлж байна. (Ж.Баздбаатар нар, Монгол Улсын түүх, УБ, 1999, 422 дахь таз) Нэгдох хэсэг судлаачид Монгол Улс дахь парламенттам ёсны төслийн нь Богд хаант Монгол Улсын төрөөн эхэлжээ хамсун үзэж, 1914 онд байгуулагдсан Улсын Дээд, Доод хурлыг парламенттам ёсны үүсэл төслийнхөө холбон тайвбарздааг байна. (Ж.Занхүү, Г.Азанчирх, Монголын түүхийн лекциүүд, УБ, 1999, 225 дахь таз) Мөн 1990-ээд оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсад парламенттам ёс байгууллагын төвийнгүй, төр тайлгийг эхолоодх төслийн шинжилгээсээр бүрзээдэн тохиосон гэж зарим бүтэээд фурдажээ. (Р.Гончигдорж, Монгол Улс дахь парламенттам ёсны үүсэл, төслийн шаардлын зандаага, Шинэ тазь, 2000, №30, 41 дахь таз).

<sup>5</sup> Улсын түүр цагийн хурзны дүрүүтэн 19-р түээ: “Энэхүү хурал жинхэнэ улсын хурал бинь тул таслан шийтгэх бүрзүүн эрхгүй болгоод хэзээнт таатогсом зүйлийг засгийн сазар мэдүүлж хаман байцаалгаж гүйцэтгэн шийтгүүзбээ зөвшино”. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, түүнд холбоодох зарим актын эмчилгээ (1921-1940), Ихэдүүсээр дэвшүүр. Улаанбаатар, 1972 он, 36 дахь таз.

хэрэгтээ 1921 оны 3 дугаар сарын 13-нд байгуулагдсан Ардын түр Засгийн газар<sup>6</sup> гартаа төвлөрүүлж байсан. Энэ бүхий эзэл Монгол Улсад хувьсталин өмнө ч, ардын засгийн эхний жилүүдэд ч торийн эрх барих төлөөллийн байгууллага байгаагүй юм.

Анхдугаар Үндсэн хуулиар Монгол Улсад торийн эрх барих дээд эрхийг хэд хэдэн байгууллага дуудаа хадгалдаг тогтолцоог бий болгосон юм. Үндсэн хууль ёсоор төрийн эрх барих дээд байгууллага (тэр үений хэлэгээр улсын дээд эрхийг барих газар) нь Улсын Их Хурал байсан бол түүний зарим үүргийг 30 гишүүн бүхий Бага Хурал чуулгани журмаар гүйцэтгэж, улмаар Бага Хурлын чуулгани чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид хэмээх 5 гишүүнтэй байнгын байгууллага ажилшуулахаар зохион байгуулжээ. Үүнийг зарим судлаачид төрийн эрх мэдэл хуваарилсан явдал гэж тайлбарладаг<sup>7</sup> боловч үнэн хэрэгтээ төрийн эрх мэдлийг хуваарилах бус, харин дээд байгууллага нь эрх мэдлийн доод байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрсөн зохицуулалт байсан юм.

Өөрөөр хэлбэл, тус улсад хэрэг дээрээ төрийн дээд эрхийг барьдаг хэд хэдэн байгууллага зэрэгцэн оршиж байсан бөгөөд хууль тогтоох байгууллага нь цаана үндсэн ажилтай жирийн ардуудаас бүрдсэн, жилд иżг удаа цөөнхоногоор хуралддаг Улсын Их Хурал ч биш, мөн жилд хоёроос доошгүй удаа цөөнхоногоор хуралдлаг Улсын Бага Хурал ч биш, харин байнгын ажиллагаатай Бага Хурлын Тэргүүлэгчид байсан гэж үзэх үндэстэй.<sup>8</sup>

Ногоотэйгүүр, хууль тогтоох ба гүйцэтгэх байгууллагуудын үйл ажиллагаа нэгдмэл байх зарчим дээр зохион байгуулгаждаж, тухайлбал Улсын Их Хурал нь хууль тогтоох төдийгүй хууль

<sup>6</sup> 1921 оны 7 дугаар сарын 16-ны Ардын Засгийн газар гэж нэрхжээх болсон.

<sup>7</sup> Л.Олонцайхан. Парламент. УБ., 2001 он, 36 дарь тал.

<sup>8</sup> Энэ нь марксизм-ленинизмийн оногчид парламентад шүйслэн таагүй хандаж, түүнийг жирийн ардуудыг хураан мэхтэх, төвөргүүрүүх, мушкуунах зорилгоор байгуулдсан газар гэж үзэх байсаны Монгол дахь тусгасан юм.

биселүүлэх, захирамжлан гүйцэтгэх дээд үүргийг Үндсэн хуульд заасан хэмжээ, хязгаарын дотор гүйцэтгэж байсаны зэрэгцээ, гүйцэтгэн захирамжлах дээд газар-Засгийн газар ажилаж байсан нь дээд эрх барих байгууллагуудын эрх хэмжээ, чиг үүрэг нь хоорондоо холилдсоныг гэрчилнэ. Тэр битгий хэл, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд: “Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ард Улс хэмээж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн, улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн Хурлаар сонгогдсон Засгийн Газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг инийтээр сүсэглэн дагавал зохино”; 4 дүгээр зүйлд: “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн Хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, ба бас мөн Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” гэж тус тус зохицуулсан нь төрийн дээд эрхийг хэрэгжүүлэхэд Засгийн газар хүссэн цагтаа шууд оролцох боломж нээлттэй байсаныг гэрчилнэ.

Анхдугаар Үндсэн хуулиар тогтоосон энэхүү тогтолцоо нэлээд удаан үргэлжилсэн билээ. Тухайлбал, 1940 оны Үндсэн хуульд: “БНМАУ-ын төрийн дээд эрх барих байгууллага нь Улсын Их Хурал мөн. Улсын Их Хурлыг 3 жилийн ирэвээнд удаа хуралдуулна. Улсын Их Хурлын чөлөө цагт төрийн эрх барих дээд байгууллага нь Их Хурлаас сонгон байгуулах Улсын Бага Хурал болио. Улсын Бага Хурлын чуулганиг жилд ирэвээнд удаа хийнэ. Улсын Бага Хурлын чөлөө цагт төрийн дээд эрхийг барих газар нь Бага Хурлаас дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга ба дорвөн гишүүнтэйгээр сонгон байгуулах Бага Хурлын Тэргүүлэгчид болио” гэж заасан бол 1960 оны Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал мөн” гэж заасан бөгөөд 33 дугаар зүйлд: “Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Ардын Их Хурлын чуулганин чөлөө цагт төрийн эрхийг барих дээд байгууллага мөн” гэж заасан байна. Эдгээр бүх байгууллага тухайн үед хэрэгжүүлж байсан сонгуулийн журмаас шалтгаалж жинхэнэ толооэлийн байгууллага болж

чадахгүй байсны дээр Улсын Их Хурал (хожим Ардын Их Хурал) нь бус харин түүнээс байгуулагдсан Тэргүүлэгчид л байнгын үйл ажиллагаа явуулж, Их Хурлынхаа нэрийн омниөс хууль баталдаг байсан нь тус улсад ийтийн жишгээс гажсан өвөрмоц тогтолцоо үйлчилж байсныг илтгэнэ.

### Гурав. Хууль тогтоох үйл ажиллагааны Үндсэн хуулийн зохицуулалт

#### 3.1. Үндсэн хууль батлах, түүнд иэмэлт, өөрчлөлт оруулах журмын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс түүхэндээ дөрвөн Үндсэн хууль баталж, дагаж мөрдсөн боловч Үндсэн хуулийг батлах, түүнд иэмэлт өөрчлөлт оруулах журмыг бусад орнууд шиг нарийчлан тогтоож байгаагүй. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиар төрийн эрх барих дээд байгууллагад улсынхаа гол хуулийг батлах, өөрчлөх үүргийг ногдуулсан байдаг. Тухайлбал, 1924,<sup>9</sup> 1940<sup>10</sup> оны Үндсэн хууль ёсоор энэ үүргийг Улсын Их Хуралд, 1960 оны Үндсэн хуулиар Ардын Их Хуралд<sup>11</sup> тус тус хариуцуулжээ. 1924 онд энэхүү үүргийг хэрхэн хэрэгжүүлэх тухай тодорхой заагаагүй бол Үндсэн хуульд иэмэлт, өөрчлөлт оруулах журмыг ахиц БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн "БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх журам" хэмээх Арван хоёрдугаар бүлгээр тогтоожээ. Уг бүлгийн 95 дугаар зүйлд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлөх явдлыг Улсын Их Хурлаар гүйцэтгэх богоод Их Хурлын тэргүүлэгчдийн гуравны хоёроос доош бус хувийн гар

<sup>9</sup> 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 6-р зүйл: "Улсын Үндсэн хуулийг өөрчлох батлах явдлыг гагчийн Улсын Их Хурлаас эрхэм шийтгээлээ зохиго".

<sup>10</sup> 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйл: "Улсын Их Хурлаас дамгаар эрхээх хяргууд нь: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг батлах ба өөрчлөх; ...".

<sup>11</sup> 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл: "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурал төвийн бүх эрхийг барих богоод үүнээс тухайбайж: а) БНМАУ-ын Үндсэн хуулийг батлах, өөрчлөх; ...".

өргөж баталснаар өөрчилнө” гэж заасан байв.<sup>12</sup> Улмаар БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлох ба халах тухай” Аравдугаар бүлэгт Үндсэн хуульд ишмэлт, өөрчлөлт оруулах журмыг илүү дэлгэрэнгүй тогтоожээ. Уг бүлэг нь хоёр зүйлээс бүрдэж байсан багаод 93-р зүйлд: “БНМАУ-ын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг гагцуу Ардын Их Хурлаар хэлэлцэж, түүнийг депутатуудын гуравны хоёроос дошигүй нь баталснаар оруулна”, 94-р зүйлд: “Коммунизмын үед төрийн зарим үүрэг мохох тутам тэр үүргийн тухай Үндсэн хуульд бичигдсэн зүйлс хүчингүй болж байна. Социализм, коммунизм байгуулах гол зэвсэг болсон төр байх хэрэгцээгүй болж, түүнийг хөдөлмөрчдийн коммунист эвлэлтээр сольсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана” гэж тус тус заажээ.

### *3.2. Ердийн хууль батлах, түүнд ишмэлт, өөрчлөлт оруулах журмын эрх зүйн зохицуулалт*

#### *3.2.1. 1924 оны Үндсэн хууль*

1924 оны Үндсэн хуулийн 11-р зүйлээр улсын дээд эрхийг хадгалах газруудын (Улсын Их Хурал, Улсын Бага Хурал, Бага Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар) эрхлэн шийтгэвэл зохих зүйлүүдийг тогтоохдоо улсын шүүх таслах газруудын хэргийг явуулах дүрэм хэмжээ, мөн иргэний ба эрүүгийн хууль зүйлийг тогтоох бүрэн эрхийг тэдгээр байгууллагуудад хамааруулжээ. Харин бусад заалттай харьцуулбал, хууль дүрэм, тогтоол, тушаал гаргах бүрэн эрхийг Улсын Бага Хуралд (12 дугаар зүйл), харин аливаа хууль дүрмийн эхийг зохиож Бага Хурлаар хэлэлчүүлэх

<sup>12</sup> Үндсэн хуулийн эз засан нь лөгдмөн утгынай гээж үзэж байна. Улсын Их Хурал нь эхийнээс ээжилд нэг удаа, хожим эхийнээг удаа цөөн доноогоор чуулдаг байсан бол түүний чуулганы чөөн цэст Улсын Их Хурлын Тэргүүлэгчид байвшиг ажиглагдаагаа байгууллага байв. Одоонор хэлбэл эз хоёр байгууллага уйл ажиглагдаагаа тус тусдаа явуулдаа байгууллага байсан юм. Иймд Үндсэн хуулийг өөрчлөх бүрэн эрхийг Улсын Их Хурал гүүрчмээнээ гэж зассан мөртээю Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн олонийн санасар уг өөрчлөлийнг баталшиг гэж зассан нь чууламдаа Үндсэн хуульд азижлаа ишмээши, өөрчлөлт оруулж бүрж эрхийг Улсын Их Хуралд биши. Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн олгомж байжээ гээж үзэжээс өөр ариагүй.

Энэ байдал цаашид ч үргэлжилсэн бөгөөд 1940-1960 онуудад хуулийг ихэвчлэн Улсын Бага Хурлын тогтоол, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, 1949 оноос хойши Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар тус тус баталж байжээ. 1960 онд шинэ Үндсэн хууль батлагдсаныар байдал олигтой дээрдээгүй билээ. 1960-аас 1989 оны хооронд батлагдсан 50 хуулийн 30 нь буюу 60 хувь нь Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар батлагдсан юм. Тухайлбал, Төсвийн эрхийн тухай хууль, Газар здэлбэрийн хууль, Хөдөлмерийн хууль, Эрүүлийг хамгаалах хууль, Шүүхийн байгууламжийн хууль, Сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын хууль, Тэтгэврийн хууль, Эрүүгийн хууль (1986 оны найруулга) зэрэг хуулиуд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар батлагджээ. Хууль баталсан зарлигийг Ардын Их Хурлын чуулганд шууд жагсаалтаар баталдаг байв. Иймд бүх нийтийн сонгуулиар Улсын Их Хурал, хожмоо Ардын Их Хуралд сонгогчдоо төлөөлен орж ирсэн депутатууд эдгэр хуулийг хэлэлцэх, санаа болдюү уралдуулах ямар ч бололцоогүй байсан юм.

1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудын үйлчилэх хугацаанд торийн эрх барих дээд байгууллага- Улсын (Ардын) Их Хурал биш, түүний ажилшагч байгууллага болох Улсын (Ардын) Их Хурлын Тэргүүлэгчид зарлигаараа тус улсад дагаж мөрдөж байсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байсан нь нэгэнт тогтсон практик байв.

Улсын (Ардын) Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар хууль баталж, Үндсэн хууль, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байсан нь Үндсэн хуульд 1949 онд оруулсан өөрчлөлт, түүнийг 1960 оны Үндсэн хуульд хэвээр үлдээсэн зохицуулалтаар тус улсад хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал (1960 оноос хойши Ардын Их Хурал) хэрэгжүүлэх тухай заалгтай шууд харшилсан практик байв. Улсын (Ардын) Их Хурлын Тэргүүлэгчид нь чуулганы чөлөө цагт Их Хурлынхаа зарим үүргийг хэрэгжүүлэх зохицуулалт нь торийн дээд эрх барих

байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй шинжийг хангахад чиглэгдсэн зохицуулалт байсан боловч, Хурлыг бүрэн орлоно гэсэн үг биш. Үүнийг, нэгд, эдгээр байгууллагын тус тусын бүрэн эрхийг тухайллан тогтоосон заалтуудаас харж болно. Ардын Их Хурлын бүрэн эрхийн тухай 1960 оны Үндсэн хуулийн 20-р зүйд: “...б) Хууль гаргах;...” бүрэн эрхийг түүнээ шууд хамааруулсан нь энэ эрхийг өөр ямар ч байгууллага хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэж байгаа юм. Хоёрдугаарт “Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь үйл ажиллагааныхаа талаар Ардын Их Хурлын омнио хариуцан тайлагнана” гэсэн 1960 оны Үндсэн хуулийн 36-р зүйл ч энэ хоёр байгууллага иэг түвшний байгууллага биш гэдгийг нотолж байна. Гуравдугаарт, энгийн логикоор авч үзвэл, парламент нь толоошийн байгууллага гэсэн түүний мөн чанараас түүний хэрэгжүүлэх аливаа бүрэн эрх нь бүх толоологчдийн оролцоотой явагдах ёстай. Тэгэвл 9 хүнээс бүрлэх Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь 320 депутатын бүрдэх Ардын Их Хурлыг бүрэн орлоно гэж үзэх нь учир дутагдалтай юм. Эдгээр үндэслэлийг иш үндэс болгон Үндсэн хуулиар Их Хуралд хамааруулсан бүрэн эрхийг Тэргүүлэгчид хэрэгжүүлж байсан практикийг дэвсэлбэл, Тэргүүлэгчид нь Их Хурлын бүрэн эрхэд халдаж байсан гэж үзэхээс аргагүй.

Негоөтэйгүүр, хуулийн дээд хүчин чадалтай актыг түүнээс доогуур хүчин чадалтай актаар батлана гэдэг нь эрх зүйн үндсэн зарчмаас хазайсан хэрэг байсан юм. Тэгээд ч хууль тогтоох үйл ажиллагаа нь хууль санаачлах, хуулийн төслийг хэлэлцэх, батлах, ёсчлох, хэвлэн нийтлэх зэрэг хэд хэдэн үе шатаас бүрдэх бөгөөд түүний ини чухал үе шат болох парламентаар хэлэлцэх үе шат үндсэндээ үгүйсгэгдэж байсан гэж хэлж болно.

Хууль тогтоох үйл ажиллагааны практикаас харвал БНМАУ-д үндсэндээ 50 орчим хууль үйлчилж байв. Зарим жилд шинэ хууль батлагддагтүй байсан бол ихэвчлэн жилдээ 2-3 хууль батлагдаж байлаа. Улсын (Ардын) Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд (1951-1986 он) шинжилгээ хийвэл нэгдэх удаагийн

<sup>18</sup> Пьер Маркс “какад дахь референдум тооолзийн ардчилмын тазаархи номуулжт шийдвэр гарсазтын нэээс” парламентын намын сан судалжамшиг эсэг номер ВР-328Е (1993)

<sup>19</sup> Ашиг 2-р хуудас

<sup>20</sup> Ханна Феминист Питкин 209

<sup>21</sup> Пьер Маркс, Девид Робертсон “орчин үеийн улс төвийн төзөв” (лондон 1985 )

<sup>22</sup> Маркку Сукси хүмүүст хүргэх нь (лейдэн маршишус Нижслефф Пабх 1993 )

<sup>23</sup> Brexit бол эрх зүйн замбракалгүй байдлыг бий болгото. Европын эрх зүйн моншор сэргүүз

Ард иргэд оөрсдийн засгийн газрыг тэдний тулгамдсан асуудлууд бэрхшээлийг үүр дунтгэйгээр олж харж шийдвэрлэж чадахгүй байна гэж үзсэн нохцолд төлөөллийн засгийн газар юуг хийж чадаагүйг болон юуг хийхийг хүсээгүйг олж тогтоох үүдиэс санал асуулгыг явуулдаг. Сонгогч бүр асуусан асуултанд хариулах боломжийг олгосон жинхэнэ ардчиллын илрөл хэмээн тодорхойлсон. Шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэхэд амар, засгийн газраас гадуурхи хуулийг бий болгох шаардлагагүй байдаг.<sup>24</sup>

Бүх нийтийн санал хураалтын давуу талуудыг дурдахын зэрэгцээ түүний үндэсний хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг тооцох шаардлагатай. Хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй засгийн газрын хууль санаачлах үйл ажиллагаанд ч нөлөөлдөг бөгөөд шууд нөлөөлөөд зогсохгүй хууль санаачлах зорилтын шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлдог.

---

<sup>24</sup> Санал охог санаачлаагаа ардчиллыг тодорхойлдог уу? КАТО бодлогын тайлан 22-р боть номер-4 2000

# ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛЬ БҮТЭЭХ, ХЭРЭГЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУДЫГ БАРИМТЛАХ НЬ

Ж.Бямбаа

*Шихицүүтэг Их сургуулийн эрүүгийн эрх зүйн тэнхлэгийн  
эрхлэгч, доктор /Ph.D/, профессор*

Аливаа хууль бүтээж хэрэглэх нь тухайн нийгмийн харилцааг зохицуулах зайлшгүй шаардлагын үр дүн болж байдаг. Энэхүү санаачлагта нь танин мэдэжүй, сэтгэн бодохуй, системчлэн буулгахуй, зөв илэрхийлэгдэхүй зэрэг субъектив зүй тогтолын үе шатыг заавал туулж онгөрөөх учиртай. “Дуундаа орж дуулах, дүрдээ итгэж тоглох” гэдэг шиг хууль тогтоогчдын дотоод итгэл үнэмшилийн бодит үр дүн нь объектив шаардлага, субъектив шалгуурын аль алийг даван туулж хэм хэмжээ болон илэрхийлэгдэнэ. Ер нь хууль бүтээх, хэрэглэх дотоод итгэл гэдэг нь нийгмийн амьдралын тухайн салбарын талаархи гүн баг мэддэг, мэргэшшийн болоод эрх зүйн ондер ухамсар толовсрон байх шалгуурыг заавал туулах биз. Мэдээж оорсдоо бүтэн туурвисан ч, бусдаас “хуулбарлан буулгасан” (эн нь шилжилтийн үсийн нэг онцлог) ч хууль үйлчлэнгүүт тухайн харилцаа (шууд) үлгэр жишээ болчихгүй нь ойлгомжтой. Тиймээс ч аливаа эрхийн хэмжээний оршин тогтинох хөрс суурийг урьдаас бүхий л талаар сайтар болтгэх нь чухал.

Эрх зүйн зарчмууд нь энэ нийтлэг шинж, тавигдах шаардлагын илэрхийлэл болж байдаг юм. Иймээс ч хуульчдын мэргэшшийн эрх зүйн ухамсар бүрэлдэж тогтох тулгуур ойлголтын нэг мөний хувьд түүшиг тусгайд нь, бас зайлшгүй үйлчлэх үе шаттай нь нягт холбон судлах ажлыг байнгын болгох зүй тогтол тулгардаг.

Онол, арга зүйн үүдлийн эрх зүйн зарчим нь эрх зүйн зорилгын тухай үзэл санаа, эрх зүй ямар байх ёстой тухай тосоолийг бэхжүүлсэн үзэл баримтлалтай уялдаа бүхийг юуны түрүүн тэмдэглэх нь зүйтэй. Тэрбээр эхлэл эрх зүйн ухамсарт бүрэлдэж

эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрхэн тусгаж буйг жичлэн авч үзье.

### **а) Хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах**

ЭБШ ажиллагаа нь төрөөс тогтоосон онцгой журмын дагуу явагддаг хэрэг дээрээ хүч хэрэглэж болзошгүй заналхийллыг сөртөө агуулж байдаг онцлогтой. Тиймээс ч ЭБШ эрх зүйн онол практикийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний эмзэг асуудалд хандах үзэл баримтлал, үйл ажиллагааг байнга төгөлдөржүүлж, ард иргэдийн хуулиа дээдлэх эрхэм нандин ухамсарыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах шаардлага оссоөр байна. Бие хүний эрхэмсэг оршихуй, орои байрны халдашгүй байдлыг хангах, иргэний хувийн болон захидал харилцааны иууцыг хамгаалахад чиглэгдсэн холбогдох хуулийн заалтуудыг ЭБШ ажиллагааны үе шат бүрт чанд дээдлэх арчилсан нийгмийн мөн чанарыг тодорхойлох олон чухал шинж энхүү зарчимд шингэжээ. ЭБШ ажиллагааны үед хүний эрх, эрх чөлөөний илэрхийлэл болсон энхүү заалтууд **процессын баталгаанд зүй ёсоор тооцогдлог**.

Гээн ч ЭБШ хуулин дахь эрх, эрх чөлөөний энхүү баталгаа зохицуулалтыг улам тодорхой болгох шаардлага хэвээр байна. Тухайлбал, хувь хүний нэр төр, алтар хүндийг хамгаалахад чиглэсэн Хүний эрхийн түгээмэл тухаг, Улс төр, эдийн засгийн эрхийн пактын тухайлсан заалтуудын үзэл санаа ЭБШ ажиллагааны оноо үйлчилж буй, тэр ч атугай шиночлэгдэн болтгэгдсэн гэх хуульд тусгалаа тэр бүр олсонгүй.

Жишэолэхэд, ЭБШ ажиллагааны оролцогчдын эрхийг тайлбарлаж өгөөгүй л бол тухайн процесс, түүний үр дүнг ач холбогдолгүйд тооцох журам үндсэндээ үйлчлэхгүй байна. Дур мэдэн баривчлах, албадан saatuuлах таслан сэргийлэх арга хэмжээг үндэслэлгүй, үзэмжээрээ хэрэглэх явдал шүүхийн шинэтгэл өрнөж буй оноо цаг үед ч огт буурсангүй. Тухайлбал, шүүхийн омнох шатаанд эрүүдэн шүүх хэлбэр багасахгүй байгаа баримтыг Хүний эрхийн Үндэсний комиссны 2013-2015 оны илтгэлүүдээс харж болно. Улсын хэмжээнд бүртгэгдсэн бух

хэргийн бараг 60 гаруй хувь нь шүүхийн омнох шатанд шийдвэрлэгддэг. Энэ нь хэрэг дээрээ маргаант асуудлыг эцэслэн шийдвэрлэх, гэм буруутай эсэхийг зөвхөн шүүх тогтоох зарчмууд илэвхтэй үйлчлэхгүй байна гэсэн уг. Хүснэгт, гомдоо шүүхэд гаргах, түүний дотор мөрдөн байцаалтын шатанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн үед шударгы, хендлөнгийн субъектэд хандах эрх манайд тун хойрго үйлчилдэг. Сэжигтэн, яллагдагчийн эрх зүйн байдлыг зааглах нь зүйн хэрэг, гэхдээ шинэчлэгдсэн гэх хуулинд туссан шиг бодит амьдралаас тасархай, хольж хутгасан, ойлгомжгүй байдалц оруулж болмооргүй санагдана. Манай ЭБШ хуульд цагаатгах эрхийг нь сэргээх журмын тухай тусгай зохицуулалт дутаж байна. ЭБШ хуулийн зүйл, заалтыг гүйвуулж хэргэлэх явдал тасрахгүй байна. **Улс төржсон өршөөл** учлал үзүүлдэг явдлыг зогсоож материалыг болон процессын хуулиа хүндэтгэн биселүүлэх боломж нохцол бурдүүлэх цаг болсон.

ЭБШ ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийн баталгааг **тухайн зүйл, заалтаанд нь** тодорхойлж огох нь зүйтгэй. Жишээлхэд, хууль сануулан байцаасан гэрч дорхиноо сэжигтэн болж хувирдаг сорог ҮР дагавартай өнөөгийн эрх зүйн зохицуулалтаароорчлогдеж таарна.

Хууль бус хорьсон, эрүүтийн хариуцлагад татсан, ТСАХ авсны улмаас учирсан эдийн ба эдийн бус хохирлыг хэдий эрх зүйн зохицуулалттай авч зөвхөн өөрийн нь гомдоор арилгадаг манай практик орчин цагийн шаардлага, тогтсон жишгээс илт хоцорсон.

Бусдын амь нас, эрүүл мэнд, эд хоронгонд зохион байгуулалтын, техникийн болон бусад хамгаалах арга хэмжээ авах нарийвчилсан зохицуулалт шаардагдсан хэвээр. Тухайлбал, гэрч, хохирогч, шинжээчийг (өмгөөлөгч байхыг үгүйсгэхгүй) зайлшгүй тохиолдолд **хамгаалалтандаваах** эрх зүйн зохицуулалт олигтой үйлчлэхгүй байна. Сүүлийн үед байцаалтгүйгээр мөрдөлт явуулж хэрэг шийдвэрлэх тухай “хий үзэгдэл” бүр эрх зүйн зарчимтай адил түвшинд “номлогдох” болсон нь хачирхалтай.

Эндээс үзэхэд хүний эрх, эрх чөлөө, хадашгүй дархан байдлыг хангах нийтлэг зарчмуудыг ЭБШ хуульд тодорхой тусгаж улам амьд үйлчлэлтэй болгох асуудал тулгамдсан хэвээр.

## 6) Хууль ёсны зарчим

Уг зарчим нь "хууль дээдлэх","хуулийг чандлан сахих" хоёр утга санааг өөртөө агуулж байдаг. Тиймээс ч энхүү зарчмын онол, арга зүйн мөн чанарыг тухайлан харуулах шаардлага бий. Илрэх онцлог нь:

ЭБШ ажиллагаанд хуулийн зүйл заалтыг чандлан баримтлах хатуу журам үйлчилнэ. Үзлэг, илгэжэг хийх хуульчлагдсан журмыг зөрчсон л бол олж авсан баримт, солт, мэдээлэл нотлох ач холбогдолоо алдана. Эрүүгийн хэрэг үүсгэхийн өмнө (тулд), үүсгэсний дараа явагдах үзлэг, илгэжэг гэхэд л өөр өөрийн баримтлах дуромтэй. Тиймээс ч хольж хутгаж огт болохгүй. Хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШ хуулийн зүйл, заалтууд нь Үндсэн хуулиас бусад хуультай зорчилдвол процесс ажиллагааны үед зөвхөн ЭБШ хуулийг баримтлана. Зүйрлэвэл, хуулийн хүчин төгөлдөр тогтоол, шийдвэр гарсан л бол хамаарах этгээдийн элдэв эрх дарх хумигдана гэсэн үг.

Хууль дээдлэх зарчмын утга агуулгыг хуулийн зүйл заалтын зорчилдоеөн, хийдлийн үед юуг удирдлага болгох, хууль ёс, шударга ёсны уялдаа холбоог ойлгон мэдрэх ногоц шинжээр нь хамгийн оновчтой хэрэглэх чадвар тодорхойдог. Жишээлбэл, таслан шийдвэрлэх шийтгэх, цагаатгах тогтоолыг гаргахдаа хуулийн болоод бодит үндэслэлийг заавалчгүй баримтлахын зэрэгцээ тэрхүү онц хариуцлагатай шийдвэр гаргагч жудаг, ёс суртахууны эрхэм наандин чанарт гарцаагүй тулгуурлаж таарна. Тийм ч учраас шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, омгөөлогч, хэнийг ч тэр эмзэг зээрээт асуудал, амь амьдралыг зөвхөн ямар нэгэн субъектив хэмжүүрээр хам хум шийдвэрлэн өдөр хоногийг аргацаагчид биш, яллагдаж, омгөөлөгдөж буй аль аль талын жаргал зөвлөнгөөрийн сэтгэл зүрхээрээ мэдэрч хар цагааныг ялган салгагч нийгмийг эмчлэн эрүүлжүүлэгчид байх ёстой гэж

үздэг. Энэ бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд заавалчгүй баримтлах алтан дүрэм эрх зүйн зарчмын жинхэнэ үйлчлэл мөн.

## в) Гэм буруугүйд тооцох

Ардчилсан, эрх зүйт төрийн нэгэн тулгуур зарчим болох гэм буруугүйд тооцох нь хүний эрхийн түгээмэл тухаглалын 11, 1950 оны Хүний эрхийг хамгаалах тухай Конвенцийн 6, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14-д тусгалаа олж, Монгол улсын Үндсэн хуулиар баталаажсан бөгөөд нэг талаас тэр, түүний байгууллага, ЭБШ ажиллагааг эрхлэн явуулагчид иргэн, ногөө талаас гэмт хэрэг өдүүлэн түүндээ яллагдаж буй этгээдийн хоорондох харилцааны агуулга мөн чанараар тодорхойлогдоно.

Яллагдаж буй этгээдэд сэжигтэн мөн хамаарах учиртай. Гэхдээ ихэнх оронд яллагдагч, сэжигтний эрх, үүрэг хоорондоо нэлзэд ялгаатайгаас гадна ЭБШ ажиллагаанд оролцох процессын хугацаа нь хүртэл оор оор. Манайд ЭБШ ажиллагаанд сэжигтэн хугацаагүй байснаа одоо байгаа эсэх нь ойлгомжгүй болсон.

Доктор Д.Баярсайхан Макс-Планкiiйн институтаас долхиин 88 орны эрдэмтгэдийн оролцуулан бэлтгэж НҮБ-ын холбогдох байгууллагуудаас зөвшөөрч 2009 онд тараагдсан ЭБШ жишиг хуулийн төсөлд сэжигтэн, яллагдагчийн эрх, үүрэгт тусгайлсан тодотгосныг жичлэн тэмдэглэсэн байdag<sup>13</sup>.

Яллагдагчийн гэм буруутай эсхийг эрх бүхий байгууллагын нотолгоогоор шийдвэрлэгддг. Тухайлбал, яллагдагчаар эх газрын гэх тогтолцоот орнуудад хэрэг бүртгэч, морден байцаагч, прокурор я татна. Мэдээж шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолоор яллагдагчийн гэм буруу эрэслэн тогтоогдоно. Цагаатгах тогтоол шүүхээс гарвал тухайн этгээд гэм буруугүй гэдэг нь ямарч эргэлзэгүй болно. Харин өршөөл, училалд хамрагдсан, хэргийн хөөн хэлмийнх хугацаа дууссан, яллагдагч нас барсан, хэргийн нохцол байдал өөрчлөгдсөн зэрэг

<sup>13</sup> Макс-Планкiiйн институтын орчтогосон семинаарт 2011 оны 5-д сард тавигдсан илтэл (Д.Баярсайхан)

“цагаатгах” боломжгүй үндэслэлээр хэрэг нь хэрэгсхгүй болсон бол гэм буруутай эсэх нь эрслэгдсэн гэж үздэгтүй.

Анхан шатны шүүхийн шийтгэх шийдвэр гарсан ч гэм буруугийн зарчим уйлчилээ бүрэн зогсоогоогүй байна. Учир нь гэм буруутай нь тогтоогдсон этгээдийн Үндсэн хуулийн баталгаа бүхий шүүхийн шийдвэрт ялтын давж заалдаа эрх тодорхой хугацаанд ишолтгэй уйлчилдэг.

Өөрийн гэм буруутгүй болохоо нотлох үүрэг хүлээхгүй ч яллагдагч нь нотлох ажиллагаанд ямарч үед оролцох эрхтэй. Харин яллаганааг эс зөвчюурсон түүний үндэслэл, няцаалтыг ЭБШ ажиллагааг эрхлэн явуулагчид ияатлан мухарлах ёстой. Ийм үед яллагдагчийн хүлээх үүрэг, эдлэх эрх нь түүний өмгөөлогчийнхтэй заавал давхцаа албагүй. Тухайлбал, яллагдагчийн гэм буруутгүй болохыг өмгөөлөгч нотлох эрхтэйгээс гадна яллаганааг “эргэлзээгэй болгох” үүргийг ч мөн хүлээж болно. Товчдоо хууль хэрэглэх, батлах нотлоход арилгаж болшгүй эргэлзээ төрүүлэх нь түүний гол зорилгын нэг яах аргагүй мөн.

### г) Мэтгэлэцх зарчим

Манай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оруулсан зарчмын гэж хэлж болох нэгэн шинэчлэл бол шүүн таслах ажиллагааны “мэтгэлэцх зарчим”-ыг хуульчилж “мандуулснаа” одоо шинэчлэгдсэн хуулиас хассан.

Ер нь мэтгэлэцэний гол шинж нь шүүхийн хэлэлцүүлгийн зүйлийг /агуулгыг/ талууд **өөредөө тодорхойлох** явдал. Гэтэл эрүүгийн мөрдөн мөшгөлт нь /тууний дотор мөрдөн байцаалт/ гүйцэтгэх засаглалын тун хаалттай хүрээнд явагддаг, оногийн эрх зүйн зохицуулалт нь ч тийм юм. Уг нь ажиллагааны энсийн үр дүн хэрэг дээрээ яллах талын хүсэл эрмэлзэлийн илэрхийлэл гэж хэлж болох “**яллах дүгнэлт**”, аль эсхүл “**яллагдагчаар татах тогтооол**” хэлбэрээр бэлтгэгддэг. Тэрхүү баримт бичгүүд шүүхийн хэлэлцүүлгийн өмнө /хэдийгээр ЭБШ хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана гэсэн заалттай авч /өөрчлөгдхөгүй, онгое хувиргахгүй. Тэгэхээр өмгөөлөх тал шүүхийн хэлэлцүүлгийн зүйлийг тодорхойлоход

**чухамдаа “даган баясахалс” оор үүрэгтүй юм. Ийм байхад бил мэтгэлцэн жинхэнэ утгаар явагдах хуулийн болоод бодит үндэслэл бүрдээн гэж сургалт, сурталчилгаа, эрдэм судлалын хүрээнд ярих, бичих үндэслэл үзүүлээ бага.**

Монголын ЭБШ ажиллагааны мэтгэлцэх зарчмын үйлчлэлд /манай хуулийн үзэл баримтлалыг боловсруулахад оролцсон/ Германы нэрт эрдэмтэн А.Дайнекер, Б.Шюнемани нар хүртэл зргэлээж байсан. Тэд “ЭБШ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-ийг Anglo-American маягийн шүүх хуралдааныг онгоц санагдуулж байна... Герман улсын ЭБШ хуульд ийм заалт 125 жилийн омноос орсон байдаг богоод хэд хэдэн шалтгаанаас болоод практикт ойт хэрэглэгдэж байгаагүй ба эдгэр нь Монголд ч хамаатай байх талтай... Иймээс цаашид шүүгчдэл шүүх хуралдааны тэнцвэрт байдлыг алдагдуулж байх үсийг мэдрэх сургалт зохион байгуулах<sup>14</sup> хэрэгтэйг тухайн үед зөвлөж байв.

Эрх зүйн зохицуулалт нь бүдог, тэгээд ч “яс маханд шингэсэн яллан” шийдвэрлэх уламжлалт арга барилыг одоо үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд тэрхүү зөвлөмжийн дагуу дан ганц сургалтаар оорчлох боломж үзүүлээ байхгүй.

ХБНГУ-ын нэрт профессор А.Дайнекер “ЭБШ ажиллагааг эрхлэн явуулагч торийн төлөөлөл ямарч үед” төвийг сахьсан байринаас эрх зүйн харилцаанд оролцдог. Түүнийг зовхон яллах талын төлөөлөл мэтгэр үзэх нь буруу. Бие хүний жам ёсны эрхийг баталгаатай хангах ЭБШ ажиллагааны үед хууль ёсыг чанд сахьсан эсэхийг ялангадж буй этгээдийн эрх, ашиг сонирхлын үүдлийс дагнан хангуулах зорилгоор мэргэшлийн омгоолгүйдийг заавал оролцуулдаг<sup>15</sup> гэж онцолсныг энд онцлох нь зүйтэй. Үзэхээр ч нийгмийн амьдралыг “тор үүрч явах хувь тавилантай” л юм бол түүнийг Гегелийнхээр “ухаалагжуулах”

<sup>14</sup> Монгол улсын ЭБШ хуулийн шинжлэх ухааны тайлбар УБ., 2003 он. Хамтын бүтээл 34-38 дахь тал

<sup>15</sup> 1997 онд МУИС-ийн ХЭС дээр болсон шүүрч эрдэмтэдийн семинар дээр хэлсэн үг

нь чухал болохоос үгүйсгэх, үзүү ядах нь ЭБШ эрх зүйн харищаанд зэрэг нолөө тэр бүр үзүүлэхгүйн нь ойлгомжтой.

Шинээр бэлтгэдсэн хуулиас мэтгэцэх зарчмыг хассан ч түүний дэвшилт мөн чанарыг эс тоомсорлосны шинж. Иймээс ирийээсээ эклээд шинэчлэгдсэн гэх ЭБШ хууль яаж үйлчилсэн ч мэтгэцэх аргыг орхиж болно. Иймээс:

- Шүүхийн өмнөх шатанд процессын баталгааг бодитойгоор хангах /түүний дотор мэтгэцээнд омгөөлох тал бэлтгэх/ бүхий л боломжийг бүрдүүлэх;
- Хуралдааны үед мөрдөн байцаалтын дутууг гүйцэхийн тулд яллах, омгөөлох чиг үүргийн аливаа хэлбэрийг шүүх дангаараа эрхлэхээс зайлсхийх харин хэргийн бодит байдлыг тогтоохын тулд талуудын идэвх, оролцоог аль болохоор хөхүүлэн дэмжих;
- Яллах тал мэтгэцэнд оролцохгүй байх, идэвхи гаргаагүй тохиолдолд шүүх түүнийг орлох түүнчлэн шүүгдэгчийн гэм бурууг иотлуулахаар шүүх оөреө санаачлан мордөн байцаалтанд буцаахаас аль болохоор зайлсхийх;
- Омгөөлох тал/иши түрүүнд мэргэжлийн омгөөлэгч/ шүүхийн аль ч шатанд өмнө тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн баримт, мэдээлээ шинээр гаргаж тавих эрх зэлэх. Шүүх түүнийг заавал нягтлан хэлэлцэдэг байх;
- Улсын яллагч, омгоөлөгч хоёр бис биендээ шүүхээр хэмэцүүлж буй хэргийн ямар ч асуудлаар асуулт тавьж хариулт авах мэтээр мэтгэцэндийн оноогийн хэлбэр, агуулгыг цаашдаа өргөжүүлэн дэмжих нь зүйтэй.

#### д) Хэргийн байдлыг тал бүрээ нь бүрэн бодитой тогтоох

Уг зарчмын гол утга учир нь аливаа эрүүгийн хэргийг мөрдөн байцааж нягтлан шийдвэрлэхэд яллах, цагаатгах, хүлрүүлэх, хөнгоруулж нөхцөл байдлыг бүрэн тогтоохоор илэрхийлэгдэнэ. Монгол улсын ЭБШ хуулийн 16 дугаар зүйцэд энэхүү зарчмыг заан тодорхойлоходоо уламжлалт эх газрын тогтолцооны зохицуулалтыг харгалзсан нь ажиглагддаг. Хэргийн байдлыг тал бүрээ нь бүрэн,

бодитойгоор тогтоохын тулд оноо үйлчилж буй хуулийн дагуу мөрдөн мөшгөх байгууллага тодийгүй шүүх хүртэл нотолгоо эрхлэх үүрэг хүлээдэг онцлогтой. ХБНГУ-ын дээр изрэлзэн эрдэмтдийнхээр зруүгийн хэрэг үүсгэхээс эхээд шүүхэд шилжүүлэх хүртэл төрийн эрх бүхий байгууллага хар цагааныг ялгах үүрэг адил тэгшээр хүлээн. Оөрөөр хэлбэл, тэд хууль зүйн утгаараа яллах, омгоолох шинжтэй ямар ч чиг үүргийг дагнан хэрэгжүүлж болохгүй аж.

Гэтэл манайд нотлох үүргийг шүүхэд хуульчлан ногдуулнаараа энэхүү зарчим нь мэтгэлцэхтэйгээ зорчилдож байна гэж үздэг. Ром-германы гэх эрх зүйн тогтолцоотой ихэнх ориуудын ЭБШ ажиллагаанд энэ хөбөр зарчим зэрэгцэн үйлчилжээ үндсэндээ болсон. Тухайлбал, ХБНГУ-ын мэтгэлцэний элементүүд зөвхөн ЭБШ тодорхой үе шат, ажиллагаанд л тусгалаа олсон байхад ОХУ-ын ЭБШ хуулианд хэргийн байдлыг болитой тогтоох ажиллагааны гол зохицуулалт нь Гэм буруугүйд тооцох, хууль ёсны байх зарчмууд шүүх эрх мэдлийг гагихүү шүүх хэрэгжүүлэх зарчмын хүрээнд агуулгаараа илэрхийлэгддэг.

Энэ нь эрх зүйн зарчмууд даангаар гэхээсээ хослон үйлчилдэг, нэг нь ногоогийнхээ илэрхийлэл болон үйлчлэх боломжтойг баримттайгаар харуулж байна. Иймд хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэхээс омни, тодотговол: хууль бүтээх ажиллагааны үед эрх зүйн зарчмуудыг зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай.

Ер нь: Улс ориуудын эрх зүйн бүлийг ангилхадаа Англо-Саксоны, Ром-Германы, Лалын, Социалист, Пост коммунист гэх зэргээр авч үздэг онол үзэл баримтлалууд одоо ч үйлчилсээр. Бас “шилжилт”-ийн гэдэг зүй ёсоор багтдаг социализмаас ангилжирч байгаа “Монгол мэтийн 4 орныг “Кочевой” буюу нүүдлийн эрх зүйн тогтолцоот” гэж онцгойлох нь ч бас бий”. “Нүүдлийн” гэдэг ангизалыг “сониучхан”, “загварчлалд баригдаагүй”, “субъектив шийдэл ихтэй” гэх зэрэг шалгууруудаас тодорхойлсон болов уу. “Зашилын”, “бис даасан шинжийн илэрхийлэл, гэхдээ уламжлалт тогтолцоондоо багтана гэж ХБНГУ-ын профессор Б.Шоллер онцлон тэмдэглэснийг дээрхтэй холбогдуулан хэлэх нь зүйтэй биз.

Ийм ч учраас эрх зүйн нийтлэг зарчмуудыг зөвхөн эрх зүйн бүлүүдэд тулгуурлан хэт загварчилах ажиллагаа даяаршлалын оног үед шүүмжлэлд сүрхий өртөж байна. Түүничлон үүрэг, роль, үйлчилэх ач холбогдоороо эрх зүйн зарчмуудын агуулга, мөн чанар улам бүр осон нэмждэж нийтлэг шинж нь тодорсоор байгааг онцлох нь зүйтэй биз.

### Эндээс хийх товч дүгнэлт

1. Хууль бүтээх, хэрэглэх ажиллагаа нь орчин цагийн шаардлагатай нягт уялдаатай, гэхдээ уламжлал, өөрийн орны онцлог, тухайн цаг үсийн эрх зүйн ухамсар соёлыг эс тоомсорлон хандахыг тодийлон тэвчдэгтүй.
2. Эрүүгийн чиглэлийн, ялангуяа эрүүгийн процессын хуулийг шинээр бүтээсэнч шинэчлэн өөрчилсон ч тухайн нийгмийн ахуй нөхцлөөс огцом тасарч боломгүй. Тиймээс юуны урьд эрх зүйн бүл дэх дэвшилт зохицуулалтыг анхаарах, эрх зүйн нийтлэг шинжтэй амьдралын шалгуур туулсан зарчмуудыг бүтээгдэж буй хуулиас хасах, утта агуултыг өөрчлох, зохицуулах журам болгон хувиргах зэрэг субъектив хандлага гаргахгүй байх. Ингэснээр хэрэгжүүлэх боломж нь эрэ дээшилнэ.
3. Эрх зүйн зарчмууд нь хэм хэмжээ агуулсан зүйл заалт гэхээсээ илүүтэй тухайн харилцааны эрх зүйн мөн чанарыг илэрхийдэй удирдамжийн шинж бүхий үзэл баримтлал. Гэтэл манайд юугаар ч сольж боломгүй энэрэглийг ёсны зарчмыг зруу, эрүүгийн процессын шинэчлэгдсэн хуулиас хассан нь онол, арга зүйн төдийгүй практик хэрэглээнд алдаа болно.
4. Эрх зүйн зарчмууд нь оөр хоорондоо уялдаатай учраас нэгнийхээ агуулгад багтан үйлчлэх, ногоогоө толоолон илэрхийлж чаддаг, гэхдээ эрх зүйн аливаа нэгэн зарчмыг зөвхөн гүн ухаан, аль эсхүл улс төрийн өнгө аясаар салган тайлбарлах, хэрэглэх аливаа оролдлого нь түүний утга агуулага, мөн чанарыг алдагдуулахад хүргэнэ.

## **ADHERING TO LEGAL PRINCIPLES FOR CREATION AND ENFORCEMENT OF LAWS**

Creation and application of laws are resulted from inevitable need for the regulation of social relations. Both creation and enforcement of laws are closely related to inner beliefs of an enforcement body.

It is important to prepare legal environment thoroughly for application of law beforehand and it should be solved during law making process. Therefore, this paper aims to describe that how legal principles influence on the process of creation and application of laws. Legal principles are the foundation of the process of creation and application of laws. Legal principles broaden more in terms of content and influence in conformity with social development.

Legal principles indicate the legal system, on the other hand, they play role of guidance and ideology in the frame of legal regulation. In addition, it is the beginning of proper resolution of complex problems and issues. Legal principles can be classified as follows in terms of its nature:

1. Natural;
2. Legal;
3. Moral.

The first one is defined as certain inherent rights by virtue of human nature and recognized and protected by social demand whereas legal principles are provided and applied in international and national laws.

Morality is determined by personal and cultural values. The conformity and unity of legal principles must be considered when it comes to classification.

It has become apparent that some principal changes are to be made to Criminal Code and Criminal Procedures Code of Mongolia. It tends to arise arguments as forms and contents of those laws have been changed significantly and politicians and scholars consider those changes as significant as democratic revolution. This paper briefly explores how legal principles which regarded as the values of humanity were reflected in those new laws and provides my own conclusion.

# ПОЛИТИЧЕСКИЕ РЕЖИМЫ В ГОСУДАРСТВАХ РАЗЛИЧНЫХ ПРАВОВЫХ СЕМЕЙ

Тирских М.Г.

Иркутский государственный университет Юридический институт  
к.ю.н., профессор кафедры  
международного права и сравнительного правоведения

Проблема методологии государственного управления тесным образом связана с правом конкретного государства. От того, как в правовой плоскости решаются вопросы организации политической власти, взаимодействия органов государственной власти и общества, идеологического и политического многообразия зависит в том числе и то какой политический режим может быть установлен в том или ином государстве.

Следует отметить, что право ни в коем случае не должно рассматриваться как безусловный ограничитель в процессе формирования того или иного политического режима. В условиях права государства англо-саксонской правовой семьи гипотетически может возникнуть и развиться тоталитарный политический режим, точно так же как и доминирование закона, как основы правовой системы в романо-германской правовой семье не является безусловным признаком авторитаристического характера политического режима.

Между тем, можно выделить две плоскости в которых наличие той или иной правовой системы является фактором формирования политического режима.

Во-первых, в тех правовых семьях в которых в праве значительную (если даже не первоочередную) роль играет идеология, политическая или религиозная (социалистическая правовая семья, или религиозно-традиционные правовые системы) создается ситуация, благоприятная для формирования авторитарного политического режима, а в апофеозе и

тоталитарного политического режима, имеющего социалистическую или религиозную идеологическую платформу.

В таких случаях, формирование либеральных или демократических (в западноевропейской трактовке представительной демократии) политических режимов требует либо смены социалистической правовой системы и замены ее на правовую систему иного типа (например, романо-германскую), либо существенной деструкции отдельных институтов социалистического государства и права, в том числе принципа партийности в государственном управлении, демократического централизма, как системы альтернативной необходимого для представительной демократии разделения властей и так далее. В случае же попытки сформировать такие режимы на основе религиозной правовой системы, например, в рамках мусульманского права сталкивается с необходимостью либо полной вестернизации права (как в Турции во время младотурецкой революции), либо частичной с обязательным введением светской модели государственного управления и установлением приоритета гражданских прав и свобод перед религиозными предписаниями (как это было сделано в Ливийской Джамахирии, Египте, Алжире и ряде других государств). В любом случае, это пошатнет устои как социалистического, так и религиозно-традиционного права, фактически превращая правовую систему такого государства в смешанную, или переходную.

Второй плоскостью следует назвать наличие у отдельных правовых систем свойств, препятствующих скорому установлению того или иного политического режима. Романо-германскую правовую семью следует признать наиболее эластичной и приемлемой для любой трансформации политических режимов. И установление демократического политического режима (Норвегия, Исландия) и авторитарного режима (Греция в период диктатуры «черных полковников») равнозначно допустимо в рамках романо-германской правовой семьи и не требует каких-либо особых

изменений в структуре права, его принципах и основаниях. Воля органов государственной власти, облаченная в нормативный правовой акт, позволяет успешно осуществлять любой политический транзит.

Несколько иной представляется ситуация в отношение права стран англо-саксонской правовой семьи. Прецедентный характер права не делает государство неуязвимым от возможной авторитаризации, или даже построения тоталитарного политического режима. Однако он значительно усложняет сам процесс преобразования и фиксации соответствующих норм поскольку требует двух вещей.

Во-первых, исключения из судейского сообщества всех лиц не лояльных к политическому режиму, что требует привлечение значительных сил и средств и чревато негативными политическими последствиями, в том числе демаршами отдельных представителей судейского сообщества.

Во-вторых, авторитаризация потребует очистки прецедентной системы от отдельных проявлений прецедентных норм не соотносимых с реалиями правовой системы. Для этого может использоваться механизм внешней надстройки в виде нормативного акта, вводящего чрезвычайный или специальный режим использования прецедентной практики.

Реальным примером такой надстройки можно назвать принятие в Соединенных Штатах Америки Патриотического акта (2001 года) и ряда иных нормативных предписаний, вводящих жесткие административные правила, механизмы принуждения граждан. Между тем, вывод отдельных административных правил из-под судебного контроля, даже с учетом принятия таких актов ставит право в соответствующем государстве на грань балансирования между актуальной государственной потребностью и «пропастью беззакония». В таком случае не приходится удивляться, что многие исследователи с настороженностью говорят о демократическом характере политического режима США, предпочитая вводить в науку новые концепты, такие, как

например «автократическая демократия», которые с одной стороны являются взаимно противоречивыми, однако поразительно точно описывающими правовую и политическую реальность. Между тем, мы обязаны отметить временный характер такого явления. Введение жестких административных ограничений, появление тайных тюрем ЦРУ и иные действия, не соотносимые с правовым порядком, отраженным в precedентах, потребуют либо постепенного отказа от использования таких методов (реставрация демократического режима, что с каждым годом существования особого положения становится менее достижимым), либо корректировки precedентной системы и исключения precedентов, препятствующих реализации данных административных мер из практики применения. А это в свою очередь приведет к значительной деформации всей правовой системы и постепенному смещению приоритетов из precedентной плоскости в формальную.

В такой ситуации, очевидно, что правовая система государства не является критической помехой для формирования нового политического режима (в противном случае может быть заменена сама правовая система), однако выступает в качестве фактора, затрудняющего процесс трансформации политического режима для отдельных видов такого политического транзита.

# ЯНЗ БУРИЙН ЭРХ ЗҮЙН БУЛУУДИЙН УЛС ОРНУУД ДАХЬ УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМҮҮД

М.Г.Тирских

Эрхүүгийн УИС-ийн хууль зүйн сургуултнын Олон улсын эрх зүйн болон  
харьцуулсан эрх зүйн тэнсмийн профессор, доктор /Ph.D/

Төрийн удирдлагын арга зүйн асуудал тодорхой улс орны хууль эрх зүйтэй нягт холбоотой байдаг. Улс төрийн засаглалын зохион байгуулалтын төрийн засалалын болон ийнгийн байгууллагуудын харилцан үйлчилгийн үзэл суртлын болоод улс төрийн олон янз байдлын асуудлуудыг хууль эрх зүйн талаас нь яаж шийдвэрлэж буйгаас аль нэг улсад улс төрийн ямар дэглэм тогтсон байж болох нь хамаардаг байна. Хууль эрх зүйг аль нэг улс төрийн дэглэм бүрэлдэн тогтох процесст гарцаагүй хязгааралагч хэмээн хэрхэвч авч үзэх ёсгүй гэдгийг тэмдэглох хэрэгтэй.

Англо-саксоны эрх зүйн бүлийн улс орны хууль эрх зүйн нехцөнд улс төрийн тоталитар дэглэм таамаглалын хувьд үүсч хөгжик болно. Түүний яг адиллаар ром-германы эрх зүйн бүлд эрх зүйн тогтолцооны нь үндэс болдог хуулийн ноёрхол улс төрийн дэглэмийн автократ шинж чанарын эргэлзээгүй шинж нь болдогтүй юм.

Тэгэхийн хамт аль алинд нь эрх зүйн тогтолцооны аль нэг байх нь улс төрийн дэглэм бүрэлдэн тогтох хүчин зүйл болдог тийм хоёр тайлбарыг онцгой ялгаж болно.

Нэгдүгээрт, хууль эрх зүйд нь үзэл суртал, улс төрийн буюу шашны (социалист эрх зүйн бүл, эсхүл шашин-уламжлалын эрх зүйн тогтолцоонууд) тогтолцоо ихээхэн чухал (тэрч байтугай тэргүүн зэргийн) үүрэг гүйцэтгэдэг тэр эрх зүйн булгуудэд авторитар улс төрийн дэглэм бүрэлдэн тогтоход таатай нехцөл байдал үүсдэг байна. Тийм тохиолдолд либерал буюу ардчилсан улс төрийн дэглэмүүдийн бүрэлдэн тогтолт нь нэг бол социалист эрх зүйн тогтолцоог халж, түүнийг оөр хэв маягийн (жишиг нь, ром-германы) эрх зүйн тогтолцоогоор солих, эсхүл социалист төр,

эрх зүйн зарим институцуудыг, түүний дотор төрийн удирдлагын намч зарчмыг, ардчилсан төвлөн удирдах ёсыг нухацтайгаар бутцийн оорчлолт хийхийг шаарддаг байна.

Шашны эрх зүй тогтолцооны үндсэн дээр, жишээлбэл, мусульманы эрх зүйн хүрээнд тийм дэглэмүүдийг бүрдүүлэх гэсэн оролдлогууд нь нэг бол эрх зүйг бүрэн баруунчлах (туркийн хувьсгалын үед Турк улсад болсон шиг) зайлшгүй шаардлагатай, эсхүл улс төрийн удирдлагын заримдаг иргэний нийгмийн загвартай болон шашны лүндэнгүүдийн омно иргэний эрх, эрх чоюог тэргүүн зэрэгт тавихтай (Ливийн жамахари, Египет, Алжир болон бусад хэд хэдэн ороонд энэ нь болсон шиг) тулгардаг байна.

Аль ч тохиолдолд энэ нь социалист эрх зүйн ч тэр, мөн шашин-улаамжлалын эрх зүйн ч тэр байр суурийг ганхуулж, тийм тор улсын эрх зүйн тогтолцоог хэрэг дээрээ холимог, эсхүл шилжилтийн болгои хувиргадаг байна.

Зарим эрх зүйн тогтолцоонд аль нэг улс төрий дэглэмийг түрээн тогтооход саад бодлог шинж чанарууд байдгийг хоёрдахь тайлбар гэж изрэх хэрэгтэй. Улс төрийн дэглэмүүдийн аль ч шилжилт оорчлолтийн хувьд Ром-германы эрх зүйн бүлийг хамгийн уян хатан, хамгийн боломжтой нь гэж хүлэн зөвшөөрөх хэрэгтэй.

Улс төрийн ардчилсан дэглэмийг (Норвеги, Исландад), мөн авторитар дэглэмийг (“хар хураандаа нарын” диктатурын үед Грект) тогтоох явдал ром-германы эрх зүйн бүлийн хүрээнд нэг адил боломжтой байсан бөгөөд хуулийн бүтцэд, түүний зарчим болон үндэслэлд ямар ч онцгой оорчлолт хийхийг шаардаагүй билээ. Төрийн засаглалын байгууламжуудын норматив хуулийн актанд туссан хүсэл зориг нь аль ч улс төрийн шилжилтийг амжилттай хэрэгжүүлэх боломж олгож байдаг байна.

Англо-саксоны эрх зүйн бүлийн ориуудын хуулийн хувьд нөхцөл байдал арай оорооор төсөөлогддөг. Эрх зүйн жишгийн шинж нь төрийг болзошгүй ганц хүний дараангуйллаас, эсхүл тэрч байтугай улс төрийн тоталитар дэглэмийг тогтоохоос болж эмзэг сүл болгодогтүй юм.

Гэхдээ тэр нь өөрчлөлтийн болон холбогдох хэм хэмжээнүүдийн тогтоон тэмдэглэх процессыг өөрийг нь ихээхэн товоогтэй болгодог, учир нь энэ нь хоёр зүйлийг шаарддаг байна.

**Нэгд:** улс төрийн дэглэмд хандах тал дээр төвийг сахидагтуй бүх этгээдийг шүүхийн хамтлагаас хасдаг богоод тэр нь ихээхэн хүч хөрөнгө шаарддаг ба улс төрийн сорог үр дагаварыг, түүний дотор шүүхийн хамтлагийн зарим толоологчийн зүгээс төрд хандан үг хэлж эсэргүүцээ илэрхийлэх уршиг удлаг юм.

**Хоёрдугаарт:** ганц хүний дарангуйдал нь эрх зүйн тогтолцооны бодит байдалд үл нийцэн жишгийн хэм хэмжээнүүдийн зарим илэрлүүдээс жишгийн эрх зүйг цэвэрлэхийт шаарддаг байна. Үүний тулд жишгийн практикийг ашиглах онцгой буюу тусгай дэглэм тогтоодог норматив актын хэлбэрээр гадаад давхартын механизмыг ашиглаж болно. Тийм давхартын бодит жишээгээр АНУ-д батлагдсан (2001 оны) эх оронч актыг болон захиргааны айхавтар хатуу журам, иргээдийг албадах албадлагын механизмуудыг тогтоосон хэд хэдэн өөр бусад норматив заалтыг иэрлэж болно. Тэгэхийн хамт шүүхийн хяналтаас болоод захиргааны зарим дүрэм журмын дүгнэлт тэр ч байтугай тийм актуудыг батлан гаргасныг харгалзан үзэж хуулийг улс орныхоо төрийн тулгамдсан чухал эрэлт хэрэгцээ ба “хууль бус ёроолтүй ангалын” хооронд тэнцвэржүүлэхийн ирмэг дээр тавьдаг байна.

Тийм тохиолдолд олон судлаачид АНУ-ын улс төрийн дэглэмийн арчилсан шинжийн тухай болгоомжтой ярж, шинжлэх ухаанд жишээлбэл “авторитар арчилал” гэх мэт тийм шинэ шинэ концентыг оруулж ирж байгаа, тэр нь нэг талаас харилцаан зорчилтэй ч гэсэн хуулийн болон улс төрийн бодит байдлыг хачин жигтэйхэн нарийн тайлбарласан бичиглэл болохыг гайхаад байх явдалгүй. Тэгэхдээ бид тийм үзэгдэл түр зуурын шинжтэй болохыг тэмдэглэх ёстой. Захиргааны хатуу ширүүн хязгаарлалтуудыг тогтоож байгаа, ТТГ-ын иууц шоронгууд бий болж буй болон жишгийн эрх зүйн тусгагдсан хууль эрх зүйн исурамтай үл нийцэх өөр бусад үйлдэл нь нэг бол тийм аргуудыг хэрэглэхээс муухан татгалзах (арчилсан дэглэмийг шинэгээх учир

онцгой байдал оршин байх явдал жил ирэх тусам улам боломжгүй болж байна), эсхүл жишгийн тогтолцоог засварлах, захиргааны эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд саад болж буй жишгүүдийг практик хэрэглэнээс хасахыг шаардах болюу. Энэ нь өөрийн залжнид бүхэлдээ хууль эрх зүйн тогтолцоог бусинулж ихээхэн өөрчлохад, тэргүүлэх ач холбогдлыг жишгийн тайлбарын гарган формаль хэлбэрээр зугуухан солиход хүргэж байна.

Ийм нөхцөл байдалд төр улсын эрх зүйн тогтолцоо шинэ улс торийн дэглэм бүрэлдэн тогтоход саад бодлогтүй (эрэг тохиолдолд хуучин эрх зүйн тогтолцоо өөрөө солигдсон байх болно) нь илэрхий богоод гэвч улс торийн дэглэмийн шилжилтийн процессыг тийм улс торийн шилжилтийн зарим төрлүүдийн хувьд хургүүлдэг хүчин зүйлийн хувиар ажилладаг байна.

# АРДЧИЛЛЫН ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ

Ч.Өнөрбаяр

Монгол Улсын Ерөнхийлогчийн Хуулийн бодлогын зөвлөх, доктор /Ph.D/

"Хэй изг хүнд бинь, хуульд захирагдлаг хүн я эрх чөлөөтэй"

Иммануэл Кант

## Үдиртгал

Уlam олон улс ардчилсан тогтолцоог хүлжэн зовшоорч, ардчилал хүн төрөлхтний ирээдүйн давалгаа болж байна. Энэ бол дэмжүүштэй өөрчлөлт юм. Гэхдээ ардчилал гэдэг уг ямагт эрэг утгыг дагуулж байсангүй. Demoscacy буюу ардчилал нь эртний грекийн "ард түмний засаглал" гэсэн үтиэс гаралтай. Харин тэд энэ изэр томъёог зайлсхийх ёстой засаглалыг тодорхойлоходоо хэрэглэж байв. Ардчиллыг монархи (изг хүний засаг), олигархи (коонхийн засаг), аристократи (язгууртнуудын засаг) зэрэгтэй зэрэгцүүлэн үзж байлаа. Грекчүүдийн хувьд ардчилал нь 3 гол дутагдалтай байв:

1. Олонхи эрх мэдлээ цоонхийг дарангуйлахад ашиглаж болно.
2. Ард түмэн сэтгэл хөдлөл болон тэвчээргүй байдалд амархан автагдаж, учир шалтгааныг умартана.
3. Хүмүүс нийтлэг ашиг сонирхлыг умартан, өөрсдийн хувийн ашиг сонирхолц хотлогддэж болох талтай.<sup>1</sup>

Тийм ч учраас ардчиллын изг хэлбэр болох либерал буюу толоооллийн ардчилал нь ардчиллын давуу тал бүхнийг өөртөө шингээхийн сацуу болзошгүй аюул болгоныг аль болох бууруулахын тулд бий болсон билээ. Ардчиллын энэхүү хэлбэр долхийг өөрчилж байна. Абрахам Линкольн АНУ-ын Иргэний дайны үед Геттисбург хотод хэлсэн үтгэндээ "Ардчилал гэдэг бол ард түмний толоо ард түмнээс бий болсон ард түмний засаг мөн" хэмээх сонгодог тодорхойлолтыг өгсөн билээ.

<sup>1</sup> Нийжээл Ашифорт. Чолоот мийгэлжийн үндэснэ зарчмууд. УБ., 2011. 14 дэх тал.

Гагшүү арчилсан тогтолцоотой улс л Үндэсн хуулт тортэй байж чадна.<sup>2</sup> Учир нь арчилсан засаг л иргэдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангах тал дээр бусад бүх засгаас давуу талтай болохоо харуулсаар байна.<sup>3</sup> Энэ нь оортогоо хамтын шийдвэр гаргахад бүх нийтийн хяналтыг тогтоох, энэхүү хамтын хяналгад бүгд эрх тэгш оролцох гэсн хос зарчмаар илэрхийлэгддэг.<sup>4</sup>

## I. Барууны аж үйлдвэржсэн орнуудын арчиллын онол ба арчиллын бодит байдал

Арчиллын онол одгөө сэргэн мандатын үедээ явж байна. Төр засгийн эрх мэдлийг арчиллын онолоор хэрхэн зовтгож болохыг тайлбарласан тоолж баршигий олон бүтээл онгорсон 20 гаруй жилд гарсан. Тухайлбал *Юрген Хабермас*-ын арчиллын үндэслэлийг хөндсон "Бодит байдал ба үйлчилгээ" (1992) иэртэй онолын хүүримэл огүүлэл болон бусад олон тооны зовлэлдөх арчиллын<sup>5</sup> онолын бүтээлүүдийг иэрлэж болно. Гэвч барууны, тэр дундаа европын аж үйлдвэржсэн орнуудын улс төрийн практикийг харвал үзүүлэхэд үндэсн хуулт арчиллын зарчмаас ухрах хандлагатай байна. Бодит арчиллыг гуравдагч срогонцийн орнуудад хөгжүүлэх гэсн оролдлогуудын ихэнх нь бүтэлгүйтсэн. Үүнийг дараах турван хүчин зүйлээс харж болно:

<sup>2</sup> Ю.Харбих. *Орчин үеийн үндсж хуулын төрийс тодорхойлох нь. ХБНГУ-ын Хамс-Зайдэлийн сангийн 10 жилийн ойд зориулсан олон улсыг симпозиумид тавсан изтээ.*

<sup>3</sup> Аргачтын чамар. Судалгааны огуулжийн энхтгэл. Аренд Лицхарт. Аргачтын хэмээжкар. (Гучин зурсаан орны төр засгийн хэлбэр ба идрээ). Орчуусам Д.Ганбат. УБ., 2007 наинуудыг үзүүлж.

<sup>4</sup> David Beetham and Kevin Boyle. *Introducing democracy: 80 questions and answers.. Polity Press. 1995. P 1*

<sup>5</sup> Thompson/Gutmann „Why deliberative Democracy”, 2004.

1. Парламентат ёсмыг халах үйл явцын үр дүнд иргэдийн улс төрийн хүснэгтийн зорилгыг нэгтгэн зангидах үүргийг арчилсан зарчмаар сонгогдсон парламентаас салтан авч төрийн бусад институцид шилжүүлэх болов. Ялангуяа, Үндсэн хуулийн шүүх улс төрийн талбарт “хулгайн ан хийдэг боллоо”<sup>6</sup> гэх шүүмж үндсэн хуулийн эрх зүйчдийн дунд түгээмэл гарах болов. Өноог хүртэл үндсэн хуулийн шүүхийг дэмжиж, түүнд итгэж ирсэн хүмүүс, байгууллагын зарим хэсэг нь түүнийг буруутгах байдал эрс иzmögдэв. Тухайлбал, Холбооны Үндсэн хуулийн Ерөнхийлогч оролцсон Германы хуульчдын 61 дүгээр Их Хурал дээр иэрт хуульч эрдэмтэн Ицензийн хэлсэн уг олны анхаарлыг их татав.

Тэрээр Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт нь олон ийтгээс эсэргүүцэл илэрхийлэх, зарим мэргэжлийн шүүх шийдвэрт нь эргээзэх, улс төрийн хүрээний зарим хэсэг дургүйцэх, тэр ч атугай Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнээс эсрэг санал огох хэлбэрээр шийдвэрийг нь буруутгах боллоо. Холбооны Үндсэн хуулийн шүүхийг эрх мэдлийн хямралд орсон, туйширсан буюу улс төржсон шийдвэр гаргаж буй, иргэдийн ухамсраас хэтэрхий холдсон хэмжээн шүүмжилж байна. Шүүмжлэл нь улиг болсон улс төрчид, мэргэжлийн шүүмжлэгчдийн хүрээнээс бус, ийгмийн олонхийн дунд өрнөж байна. Эсэргүүцлийн суулт хийх асуудлаар шүүх шийдвэр гаргахдаа хуулийг оорийнхoo үзэмжид ийшүүлэн тайлбарласан, гэрээний талууд адил тэгш эрхтэй гэсэн ерөнхий зарчмыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр зарим тохиолд үйлчилдэг гэрээний эрх зүйд харш шийдвэр гаргасан, Үндсэн хуулийн эрх зүйг гэрээний эрх зүйл шууд хэргэлзсэн, хуульд огсон тайлбарыг үл хайхарсан гэсэн шүүмж гарсаар байна. Түүгээр зогсохгүй Үндсэн хуулийн шүүх орон сууц түрээслэгчид

<sup>6</sup> Р.Мэдэвнхэфф. Үндсэн хуулийн шүүх улс төр, ердийн шүүхийн тогтолцооны зорилждооний талбарт. Үндсэн хуулийн цэц болон захиргааны хөргийн шүүхийн түүхийн андсам асуудал. Олон улсын хуралд тавьсан штагэл. УБ, 2004 он

өмчлөгчтэй адил эрх эдлүүлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэт өргөн утгаар тайлбарласны улмаас иргэний болон эрүүгийн эрх зүйгээр зохицуулагдсан нэр торгоо хамгаалах эрхийн ач холбогдлыг бууруулсан, тус шүүхийн шүүгчид өөрсдөө дагаж мөрдөх ёстой срийн хуулиудын заалтуудыг үл ойшоосон зэрэг гомдол тасрахгүй байна. Юм бүрийг хэт нарийвчлан үзэх явдлыг шүтдэгэрээ Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа бүхнийг заагч халамжит төрийн арга барилыг эрхэмлэсэн Их Фридрих хааны засаглалыг санагдуулам “дээд зиндааны эрхэмсэг шүүгчдийн эрх зүйн ноёрхол”-той адилтгах боллоо.<sup>7</sup>

Ийнхүү үндсэн хуулийн шүүх үнэн хэрэгтээ хууль тогтоогчийн дурд орлон тоглох байдалд шилжкив. Өөр нэг жишээ гэвэл, Европын Холбооны дээд шүүхийг иэрлэж болно. Ардчилсан зарчмаар олгогдсон бүрэн эрхгүй уг шүүх улс орнуудын эрх мэдлийг Европын холбооны түвшинд өөртөө бүрмөсөн шилжүүлэн авсан билээ. Ингэснээр хүний эрх, эрх чөлөө, ардчиллын хувьд иżн чухал шийдвэрүүд улам бүр парламентаас гадуур шийдвэрлэгдэх болов.

2. Ардчиллын үржил шимт хорс болсон иргэд нийгмийг бүхэлд нь хамарсан асуудлуудыг шийдвэрлэдэг улс төрийн салбарыг сонирхохоо больсноос болж ардчиллын чанар суларч байна. Дэлхий дахинаа улс төрийн намуудын гишүүдийн тоо эрс цоорч байгаагаас үүнийг харж болно. Ардчилал амжилттай байхын гол хорс суурь нь улс төрийн идэвхтэй иргэд, олон түмэн юм. Тэд нийгмийн амин чухал асуудлуудаар улс төрийн хэлэлцүүлэг орнуулж өөрсдийн төлөөдлөө парламентад оруулах замаар ардчилал хэрэгждэг. Гэтэл ийм иргэдийн тоо улам бүр цоорч тэдний оронд засгийн газарт үйлчилдэг хэвлэл мэдээлийн

<sup>7</sup> Дитрак Маго. Эрх зүй, улс төрний хөөрөндын харицааны Үндсэн хуулийн шүүхийн эзлэх байр суурь. Үндсэн хуулийн шүүх, парламент хөөрөндын харицааны эрх зүйн базон ёс зүйн гидэс. Симпозиум. УБ. 1998. 70-71 дэх тал.

хэрэгслээр халхлагдсан "албан ёсны байр суурь" гэгч зүйл гарч ирэх болов.

3. Гуравдагч сртонийн орнуудад дарангуйллын тогтолцоо урьдын адил төрөл бүрийн хэлбэртэйгээр (хаант засаг, теократ засаг, еронхийлогчийн дарангуйлалт засаг, цэргийн дарангуйлалт зэрэг) оршин тогтиносор байна. Барууны ардчилсан орнууд ёөрт нь ашигтай л байвал тэдгээр дарангуйлалт засагтай улс орнуудтай дуртайяа хамтран ажиллаж байна. Гагцхүү АНУ-д таалагдахгүй бодлого баримталж байвал дарангуйллын эсрэг тэмцэж байна. Ардчиллын бас нэг шинэ тоглоомын хэлбэр болох "ардчилсан авлигажсан орнууд" гэсэн шошготой улс орнуудын тоо нэмэгдэх болов. Эдгээр улс орнуудад ардчилсан сонгуулиар эрх мэдэлд хүрсэн улс төрийн нам нь эрх мэдлээ дуулиант авлигын хэрэг үйлдвэрэд ашигладаг бөгөөд дараагийн сонгуулиар сөрөг хүчиний нам гарч ирсэн ч авлигатай тэмцэхийн ороонд мөн л ѡөрсдийн явцуу эрх ашгаас салж чадахгүй байна.

## II. Иргэд шинэ засаглалыг хүлээн зөвшөөрөх асуудал

1. Улс төрийн онол эдгээр үйл явдлыг ардчиллын шинэ хэлбэр төдийгөөр тайлбарлах нь цөөнгүй ("олон түвшинт ардчилал" зэрэг). Гэвч болж буй үйл явдлуудыг анхааралтай ажиглавал ардчиллын эрх мэдэл олгох үүрэг нээрхий доройтож, ард түмний төлөөлөл болсон парламентын бүрэн эрхт байдал бусад институцад шилжиж буй шинж тэмдэг нээрч байна. Санал асуултын үр дүнг харвал улс төрчдийн нэр хүнд урьд омнө байгаагүйгээр доод түвшинд хүрэв. Зарим судалгаагаар хөрөнгө оруулалтын банкирийн нэр хүнцээс ч доогуурт бичигдэх түвшинд хүрсэн байна.

2. Хамгийн сонирхолтой нь "ардчилсан авлигажсан орнууд" гэж иэрлэгдсэн улс орнуудад ардчилал доройтож байгааг иргэд нь ил тод шүүмжилж, эсэргүүцж, түүнтэй тууштай тэмдэг байхад

барууны орууудад ямар нэг эсэргүүцэл огт гарахгүй байгаа нь хачирхалтай. Эрх мэдлийн хамрал нь нийгэмд эмх замбараагүй байдал бий болгож, засаглалын институцуудыг томоохон оорчлолтод оруулах ёстой. Гэтэл тэгсэнгүй. Гүйцэтгэх засаглалын хэрэгжүүлж ирсн төрийн эрх мэдэл зарим нэг багахан оорчлолтийг эс тооцвол хэвээр байсаар байна. Иргэдээс хол хөндий, ардчилсан үндэс суурь муутай Европын Холбоог олон талаас шүүмжилж муулдаг боловч Засгийн газруудын төлоологч, бюрократуудаас бүрдсэн "Брюсселийн засаглалын" эсрэг шийдвэртэй тэмцж байгаа хэн ч алга. Үүгээс харвал орчин үеийн аж үйлдвэржсэн орууудын төрийн засаглалд бидний бодож байсан хэмжээний ардчилсан эрх мэдэл шаардлагагүй бололтой. Үүний хажуугаар дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд Герман орон эд материалын болон оюун санааны хувьд бүрэн сүйрсний улмаас ил тод эх оронч үзэл устан үгүй болсон, энэхүү эх оронч үзэл устах үзэгдэл хоёр Герман нэгдээнээр зогссон гэхээсээ илүүтэй улам хүчээ авсан нь зөвхөн Германы гэх онцлогтой оор нэг хөгжлийн шугамыг бий болгосон нь улс төрийн асуудалд эвлэрэнгүй хандах үзэл юм. Үүгээ гадна цаг уурын оорчлолт, санхүүгийн хамрал зэрэг дэлхий нийтийг хамарсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэж үздэг, улс төрийн хүрээнийхнийг парламентын ардчиллын үзэл санааг устгагчид гэж үзэх хандлага түгээмэл болов. Учир нь сорог хүчин нь хуучин засгийн газрын баримталж байсан бодлогоос оор бодлого санал болгож чаддагтүй, улс төрийн оор оор намууд оор оор сонголтыг санал болгодогтүйтэй холбоотой.

3. Орчин үеийн аж үйлдвэржсэн оруууд засаглалыг өмнөх үеийнхэнтэй харьцуулбал бүтиэл сууринж хэрэгжүүлдэг. Үүнийг Макс Вебер бюрократ засаглал гэж тодорхойлсон байдаг<sup>8</sup>. Өөроор хэлбэл төрийн эрх мэдлийн үйл ажиллагааг хуулиар зохицууллагдсан захиргааны байгууллагууд хэрэгжүүлдэг. Аих

<sup>8</sup> *Wirtschaft und Gesellschaft*, Ausgabe. Mohr-Verlag 1972, S. 124 ff.

ардчилсан хууль тогтоогч нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагавандаз мөрдлөгө болгох эрх зүйн хэм хэмжсөг батлах замаар тэднийг хянахыг эрмэлзэн. Улмаар захиргаа нь ардчилсан эрх мэдэл бүхий хууль тогтоогчийн улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй болж ирэв. Гэвч цаг хугацаа онгорех тусам парламентийн ардчилсан эрх мэдэл хумигдаж захиргааны дангаар ноёрхох засаглалд шилжиж, аажмаар захиргаа парламентийг оөрийн төловлөгөөг хэрэгжүүлж, хэрэгцэг хангахад тусладаг арга хэрэгсэл мэтээр ойлгох болов. Энэ хандлага Европын холбоонд маш тод ажиглагдаж байна. Энд эрх зүйн шинэ зохицуулалт оруулж ирэх санаачлагыг гагшүү Европын Холбооны комисс болон гишүүн орнуудын Засгийн газруудаас бүрдсэн Европын зөвлөл санаачлах эрхтэй байдаг ба Европын парламент оороо бие дааж хууль санаачлах эрхгүй. Парламентын ардчиллын үржил шимт хөрс болсон иргэд олон нийт нь хараахан нэгдмэл биш тул Европын парламентын давуу эрх хэрэгжиж чадлагтгүй.

4. Олон нийт засаглалын энхүү хэлбэрийг хэрхэн хүлээн зөвшөөрч байгааг тайлбарлахад *Макс Вебер*-ийн онол билэнд тусална. Түүний онолоор бюрократ засаглал нь эрх зүйн дагуу хэрэгжиж буй хууль ёсны засаглал аж. Захиргааны үйл ажиллагаа нь эрх зүйд тулгуурласан тул уг засаглал нь оновчтой, ил тод, удирдаж болох, хязгаарлаж болох засаглал гэж тэр бичсэн. Ардчилсан эрх зүйт төрд хөндөж үл болох үндсэн эрхийн тусламжтайгаар энхүү заагийг тогтоодог. Бие даасан хараат бус шүүх уг зааг мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт тавьдаг. Энхүү баталгаа нь захиргааны аппаратын мэргэжлийн ур чадварт найдах найдлагасаас гадна ардчилсан эрх зүйт төр дэхь бюрократ засаглалын байр суурь түүнд захирагдаж буй иргэлэл хулзэн зөвшөөрөгдох явдал юм. Хэрэв захиргааны аппарат иргэдийн үндсэн хэрэгцэг хангаж, төрөөс хүлээх хүлээлтийг нь хангаж

чадах аваас, чингэхдээ эрх зүйт ёсны зарчимд суурилсан хүрээ хязгаарыг зөрчихгүй байх аваас заавал ардчилсан зарчмаар эрх хэмжээгээ олж авсан торийн эрх барих дээд байгууллага болох парламентыг царайчлахгүйгээр оортой шаарлагатай эрх мэдлийг оорео бий болгож чадах юм (**Output-Legitimation** гэдэг). Бюрократ засаглалын оортой эрх мэдэл бий болгох энхүү чадварын нэг илэрхийлэл нь ялангуяа барууны оруулад шүүх эрх мэдэл ард түмний дунд ихээхэн нэр хүнд өндөртэй байдаг явдал юм. Тиймдээ ч Холбооны Үндсэн хуулийн шүүх Бундестагаас ч илүү өндөр нэр хүндтэй байдаг. Энэ жишээн дээрээс ардчилсан зарчмаар хүсэл зорилгоо нэгтгэх процессоос илүүтэй ардчилсан эрх зүйт төрийн институцууд нэр хүндтэй байна. Эдгэр институцууд орчин үеийн аж үйлдвэржсэн оруулад оорео оорсдийнхөө засаглалыг хүлээн зөвшөөрүүлж чаджээ.

5. Ердийн иргэний хувьд хууль дээдэлдэг төртэй байх нь эрх мэдлийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангахаас хавыгүй ишүү чухал байдаг. Учир нь парламентын сонгуульд санал огех замаар эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох нь намын гишүүнчлэлээрээ дамжуулж улс төрийн карьер хийж эрх мэдэлд хүрч улс төрийн зорилгоо хэрэгжүүлэх боломжтой харьцуулбал статистикийн хувьд маш өчүүхэн байдаг. Оороор хэлбэл гагцхүү санал огех эрхдээ найдах нь тухайн хүний хувьд хангалтгүй байдаг. Харин өдөр тутмынх нь амьдралыг зохицуулж байдаг эрх зүйт төрийн бүтэц иргэн хүнд ишүү чухал байдаг.

### **III. Эрх зүйт ёсны бүрдэл, түүнийг бий болгох, хамгаалахын ач холбогдол, учирч буй аюул занал**

1. Эрх зүйт ёс хэрэгжсэнээр иргэн, төрийн байгуулзага, албан тушаалтан хуульд захирагдаж, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж, хараат бус, шударга шүүх төловших

үндэс бүрдэнэ.<sup>9</sup> Учир нь эрх зүйн үзэл санаа эрх чөлөөнд оршидог. Иймд эрх чөлөөнд суурилсан нийгэм бүр зайлшгүй эрх зүйт ёсыг шаарддаг. Учир нь эрх чөлөөнд суурилаагүй дэг журам дарангуйлалд хөтөлдөг, дэг журамгүй эрх чөлөө дур зоргыг бий болгодог. Тийм учраас эрх чөлөөт орнуудад засаг төр нь үйл ажиллагаанд даа эрх зүйт ёсыг түүштэй хэрэгжүүлдэг бөгөөд эн нь эзэрхэх засаг бүхий улс орнуудаас тэдгээр орны ялгарах гол онцлог гэж хэмж болно. Үүнийг иш үндэс болговол, Үндсэн хуулийн хөгжлийг эрх зүйт ёсны үүдлийс судалж, тайлбарлах хандлагага одгөө дэлхий дахинаа тэргүүлэх чиглэл болов. Ногоотэйгүүр эрх зүйт ёсыг үндсэн хуульт ёсны зарчим болохын хувь нь тайлбарлахдаа төрийн эрх мэдлийг хуваарилж, түүний дур зоргыг хязгаарлах асуудлыг иш тэргүүнд авч үздэг<sup>10</sup> нь үүнтэй салшгүй холбоотой юм.

2. Эрх зүйт ёс гэдэг нь төрийн эрх мэдлийн байгууллагууд хуульд захирагддаг байж, ийнхүү захируулахад чиглэгдсэн иргэдийн шаардлагыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүүц хэмжээний институц байж иргэдийн шаардлагын дагуу хэрэгжилтийг хангадаг байхыг хэлнэ. Түүний хэрэгжих гол нохцөл нь төрийн институцууд эрх мэдлийн хуулийн хүрээнд хэрэгжүүлэх, тэдгээрт бие даасан, хараат бус шүүх эрх мэдлийн байгууллага хяналт тавьдаг (үүр дүнтэй эрх мэдлийн хуваарилалт), иргэний үүслээ эрхийг хамгаалах механизм бүрдсэн байх, эрх зүйн зохицуулалт тодорхой байх, ирээдүйд эрх зүйн харищаа тогтвортой байх (эрх зүйн найдвартай байх зарчим) юм. Эдгэр нохцлууд хангагдсанар иргэд ирээдүйн хийх алхамаа тухайн

<sup>9</sup> Vicki C. Jackson, Mark Tushnet, *Comparative Constitutional Law (2nd edition)*, Foundation Press, 2006, p 243.

Хоёрдугаарт урамшууллын хэм хэмжээ нь хүрэх үр дүндээс нийцж тохирсон байх

Гуравдугаарт эрх зүйн урамшууллын үндэслэл нь оновчтой, эрх зүйг хэрэглэгч байгууллагуудын тэдгээрийг (урамшууллын зохицуулалтыг) хэрэгжүүлэх хугацаа тодорхой байх, дерэвдүгээрт, зохицуулалтын томъёоллын хэлитгээ ойлгомжтой, оновчтой, таамаглал болон диспозиц санкцууд товч тодорхой байх, тавдугаарт, захирагдагсдын (үялдуулагчдын) үнэжэлэлгүйгээр эсхүл цаг үеэ олоогүй, бүрэн бус урамшууллын толоо эрх бүхий албан тушаалтанц хүлээлгэх хариулагыг тодорхойлсон байх, зургаад, урамшууллын зохицуулалт хууль бус байвал түүнийг солих, өөрчлох, халах боломж тусгагдсан байх.

Оросын хийгээд олон улсын эрх зүй дэх (хууль зүй дэх) урамшууллын дэг журмыг боловсронгуй болгоход чиглэсэн дээр дурдсан зөвлөмжүүд нь орчин үеийн ийнхүм дэх хэрэгжээт асуудалд эрх зүйн урамшууллын үзүүлэх ногоонийг ицэвхижүүлэх ач холбогдолтой болно.

# ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ТҮҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ОНОЛ АРГА ЗҮЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

*P.Оюунбадам  
Шихихутуг Их сургуулийн багийн  
гавьяат хуульч, доктор /Ph.D/*

## **Нэг. Ялны зорилгын шинчлэлтийн асуудал:**

2002 оны Эрүүгийн хуулыд эрүүгийн хариушлагын зорилгыг иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хөргийн улмаас зорчигдсон эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж хуульчилсан. Харин 2015 оны Эрүүгийн энэхүү суурь зорилтууд дээр гэмт хэрэг үйлдсэн хүнийг шийтгэж цээрлүүлэхээс гадна нийгэмшиүүлэх зорилгыг давхар агуулснаараа ач холбогдолтой. Мен ял тэнссэн, эсхүл хориоос өөр төрлийн ял шийтгүүлэсн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүргийг хүлээнэж, эрхийн хязгаарлалтыг давхардуулан тогтоож болохоор заасан. Тухайлбал, гэмт хөргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, ходолморлох дадал олгох сургалтад хамрагдах, нийтэд тустай тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, сэтгэл заслын, доитох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх, оршин суух газар, ажил, сургуулиа борчлох, зорчин явахдаа хяналт тавыж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэгт омчлох, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох эзргээр заасан.<sup>1</sup>

2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилтээс хараад Монгол улсын эрүүгийн хариушлагын тогтолцоонд хорих ял дийлэнх хувийг эзэлдэг. Шүүхийн шүүн таслах ажиллагааны иөгдсэн

<sup>1</sup> Н.Гантуул. Монгол Улсын яриа изээлчидийг майгаануулж ажилласганы тарим асуудал. "Шүүхийн мийдвэр судцажсан судзуулсан тусламжийн УБ", 2015 №10 20 дэхь тал

мэдээгээр нийт ялын дотор хорих ялын эзлэх хувь 60-70%, давтан гэмт хэрэгтэн 49%-тай байна.<sup>2</sup> Энэ нь хорих, баривчлах, цаазаар авах ялыг хавттайруулан оногдуулж байгааг харуулж байна. Иймээс эрүүгийн хуулийг эргэн харах, шинчлэх, бөрчлох нь тулгамдсан шаардлагыг байгааг харуулж байна. Иймд хорих ялын осолтийг бууруулах, широн дүүргэлтийг багасгах асуудлыг шийдвэрлэх арга зам бол алтарнатив шийтгэлийн арга хэмжээ хууль здийн засгийн байдал хоригдлыг суллахад хэрхэн бэлдэх хоригдлын ажил эрхлэлтийн байдал, харуул хамгаалалтын иехцөл байдал ямар байх, хорих байранд хүний эрхийн стандартыг хэрхэн хангах зэрэг олон хүчин зүйлээс хамаарах учиртай.

### **Хоёр. Харьцуулсан судал**

Ял оногдуулалт түүнээс хорих ял оногдуулах үндэслэл нь монгол улсад ийм байdag бол Гадаадын зарим оронд ямар болохыг харьцуулан авч үзлээ.

Гадаад орнуудац ял оногдуулах үндэслэл нь улс орон болгонд улс үндэсний онцлогтой холбоотой ялгаа байх боловч тодийлон хол ялгаатай биш ойролцоо байдал. Энэхүү илтгэлийн хүрээнд дараах хэд хэдэн улс орны ял оногдуулалтыг авч үзлээ.

**Герман улсад:** Германы эрүүгийн хууль тогтоомжоор ял хэрэглэх асуудал томоохон байр суурь эзлэдэг. Энэ нь ял оногдуулах шийдвэр гарах үесээ эхлээд ялаас чөлөөлох, ял тэнсэн болон ялыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх иехцөл байдлыг шийдвэрлэхтэй холбогдсон цогц үйл ажиллагаа болдог. Хорих ял нь торлийн хувьд: хугацаатай хорих ял, бүх насаар нь хорих ял гэсэн төролтэй. Хорих ялыг 1 жил хүртэл хорих ял, 1-15 жил хүртэл хорих ял гэж ялган үздэг.

Англи улсад ялын онолын 3 үндэслэлийг дэвшүүлсэн байдал.

- ✓ Ял бол бусдад гэм хохирол, аюул учруулсны иехон төлөөс
- ✓ Ял бол зэрлэг балмад, худалч, хулгайч, танхай этгээдийн омгийг дарах, айлгах, залхаах хэрэгсэл
- ✓ Ял бол гэмт хэрэгтнийг засан төловшүүлэх хэрэгсэл гэж үздэг.

<sup>2</sup> НИНГЕГ. 2015 оны эхийн түүхийн таблаагас

Америкийн эрх зүйн онолд ялны шинж, зорилгыг 4 үндсэн хэсэгт авч үзсэн байdag.

- ✓ Нохон толуулэх, гэмийг хариулах
- ✓ Залхаан, цээрлүүлэх
- ✓ Гэмт хэрэг үйлдэх боломжийг хаах, таслан зогсоох
- ✓ Засан төловшиүүлэх, зан төловийг засан баарчлох

Англи-Америкийн эрх зүйн ихэвх орнуудын эрүүгийн эрх зүйд ялны гол зорилгыг гэмт хэрэгтнийг ийгмээс тусгаарлан, цээрлүүлэх, зорчигдсон эрх ашиг сонирхлыг нохон сэргээлгэх явдлыг хангах, засрал төловшиийг ойлгоход түлхэц үзүүлэх, гэмт хэргийг дахин үйлцэхгүй байх нөхчлийг бий болгох, хувь хүн, орх гэр, улс, ийгмийг гэмт хэргийн хадллагаас хамгаалах гэх мэтээр тодорхойлсон байdag.

Эх газрын эрх зүйн системийн орнуудын ялны зорилгыг үйлдээн гэмт хэрэгт нь тохирсон шийтгэлийг /цэрэлэл/ шударгаар оногдуулах, учирсан хорихол, үр дагаврыг гэмт этгээдээр нохон гаргуулах, гэмт этгээдийг засч, төловшиүүлэх, дахин ийгэмшүүлэх, гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зэргийг хамааруулж үздэг.<sup>3</sup>

#### **Гурав. Шинэчлэн найруулсан эрүүгийн хууль болон УИХ-ын тогтоол**

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд "Эрүүгийн хариуцлага" хэмээх хууль зүйн ойлголтыг "Ял, албадлагын арга хэмжээ" болгон тодорхойлж, уламжлалт "Хорих", "Торгох" ялаас гадна "Нийтэд тустай ажил хийлгэх", "Зорчих эрхийг хязгаарлах", "Эрх хасах" зэрэг ялны торлийг шинээр иżмээн. Мөн хуулийн этгээдэд ял оногдуулах гэсэн бүлэг шинээр иżмж, "мөнгө угаах", "байгаль орчинд хохирол учруулах", "терроризмыг санхүүжүүлэх" зэрэг тодорхой торлийн гэмт хэрэгт хуулийн этгээд буюу компани баарийнхое хөрөнгөөр хариуцлага хүлээдэг байх, түүнд торгох, эрх хасах, татан буулгах ял оногдуулахаар тусгайлан хуульчилж.

<sup>3</sup> Доктор Ph.D. Д.Баяршилан Харцаасан эрүүгийн эрхийн 2012 он 167-176

2015 онд боловсруулсан батлуулсан эрүүгийн шинэ хууль гэмт хэрэг үйлдсэн хүнд доор дурдсан ял оногдуулахаар заасан:

- ✓ торгох ял;
- ✓ нийтэд тустай ажил хийлгэх ял;
- ✓ зорчих эрхийг хязгаарлах ял;
- ✓ хорих ял;
- ✓ эрх хасах ял гэж хориход ос оор торлийн ялыг нэмэгдүүлж баривчлах, цаазаар авах ялыг ялны төрлөөс хассан юм.

Түүничлэн Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах”, “ялны бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголтой болгох” зорилтыг дэвшүүлсэн богоод Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор “Хорих аngийн төрөл, дэглэмийг нэмэлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хотолбөр”-ийг баталсан юм. Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийг баталж, ялны төрлийг торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах гэж шинээр тодорхойлж, хорих ялыг нэмэлттэй, хаалттай хорих байгууллагад, өсвөр насын хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эзлүүлэх, хуулийн этгээдэд ял оногдуулахаар тусгасныг харгалзан эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоол гүйцэтгэх ажиллагааг тухайн ялны онцлогт тохируулсан хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлыг шинээр хуульчилсан байна.<sup>4</sup>

Илтгэлийн хүрээнд ялны тогтолцоо хорих болон хориход ос оор торлийн ялыг хэрхэн хэрэгжүүлэх, ял эзлүүлэх байгууллагын төрөл, дэглэмийн эрх зүйн зохицуулалтын шинэчлэлтийн асуудлыг авч үзэхийг зорьсон болно.

<sup>4</sup> Хууль түүнчлэлийн стратеги /2009-2021/. УК 2009.38 дэхь нийз.

## **Хаалттай хорих газрын аюулгүй байдал**

Оргох магадлал ондоргамт хэргтийүүд онц аюулгтай ялтан байна. Тиймээс тус хорих анги нь ондоржүүлэсэн хяналттай байна. Ердийн хорих ангиуд энэ хэсгийг тусгаарласан байх бөгөөд хараа хяналтыг ондоржүүлэсн байх богоод ажиллах амьдрах байр нь бүгд тусгаарлагдсан байна. Гадна хэсгийн харуул хамгаалалт: орчны талбайг албан хаагч хугацаатай зргж тойрио. Торон болон хэрэмэн хананд тулах хяналтыг телекамер мөн гэрэлтүүлж болон нохойтой албан хаагч хийнз.

- Хаалттай хорихын хэрмэн хана нь 6-8 метрийн ондортой бетоноор хийгдсэн, авирах хамгаалалттай байна. Тус ханыг электрон хяналтын систем байрлуулах бөгөөд өргөст тор байх шаардлагагүй. Орох, гарах гарц нь шалган нэвтрүүлэх хэсэг харагдахаар мөн төв хяналтын байранд харагдахаар байна. Тус гарц нь хоёр талдаа тусдаа харагддаг хаалгатай байх бөгөөд тээврийн хэрэгслэл болон хүмүүсийг тус тусад нь нэвтрүүлдэг байна. Дотор талбай нь хяналтын хамгаалалтын дунд хэсэг байх бөгөөд байгууламж болон ханан хэмрийн дундах хэсэг байна. Тус хэсэг нь төв хяналтын байрнаас харагдах боломжтой эзвэл төв хяналтын байртай хяналтын электрон системээр холбогдсон байх богоод видео, гэрлэн түяаны дохиололтой мөн албан хаагч хяналт тавьж болохуйц замтай байна.

### **Далоо. Харьцуулсан судлал**

#### **АНУ-ын Колорада мужид**

Доод түвшинд Аюулгүй байдал хангай засах сайжруулах байгууллага нь нээлттэй дэглэмтэй бөгөөд хоригдлын өөрийнх нь мэргэжлээр зам барилга, ходоо аж ахуйн салбарт ажилтуулдаг байна.

Дунд түвшинд Аюулгүй байдал хангах засан сайжруулах байгууллага нь хаалттай дэглэмтэй цэргэжүүлэсн хамгаалалттай байдаг.

Дээд тувшинд Аюулгүй байдал хангах prison широн, гяндан нь чанга дэглэмтэй, хаалттай байдаг.

Нээлттэй дэглэм нь Ял эдлэж байгаа хоригдлууд илүү эрх чөлөөтэй хоригдож байгаа байрлаасаа гадуур гарч ажил эрхлэх боломжийн байдаг ба орой нь эргэж ириз.

Онцгой тувшинд Онцгой дэглэмтэй хаалттай, цэрэгжүүлсэн хамгаалалттай байна. Энд бүх насаараа хорих ял эдлэгчид гэх мэт илээд аюултай гэмт хэрэгтийнүүдийг хорьдог байна.

АНУ-ын Луизиана, Алабама, Миссисипи зэрэг омниод мужийн засан сайжруулах болон хэд хэдэн гянданд түр баривчлагдсан, шүүхээс ял ногдуулах хугацаа хүлээсэн гэх мэт бас янз бүрийн хугацаатай хүмүүсийг хорьдог. Энэ нь шүүхээр ял оногдуулсан зарим хэрэгтийнүүд тов гянданд ирээд ял эдлэх хугацаандаа, дахин шинээр мэдүүлэг өгч, шүүхээр дахин хэрэгээ хянуулах боломж олгодог зохицуулалт байдаг.

**ХБНГУ-д** хорих ял эдлүүлэх дэглэм нь ирэлттэй, хаалттай 2 дэглэмтэй. Нээлттэй хорих газар 6 сар хүртэл хугацаатай хорих ялтай хүмүүс байдаг. Фөреөөр хэлбэр богино хугацааны ялтай хүмүүс байдаг бол хаалттай хорих газар нь Герман улсын ял эдлүүлэх байгууллагын үндэсн торол гэж үздэг. Хамгаалалт нь хатуу чанга журамтай байдаг байна.

**Англи улс:** Хорих ялны дэглэмийг ирэлттэй, хаалттай гэж ангилан ял эдлүүлдэг.

Ирэлттэй дэглэмд: Ял эдлэгчдийг засралаар нь ангилан ажил хийлгэдэг. Хорих ял эдлэж байгаа хоригдлууд илүү эрх чөлөөтэй, байрнаасаа гадуур гарч ажил эрхлэх боломжтой байдаг ба орой нь эргэж ирдэг.

Хаалттай дэглэмд: Харуул хамгаалалттай дэглэмийн хувьд хатуу чанга байна.

Англо-Саксоны болон Ром-Германы эрх зүйн системтэй улс орнууд ихэнхдээ ирэлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлдэг боловч өөр хоорондоо зарчмын ялгаатай байна.

**Хорих ангийн ирэлттэй хэлбэр нь**

- Гэртээ харихад болитэх \ furlough and Hafturlaub \

- Богино хугацааны хорих хэлбэр \Ausgang\
- Ажил хөдөлмөр эрхлэх дэглэм \Freigang \ гэсэн ялгаатай дэглэмтэй.

Гэртээ харихад бэлгэх дэглэм нь хуанлийн 21 одрийн омноос, богино хугацааны хорих хэлбэр нь хорих байгууллагаас гадуур өдөрт хэдэн цаг ажил эрхлэх боломж олгодог.

Харин ажил хөдөлмөр эрхлэх дэглэм нь хорих ангийн хяналгаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг 'кард 500 дойч марк'. Энэ хэлбэр нэгээд түгээмэл бөгөөд германы нийт хорих ангийн 60% нь ийм нехцелтгэй байна.

ХБНГУ, Польш, Чех, Эстони, Латви зэрэг Европын холбооны гишүүн орнуудын ял залуулэх тогтолцооны шинэчлэгээс судалж үзвэл хорих ял залуулэх дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх замаар хорих ялны үр нөлеөг дээшилүүлэх асуудлыг оновчтой шийдвэрлэж байна. Дээрхи улс орнуудад хэрэгжиж буй хорих ангийн нээлттэй болон хаалттай дэглэмийн гол агуулга нь ялтыг сургах, байнгын тасралтгүй ажлын байраар хангах, ял залуулэх орчин иөхцлийг хүний эрхийг хангасан стандартын дагуу бүрдүүлэх зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэж, хорих ял залж буй хүмүүсийг шийгэмшүүлэхэд чиглэгддэг<sup>15</sup> байна.

### Швейцари улсад

Дүүргийн, орон нутгийн, захиргааны, төвлөрсон хорих газар гэж ангилдаг. Тэнд богино хугацаатай ялтыг нээлттэй, хагас нээлттэй гэсэн 2 төрлийн дэглэмд ял залуулдаг.

### Нээлттэй, хагас нээлттэй хорих газрын хамгаалалт нь

Хамгаалалтын байдал гадна талын аюулгүй байдлын хэсэг, тороон хашаа, хэмрэн хашаа, дотор талбай, орох гарах хаалга, гарын-2, барилга болон хананы мэдрэгч, талбайн урд хэсэг нь үечлэн буюу эргэж тойрон хянаж байна. Гарын ирг дзор тээврийн хэрэгсэл

<sup>15</sup> Vancouver Canada 2004.11 ICPA. 26<sup>th</sup> Conference Paper

болон иргэн зөвшөөрлөөр нэвтрэхээс. Торон хашаа болон ханан хэрэм нь хорих ангийн нийт талбайг тусгаарлана.

### **Хаалттай хорих газрын аюулгүй байдал**

Оргох магадлал ондор гэмт хэрэгтийүүд оиц аюултай ялтан байна. Тиймээс тус хорих анги нь ондоржүүлсэн хяналттай байна. Ердийн хорих ангиуд энэ хэсгийг тусгаарласан байх бөгөөд хараа хяналтыг ондоржүүлсэн байх болоод ажиллах амьдрах байр нь бүгд тусгаарлагдсан байна. Гадна хэсгийн харуул хамгаалалт: орчны талбайг албан хаагч хугацаатай эргж тойирно. Торон болон хэрмэн хананд тулах хяналтыг телекамер мөн гэрэлтүүлэг болон нохойтой албан хаагч хийнэ.

### **Дүгнэлт**

1. 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжэлтээс харахад Монгол улсын эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хорих ял дийлэнх хувийг эзлж байна. Тухайлбал шүүхийн шүүн таслах ажиллагааны иэгдсэн мэдээлээр нийт ялын дотор хорих ялын эзлэх хувь 60-70%, давтан гэмт хөрөтэн 49%-тай байна. Энэ нь хорих, баривчлах, цаазаар авах ялыг хавтгайруулан оногдуулж байгааг харуулж байна. Иймээс эрүүгийн хуулийг эргэн харах, шинэчлэх,өөрчлох нь тулгамдсан шаардлагага байгааг харуулж байна. Хорих ялын осолтийг бууруулах, шорон дүүргэлтийг багасгах нь тулгамдсан асуудал болсоор байна.
2. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлснээр ялтны ял эдлэх хугцаанд нь ялтныг гэр бүл, наиз ноход, хамт олныхоо дунд хөдөлморлох, нийгэмтэйгээ харьцах, үр хүүхдээ осгох, гэм буруугаа ухааран хүмүүжих, шоронжих сэтгэлгээнээс хол байх нохцел бүрдэнэ. Хорих ял оногдуулсан ялтаанд тороос зарцуулж буй хөрөнгө, нийгэмшигүүлэх зардал багасна.
3. 2015 онд шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд хорих ялын дэглэмийг нээлттэй хаалттай дэглэмтэй байна гэж хуульчилсан. Шинэ хуулийг мөрдох хугацаа хойшилсон ч 2002 оны эрүүгийн хууль хэвээр үйлчилж байгаа онөө үед хорих

- ялын жир, чанга, онцгой, гэсэн дэглэмүүдийг зайлшгүй вөрчлөх шаардлагатай байна. Учир нь:  
Нэгдүгээрт оноогийн жир, чанга, онцгой дэглэмүүдийн хоорондын ялгаа багассан. Хоёрдугаарт дэлхийн бусад ихэих улс хорих ялны ишлэлтэй хаалттай дэглэмд ишилжсэн.
4. 2002 онд баталсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хоригдлыг бусадтай уулзах, харицах эрх зүйн байдлыг дээрдүүлсэн. Ялангуяа жирийн дэглэмийн ялган бусадтай уулзах захидал илгээмж авах эрх нь хязгаарлалтгүй болсон. Чанга ноцгой дэглэмийн түр ба удаан хугацааны уулзалтын тоо нэмэгдсэн. Энэ бүхэнтэй холбоотойгоор илгээмж авах, захидал бичих, шаардлага байхгүй болсон.
  5. Мөн хорих ангийн хамгаалалтын бүсүүдийн хоорондын ялгаа тун бага болсон. Бүх дэглэмүүдэд хамгаалалтын хэрэгслэл, тоног тохөөрөмж, гадна талын харуул хамгаалалт, хяналт зэрэг үзүүлэлтүүд бүгд адил болж байна.
  6. Сүүлийн жилүүдэд төвлөрсөн хорих ангиудын гадна хамгаалалтын хөрмэн хашааг дэглэмийн ялгаа харгалзахгүйгээр барьж байгуулсан. Энэ нь хорих ангиуд ял элдүүлэх дэглэмийн ялгааг харгалzan тогтоосон хамгаалалтын олон бүс байх шаардлага багассаныг харуулж байна. Эндээс хорих ялны дэглэмүүдийн хоорондын зааг ялгаа багассан болохыг харуулж байна.
  7. Орчин үед ялангуяа жирийн дэглэмд хорих эдлэж байгаа засрал хүмүүжил сайтай зарим хоригдлыг олон нийтээс тусгаарлаж байна гэж үзэхэд эргэлзээгэй болж байна.  
Зарим нохцөлд жирийн дэглэмтэй ялтинууд харуул хамгаалттайгаар олон нийтийн дунд ходолморлож байгаа практик байна.

# **AMENDED CRIMINAL CODE OF MONGOLIA AND ITS CHALLENGES OF IMPLEMENTATION IN CONTEMPORARY CONFLICTS**

The purpose of this speech is to underlie an overview of revised criminal code of Mongolia on issues in regarding to punishment principle, circumstances of incarceration and imprisonment punishment, overview of newly introduced punishment of home detention, process of punishment imposition, authorized legal bodies and prisoner security category classification.

## **1. Issue on amendment of punishment purpose**

Current Criminal Code of Mongolia (2002) defines the purpose of penalty and criminal liability as follows: "to protect citizens and society from criminal interference, restore the infringed rights, punish and educate (upraise) the offenders, and prevent from committing crimes". whereas this article is modified in Criminal Code in 2016 as "Purposes of criminal liability shall be protection of the citizen and society from criminal encroachments, restoration of the rights violated in result of a crime, deterring the persons who committed crime, prevention of crimes and helping inmates back into society ". It can be analyzed it brought up issues prisoner's life after imprisonment. Rehabilitation has been played a big role in the history of imposition of criminal punishment.

In scope of legislation reform of Mongolian government policy on rehabilitations can be emphasized by following distinguishes:

1. Reduce the imprisonment share and duration as raising the duty of non-imprisoning penalty policies.
2. Policy of prison's activity should be guided by "socialize" but "punish", transfer prison institution into open - close regime, to bring prison environment close to international level, to create practical field to let different types of penalties to take place, to bring the activity of convict's socialization into professional level, to encourage prisoners and to focus on effectiveness on punishment system.

Correction facility and decision enforcement service's social work is a professional work to implement social reintegration programs to inmates, develop inmate's ability to participate in social relations, keep them sustainable in social psychology and to develop their behaviors. In

practice, correction facility and decision enforcement service's work is differentiated by the crime committed by the convict's personality, age and gender.

In scope of this speech I have obtained information on other countries of practice imposition of criminal punishment procedures. Even though it is different from country to country but there are significant amount of similarities in imposition of punishment.

### **2. Issue 'Limitation on the right to travel':**

The detention /imprisonment/ is being overwhelming majority of The Criminal liability system since Criminal Law of Mongolia implemented in 2002. According to the unified information data of the court decisions, around 75% of were detention sentences, 10-15 % of were arrest, and 1-5% of were other penalties of all sentences. Totally there is 90% of detention sentences. This evidences that the issuance of sentences to detain, arrest and capital punishment is too common in court practice. Therefore revised criminal code includes the home detention as a criminal punishment. Home detention provides an alternative to imprisonment and aims to reduce re-offending while also coping with expanding prison numbers and increasing costs. It allows eligible offenders maintain family relationships and responsibilities and attend rehabilitative programs that contribute towards addressing the causes of their offending.

### **3. Issue 'Detention regime':**

Following that, I quoted the 193rd act of Government in 2012 approved the program "Transferring prison type and regime into open - close regime system" in my speech. Developed countries such as Germany, in Colorado State of the US, the UK and Switzerland have implemented the practice of open, closed and half-open regimes of the detention. If we take a look from legal regulations and practical acts side: the formulation which has made on the basic attributes of prison sentences necessarily leads to changes and it set purpose to bring the type and regime of imprisonment into the international standard.

**МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТМООЖООС  
ЯЛГАМЖТАЙ МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ  
ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМД ҮНДЭСЛЭН  
ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ**

*Ц.Мандах, /LL.D/*

*Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын  
хурээлэнчийн захираг, хууль түйн ухааны доктор*

**Товчагуулиг**

Энэхүү өгүүлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос ялгамжтай тохиолдолд хэрэглэх хэмжээг, тухайн олон улсын гэрзний үйлчлэл болон шүүхэд шууд хэрэглэгдэх боломжтой эсэх зэрпийг хэрхэн тодорхойлох талаар онолын түвшинд төвч дүн шинэкилгээ хийх замаар Монгол Улс аливаа олон улсын гэрзэнд нэгдэн орох буюу соёрхон батлахдаа дотоодын хууль тогтоомжийг түүнд ийнцүүлж ариг хэмжээ аваагүйгээ үүсэх бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар жишэнд тулгуурлан тайлбарлав. Тодруулбал, хууль тогтоогч олон улсын гэрзэнд нэгдэн орохдоо дотоодын хуулийг түүцүү ийнцүүлээгүйгээ болж зарим тохиолдолд Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хуультай зорчилтгэй хэрэгжих боломжтой байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурал “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн ижмэлт II Протокол”-д нэгдэн орох тухай хуулийг 2012 оны 1 дугээр сарын 5-ны өдөр баталсан. Ингэснээр Монгол Улс цаазаар авах ялгүй орон болсон бөгөөд тус ижмэлт II Протоколд нэгдэн орсноор Монгол Улс олон улсын омни цаазын ялыг бүрмөсон халах үүрэг хүлээсэн боловч тухайн үезд хууль тогтоогч Монгол Улсын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаагүй тул өнөөг хүртэл энэ торлийн ял Монгол Улсын Эрүүгийн хуульд хүчин төгөлдөр хэвээр байна. Иймд тус олон улсын гэрээ болон Эрүүгийн хууль хоорондоо зорчилтгэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжтой зорчилгэй

тохиолдод тухайн олон улсын гэрээг шүүхэд хэрэглэхдээ олон улсын эрх зүйн "Pacta sunt servanda" буюу "гэрээг заавал биелүүлэх зарчим", Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн ийтгээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд тулгуурлан тайлбарлан хэрэглэх замаар залруулах боломжийн талаар энэхүү өгүүлэлтээр хөндөв.<sup>1</sup>

**Түлхүүр үг:** олон улсын гэрээ, гэрээг заавал биелүүлэх зарчим, олон улсын эрх зүйн ийтгээр хүлээн зөвшөөрсон зарчим, олон улсын гэрээг тайлбарлан хэрэглэх

## 1. Олон улсын гэрээний үйлчил, түүнийг соёрхон батлах нь

Олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн систем нь харицсан адилгүй боловч нягт уялдаа холбоотой. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөөний талаарх хэм хэмжээ нь хүний эрхийн талаарх олон улсын баримт бичгийн заалтуудад үндэслэгдсэн байдаг. Олон улсын эрх зүйн нэг онцлог нь эрх зүйн тухай тогтолцоон дахь субъектгүүдийн эрх үүргийг тодорхойлдог. Ногоотгайгуур улс орнууд олон улсын эрх зүйн дагуу үүрэг хүлээхийн сацуу түүнийг үндэсний хэмжээнд буюу дотоодлоо мордох, нутаг дэвсгэрийнхээ хүрээнд биелдлийг нь хангах үүрэгтэй. Үүнийг олон улсын эрх зүйн хэмжээний хэрэгжилт буюу имплементаци гэнэ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн З-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин тогтолцор болмогц дотоодын хууль тоогоомжийн нэгэн адил үйлчилэл" гэж заасныг Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венний конвенцтэй уялцаатай, цогц байдлаар, хамтагтан хэрэглэх учиртай. Монгол Улсын хувьд олон улсын гэрээний эрх зүйн хэм хэмжээ, олон улсын ийтгээр дагаж

<sup>1</sup> Энэхүү өгүүлэл нь эхийнчийн 2015 оны Шүүх эрх мэдээ энхэмжлэл №1 дугаарын ийтгэлэдсэн "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Нактын Цагаанаар авах язгуулзасанд чиглэлийн Нэмэлт II промоколын олон улсын эрх зүйн pacta sunt servanda зарчмын үндэслэл хэрэглэх нь" өгүүлэлийн гол саналд тулгуурлан холбогдох наимзэт судалгаачийн мэдээллийн боломжуулалтадсан болно.

мердөх зарчим, хэм хэмжээ, НҮБ-ын дурэмд заасан зорилго, зарчим заавал биелэгдэх хэм хэмжээ юм.<sup>2</sup> Түүчилэн БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд харшилаагүй БНМАУ-ын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиоддолд мөнхүү олон улсын гарзний заалтыг баримтална” гэж зааснаас харахад Монгол Улсад олон улсын гэрээ давуу хүчин чадалтай болохыг харуулж байна.

Олон улсын хоёр болон олон талт гэрээ байгуулах, биелүүлэх, хяналт тавих, цуцлах, иэдэн орох, гарагтай холбогдсон харилцааг зохицуулдаг 1993 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заавал соёрхон батлах олон улсын гэрээг тусгасан ба 10 дугаар зүйлийн 10.2-т Монгол Улсын хууль тогтоомжийд зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батлахаар заасан байдаг.

Соёрхон батлах гэж олон улсын гэрээг төрийн эрх барих дээд байгууллагаар батлагжлахыг хэлнэ. Соёрхон батлах нь төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр учраас тухайн улсын төрийн бүх шатны байгууллагын хувьд гэрээг заавал биелүүлж зөвшөөрлийг илэрхийлж байгаа хамгийн изр хүнд бүхий хэлбэр мөн юм.<sup>3</sup> Түүчилэн Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 15-д “Улсын Их Хурал Засгийн газрын оргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх”-ээр заасан, Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 болон Хорин тавдугаар зүйлийн 15-ын залт нь соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн изгэн адил хүчинтэй болохыг

<sup>2</sup> Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дээдэрэмжүй тайзбар, Узамбаатар хот, 2011 он, 7 дахь тал

<sup>3</sup> Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дээдэрэмжүй тайзбар, Узамбаатар хот, 2011 он, 16 дахь тал

нотолсон, тэдгээрийг торийн бүх шатны байгууллага дагаж мөрдөх үүрэгтэй болохыг хуульчилсан заалт юм.

Харин олон улсын гэрээний томъёоллын хувьд, Олон улсын гэрээний тухай хуулийн З дугаар зүйлийн 1-д “Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын иж буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлоян тоогоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиrolноог хэлнэ” гэж тодорхойлжээ. Олон улсын гэрээ нь гэрээ, хэлэлчээр, тунхаглал, пакт, контракт, конвенц, протокол зэрэг нэр, хэлбэртэй байж болни.<sup>4</sup>

## **2. Монгол Улсын иэгдэи орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос ялгамжтай тохиолдолд хэрэглэх хэм хэмжээг тодорхойлох нь**

Олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжэог хэрэгжүүлэх 2 төрлийн арга зам байдаг. Энэ нь олон улсын гэрээнд иэгдэж орсноор түүнийг шууд дагаж мөрдөх эсхул олон улсын гэрээнд иэгдэж орсноор түүний заалтуудыг дотоодынхао хууль тогтоомжийн тусгах явдал юм. Олон улсын эрх зүй болон дотоодын хууль тогтоомжийн талаар хоёр онол байдаг. Эдгээр нь монист онол буюу дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь иэгдмэл шинжтэй, дуалист онол буюу дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь бие даасан шинжтэй бөгөөд тус тусдаа хотжине. Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн заалтын үзэл санаа нь монист онолд илүү нийцж байгаа бөгөөд дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь иэгдмэл шинжтэй юм. Хэдийгээр Монгол Улсын хувьд дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь иэгдмэл шинжтэй хэдий ч олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй

<sup>4</sup> Монгол Улсын Хууль зүйн нам, “Монгол Улсын Үндсэн хуулийн иэр тэмьёоны дагавар”, Улаанбаатар хот, 1993 он, 25 дахь тал.

байсаар байна. Энэ нохцөл байцлыг харгалзан, 2008 оны 2 дугаар сарын 28-ны одор Монгол Улсын дээд шүүх олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн ўйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоол гарсан.

Тус тогтоолд, “шүүх эрүүгийн хэрэг, иргэний болон захирагааны эрх зүйн маргзаныг хянан шийдвэрлэхдээ хүчин тогтолдор болсноор заавал даган мөрдөх шинийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид измэлт, оөрчлөлт оруулахыг шаардсан заалттай, Үндсэн хуулыд харшилаагүй, үндэхний эрх зүйн хариулсаны оролцогч эзтээлүүлэл шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэн” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин тогтолдор болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилээ” гэж заасан нь олон улсын гэрээ, конвенци олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болох хэдий ч Монгол Улсын шүүхийн практикт олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцыг хэрэглэдэг жишиг тогтоогүй ба шүүхийн практикт дотоодын эрх зүйг оргоноөр хэрэглэдэг тул, дотоодын эрх зүй нь хүний эрхийн гол гэрээ, конвенцуудын үзэл санаатай уялдахгүй, зөрчилдөх зэрэг асуудал нь эрх зүйн захирагдах ёсны гол асуудал болоод байна. Иймээс Монгол Улс нь эрх зүйд захирагдах ёсыг Монгол Улсад толовшүүлэх, мөрдүүлэхийн тулд нэн тэргүүнд хийх чухал алхам бол одоогийн мөрдэж буй хууль тогтоомжуудаа олон улсын гэрээ конвенци, тэр дундаа олон улсын хүний эрхийн гол гэрээ конвенцуудын

зарчмуудтай хэр нийцэж байгааг нь дүгнэн шинжилж, шүүгч шийдвэр гаргах ажиллагаандыа эдгээр гэрээ конвенцуудыг хэрэглэдэг, үзм санаанд нь тулгуурлан хэргийг шийдвэрлэдэг шүүхийн практик тоогоо, улмаар аль ч шатандаа эрх зүйд захирагдах ёсны гол амин сүнс болсон хүний эрхийг дээдэлж, хамгаалдаг болох явдал юм.<sup>5</sup>

### 3. Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтын дагуу олон улсын гэрээг хэрэглэх боломж

Монгол Улсад одоо мөрдөгдж байгаа ихэнх хуульд Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хууль тоогоомжоос давуу хүчин чадалтай гэж тусгагдсан байдаг. Тухайлбал, Иргэний хуулийн 539 дүгээр зүйлийн 539.2.-т Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын Иргэний хуульд зааснаас өөрөөр заасан богоод энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтад харшилаагүй бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдено гэж заасан. Харин Эрүүгийн хууль нь өөрөө онцлогтой богоод Монгол Улсын иэгдэн орсон олон улсын гэрээнд Эрүүгийн хуульд зааснаас өөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг бусад Монгол Улсын ихэнх хуулийн адил шууд хэрэглэх боломжгүй юм.

Монгол Улсын одоо үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 2.2-т “Эрүүгийн хууль тоогоомж нь энэ хуулиас бүрдэн” гэж заасан ба мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 болон 13 дугаар зүйлийн 13.1-ээс харахад эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, ял онооход зөвхөн Эрүүгийн хуулийг хэрэглэхээр заасан байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөвхөн Эрүүгийн хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн гол ойлголт тодорхойлогдож байна. Гэсэн хэдий

<sup>5</sup> Ц.Мандах, “Эрх зүйд захирагдах ёс ба шүүх эрх мэдэл”, Шүүх эрх мэдээ замчилгаа, 2014 №2, 115 дэхь тал.

ч Монгол Улсын Эрүүгийн хуулийн Эрүүгийн хууль тогтоомжийг тодорхойлсон үндэснэ хэсэг нь 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг юм. Энэ зүйлд эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндэснэ хууль, олон улсын эрх зүйн нийтгэр хулээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэн гэж заасан нь Монгол Улсын бусад ихэнх хуулыд<sup>6</sup> тусгагдсан олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжос давуу үйлчилгэх тухай<sup>7</sup> зүйл, хэсгээс өөроор тусгагдсан юм. Тэгвэл Монгол Улсын ногдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн ижмэлт II Протокол /цаашид ижмэлт II Протокол гэх/-ыг хэрхэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжтой талаар дараах хэсэгт дун шинжилгээ хийж тайлбарлав.

**1) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн ижмэлт II Протоколыг хэрэглэх асуудал, үүссэн бэрхшээл<sup>8</sup>**

<sup>6</sup> Олон улсын сэргээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэжүүг тайзбар. Улаамбаатар хот, 2011 он, 97-147 дарь тал

<sup>7</sup> Олон улсын эрх түүгүйн хууль тогтоомжоос давалгайдал чанар нь олон улсын эрх түүн үр агаажмын үзүүлэх чухал похижд юм. Түүчинд энэ нь улс сүүний хөгөөндийн хувь ёсны харилцаа, энэ тайван, агуулж байдлыг салхи хамгаалж хууль зүйн баталсан болж байна. (М.Дүүрэсэрж. О.Хоссвар. "Олон улсын эрх түүн." Улаамбаатар хот, 1999 он, 4 дэх тал)

<sup>8</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах язгуу гүйцэтгэхгүй байх өөртэй байр суурин 2010 оны I дүгээр сарын 14-ний одор УИХ-ын чуулган дээр ихэрхийлсэн. Үгэээр Монгол Улс практикст цаазаар авах язгуу гүйцэтгэхээс үндэснэээ түрэлжтэй ба Ерөнхийлөгчийн энэхүү байр суурин: эрх түүн хувьд баталгаажуулж, 2012 оны нааддугээр сарын 5-ийн Монгол Улсын Их Хурал Ихэвэсэн Үндэстний Байгуулалтын Ерөнхий Ассемблейдээс 1989 оны 12 дусаар сарын 15-ийн одор баталсан Иргэний болон улс төртэй зүрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах язгуу замгаад чиглэсэн ижмэлт II Протоколд ийдэм орох тухай хуулийн төслийн хэзээрж баталсан. Хэдийгээр тус олон улсын сэргээнд ийдэн орсон хэдий ч олон улсын гэрээ хүчин тогтолцор болж эхэлж өдрөөс хойш шүүхээс хий хийдэн удааг цаазаар авах язгуу ишоосын туз тус олон улсын сэргээх хэрэгжээд үүссэн барилгаа хэлээн тодорхойлж.

## Гэрээгээр хүлээсэн үүрэг:

Монгол Улсын Их Хурал Нэдээний Ундастний Байгууллагын Ерөнхий Ассемблейгаас 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протокол /цаашид нэмэлт II Протокол гэх/-д 2012 оны нэгдүгээр сарын 5-иц нэгдэн орох тухай хуулийн төслийг хэлэлцэж баталсан. Тус протоколд нэгдэн орсон буюу түүнийг соёрхон баталсан улс орон оорийн шүүхийн харьяалмын хүрээнд хамарагдах хэний ч хувьд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх, түүничэн өөрүүн эрх хэмжээний хүрээнд цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах гэсэн үндээн 2 үүргийг хүлээдэг.

Гээни хэдий ч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тодорхой заалтуудаар цаазаар авах ял оногдуулах гэмт хэргийг тодорхойлж өгсөн бөгөөд дээрх олон улсын гэрээнд нэгдэн орохдоо Эрүүгийн хуулийн цаазаар авах ялыг хүчинчүй болгох Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт хуулийг өргөн барьж, батлагчийг юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс тус нэмэлт II Протоколд нэгдэн орох үед дотоодын хууль тогтоомжийг түүнд ишүүчүүлэх арга хэмжээ аваагүй тул Монгол Улсын олон улсын гэрээ ба Эрүүгийн хууль хоорондоо зорчилтэйгээр хэрэгжиж байна.

Нэмэлт II Протоколын оршил хэсэгт дурдсанчлан, Монгол Улс нь тус протоколд нэгдэн орсноор Монгол Улс цаазаар авах ялыг халах нь хүний нэр төрийг бэхжүүлж, хүний эрхийг хөгжүүлийн гэдэгт итгэж, Пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг халах нь зохицой гэснийг онцлон тэмдэглэж, цаазаар авах ялыг халахад чиглэсэн бүхий л арга хэмжээ нь хүний амьд явах эрхийг хангах баталгаа болох ёстойг ухамсарлаж, цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын өмнө хүлээхийг хүсч нэгдэн орсон гэж ойлгох нь зов юм.

Иймд Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хууль тогтоогч нэмэлт өөрчлөлт оруулж, цаазаар авах ялыг

хүчингүй болгоогүй тул энэхүү ял нь хүчин төгөлдөр хэвэр байна. Энэ нь зруүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цаазын ялыг оногдуулах эсэх дээр эргэлзээтгэй байдлыг үүсгэж байна.

### **Гэрээний хүчин чадал, хэрэглэх боломжийг тодорхойлох нь:**

Өмнөх хэсэгт хийсэн дун шинжилгээнээс харахад, Монгол Улсын Эрүүлийн хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа нэмэлт II Протоколыг 2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улс төрийн эрх барих дээд байгууллагаараа багламжилж, хууль гаргасан тул тус нэмэлт II Протокол нь заавал биелгидэх, хүчин төгөлдөр Монгол Улсын хууль юм.

Энэ хэрээнд авч үзвэл Монгол Улс нэмэлт II Протоколд нэгдсэнээр оорийн үндэсний хууль тогтоомжид холбогдох нэмэлт, оорчлолт оруулах шаардлагатай гэж үсэн эсэх талаар түүхчилжсэн тайлбар хийх нь зов юм. Түүхчилсэн тайлбарыг хийхдээ эрх зүйн актыг баталж хэлэлцж байх үед ямар санал болдоор хууль тогтоогч баталсан бэ гэдгийг эргэж харах нь зүйтгэй. Өөрөөр хэлбэл, тухайн хэм хэмжээг тогтоож байх цаг үеийн нехцэл байдал, хүчин зүйлсийг тооюу арга юм. Энэ үүдлийн УИХ-ын холбогдох байнгын хороодын санал, дүгнэлт, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, протоколыг судлан үзвэл, хууль тогтоогч холбогдох дотоодын хууль тогтоомжид нэмэлт, оорчлолт оруулах шаардлагатай гэж үзэгүй байна.<sup>9</sup>

<sup>9</sup> Ирэгийн болон улс төвийн эрхийн тухай олон улсын Пактын цагааар авах ялыг харахад чылжсэн Нэмэлт II Протоколыг соёртом батлах тухай хуудийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2010 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд орлог лэдүүгээ. Тус нэмэлт II Протоколд нэгдсэн орлогыг төвшиндээ тухай асуудлыг Аюуэгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2010 оны 10 дугаар сарын 12-ны одрийн хуралдаанаараа хэвлэлтээж горимын саналын дагуу Хүүзүү зүйн байнгын хорооны хуралдаанаар хэвлэлүүзэхээр шийдвэрлэсэн ба дээрх асуудлыг Хүүзүү зүйн байнгын хорооны 2010 оны 10 дугаар сарын 19, 26-ны өдөр шүс тус хэлээжсэн. Хүүзүү зүйн байнгын хорооны шийдвэр дээрх асуудлыг хэлээндэх ялангуяа цагааар авах ялыг сүйцгүүжээний дараа тухайн энэхэд гэм буруугүй нь тогтолцоогүй нийцэх байдлыг бичсан тогтолц боломжгүй болно, дээрх ял нь гэмт хөргөлийн саралмын багасгасдаа тухай оровсогт

Түүгүйлэн тус олон улсын гэрээнд оролцогч улс дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай талаар тусгайлан заагаагүй ба гэрээний дагуу оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд цаазын ялыг зовхон дайны цагт хэрэглэхийг л зөшвөөрдог байна. Иймээс нэмэлт II Протокол нь Монгол Улсын нутаг дэвсгэрт шууд үйлчлэх буюу өөрөө биелгэдэх шинжийг агуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагазанд тус измэлт II Протоколыг шууд хэрэглэж болох эсэх талаар дүн шинжилгээ хийж узвэл, 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтгээр хүчин зовшоорсон хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” Монгол Улсын Дээд шүүхийн 09 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэгт, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Үйлдэл, эсэхийн гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариушлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно” гэж заасан тул Эрүүгийн хуульд тусгайлан заасан

тохиолдолд л эрүүгийн гэмт хэргийн шинжнийг тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээг шүүхэд хэрэглэж болно гэж тус тоогоод онцолсон байна. Үүнээс харахад Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан цаазаар авах ялыг хүчингүй болгосон талаар тусгайлан заагаагүй учир тус измэлт II Протоколыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх боломжгүй мэт харагдаж байна. Гэхдээ дээр дурдсанчлан Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсэгт засны дагуу Монгол Улсын Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг бүр нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд ийтийүүлэн иждэн орсон олон улсын гэрээ, конвенцийн зарчим, үзэл баримтлалд үндэслэж байх ёстой юм.

## 2) Олон улсын гэрээг *Pacta sunt servanda* зарчмыг тулгуурлан хэрэглэх нь

Хуулийг зорилго, чиг үүрэгт нь тулгуурлан тайлбарлах арга нь аливаа хэм хэмжээг хууль тогтоогчийн зорилгод тулгуурлан тайлбарлах явдал юм. Үүгээр ямар харилцааг зохицуулах, ямар зорчигдсон эрх ашигийг хамгаалах гэснийг тайлж уншина. Энэ байдал тодорхойгүй буюу бурхэг тохиолдолд түүнийг системчлэх байцлаар хайна. Тодруулбал, хуулийг зорилгоос нь эхэлж уншаад тухайн хуулийн хамаарах бусад систем төдийгүй Үндсэн хуулийн суурь зохицуулалт хүртэл шалгаж үзж юм.<sup>10</sup> Энэ хүрээнд, хуулийн зорилго, зохицуулалт нь тодорхой бөгөөд измэлт II Протоколын дагуу оролцогч улс нь цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын омни худээж, борийн шүүхийн харьяаллын хүрээнд хамарагдах хэний ч хувьд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй буюу оролцогч улс бур борийн шүүхийн харьяаллын хүрээнд цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах юм.

<sup>10</sup> Н.Лундэндорж. "Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй (Лекцийн тэмдээгээл)", Шүүх эрх мэдэлт энхийгээ, 2015 он №1, Улаанбаатар хот, II дахь тал.

Дээр дурдсанчлан, тус нэмэлт II Протоколд иягдэн орсноор Монгол Улс хоёр үүргийг олон улсын омно хүлээж байгаа бөгөөд эдгээр нь Монгол Улсад цазын ялыг түйцэтгэхгүй, цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах юм.

“Аливаа хүчин тоголдор гэрээг түүшил оролцож улсууд заавал биелүүлэх үүрэгтэй богоод түүнийг үзүүч шударгаар хэрэгжүүлнэ” гэж Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн Конвенцид заасан байdag.<sup>11</sup> Энэ нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон *Pacta sunt servanda* буюу гэрээг заавал биелүүлэх зарчим юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “гэрээгээр хүлээсэн үүрээ шударгаар сахин биелүүлэх” зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын II нэмэлт Протоколын зургадугаар зүйлийн 1-д “Энэжүү Протоколын заалтууд нь Пактын хувьд нэмэлт заалт болон хэрэглэгдэнэ” гэж заасан тул нэмэлт II Протокол нь Пактын нэг хэсэг болно.

НҮБ-ын Хүний Эрхийн хорооны 80 дугаар чуулганаас “Пактын гишүүн улсуудад хүлээгэсэн нийтлэг үүргийн тухай” 31 дүгээр зөвлөмжийг гаргасан байна. Тус зөвлөмжийн 4 дахь хэсэгт “Пактын дагуу оролцогч улсын хүлээсэн ердийн үүрэг болон Пактын 2 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг нь Пактын оролцогч улс бүрт бүхэлдээ үйлчилнэ” гэж заасан. Түүничлэн “бүх шатны төрийн байгууллага (уүнд: хууль тогтоох, түйцэтгэх болон шүүх эрх

<sup>11</sup> Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвент, 1969 оны 5 дугаар сарын 23-ны өдөр баталж, 1980 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр хүчин тогтолцоор болсон. (Монгол Улс 1988 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр иэхдэн орсон. Төрший лэдээээз тусгай дугаар, II боть, 459 дэг тах.)

мэдлийн байгууллага хамаарна) болон бүх шатны буюу улсын, бүс нутгийн эсхүл орон нутгийн олон ийтийн байгууллага, төрийн байгууллага оролцогч улсын хүлээсэн үүргийг хүлээнэ. Олон улсын, тэр дундаа Хорооны ёмно тухайн оролцогч улсыг ихэвчлэн толооцдог гүйцэтгэх засагдал нь хариушлага хүлээхэс хэлпрэх болон үр дагавраас зайлсхийн зорилгоор аль нэг засаглалын салбарын Пактын зүйл заалттай тохирохгүй буюу харшилсан үйлдлийг буруутаж болохгүй юм. Энэхүү ойлголт нь Олон улсын гэрээний эрх зүйн тухай Веннийн конвенцийн 27 дугаар зүйлийн тусгайдсан зарчмыг шууд хамааралтай ба тус зүйлийн дагуу Оролцогч нь гэрээг биелүүлэхгүй байгаагаа зонгтохийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтаас иш татах ёсгүй юм.<sup>12</sup>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр Үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад ийцүүлон түүнд хүлээн зөвшөөрсон эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах Үүрэгтэй" гэж заасан. Гэхдээ энэхүү зарчмыг Үндсэн хууль болон бусад дотоодын хуулийн зүйл заалтаас иш татаж биселүүлээгүй Үүрэг эсхүл гэрээний дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлээгүйгээ зөвтгөж болохгүй юм.<sup>13</sup>

Хуулийг тайлбарлан хэрэглэхдээ хууль тогтоогчийн санаа бодол, зорилгыг алдагдуулж хэрхэвч болохгүй тул шүүгч шүүн таслах ажилзагааг хэрэгжүүлэхдээ хууль бол улс төрийн бодлого,

<sup>12</sup> НҮБ-ын Хүний Эрээний хорооны 80 дугаар чуулжитас гарсан "Пактын ширүүти улсуудад хүзүүлэхэн шийнэгүйгээ тухайн" 31 дүгээр зөвлөмжийн 4 дахь зүйл (*The Nature of the General Legal Obligation Imposed on States Parties to the Covenant* CCPR/C/21/Rev.1/Add. 1326 May 2004) Цахилм хөзбоос

<http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QIGIdPPBiCAqhkKb7vhsjYoiCfMKoJBy2FVuVzRELM/TnjRO+fnl3cPVrCM9YR0iW6Tqzop3f9kUfpWog/fW/TpKj2tPbZsbEhw/GcZRASjdFnuiJORnb,IE,al1/hbv3IWdOP12mFTDw6ZSwMMymOGVH>

<sup>13</sup> Мон тэнд

шийдвэр гэдгийг ямагт анхаарч байх ёстой бөгөөд бодлогыг ойлгоогүй цагт хуулийг зов тайлбарлан хэрэглэх боломжтүй юм.<sup>14</sup> Энэ үүдлийс нь хараад измэлт II Протоколд нэгдэн орж, хууль тогтоогч цаашид Монгол Улсад цаазын ялыг халж, гүйцэтгэгүй гэж Монгол Улсын хуулийг гаргасан богоод энэ улс төрийн шийдвэр нь цаг хугацааны хувьд цаазын ялыг хэрэгжүүлж бодлого гарсан тул сүүдц батлагдсан хууль нь хүчин төгөлдөр байх онолоор<sup>15</sup> үйлчлэх ёстой юм.

Дээр дурдсанчлан *Pacta sunt servanda* буюу гэрээг заавал биелүүлэх зарчим нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим бөгөөд түүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж заасан тул Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасан “Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ” гэж заасныг үндэслэн шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тайлбарлын хэрэглэх нь оновчтой санаадаж байна. Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 нь тус зүйлийн 2.2-оос илүү хүчин чадалгай буюу Эрүүгийн хууль тогтоомжийг тодорхойлсон үүдсэн заалт юм. Оороор хэлбэл “Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ” гэж заасан тул Монгол Улсын Эрүүгийн хууль нь оороо Монгол Улсын Үндсэн хуулиас салбарлаж гарсан органик хуулийн хувьд тус хуулийн зүйл заалт бүр нь Монгол Улсын Үндсэн хуульд үндэслэх ёстой билээ.

<sup>14</sup> Н.Лүрнэдорж. “Хүсь тайлбарлан хэрэгжэх онох арга зүй (Лекцийн тэмдэлэх)”, Шүүх ээж мэдээ зүйснгээ, 2015 он №1, Ушамбаатар хот, 9 дэх талз.

<sup>15</sup> *Leges posteriores priores contrarias abrogant*

*Subsequent laws repeal those before enacted to the contrary.*

2 Rol. R. 410; 11Co. 626, 630. *Law Dictionary. Adapted to the Constitution and Laws of the United States. John Bouvier. Published 1856.*

### **3) Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга дахь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ**

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 3-ны одор баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад 2002 оны Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасантай адил Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэн гэж тусгагдаагүй байна. Тус хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг, ял, албадагын арга хэмжээг энд хуулиар тодорхойлно”, мөн зүйлийн 3-т “Үйлцэл, эс үйлдвүүг шинээр гэмт хэрэгт тооцсон, шинээр ялны төрөл, хэмжээг тогтоосон Эрүүгийн хуулыд ишмэлт, бөрчлолт оруулсан хууль энд хуулийн бүрэлэхүүн хэсэг болно” гэж Эрүүгийн хууль тогтоомжийн бүрдэл болон гэмт хэрэг үйлцсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийг тус тус тодорхойлсон байна. Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4-т “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэж заасан нь зөвхөн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээний тухайд тус хуулыд тусгагдаагүй бөгөөд шинэчлэн баталсан Эрүүгийн хуулыд Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэх тухай тусгагдаагүй байна.

#### **Дүгнэлт**

Монгол Улс төрийн эрх барих дээд байгууллагаараа батламжилж соёрхон батажсан аливаа олон улсын гэрээгээр хүлээсэн үргийг заавал биелүүлэх ёстой бөгөөд энд нь верөө олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн *Pacta sunt servanda*

буюу гэрээг заавал биелүүлэх зарчим юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1-т “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, мөн зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлийн” гэж заасан тул Монгол Улсын бүх шатны төрийн байгууллага олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө болон гэрээгээр хүлээсн үүргийг хэрэгжүүлж ажиллах ёстой нь хараадж байна. Нэгэнт гэрээгээр хүлээсн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн олон улсын гэрээнд нэгдэн орох үед цаг тухайд нь дотоодын эрх зүйн хууль тогтоомжийг тухайн гэрээтэй уялдуулж, шаардлагатай өөрчлөлтүүдийг хууль тогтоогчийн зүгээс хийж байх ёстой байна.

Монгол Улс одоогийн мөрдөж буй хууль тогтоомжуудаа олон улсын хүний эрхийн гол гэрээ конвенцуудын зарчмуудтай хэр нийцэж байгааг нь дүнгэн шингжилж, шүүгч шийдвэр гаргах ажиллагаанд заалтадаа эдгээр гэрээ конвенцуудыг хэрэглэдэг, үзэл сананд нь тулгуурлан хэргийг шийдвэрлэдэг шүүхийн практик тогтоох, улмаар аль ч шатаанд заалтадаа эрх зүйд захирагдах ёсны гол амин сүнс болсон хүний эрхийг дээдэлж, хамгаалдаг болох нь чухал байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулыц заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмоц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан хэдий ч энэхүү нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэлтэй байсан хэдий ч Эрүүгийн хууль эзрэг зарим онцлог бүхий хуулийн дагуу энэхүү дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил бүхий олон улсын гэрээг шууд хэрэглэх боломж нь хязгаарлагдмал байна. Иймд тухайн эрх зүйн хэм хэмжээний уялцаа холбоо, үр дүн, зорилгыг аяхаарч судлан хэрэгжүүлж, бүх шатны төрийн байгууллага Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө болон гэрээгээр хүлээсн үүргийг хэрэгжүүлж байгаагийн хувьд шүүгч шүүхийн шийтгэх тогтоолын үндэслэх

хэсэгт дээрх байцлаар Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарлан хэрэглэж байх нь зүйтэй нь харагдаж байна. Оороор хэлбэл, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжтой зөрчилгэй тохиолдолд болон хууль тогтоогч дотоодын хууль тогтоомжийг олон улсын гарэлтэй уялдуулан борчюлт хийгээгүй тохиолдолд тухайн олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх үед шүүгч түүнийг гарсгаар хүлээсэн үүрэгтэй нь уялдуулан тайлбарлан хэрэглэх замаар залруулж байх нь зөв байна.

Түүничлийн шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулыд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээний тухай огтхон ч тусгагдаагүй богоод Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэх тухай огт тусгагдаагүй нь учир дутагдалтай байна. Энэ нь цаашил шүүхээс эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэх ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэсэн эсэхэд тайлбар хийх боломжийг нь хязгаарласан байна. Иймэл шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулыд энэ төрлийн зүйл заалтыг ижмж оруулах зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

# SOME ISSUES WITH THE INTERPRETATION AND THE APPLICATION OF INTERNATIONAL TREATIES RATIFIED BY MONGOLIA WHICH ARE INCOMPATIBLE WITH MONGOLIA'S DOMESTIC LAWS, BASED ON COMMONLY RECOGNIZED INTERNATIONAL LAW PRINCIPLES

This article provides a brief analysis on how to define whether the international treaties which Mongolia is a party to are incompatible with its domestic legislation, and what power Mongolian courts have to apply international law which is inconsistent with domestic legislation. It provides examples of how international law principles apply where Mongolia's legislators have not taken measures to adapt domestic legislation by ratifying the international treaty.

Specifically, when legislators ratify international treaties which are incompatible with the domestic laws and do not take any action to adapt the domestic law, Mongolian domestic laws remain in force although they are incompatible with the ratified international treaties.

For example, Mongolian State Great Hural adopted the law of ratification of "The Second Optional Protocol to the *International Covenant on Civil and Political Rights*, aiming at the abolition of the *death penalty*" on January 5th 2012, and it is already in force and effective as domestic legislation. Since the ratification, Mongolia is obliged to abolish the death penalty in accordance with Article 1(2) of the Second Optional Protocol, however the death penalty remains an available sentence under the Criminal Code of Mongolia.

This article identifies possible ways to interpret and apply international treaties which are incompatible with domestic laws, based on the Constitution of Mongolia and commonly recognized principles and norms of international law.

**Keywords:** international treaty, *pacta sunt servanda* principle, commonly recognized principles of international law, interpretation and the application of the international treaties

# ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС, ХУУЛЬ ЗҮЙН ПОЗИТИВИЗМЫН ХОЦРОГДОЛ

/Эрүүгийн эрх зүйн хүрээнд/

П.Баянбаатар

Шихихутуг их сургуулзийн

Эрүүгийн эрх зүйн тэнцэлжийн ахлах багш, докторант

Б.Гантуурэв

Төр, захиргааны эрх зүйн тэнцэлжийн ахлах багш, докторант

## АГУУЛГА

1. Хууль хэрэглэх ойлголт, үйл ажиллагааны онцлог /хууль зүйн позитивизмд дүн шинжилгээ хийх нь /
2. Хууль хэрэглэх аргачлалд хуулийн тайлбарын үзүүлэх нолоо
3. Дүгнэлт
4. Хавсралт

## Оришийн оронд

Хуулийн хэм хэмжээ судлан үзэх явц болон практик дээр хуулийг хэрэглэх нэг мор ойлгоход бэрхшээлтэй, хуулийн зохицуулалтыг нэг мор ойлгоход эргэлзээтэй, тодорхой бус нэг асуудлыг хуулийн хэд хэдэн зүйл заалтаар оруулсан хэм хэмжээчилсэн, тайлбарласан зүйлс байна.

Тиймээс тухайн эрх зүйн хэм хэмээг хэрхэн тайлбарлах, хэрэглэх тал дээр арга зүйн хувьд судалгаа явуулж, гарах арга замыг тодорхойлох шаардлага байгаа гэдэг нь харагдаж байна.

Судлаачийн зүгээс энэхүү сэдвийн хүрээнд хууль хэрэглэх ойлголт, үйл ажиллагааны онцлог хийгээд хууль хэрэглэх аргачлалд хуулийн тайлбарын үзүүлэх нолоог тодорхойлох, хууль зүйн позитивизмын хоцрогдолыг даван туулах арга замыг эрэлхийлэхийг зорьсон болно.

Судалгааны ажлыг шинжлэх ухааны судалгааны макро харьцуулалтын / macrocomparatismus / аргыг сронхийлон ашиглсан болно.

## 1. Хууль хэрэглэх ойлголт, Үйл ажиллагааны онцлог

/хууль зүйн позитивизмын үүдлийс дун шинжилгээ хийх нь /

Харьцангуй хийсвэр системээс<sup>1</sup> тодорхой шийдвэр гаргадаг системрүү шилжих асуудал эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тухай мөн эрх зүйн хийдлийг даван туулах тухай асуудалтай холбогддог. Тийм учраас эрх зүйг хэрэглэх үйл ажиллагаа эрх зүйг тайлбарлах, эрх зүйн хийдлийг даван туулах зэрэг асуудлыг онолын үүдлийс холбон авч үзэх шаардлагатай болдог.

Эрх зүйг хэрэглэх уламжлалт сургаалын онолын үндэслэл, хууль зүйн позитивизм асуудлыг авч үзэх нь:

19 зууны эхэн үеэс эхэн эрх зүйд хандах хандлага социологийн, түүхэн, жам ёсны эрх зүйн зэрэг чиг хандлагатай болж эхэлсэн багаад энэхүү байдал нь эрх зүйн бүтэц, хууль хэрэглэх механизмыг илүү их нарийвчлан авч үзэхэд шууд хүргэсэн. Эрх зүйн тодорхой бус байдал нь тухайн үеийн нийгэм эдийн засгийн нохцол байдалтай тохиরхгүй байсан учраас нийгэмд гарсан тодорхой маргаантай асуудлыг шийдвэр арга замуудыг илүү их логик дэс дарааллтай болгох, түүний тусламжтайгаар зан үйлийн горимуудыг нарийвчлан тодорхойлсон, аксиомуудыг гаргаж ирэхэд хүрсэн байна. Эрх зүйн ойлголт хэм хэмжээг тодорхой системд хэлбэржүүлэн авч үзэх боломжийг хүлээн зөвшөөрөх явдал 1804 оны Францийн Иргэний кодиксоор дамжин илэрсэн. Уг кодикс нь хэл найруулга, иэр томъёо бүтцийн хувьд харьцангуй онцлог түвшинд хийгдсэн байна. XVIII зууны сүүлийн XIX зууны эхээр бий болсон кодикеүүд нь

<sup>1</sup> Эрх зүйг хэрэглэх болох хэрэгжүүлэх үйл ажиллагааны шүүхийн сурваат нь социализм системийн улсуудад хот их хийсгэр, олон шийтэд хүчинчлэлийн болгатай явж үрсэн байна.

нийгмийн амьдралд үүссэн нохцол байдалуудыг бүхийл боломжит хүрээнд зохицуулж байжээ.<sup>2</sup>

Дээрх үзэл санаа, үнэт зүйлийн тархалт нь эрх зүйд хууль зүйн позитивизмыг улам бүр баталгаажуулах үндсэн шалтгаан нь болсон байна. Тухайн үеийн үзэл баримтлааар бол төгс хууль гэдэгт кодикс<sup>3</sup>-ийг тооцдог байжээ. Энэхүү үзэл хандлагын логик үр дагавар кодификаци бөгөөд шүүх кодификацийг хэрэглэх явдал нь кодикет сорог тайлбар хийх хандлага ажиглагдаж байсан.

Позитивизмыг авч үзэхийн өмнө эрх зүйд хандлагыг авч үзэх шаардлагатай байдаг. Тухайлбал: ёс суртахуун хэмээх ойлголтын дор иэгдэж байгаа нийгмийн олон хүчин зүйлс эрх зүйн агуулгад нилээдгүй нолоө үзүүлдэг байна.

Эрх зүйн шинжлэгээ зан үйлийн горим журмыг авч үзэх оөр оөр үзэх хандлагын гол шалтуур нь судлаачдын үзсэнэр дараах хэд хэдэн зүйлд төвлөрөн илэрдэг.

1. Эрх зүйн хэм хэмжэог түүний хууль зүйн хүчин чадалтай адилтган авч үзэх хандлага. Энэ хандлага нь: хууль зүйн хүчин чадал нь төрийн засаглалын дээд байгууллагын хүсэл зоригийн үр дагавараар тодорхойлогдоно гэж үздэг. /Дж.Остин/<sup>4</sup>

2. Хүлээн зөвшөөрөгдсон зан үйлийн горим журам. /Г.Л.А.Харт/

3. Төрийн байгууллагын эрх хэмжээний дагуу батлагдсан үндсэн хэм хэмжээн дээр тулгуурлан гарсан зан үйлийн горим журам<sup>4</sup> /Х.Кельзен/ хэмээн тайлбарлан авч үзсэн байдаг.

Эрх зүйг ойлгох ойнголтой эрх зүйн эх сурвалжийн ойлголтыг давхар авч үзэж болдог. Эрх зүйн эх сурвалж хэмээх ойлголтыг нийгмийн харилцааг зохицуулагч хүчин зүйлс тэдгээрт хууль зүйн ач холбогдол бий болгох процесстой холбон тайлбарлах хандлага байдаг байна. Энэхүү хандлагыг Й.Эссер дараах байдлаар тайлбарласан байдаг.

<sup>2</sup> Kantorowicz H. Op. cit. S. 30

<sup>3</sup> Кодикс гэдэг нь төргийн буюу ойролцоо шинжлэгээ тайванийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүдийн ижтээн системчилсан хувьчилсан акт юм.

<sup>4</sup> Kelsen H. Das Naturrecht in der politischen Theorie. Ed. F. M. Salzburg, 1963, s.148

Эрх зүйн эх сурвалжийг булгийн усны эхтэй адилтган үзсэн байна. Чулуу бол булгийн усны эх сурвалж биш, ус чулуун дороос урсан гардаг. Яг энэ үзэс эхлээд усыг хүн ашиглах боломжтой. Эндээс эх сурвалж гэдэг ойлголтыг эрх зүйн хэлбэрт хүчин чадал олгож байгаа нийгмийн харилцааг зохицуулагч эрх зүйн арга хэрэгслэл механизм гэж үзсэн байна.

Хууль зүйн позитивизмын гол зорилго ба логик нь эрх зүйн хэм хэмжээг тодорхой хэлбэрийн шаардлагад нийцүүлж явдал юм. Үүнтэй холбоотойгоор эрх зүйг нийгмийн нэг үзэгдэл болгон, нийгмийн бусад үзэгдээс зааглах эрх зүйд ямар нэг нөлөөлөх байдлаар авч үзсэн байдаг. Энэ утгаараа хууль зүйн позитивизм нь эрх зүй, эрх зүйг бүтээх, эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааг зааглах гол үндэс суурь болсон юм.

### **Хууль зүйн позитивизмд гарсан хүндэрлэгтэй асуудлууд**

Хууль зүйн позитивизмын хүрээнд гарч ирсэн хүндэрлэгтэй асуудлууд нь дараах хэд хэдэн хүчин зүйлтэй холбогдуулж тайлбарладаг байна.<sup>5</sup>

1. *Нийтийг хэм хэмжээний хийсвэр шинж ба шуухэр хянан шийдвэрлэгдэж байгаа тохиолдол хоорондын харилцаан хамааралгүй байдлаас бий болсон хууль тогтоомжийн агуулгын тодорхой бус байдал нь хууль хэрэглэхэд хүндэрлэгтэй учруулдаг.*

Энэ нь эрх зүйн хийдлийг бий болгодог ба үүнийг арилгахын тулд шуугч хуулийг тосоотэй хэрэглэж, эрх зүйн зарчмыг, шударга ёсыг удирдлага болгох, харилцаанд оролцогчдын ухаалаг оновчтой шийдлийг тус тус харгалзан үзэж болно.

2. *Хуулийн олон салмаа утгатай байдал нь хууль хэрэглэхэд хүндэрлэгтэй учруулдаг.*

Энэ нь хуулийн агуулгыг тодорхой бус болгож хүн бүр хуулийг оорийн мэдлэг боломжийн хүрээнд ойлгох, бичих хандлагыг бий болгодог. Хууль тогтоогч оновчтой бус томъёолол хэрэглэсэн,

<sup>5</sup> Правоприменение: Теория и практика. Отв. Ред. Ю.А.Тихомиров. М., 2009. С. 39

хуулийн үйлчлэл оновчтой бус хүрээнд үйлчилсэн дутагдалтай байдалд оруулсан байдал.

3. Эрх зүйн хэт их системчлэл нь хууль тогтоогчид тодорхой нэг хязгаарлалт тогтоож огноод хүргэдэг. Хэрэв хууль тогтоогч системт чанарыг ул харгалзан үзсэн бол хуулийг хэрэглэгч субъект хууль тогтоомжийг алдаатай хэрэглэгчдэд шууд хүргэдэг.

4. Хууль тогтоох ба хууль хэрэглэх үйл ажиллагаанд нолоогдог оор нэг хүчин зүйл бол эрх зүйн тогтолцоо хэт хаалттай байдал юм. Оөрөөр хэлбэл, эрх зүйн тогтолцоог хэт явцуу байдлаар авч үздэг. Энэ нь хууль тогтоогч болон эсвэл хууль хэрэглэгч субъектын гаргаж байгаа шийдвэрт шууд нолоо үзүүлдэг. Эрх зүйн тогтолцоог нээлттэй авч үзэх нь эрх зүйн гарал үүслийг судлах, түүнийг зөв тодорхойлоход нийлээдгүй ач холбогдолтой. Гэхдээ анхаарах гол зүйл нь рецепци хийх явдал юм. Үүний тод жиншээ бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үзтэг зүйл болох мэтгээрх зарчмын дүгнэлт хийж болно.

Эрх зүйн хэм хэмжээний актын агуулга ба эрх зүйн тодорхой шийдвэрлийн агуулгыг тодорхойлж байгаа нийгмийн хүчин зүйлийн дотроос хамгийн их нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийг олж тодорхойлоход Х.Кельзений эрх зүйн цэвэр онол чухал ач холбогдолтой.

Х.Кельзен эрх зүйн шинжлэх ухааны судлах зүйлийг албадлагын журмаар хэрэгжүүлж байгаа хэм хэмжээний нийлбэр болох эрх зүйг судлах явдлаар хязгаарлаж болно. Үүнтэй холбоотойгоор торийн эрх бүхий байгуулагын эрх хэмжээ нь үндэсн хэм хэмжээг бий болгох гол үндэс бөгөөд эрх зүйг нийгмийн харилцааны бусад зохицуулж байгаа арга хэрэглээс ялгах шалтуур нь болно гэж үздэг.

*Эрх зүйн цэвэр онол нь хууль зүйн позитивизмийн логик хөгжлийн дэс дарааллыг илүү их хөгжүүлсэн бодоод эрх зүйг*

биелүүлнэ, шүүх эрх мэдлээс хуулийг зөвхөн хэрэглэнэ гэсн байдлаар тайлбарлажээ.<sup>11</sup> Мөн шүүхийн тухай хуульд шүүхээс тусгайлан хууль хэрэглэхтэй холбоотой заалтыг нарийвчлан оруулсан байдал.<sup>12</sup> Үүнээс бяцхан дүгнэлт хийвэл хуулийг зөвхөн шүүх хэрэглэдэг гэж дүгнэж болохоор байна.

Гэсэн хэдий боловч хууль хэрэглэх хэлбэр нь нэг талаас зохион байгуулах негеэ талаас засаглах шинжтэй байдал.

Хуулийг хэрэглэх зохион байгуулах хэлбэр нь: тодорхой албан тушаалтан нэг бүрчилсэн зохицуулалтын актын тусlamжтайгаар тодорхой асуудлыг шийдвэрлэж байгаа удирдах зохион байгуулах ажиллагаа юм. Үүнд тодорхой эрх зүйн хариулцааг үүсгэх, бөрчлох, дуусгавар болгох, тодорхой үйл ажиллагааг удирдах, нэг бүрчлэн зохион байгуулах шинжтэй хариулцаа багтдаг.

Хуулийг хэрэглэх ажиллагааны засаглах хэлбэр нь эрх зүйн зорчлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрх сэргээх мөн төрийн албадлагын бүх торлийн арга хэмжээг авах, хариушлага хүлэолгэх асуудлыг зохицуулах, хамгаалах шинжтэй засаглан захирамжлах ажиллагаа юм. Шүүх бол хууль хэрэглэх засаглах хэлбэрийн субъект ба харин зохион байгуулах хэлбэрийн субъектэд тодорхой нэг бүрчилсэн акт гаргаж буй албан тушаалтан<sup>13</sup> байх боломжтой юм.

<sup>11</sup> Мөн тэнд

<sup>12</sup> Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Эрх зүйн излэсэн мэдээллийн систем <http://legisinfo.mn>—ээс ишигэв.

<sup>12.1.</sup> Шүүх хэрэг, марсаныг хянан шийдвэрлэхэд Үндсэн хууль, шүүнд ишшүүтийн гарсан бусад хуувийг хэрэглэн.

<sup>12.2.</sup> Шүүх Үндсэн хуувьд ишшүүчүү, хэрэг, марсаны гарах үед хүчин төвлөрөө болохгүй, албан ёсвор тийтгээдээгүй хуувьд хэрэглэхгүй.

<sup>12.3.</sup> Тодорхой хэрэг, марсаныг хянан шийдвэрлэхэд хэрэгзэх дүүрэг нь Үндсэн хуувьд ишшүүчүү байна гээх үзэг ширүүт тухайн хэрэг, марсаныг хянан шийдвэрлэх ажиллагааг түүдээтуүлж, самааш Уснын Дээд Шүүхийн оруулна.

<sup>13</sup> Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2002., 3 дугаар зүйл, 3.1-дх зигамт, 3.1.2. "Захиргааны албан тушаалтат" гэж эс хуулийн 3.1.1-д зассан байгууллагын тийтийн эрх зүйн хэрээмжийн тодорхойлжсан зохион байгуулах бүрэн

Зарим судлаачид “хуулний зөвхөн шүүх хэрэглэдэгтүй, төрийн бусад байгууллага, албан тушаалтан, иргэн бусад этгээд шийдвэр шийдэл гаргахдаа хэрэглэдэг” гэж тайлбарласан байдал.<sup>14</sup>

Шүүхийн тухай хуулийн 23 зүйлийн 23.2 дахь зүйлд иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбаруулах тухай санаалаа Монгол Улсын Дээд Шүүхэд ирүүлнэ гэжээ.

Үүнээс үзэхэд хууль хэрэглэх субъектэд иргэн ч адил хамаарах байдлаар тайлбарлаж заасан байна. Хууль хэрэглэх зохион байгуулах, засаглах хэлбэрийн аль нэг чиг үүргийг хэдийгээр хувь хүн хэрэгжүүлдэг боловч тухайн этгээд зөвхөн нэг бүрчилсэн актын үндэснээ дээр шийдвэр гаргах албан тушаалтан байх ёстой гэдэгт тал өгч хандах ёстой юм.

## 2. Хууль хэрэглэх аргачлалц хуулийн тайлбарын үзүүлэх нюанс

Хууль тайлбарлах үйл ажиллагаа эрх зүйг хэрэгжүүлэх процессын зайлшгүй, чухал элемент юм. Ямар нэг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхийн өмнө уг хэм хэмжээний утга агуулгыг сайн ухаж ойлгох, зарим тохиолдолд уг хэм хэмжээг тайлбарлах шаардлага гардаг. Хууль тайлбарлах үйл ажиллагаа бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, таниулахад чиглэгдсэн өөр өөр субъектэс хэрэгжүүлдэг олон талт, нарийн үйл ажиллагаа юм.<sup>15</sup>

VI зууны үед ээзэн хаан Юстиниан баорийн Дегистийг төгс боловсорсон хэмээн үзэж тайлбарлахыг хатуу хориглосон байна. Хөрөнгөт ёсны хөгжлийн эхний үед зарим сэтгэгчид /Ш.Л.

Эрхийг бие даан хэрэгжүүлэхэд төрлийн эсвэл энэ албан хаагч, түүнчлэн тийштэй эрх зүйн холбоодалтой асуудлыар бусдын замжрамжиссан шийдвэр гаргахдаа төрлийн бус албан тушаалтныг ойлгоно. Хартын хувийн эрх зүйн хүрээнд ашигийн талзог болон ашигийн талзог бус үйл ажиллагаа явуулдаг хүстэн энгээндийн шийдвэр гаргах албан тушаалтанд ойлгаж боллоо.

<sup>14</sup> Монгол Улсын Дээд Шүүх. “Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, оног практикийн тулгарчидсан асуудал”. УБ. 2008. 224-дэх таз

<sup>15</sup> В.Н. Храповицкий. Теория государства и права. М. 1997., С. 29

Монгольс. Ч.Беккари зэрэг эрдэмтэд / хамжлагатнуудын шүүхээс хуулийг тайлбарлахыг эсэргүүцж хуулийн үзэл санаа үг үсгийг нарийн чанд мөрдохийг шаардаж байв. Хөрөнгөтнүүд засгийн эрхэнд гарсны дараагаар шүүхээс хуулийн үзэл санааг тайлбарлах эрхийг олгосон юм.<sup>16</sup>

Энэ үзэл санаа нь анх Наполеоны Кодекст зөвхөн хуулийн хүрээнд тайлбарлах агуулгаар илрч байжээ.

Нийгмийн харилцаа аажимдаа нарийн төвөгтэй болохын хэрээр хуулийг тайлбарлах үзэл санаа улам дэлгэрч хуулийг тайлбарлах нь эрх зүйн хийдлийг даван туулах томоохон арга хэмээн үзэх болов.

Харин Социалист эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад хууль тайлбарлах ажиллагаа нь ямагт хувьсталч, ангич, намчирхсан үзэл сурталт автагдаж хүний эрх, эрх чөлөөг хясан боогдуулж байсан юм.

“Тайлбарлах” (interpretatio-зуучлах гэсэн латин гаралтай үг.) гэсэн нэр томъёо нь олон утга илэрхийлэв. Хүмүүнлэгийн шинжлэх ухаанд хүн төрөлхтоний соёлын объектуудыг (урлагийн бүтээлүүдийг тайлбарлах зэрэг) танин мэдэхүйн арга буюу янз бүрийн хэл зүйн бичвэрүүдийг (бичгийн эх сурвалжуудыг) ойлгох гэсэн агуулгатай.<sup>17</sup> Эрх зүйн шинжлэх ухаанд тайлбарлах гэсэн нэр томъёо нь эрх зүйн хэм хэмжээг илэрхийлсэн бичвэрүүдийг ойлгох утгаар хэрэглэгдэнэ.

Хуулийг тайлбарлах үйл ажиллагааны талаар харилцан адилгүй оор санал байдаг.<sup>18</sup> Тухайлбал, зарим судлаачид “хуулийг тайлбарлах үйл ажиллагааг зөвхөн эрх зүйн агуултыг нь ухаж ойлгох үйл ажиллагаа” гэж үздэг бол бусад судлаачид “хуулийг тайлбарлах үйл ажиллагаа бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж таниулах үйл ажиллагаа” хэмээн тодорхойдог байхад гуравдах

<sup>16</sup> В.В.Лазарев. *Общая теория государства и права. Т.2. М., 1998. С-324*

<sup>17</sup> Ч.Нямсүрэн. Эрх зүй төрийн сронхий онол. УБ. 2004., 209-дэх таз

<sup>18</sup> В.И.Хроманюк. *Теория государства и права. М.,1997. С- 30*

хэсэг нь "эрх зүйг тайлбарлах ажиллагаа нь дээрх хоёр үйл ажиллагааны нэгдлээс бүрдэнэ" гэж үздэг байна. Үүнээ үзвэл:

Хуулийг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулга, нэр томъёог тодруулах, и зан харуулах үйл ажиллагаа юм.<sup>19</sup>

Өнөө үсийн хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах талаар хоёр гол үзүүлсэн санаа ноёрхж байгаа юм.

Нэг талаас Оросын эрдэмтэд..." эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах ажиллагааг нь эрх зүйн хэм хэмжээ хэрэглэх үйл явцтай хамт хэрэгждэг учраас ямар ч хуулийг тайлбарлаж болно"<sup>20</sup> гэж үзэж байгаа бол, ногөө талаас барууны зарим эрдэмтэд: тайлбарыг зөвхөн тодорхой тохиолдолд буюу хууль бүрхэг байх, зорчилтгэй байх үед хийнэ гэж үзэж байгаа юм.

Эдгэр үзэл санаа нь эрх зүйг бүтээх, танин мэдүүлэх, хэрэгжүүлэх үе шатанд байвал зохих үзэгдэл, эсвэл эрх зүйн хийдлийг шийдвэрлэх арга хэрэгсэл гэж үзэхтэй холбоотой юм.

*A. Оросын Холбооны Улсын эрдэмтэд эрх зүйг тайлбарлах арга, төрлийг дараах байдлаар авч үзсн байдал.*<sup>21</sup> Эрх зүйг тайлбарлах аргад:

- Хэл зүйн арга
- Логикийн арга
- Системчлийн тайлбарлах арга

<sup>19</sup> Судлаачийн эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах гэдэг сривийн ойлголтыг азон янзаар тодорхойлжсон байдал. Үргийг дараах бүтээгдүүдээс дэлгэрүүлжин уншиж болно. В.И. Храпанюк. *Теория государства и права. М., 1997, С- 30.* В.В.Лазарев. *Общая теория государства и права. Т.2. М.,1998. С-440.* Н.И.Матузов, А.В. Мазыссо. *Теория государства и права курс лекций. М., С- 417.* А. Алексеев. "Источники права". М.,1998 . Ч.Нямсүрж. Эрх зүй төрлийн сривийн онол. УБ. 2004., 209-дэх тал, Монгол Улсын Дээд Шүүх. "Шүүхээс хуудас тайлбарлах хэрэгтэй оногт практикийн түүхэндсэн асуудал". УБ., 2008. 22-23-дэх тал хэрэгээс тодорхойлжшүүдээс үзэж болно.

<sup>20</sup> В.В.Лазарев. *Общая теория государства и права. Т 2. М. 1998, С- 324*

<sup>21</sup> Дээрх анхилалтыг манай орны эрх зүйн онол судлаачидын бүтээгдэж иштэжээ байдлаар гарж болто.

хэрэглэдэгтүй гэдэг үндэслэлийс үүдэн тайлбарыг агуулга, цаг хугацааны хувьд нэг мөр хэрэглэх байдлаар тайлбарласан байна. Эрүүгийн хуулинд хууль тогтоогчийн зүтгэс тайлбаруудыг /Аутент тайлбар/ хийсэн байдал. Энэхүү тайлбарыг дараах байдлаар төрөлжүүлэн авч үзж болно.

### 1. Хэл зүйн тайлбар<sup>31</sup>

Эрүүгийн хуулийн тусгай ангид дараах нэр томъёог тайлбарласан байдал. Үүнд: Мөлжих, жолооч, тээврийн хэрэгсэл, төрийн албан хаагч, төрийн албан тушаалтан, төрийн бус байгууллага, аж ахуйн изгжийн албан тушаалтан гэсэн нэр томъёог тайлбарласан байна.

### 2. Системчилсэн тайлбар:<sup>32</sup>

Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой зүйл заалтыг сроихийн ангийн ялаас чөлөөлөх үндэслэл журмын холбогдох заалттай уялдуулан тайлбар өгсөн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх тайлбарууд нь эрүүгийн хуулийг төсөөтгэй үл хэрэглэх, мөн зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг хэмээн заасан тохиолдолд Эрүүгийн хариуцлага ногдуулах тул туйлын тодорхой байдлаар тайлбарласан байдал.

Гэтэл Иргэний хуулинд Эрүүгийн хуультай ижил байдлаар тайлбарласан заалт байдалгүй ч тухайн хэм хэмжээний агуулга, үзэл санаанд дүгнэлт хийхэд хууль тогтоогчийн зүтгэс тайлбар хийсэн явдал байна.<sup>33</sup>

Монгол Улсын Дээд Шүүх нь Үндэсн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах талаар Үндэсн хуулийн 50 дугаар зүйл 50.1.5- д заасан байдал.

<sup>31</sup> Дэлгэрэнгүй хамрагд № 1-ээс үзүүлүү.

<sup>32</sup> Дэлгэрэнгүй хамрагд № 2-оос үзүүлүү.

<sup>33</sup> Монгол Улсын Президент хууль 251 дүгээр зүйл, 252 дугаар зүйл. Эрх зүйн мэдээллийн ижедсэн систем <http://legalinfo.mn>-ээс иштэй.

Улсын Их Хурал хууль тайлбарлах тухай заалт Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулинд байдалгүй боловч "аутент" тайлбарыг Улсын Их Хурлын зүгээс хууль батлах үйл ажиллагаатай давхар хийсэн байгааг дээрх жишээ харуулж байна.

Магадгүй энэ тохиолдод тухайн хуультай хамт батлагдсан тайлбарыг хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлах эрхийн дагуу Монгол Улсын Дээд Шүүхээс тайлбарыг тайлбарлаж болох эсэх нь эргэлзээтэй байна.

## ДҮГНЭЛТ

Эх газрын эрх зүйн тогтолцоо XII-XII зууны дунд үед бүрэлэн тогтсон гэж судлаачид үздэг богоод түүний улбаа ХрТӨ VI-I зууны үед бүрэлсэн ба эртний Ромын эрх зүйн үзэл санаа иөлеөлсөн. Өнөө үед Европын болон Латин-Америкийн ихэных улсуудад энэ тогтолцоо үйлчилж байна. Энэхүү тогтолцооны гол онцлог нь эрх зүйн хэм хэжээний акт эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж болон хэрэглэгдэг ба тэдгээрийг нийзэд хийсвэр шинжлэхүүнээр бүтээгдээс үүдэн эрх бүхий субъектээс тайлбарлагдан, үйлчлэлийн цар хүрээгээ тодорхойдог байна.

Манай орны эрх зүйн тогтолцоо нь агуулга, хууль зүйн техник, эрх зүйн эх сурвалж, арга зүй талаас нь авч үзвэл эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах ба энэ утгаараа нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулалтанд оруулах шаардлага тавигдаж байдаг.

Тухайн хуулийг хэрхэн зөв хэрэглэх, тайлбарлах асуудал нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой юм.

Тиймээс судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна.

1. Монгол улсын хууль тогтоомжийн системчилгийг эрх зүйн философиийн үүднээс авч үзвол позитив шинжлэхүүнээр тогтолцоонд хамаарахад хууль зүйн позитивизмд гарсан хүндэтгэй асуудлыг онолын үүднээс зайлшигүй тайлбарлах шаардлага гарч байна.

Бид иэгдүгээр дэд хэсэгт хууль зүйн позитивизмд гарсан хүндрэлтэй асуудлуудыг дурьдсан. Үүнийг өөрийн орны хууль тогтоомжтой харьцуулан дүгнэвэл:

А. Хуулийн олон салаа утгатай байдал нь хууль хэрэглэх үйл ажиллагаанд хүндрэл бий болгодог гэсэн хандлага нь Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйл 50.1 дэх хэсэгт “энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт шийгэмд ашигтай ажлыг цалин холс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гээ” гэж заасан байтал шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлд 96.6 дугаар зүйлд заасан нь цалин холс олгох тухай заасан нь шүүхийн зүгээс аль хуулийг баримтлан шийдвэрлэхэд эргэлзээ төрүүлж байдаг.

Мөн Захиргааны хариуциагын тухай хуульд захиргааны зөрчил гэж зүйлчилсэн заалтууд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 37-р зүйл заалтуудтai хэл зүйн болон агуулгын хувьд шууд давхцаж байна. Хэдийгээр эрүүгийн хуулийн шинчилсэн найруулгыг хийж, зорчлийн тухай хуулийг батласан боловч хүчин тогөлдөр нийтээр дагаж мөрдөөгүй байна.

Тиймээс энэхүү давхацсан, олон салаа утгатай байдал нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээний үнэ цэнийг бууруулах мөн хууль хэрэглэхэд хүндрэл учруулдаг тул хуулинд ишмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага ёндер байна.

В. Хууль тогтоох, хууль хэрэглэх үйл ажиллагаанд илөөлөх эрх зүйн тогтолцоог хэт хаалттай байдлаар үзэх явдал юм.

Хэдийгээр манай улсын хувьд тодорхой түвшинд эрх зүйн тогтолцоог ишлэлтэй авч үзэн хуульчилсан боловч хууль тогтоомжийн системчлэлийг хийгээд агуулга, үнэт зүйлсийн түвшинд хийдэлтэй учраас хууль хэрэглэгч субъект тухайн хуулийг хэрэглэхэд хүндрэл учирч байна.

Тухайлбал: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд мэтгэлийх

зарчмыг хуульчилж өгсөн боловч үнэтэй зүйлсийг нь үнэтэй чигэр нь рецепци хийгээгүй байдаг. Учир нь Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны мэтгэлүүдээр зарчмын үнэтэй зүйлс нь мэтгэлүүдээр талуудын эдлэх эрх хууль зүйн хувьд ижил түвшинд байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд оорийн гэм буруутай үйлдлийг үл хүлээн зөвшилцөн тохиолдолд мэтгэлүүдээр мэт. Гэтэл манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд дээрх үнэт зүйлсийн агуулга үзэл санаа суугаагүй байдаг. Одоогийн эрүүгийн хөргийг шалган шийдвэрлэх хуулийн төсөлд мөн адил үнэт зүйлийн хувьд тусгалаа олоогүй.

Тиймээс хууль тогтоогч оорийн хууль тогтоох субъектив үйл ажиллагаанд нийгмийн амьдралын объектив хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх ёстой байна.Өөрөөр хэлбэл орчин үеийн позитив онолын хамгийн гол цөм болох эрх зүй, эрх зүйг хэрэглэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг эрх зүй гэсэн ойлголтын хүрээнд хамааруулж авч үзэх явдал юм.

Мөн эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн харилцан хамаарлыг тогтоохдоо рецепцийг зөв хэрэглэх нь онолын болон практик ач холбогдолтой.

2. Эрүүгийн хуулинд тайлбар гаргахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгцээ шаардлагага онцлог байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн оорийных нь үзэл санаа, агуулгыг оорчлох буюу алдагдуулахгүй байх.
- Эрүүгийн хуулийн заалтыг хүндрүүлэн тайлбарлахгүй байх.
- Эрүүгийн хуулийг тосоотай хэрэглэдүүтүү хууль ёсны зарчмыг баримтлан тайлбарлах.
- Эрүүгийн хуулийг тайлбарлахдаа уг хуулийн хэм хэмжээг оор хооронд нь логик зорчилтуулж бодит хуульчлагдсан байдлыг нь баримтлан тайлбарлах зэрэг болно.

Ийнхүү олон шаардлагага тавих нь Эрүүгийн хууль оороо нийгмийн амин чухал харилцаануудыг гэмт халдлагаас хамгаалдаг, зорчигдсон эрхийг сэргээж, гэм буруутай этгээдэд эрүүгийн

хариуцлага тооцлог, бүтэх, тайлбарлахад нарийн мэргжлийн ур чадвар шаардагдах хууль юм.

3. Онолын ойлголт хийгээд хууль тоогоомжийн хоорондын зааг ялгааг багасгах нь хууль хэрэглэх үйл ажиллагаанд ач холбогдолтой юм.

Онолын ойлголтын хувьд хууль хэрэглэх хэлбэр нь иż талаас зохион байгуулах нөгөө талаас засаглах шинжтэй байдаг гэж бид иżдүгээр бүлгээр авч үзсэн. Шүүх бол хууль хэрэглэх засаглах хэлбэрийн субъект ба харин зохион байгуулах хэлбэрийн субъектэд тодорхой иż бүрчилсэн акт гаргаж буй албан тушаалтан байх боломжтой юм. Харин шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт иргэн, албан тушаалтан, аж ахуйн иżж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдох, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салсаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Монгол Улсын Дээд Шүүхэд ирүүлиэ гэжээ. Үүнээс үзэхэд хууль хэрэглэх субъектэд иргэн ч адил хамаарах байдлаар тайлбарлаж заасан байдаг.

Хувийн эрх зүй тэр дундаа ямар салбар эрх зүй гэлгээш шалтгаалан хууль хэрэглэх субъектыг оор оор агуулгаар тайлбарлах шаардлага байгаа гэх Оросын холбооны улсын судлаачдын үзлийг дэмжиж байна. Тухайлбал: Хувийн эрх зүй тусгайлан Иргэний эрх зүй, Ходолморийн эрх зүйд тодорхой иргэн хууль хэрэглэх тохиолдол байхад, ийтийн эрх зүй тусгайлан эрүүгийн эрх зүйд иргэн хууль хэрэглэх онолын үндэслэл байхгүй юм.

Онолын хувьд эрх зүйн хэм хэмжээний агууллыг тухайн эрх зүйн хэм хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарлаж буй тайлбарыг аутент тайлбар гэдэг. Гэхдээ манай орны хувьд тухайн үзлэ баримтлал эрх зүйн тодорхой хэм хэмжээнд орсон тохиолдолд албан ёсны эрх зүйн эх сурвалжид тооцогддог.

Монгол Улсын Дээд Шүүх нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах талаар Үндсэн хуулийн 50 дугаар зүйл 50.1.5- д заасан болно. Гэтэл Улсын Их Хурал

хууль тайлбарлах тухай заалт Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулинд байдагтүй боловч "зутент" тайлбарыг Улсын Их Хурлын зүтгээс хууль батлах үйл ажиллагаатай давхар хийсэн байгааг бид өмнө дурьдсан.

Өриодийн судлаачид эрх зүйн хэм хэмжээг батласан субъект өөрөө тайлбарлах ажиллагааг угүйсгэх болсон ба учир нь тухайн тайлбарт улс төрийн ашиг сонирхол, хүсэл зориг тодорхой нөлөөлоо магадлалтай хэмээн тайлбарласан байна.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлд гэм буруутгайд тооцох гээд 13.1 дах хэсэгт шүүхийн шийтгэх тогтоол гарах хүргэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутгайд тооцохгүй хэмээн сөнхий хэм хэмжээг хуульчилсан байдал. Харин 13 дугаар зүйл 13.2 дах хэсэгт эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутгай эсэхэд түүничлэн Эрүүгийн хууль<sup>59</sup> болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэж иж дэх хэсэгт заасан зарчмыг дэлгэрүүлэн хуульчилсан. Энхүү агуулга нь үндсэн хуулинд заасан хуулийг тайлбарлах агуулгатай шууд зорчилдож байгаа ба шаталсан зорчилдоон бий болж байгаа учир хууль тогтоох, ижмэлт өөрчлөлт оруулах замаар шинэчлэх шаардлагатай байна.

<sup>59</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль – "Төрийн мэдээлэл" эзэнтгэлийн 2002 оны 5 дугаар тиймээдсэн

**Улсын их хурлаас эрүүгийн хуулинд дараах байдлаар  
хэл зүйн тайлбар хийсэн байна**

**113 дугаар зүйл. Хүн худалдаалах**

Тайлбар: 1. Энэ хуулийн 113.1-д заасан “молжих” гэдгийг худалдагдсан хүний бисийг нь үнэмлүүлэх зэрэгээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөл байлагах, албадан хөдөлмөр хийлгэх, эд зэрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

**215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслэгийн ходолгооний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зорчих**

Тайлбар: Энэ зүйлд заасан “жолооч” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд, “тээврийн хэрэгсэл” гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, оөрөө явагч бусад машин, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүчинчлэн бусад механизксан тээврийн хэрэгслийг тус тус ойлгоно

**230 дугаар зүйл. Торийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсргүүцэх**

**231 дүгээр зүйл. Торийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох**

Тайлбар: Энэ хуулийн 230, 231 дүгээр зүйлд заасан **Торийн албан хаагч** гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

**263 дугаар зүйл. Торийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалтын байдлаа урвуулах**

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан **торийн албан тушаалтан** гэдэгт торийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхээж байгаа этгээдийг хамааруулна.

**265 дугаар зүйл. Торийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах**

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн изгжийн албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн изгжээд удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.

301 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг, хүмүүст халдан довтлох

Тайлбар: Энэ зүйлд дурдсан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс гэдэгт гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтиууд, дипломат элч, түүчинчлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад оорийн улсын төрийн изэрийн омниөөс үйл ажиллагaa явуулах эрх бүхий этгээд хамаарна. Дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан орөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна

**Улсын их хурлаас эрүүгийн хуулинд дараах байдлаар  
системчилсэн тайлбар хийсэн байна**

**79 дүгээр зүйл. Эх орноосоо урвах**

Тайлбар: Гадаад улсын тагнуулын албанад элссэн боловч авсан даалгавраа биелүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын албатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн **Монгол Улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлно.**

**82 дугаар зүйл. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах**

Тайлбар: Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулахад оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс омни энэ тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлно.

**89 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх**

Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мешгогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогонох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэсэн бол энэ зүйл хамаарахгүй.

**108 дугаар зүйл. Хүн хулгайлах**

Тайлбар: Хүн хулгайлсан үйлдэл нь бие даасан **өөр** гэмт хэргийн шинжгүй бөгөөд хулгайлгэсэн хүнийг сайн дураараа сулласан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнэхгүй.

**113 дугаар зүйл. Хүн худалдаалах**

Тайлбар: 2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглээни бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнэх.

*177 дугаар зүйл. Зандалчлах*

Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэлтгэхэд идэвхтэй оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс омно эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсхүл энэ үйлдлийг таслан зогсооход идэвхтэй оролцсон богоод түүний үйлдэлд **өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.**

*185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх*

Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодисыг зохих зөвшөөрөлгүй хадгалж байгаад зохих байгууллагад сайн дураараа авчирч өгсөн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

*270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах*

Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

## НОМ ЗҮЙ

1. Монгол улсын дээд шүүх. Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, онол практикийн тулгамдсан асуудал. УБ. 2008
2. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ.2008
3. Ч.Нямсүрэн. Эрх зүйн онол, УБ.2010
4. Б.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ.2010
5. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ.2012
6. А.К. Романов, Их Британий эрх зүй болон эрх зүйн тогтолцоо, УБ, 2016
7. Kantorowicz H. Op. cit.
8. Kelsen.H. Das Naturrecht in der politischen Theorie . Ed. F. M. Salzburg, 1963,
9. Правоприменение: Теория и практика. Отв. Ред. Ю.А.Тихомиров. М., 2009.
10. Kelsen.H. Das Naturrecht in der politischen Theorie . Ed. F. M. Salzburg, 1963
11. Алексеев. С.С. Указ. Соч. Т.1
12. Llewellyn.K. The Bramble Bush
13. В.Н. Храпанюк. Теория государства и права. М. 1997
14. В.В.Лазарев. Общая теория государства и права. Т.2. М., 1998
15. Н.И.Матузов, А.В. Малько. Теория государства и права курс лекций. М
16. Walter Sinnott-Armstrong. Word Meaning in Legal Interpretation. San Diego Law Review, May-June 2005, Vol 42, number two
17. N.S. Bindra, The interpretation of statutes and General Clauses Acts (Central and States) with WORDS AND PHRASES Fourth Edition, 1965
18. San Diego Law Review What is Legal Interpretation Vol 42
19. Walter Sinnott-Armstrong, Word meaning in Legal Interpretation. San Diego Law Review. Review What is Legal Interpretation? Vol 42

## **THEORETICAL BASIS OF APPLYING LAW AND LAG OF LEGAL POSITIVISM**

/ Criminal law framework /

Studying legal norms and applying law in the practice are difficult to understand, and doubt. So it is demanded to, define ways to apply law and how to explain legal norms.

Researchers to study way to go through lag of legal positivism, to define influence of legal interpretation in applying law and concept of applying law. In framework of legal positivism there are some problems related some factors. Including:

1. Common standards abstract nature and shall be settled in certain mutual legislation Court of content created in unrelated cases caused is difficult to apply the law. It threw the law, which must be taken into account by the use of similar law judge to remove it, the legal principle of justice, management and relations participants intelligent solutions.
2. Patchwork essence of the law that they can understand and write trends within your own knowledge, even as uncertainty laws contents of the law complicity. It is difficult to apply the law. Legal use of appropriate terminology and being served into state failure within the legal service assists.
3. Legal excessive systematic leads to give a clear restriction on the legislature. If not what is the law, taking into account the quality of user-setter systematic law subject to other factors that affect the process of determining the direct and teach applicable law. Law erroneous application of the law is that the legal system is too closed. Researchers, studied to go through ways some problematic issues in framework of legal science

орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал зүй ёсоор багтдаг байна. Үүнд:

1. Хойн үеийнхний эрхийг хамгаалах, энэ нь хойн үеийнхэнд зайлшгүй хадгалагдах,
2. Хойн үеийнхэнд хүрээлэн буй орчны хэвийн төлов байдлыг зайлшгүй хадгалж үзүүх,
3. Хойн үеийнхний байгалийн баялаг ашиглах боломжийг хамгаалах шаардлага гэсэн элементүүд орно.

Судалж үзэн оруулад эдгэрээр эрхийг Үндэсн хуулиараа хуульчлан хамгаалахын зэрэгцээ хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тусгай байгууллага байгуулж, тодорхой эрх, үүрэгтэй (хүрээлэн буй орчны асуудлыар иргэдийн санал, хүснэгт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, төрийн байгууллагатай харилцах, санал хүснэгтээ уламжлах гэх мэт) байх асуудлыг мен хуульчилдаг байна.

Монгол Улсын Үндэсн хуульд бидний ирээдүй хойч үеийн хүрээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах хэм хэмжээг тунхаглан тогтоох нь Монгол Улсын Үндэсн хуулийг боловсронгуй болговол зохих нэгэн чиглэл болох нь тодорхой бөгөөд эл асуудлыг бэлчээрийн тухай хуульд давхар баталгаажуулах асуудал онол, практикийн ач холбогдолтой.

Бэлчээрийн харилцааг зохицуулах тусгай хуультай байхаар боловсруулсан төслүүдийг сүүлийн 4 жилд Улсын Их Хурлаар хэлэлчээгүй, хэлтийн асуудлын жагсаалтад ч багтаагүй одий хүрсэн нь бэлчээрийн харилцааны асуудлаар төрийн бодлого дутагдаж байгаагийн нэг баримт мөн. Ийм бодлогогүйгээс бэлчээрийн доройтол ихэсч, бэлчээр ашиглагчдын эрх хязгарагддаж буй бодит байдал сүүлийн үед илтээд ажиглагдах болов. Уул уурхайн үйл ажиллагаа болон хууль бус үйлдлийд хүрээлэн буй орчин, ялангуяа бэлчээр, усны тооц хүн, малд олон тооны эрдэл учруулж байна. Эдгэрээс гарах нэг гарц бол бэлчээрийн харилцааны овормоц олон талт асуудлыг иж бүрэн

ШИХИХУТУГ ИХ СУРГУУЛЬ



**Хууль бүтээх үйл ажиллагааны  
шинжилэх ухааны үндэс, хууль  
тогтоомжийг боловсронгуй болгох  
үндсэн чиглэл**

(ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БАГА ХУРЛЫН МАТЕРИАЛ)

2016 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ОДОР

Улаанбаатар хот  
2016 он

DDC 340

ННА 67

X - 758

Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх  
ухааны үндэс, хууль тогтоомжийг  
боловсронгуй болгох үндсэн чиглэл

Редактор: Ч.Даваадаш

Д.Отгонтуяа

Эмхэтгэсэн: Э.Анхбаяр

Хэвлэлд бэлтгэсэн: Б.Энхжин

Хавтасны дизайн: Б.Энхжин

Цаасны хэмжээ: 148x210

Хэвлэлийн хуудас: 16,5 х.х

ISBN: 978-99973-51-16-6



"Соёмбо принтинг" ХХК-д  
хэвлэв.

## ГАРЧИГ

### БАГА ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН УГ

Шихихутуг Их сургуулийн дэд захираг, доктор /Ph.D/, профессор Ч.Даваадааш.....

9

## ҮНДСЭН ИЛТГЭЛ

### ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГЛАНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор  
Д.Лүнжигжижан.....

11

## ИЛТГЭЛ

### ХУУЛНИЙ АМИН СУНСИЙГ ЧИНГИС ХААНЫ ӨВД ТУЛГУУРЛАН СУДАЛСАН НЬ

Академич, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, Шихихутуг Их сургуулийн хүндэт доктор  
С.Нарангерэл.....

32

### ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА: ТҮҮХЭН СУРГАМЖ

Удирдлагын академийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор  
Ч.Энхбаатар.....

56

### ХУУЛЬЧДАД ХУНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ НЬ ӨНӨӨГИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА МОН

Хүний эрхийн үндэсний комиссын дарга, доктор /Ph.D/, профессор Ж.Бямбадорж.....

74

### ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ҮЗҮҮЛЭХ НОЛОО

АНУ-ын Тринити хуулийн сургуулийн профессор  
Кристофер Калл .....

81

**ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ХУУЛЬ БҮТЭЭХ,  
ХЭРЭГЛЭХЭД ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУДЫГ БАРИМТЛАХ  
НЬ**

*Шихижтуг Их сургуулийн зүргүүлэх эрх зүйн тэнхмийн  
эрхэлгэч, доктор /Ph.D/, профессор Ж.Бямбаа.* ..... 103

**ЯНЗ БУРИЙН ЭРХ ЗҮЙН БҮЛҮҮДИЙН УЛС ОРНҮҮД  
ДАХЬ УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМҮҮД**

*Эрхүүгийн УИС-ийн хууль зүйн сургуулийн Олон улсын  
эрх зүйн болон харьцуулсан эрх зүйн тэнхмийн профессор,  
доктор /Ph.D/ М.Г.Тирских.* ..... 118

**АРДЧИЛЛЫН ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛАХАД ЭРХ  
ЗҮЙТ ЁСНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ: ХАРЬЦУУЛСАН  
ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх,  
доктор /Ph.D/ Ч.Өнөрбаяр.* ..... 126

**АНУ-ЫН ХОЛБООНЫ ХУУЛЬ ТАЙЛБАРАХ  
АРГАЧИЛГААНЫ СТАНДАРТЧИЛАЛ БА ХОЛБОГДОХ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД**

*БНСУ-ын Хандуны Олон Улсын хууль зүйн сургуулийн  
профессор Дэвид Коллиер* ..... 144

**ОЛОН УЛСЫН БОЛОН ОРОСЫН ХУУЛЬ  
ТОГТООМЖ ДАХЬ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИГЧ ГОРИМ  
ЖУРМУУДЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ  
БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД**

*Эрхүүгийн УИС-ийн хууль зүйн сургуулийн дэд профессор,  
доктор /Ph.D/ О.А.Шабаева.* ..... 157

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ  
ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН ОНОЛ АРГА ЗҮЙН  
ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

*Шихижтуг Их сургуулийн багши, гавьяат хуульч, доктор  
/Ph.D/ Р.Оюунбадам.* ..... 166

**МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ХУУЛЬ  
ТОГТООМЖООС ЯЛГАМЖТАЙ МОНГОЛ УЛСЫН**

**ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН  
ЗАРЧИМД ҮНДЭСЛЭН ТАЙЛБАРАЛАН ХЭРЭГЛЭХ  
АСУУДАЛ**

*Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн  
захирал, доктор /Ph.D/ Ц.Мандах.....* 191

**ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ОНОЛЫН ҮНДЭС, ХУУЛЬ ЗҮЙН ПОЗИТИВИЗМЫН  
ХОЦРОГДОЛ**

*Эрүүгийн эрх зүйн хүрээнд/  
Шихихутуг Их сургуулийн ахлах багши, докторант  
П.Баянбаатар, ахлах багши, докторант  
Б.Гантуурэв.....* 209

**БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДУН  
ШИНЖИЛГЭЭ**

*Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багши,  
доктор /Ph.D/ М.Сувд.....* 236

**ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖЛЭХ  
УХААНЫ ҮНДЭС ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА /УЗЭЛ  
СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ/**

*Шихихутуг Их сургуулийн багши, магистр  
Ц.Амарсанаа.....* 249

**БАГА ХУРЛЫГ ХААЖ ХЭЛСЭН ҮГ**

*Шихихутуг Их сургуулийн захирал, профессор  
Д.Оюунцэц.....* 263

## **CONTENT**

### **OPENING ADDRESS BY**

**MR. CH.DAVAADASH**

Ph.D. Prof. Vice-director of the Shiihutug University

### **ISSUES OF IMPROVEMENT OF THE SCIENTIFIC BASIS FOR LAW MAKING PROCESS**

**Sc.D. Prof. D.LUNDEEJANTSAN**

Member of State Great Hural /Parliament/, Honorary lawyer

### **STUDYING ESSENTIALS OF THE LAW BASED ON HERITAGES OF GENGHIS KHAN**

**Sc.D. Prof. S.NARANGEREL**

Academician, State Emeritus of Science, Honorary doctor of the Shiihutug University

### **LAW MAKING PROCESS: HISTORICAL ADMONITION**

**Sc.D. Prof. CH.ENKHBAATAR**

Head, Department of Law, Government Agency of Mongolia-Academy of Management

### **THE MODERN DEMAND AND REQUIREMENT OF ALLOWING KNOWLEDGE OF HUMAN RIGHT FOR LAW-YERS**

**Ph.D. J.Byambadorj**

Chief of National Human Rights Commission of Mongolia

### **CONTEMPORARY TRENDS INFLUENCING DOMESTIC LAW MAKING**

**Prof. CHRISTOPHER A.KALL**

Trinity Law School, California, The United States of America ...

### **ADHERING TO LEGAL PRINCIPLES FOR CREATION AND ENFORCEMENT OF LAWS**

**Ph.D. Prof J.BYAMBAA**

Head, Department of Criminal Law, the Shiihutug University

## **POLITICAL REGIMES OF LEGAL FAMILY IN THE COUNTRIES**

**Ph.D. Prof. TIRSKIH.M.G**

Department of International and Comparative law, the Irkutsk State University

## **ROLE OF RULE OF LAW IN OVERCOMING A CRISIS OF DEMOCRACY: FROM THE PERSPECTIVE OF COMPARATIVE LAW**

**Ph.D. CH.UNURBAYAR**

Legal advisor of President of Mongolia

## **STANDARDIZATION OF THE FEDERAL STATUTORY INTERPRETATION RULES**

**Prof. DAVID W. COLLIER**

The Handong International Law School, Pohang, Korea

## **IMPROVING MAIN STREAMS OF SUPPORTIVE RULES IN THE INTERNATIONAL AND RUSSIAN LEGISLATION**

**Ph.D. Prof. O.A.SHABAEVA**

Law School of the Irkutsk State University

## **AMENDED CRIMINAL CODE OF MONGOLIA AND ITS CHALLENGES OF IMPLEMENTATION IN CONTEMPORARY CONFLICTS**

**Ph.D. R.OYUNBADAM**

Lecturer of the Shihihutug University, Honorary lawyer

## **SOME ISSUES WITH THE INTERPRETATION AND THE APPLICATION OF INTERNATIONAL TREATIES RATIFIED BY MONGOLIA WHICH ARE INCOMPATIBLE WITH MONGOLIA'S DOMESTIC LAWS, BASED ON COMMONLY RECOGNIZED INTERNATIONAL LAW PRINCIPLES**

**LL.D. TS.MANDAKH**

Director of the Judicial Research, Information and Training Institute under the Judicial General Council of Mongolia

**THEOROTICAL BASIS OF APPLYING LAW PROCESS AND  
LAG OF LEGAL POSITIVISM**

**Ph.D candidate P.BAYANBAATAR**

Senior lecturer, Department of Criminal law, the Shihihutug University,  
**Ph.D candidate B.GANPUREV**

Senior lecturer, Department of State and Administrative law, the Shihi-  
hutug University

**LEGAL ANALYSIS OF LAW DRAFT ABOUT PASTURE UTI-  
LIZATION IN MONGOLIA**

**Ph.D. M.SUVD**

Lecturer, Law School of the Otgontenger University

**A PERSPECTIVE AND SCIENTIFIC STUDIES OF LAW MAK-  
ING PROCESS**

**LL.M. TS.AMARSANAA**

Lecturer, Department of State and Administrative law, the Shihihutug  
University

**ALLOCUTION AT CLOSING CEREMONY OF INTERNA-  
TIONAL ACADEMIC CONFERENCE**

**Prof. D.OYUNTSETSEG**

Rector of the Shihihutug University

**“Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”**  
**сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг**  
**иээж Шихихутуг Их сургуулийн дэд захирал, доктор,**  
**профессор Ч.Даваадашийн хэлсэн үг**

*Эрхэм хүндэт эрдэмтэн профессор багши нараа*

*Эрхэм хүндэт зочид төвлөөлогчид өө*

*Эрдэмд шамлан суралцаач хүндэт оюутан нараа*

*Энд хурган цугласан эрхэм ноход өө*

Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Юуны омно ТА бүхэндээ эрдмийн гэгээн уурхай Шихихутуг сургууль үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье. Шихихутугчнууд сургуулийнхаа 25 жилийн ойг ихээхэн нэр тортгүй, ололт амжилт дүүрэн угтацгааж байна. Ойн босгон дээрээ Шихихутуг ХЗДС маань их сургуулийн статустай боллоо. Энэ бол эзэн Чингис хааны Их Заргачийн нэрээр овоглосон Шихихутуг сургууль Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд өөрийн баттай байр суурь, нэр хүндтгэй орон зайгаа эзэлсэн, эх ороондоо болон гадаадад хүлээн зөвшиөөрөгдсөний бодит нотолгоо билээ.

Шихихутуг ХЗДС сургалт-судалгааны тов болох стратегийн зорилтоо хэрэгжүүлэх үйлстээ томоохон алхам хийсний ачаар их сургууль болох нохцлоө бүрдүүлсэн юм. Нэг үгээр их сургуулийн шаардлагыг бүриээ хангасан хэрэг юм. Энэ эрхэм үйлст сүүлийн 10 жил дараалан Монголын тэр, эрх зүйн тулгамдсан асуудлуудаар жил бүр зохион байгуулж ирсэн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болон гадаадын нэр хүндтгэй эрдэм шинжилгээний байгууллагатай цөөнгүй жил хамтарсан судалгаа шинжилгээний тосол хотолбер хэрэгжүүлж байсан явдал үнэтгэй хувь нэмэр оруулсныг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Сургууль үүсч байгуулагдсаны 25 жилийн ойн цогц арга хэмжээний хүрээнд багтаж буй онөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурал маань сонгож авсан сэдвийнхээ хувьд ч, илтгэл тавин оролцож буй дотоод, гадаад эрдэмтэн судлаачдын

бүрэлдэхүүнийхээ чанар чансаагаараа ч үнэхээр онцлог бөгөөд ихээхэн жин дарах үйл явдал болж байна.

Чөлоот арчилсан шинэ нийгмийн тогтолцоог төгс төгөлдөр болгоход, ёс суртахууныг амин сүнсээ болгосон хууль эрх зүйт төрийг жинхэнэ утгаар байгуулахад хууль бүтээх үйл ажиллагааз амин чухал ач холбогдолтой нь тодорхой. Чухамхүү энэ үйл ажиллагааны шинжлэх ухааны үндсийг эрэ дээшилүүлэх явдал онөөгийн Монголын нийгмийн өмнө тулгамдсан зорилт яах аргагүй болоод байна. Энэ түүхэн зорилтыг амжилттай хээргжүүлэх үйлст Шихихутуг их сургуулиас санаачлан зохион байгуулж буй онөөдрийн “Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал иэн чухал, үзтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Манай онөөдрийн олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаанд бидний идэвхитгэй хамтран ажилладаг түнш сургууль болох БНСУ-ын Хандоны их сургуулийн төлөөлөгчид, ОХУ-ын Эрхүүгийн их сургуулийн төлөөлөгчид оролцож байгааг баяртайгаар уламжлай.

Ингээд “Хууль бүтээх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаа нээснийг мэдэгдье.

# ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛ

Д.Лүндээжсанџан

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч,  
хууль зүйн шинжлэх ухаалын доктор, Профессор

Монгол Улсын Их Сургуулийн хуулийн салбарын V курст 1979 оны овлийн шалгалт дуусаад амралт эхлэх гэж байхад Э.Авирмэд багш (Монгол улсын гавьяат хуульч) маань тэнхимд дуудаад “Совершенствование законодательства (хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал) гэж мэргэших тусгай курсын хичээлийн лекц бэлтгэж байх хэрэгтэй. Хавар доод ангийн мэргэших курсынхаанд заалгана. Цоо шинэ хичээл. Май энэ номыг ашигла гэж хатуу ногоон хавтастай орос ном огов. Энхуу ном нь хууль тогтоомжийг бүтээх, системчилэх техникийн тухай бичсэн ном байж билээ.

Энэ мэргэших курсыг хуулийн одор, орой, эчинэ ангид З жил хиртэй орсон юмдаг. Одоо лекц нь ч алга болжээ. Гэхдээ сэтгэлд маш тод дурсамж үлдэж хоцорсон. Сэтгэлийн гүнд нэг тод оч үлдсэн нь хууль бүтээх ажилд гуч шахам жил зүтгэхэд шинжлэх ухаанчаар хандах ёстой гэсэн итгэл үнэмшилийг бий болгож өгсөн явдал юм. Энэ хичээлд бэлтгэх гэж тэр үсийн Шүүх яаман дзор байнга очдог байж билээ. Учир нь хууль боловсруулах ажиллагааг зрхээдэг Шүүх яамны сайд нь Б.Чимид багш, Сайд Нарын Зовюлийн Хэрэг Эрхлэх газрын хуулийн хэлтсийг О.Амархүү багш, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдний газрын хуулийн хэлтсийг Г.Совд багш нар маань удирддаг байсан юм шүү дээ.

Хуулийн төсөл боловсруулах ажил бол хатан хааны титэм, ээмэг, богжийг урлахтай адил нарийн, адармаатай, инжээн ажил юм. Би бээр Б.Чимид, О.Жамбалдорж, О.Амархүү, С.Цэрэндорж, Ж.Амарсанаа, Н.Лувсанжав, Д.Дэмбэрэлцэрэн, С.Нарангэрэл, Ц.Нямдорж, Ч.Энхбаатар гээд үс үсийн хууль бүтээх ажилд зүтгэж

ирсэн хүмүүсийн хууль зүйн техник, арга зүйгээс л суралцахыг хичээж ирсэн хүний нэгэн нь болой.

Эдүгээ хууль тогтоох нь зөвхөн улс төрд л хамаатай зүйл гэсэн сэтгэлээ орхигдож энэ бол хүмүүнлэгийн олон ухааны уулзвар бөгөөд шинжлэх ухаан бүрийн судалгааны онцгоеөс нь харах учиртай шинжлэх ухааны судалгааны зүйл гэдэг нь тодорхой болж байна. Энэ бүхийг нөхцөлдүүлэгч гол хүчин зүйл нь **өөрийн амьдралын зүй тогтлоос уламжлан гарсан харилцаа**, хүн төрөлхтний хэмжээнд хууль тогтоох үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдсөн үзэت зүйлс хоёрыг оновчтой хослуулснаас хамаарна. Энэ хослолын зөв зохицол дээр орчин үеийн хууль тогтоох үйл ажиллагаа хийгээд эрх зүйн хэм хэмжээ бүтээх технологи хууль зүйн техник тулгуурлаж байна.

**1.Хууль тогтоох үйл ажиллагаанд орчин үеийн сонгодог онол, дэлхийн жишгийг харгалзаж үзэх хандлага бий болюү.** Энэ хандлагыг хэн нэгэн сэтгэгч зохигоогүй. Харин хууль тогтоох үйл ажиллагааны хөгжлийн нэгэн хандлага, бодит амьдралын тусгал юм. Тэгэхээр, Монголын хууль тогтоох үйл ажиллагааг хөгжүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалж шинжлэхэд хууль тогтоох онол, арга зүйг ашиглах нь хууль тогтоох үйл ажиллагааны зүй тогтол, онцлог, уламжлал, шинчлэлийг тодорхойлох гол цэг, арга зүйн чухал үндэслэл болох төдийгүй ногеө талаас улс орны эрх зүйн тогтолцоог сонгодог хэлбэрт ойртуулах, оруулах, түүний хөгжлийг товчлох, тосож хөгжих изг чухал механизм болж огно гэж хэлж болмоор санагдана. Монголын хууль тогтоох үйл ажиллагаанд хууль тогтоох онол, арга зүй аажим алгуур боловч извтэрч эхэлсэн гэж хэлж болно. Хууль тогтоох онол нь олон салбарыг хамарсан шинжлэх ухаан юм. Үүнтэй холбоотойгоор мөн хууль тогтоох онол, арга зүй нь эхлэл тодий байгаагаас хамаарч энэхүү салбарын тогтолцоо одоогоор байхгүй байгаагийн шалтгаан оришино. Тийм ч учраас энэ

удаад хууль тогтоох процедурын хүрэнд зөвхөн хамгийн чухал сэлэв ба асуудлыг нэрлэх боломжтой байна. Үүнд:

**Нэгдүгээрт:** Оршихуй ба байх ёстой зүйл (хууль) харилцан нохцолдсон энхүү хууль тогтоох арга зүйн шинж чанарын дагуу бодит байдал дун шинжилгээ хийх ба үзүүлэхийн чиг баримжааг тодорхойлох нь шийдвэрлэх ач холбогдолтой юм.

**Хоёрдугаарт:** хууль тогтоох арга хийгээд техникт хамаардаг хуулбарлан шилжүүлэх, хүлээн авах (рецепции) ба хүчингүй болгох асуудлыг судлах шаардлага тавигдаж байна.

Хууль тогтоох үйл ажиллагаа нь эрх зүйг зээлдэн хэрэглэх, уламжлан шилжүүлэх (рецепции), нэг талын болон хоёр талын сонирхлын дагуу экспортлох, импортлох арга замаар явагдаж байна. Өдгөө “эрх зүйн рецепции” хэмээх ойлголтоор тэмдэглэсэн үзүүдэл, үйл ажиллагаа дэлхий дахинаа түгээмэл үйлчилдэг болсон хэдий ч харин түүнд хууль тогтоогчид хэрхэн хандах арга, ухаан, эрх зүйн соёл, ухамсар харилцан адилгүй байна. Үүнээс хамаарч хууль тогтоох үйл ажиллагаа, түүний эцсийн үр дүн, үүрэг, зорилго харилцан адилгүй үр дагаварыг авчирсаар байна. Гэтэл уг ойлголт манай оронд шинжлэх ухааны хувьд нэг мор тайлбарлаж, тодорхойлсон зүйл одоогоор ховор бөгөөд харин олон улс гүрэнд оргон тархсан хэлний толь бичигүүдэд “нэг улсын эрх зүйн тогтолцооны элементийг илрүүлэхэдэг ойлголт” гэсэн нийтлэг утгаар тодорхойлсон нь харагдана.

Хууль тогтоох үйл ажиллагаанд “Эрх зүйн рецепции” хийхийн өмнө хуулийн төсөл боловсруулагч, хууль санаачлагч нар дараах дорвон үндэснээс нохцлийг тооцож судалсан байх ёстой. Үүнд:

- Рецепцилэн авах гэж буй хууль нь оорийн эх орондоо тухайн эрх зүйн харилцаагаа бүрэн дүүрэн зохицуулж байгаа эсэх нь хангалттай үндэслэлээр батлагдсан эсэх. Тодруулбал, зохицуулах ёстой эрх зүйн харилцааг анх батлагдсан газраа ч зохицуулж чадахгүй байгаа эрх зүйн шийдлийг өөр бусад орон рецепцилэхээс татгалзах хэрэгтэй.

- Рецепцилж авах гэж буй хууль нь Монголын эрх зүйн тогтолцоонд байраа эзэлж, уялдаа шүтэлцээ, нийцгэйгээр нутагшиж чадах эсэх;
- Рецепцилэн авах хууль нь зохицуулалтын агуулга, хэлбэрээрээ монголын хууль цаазын соёл, уламжлал, үндэстний зан заншилд хэрхэн нийцэх эсэх;
- Рецепцилж авсан хуулийг Монгол Улсад үр дүнтэйгээр хэрэгжүүлнэ гэсэн магадлал онцор байгаа эсэх;

Мөн хууль тогтоох үйл ажиллагаанд эрх зүйн рецепцийг хэрэглэхдээ нэгд, тодорхой үзэл баримтлал, юуны омно үндэсний тогтолцоо, түүний хамаарах бүлээс хоёрт, ойртож буй хууль тогтоомжийн талаас нь харгалzan үзэж зээлдэн авч нутагшуулах нь зохистой юм. Тэгэхдээ тухайн хуулийн үр ашигтай болох нь бусад орны туршлагаар батлагдсан хэдий ч өөрийн ороонд рецепцилэн авч хэрэглэхдээ шууд хуулбарлах бус үндэсний соёл иргэншил, уламжлалт заншил, онцлог зэрэг бодит нохшийг иэн түрүүнд харгалzan үзэх ёстой юм. Тодруулбал, үндэсний онцлог (уламжлал, түүх, соёл, үндэсний эрх ашиг, монгол хүний аж төрөх онцлог, үндэсний аюулгүй байдал) -ийг зөв гаргах нь эрх зүйн рецепци хийхэс илүү чухал асуудал билээ. Гуравдугаарт, Хуулийг томъёоюу нь чухал үүрэгтэй бөгөөд тухайлбал, хэл зүйн онолын судалгааг явуулах, хэлний зүйн дүн шинжилгээ хийх арга барилыг ашиглах нь зүйтэй юм. Түүничлэн эрх зүйн бүрдлийг ойлгомжтой байхад анхаарах нь зүйтэй бөгөөд харин түүнийг шүүн тунгаахдаа эн тэргүүнд тоо тоймшигүй олон хууль гаргахаас урьдчилан сэргийлэх нь зүйтэй. Хуулийн төлөвлөлтийг оновчтой болгоходо юуны омно хуулийн зорилт, зорилгын тоссоолол, толовчлолтойг боловсруулахад анхаарвал зохино. Тодруулбал, хуулиар зохицуулах зүйл болсон иймгийн харилцааг шинжлэх ухааны шалгуураар бүлэглэх арга зүйг оновчтой хэрэглэх хэрэгтэй байна.

**2. Зохицуулалт шаардсан харилцааны мон чанар, хувьслмын чиг хандлагыг судалж ухаарах.** Аливаа шинжүүх ухааны зорилгод судалж буй үзэгдэл, харилцааны чиг хандлагыг тогтоож прогнозчилох асуудал чухал ач холбогдолтой. Энэхүү шаардлагын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд хуулийн төслийг боловсруулах, батлах үед оршин буй харилцааных нь хөрсон дээр боловсруулан дүгнэж батлан гаргахаасаа илүү тухайн зохицуулалтыг шаардаж буй харилцааны цаашдын ирээдүйг харах хэрэгтэй байна. Тодруулбал, тухайн зохицуулалтыг шаардаж буй тэрхүү харилцааг олон онцгөөс харж, дүгнэж тодорхойлох шаардлагатай байна. Хуулийн зохицуулалт шаардсан ямар ч харилцаа өөрөө маш олон талтай учраас тийм бололцоог олгож байгаа юм. Өөроөр хэлбэл, оршин буй харилцааныхаа хөрсон дээр боловсрогдсон хууль цааш ирээдүйдээ эрх зүйн зохицуулалтын механизм болж чадахгүй гэсэн уг буюу хуулийн эцсийн зорилго бол хууль байхад биш идэвхитэй үйлчилж нийгмийн харилцааг тогтвортой зохицуулахад оршино. Энэ талаар академич С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" номондоо: "Хууль тогтоогчид эрх зүйн хэм хэмжээг толгойдоо юу гэж бодож санасан дур зоргоороо гаргаж, эрх зүйн түүхэн хэв маягийг өөрчилж болохгүй. Хууль тогтоогчид эрх зүйн заалтын тусламжтайгаар гагихүү нийгмийн харилцааны хөгжлийн эрэлт хэрэгжээг хуульчлан томъёоддог"<sup>1</sup> хэмээн дүгнэн хэлсэнтэй санаа нийлж байна.

**3. Нийгмийн санаа бодол, эрдэм шинжилгээний байгууллагын мэргэшсэн судлаачдын санаа бодлыг авах.** Хууль тогтоох үйл ажиллагаанд эл асуудал дутагдсан хэвээр л байна. Энэ ажлыг гүйцэтгэх гол байгууллага нь Тамгын газрын дэргэд ажиллах судалгааны алба юм. Оноөдор ажиллаж буй судалгааны төв нь чадавхидаа тааруулаад захиалгат судалгаа, мэдээлэл лавлагаанаас

<sup>1</sup> С.Нарангэрэл. Монгол ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 74 дэх тал.

цааш хэтэрч чадахгүй, өөрийн гол үүргээ сонгодог утгаар нь хэрэгжүүлж чадахгүй байна гэж хэлж болно. Зарим улс оронд ийм төрлийн үүрэг гүйцэтгэдэг байгууллагыг хууль зүйн шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ-судалгааны гол төв гэдэг утгаар нэр хүнд бүхий Хууль зүйн сургуулиудад байгуулан ажиллуулж байна. Энэ байгууллага нь өдгөө дэлхийн олон улс оронд байгуулагдаж байгаа нь үр дүнтэй байна гэсэн баталгаа болж байгаа учраас манай улс ч байгуулан ажиллахад илүүдэх юун. Мен "Хууль тогтоох онол, арга зүй" гэсэн нэртэй хичээлийг хууль зүйн сургуулиудийн сургалтын төлөвлөгөөндөө оруулан бие даасан хичээл<sup>2</sup> болгон үзэхийн сацуу энэ асуудлыг "Эрх зүйн онол" хичээлийн судлах зүйлийн нэг гэж үзжээ байна.

#### **4. Парламентын чадавхийг сайжруулах (сайн парламент бол сайн л хууль батлан гаргана, муу парламент бол муу хууль л батлан гаргана гэсэн үг)**

Хууль бол улс төрийн бодлогын томъёолсон илэрхийлэл, хэрэглүүр<sup>3</sup> учраас улс төрийн бодлого хууль тогтоомжийн уялдаа хамаарлыг нарийн судалж, хуулийг улс төрийн бодлогын алдаа гажуудлаас хамгаалах, улс төрчдийн аминчхан, явцуурсан үзлийн түр зуурын хэрэгслэл болохгүй байх хууль зүйн болон бусад арга, хэрэгслийг шинжлэх ухааны үүдиэс судалж боловсруулах шаардлага улам хурцаар тавигдаж байна. Энэ нь нийгмийн харилцааг хүний сайн сайхан шийтгэг эрх ашгийн толоо зохицуулж буй хууль улс төрчдийн бүрэн эрхийн хугацааны хүсэл зориг болчих вий гэсэн болгоомжлолыг төрүүлж байна. Ногоо талаас нь авч үзвэл, Улсын Их Хурлаас батлагдан гарч буй хуулиудад хуулийн чанар, агуулга, үр дүн, тогтвортой үйлчлэх

<sup>2</sup> Christopher, E. Legal techniques NSW., 2002, болон Капшитта Т.В. Юридическая техника М., 2011.

<sup>3</sup> Б.Чижээр. Зохицтой тогтолцоог баримжсаныг нь эрх зүйн шинжилгээний үр дүнтэй хэрэгжүүлж ундаа болох нь (Олон улсын сийнээзүүнд тавьсан исгэлээ). Төрийн захиргаа сэргүүл. УБ, 2002. 252 дэхь тал.

шинж буюу "амин сунстэй хууль" чамлалттай байна. Энэ нь юуны өмнө хуулийн төслийн боловсруулалт муу байгаагаас буюу хууль тогтоох үйл ажиллагааны техниктэй холбоотой юм.

**5. Хууль тогтоох үйл ажиллагаанд түгээмэл болон танин мэдэхүйн аргуудыг зохицой ашиглах.** Хууль тогтоох үйл ажиллагаанд судалгааны зөв арга, гүн ухаарал, бүтээлч хандлага шийдвэрлэх үүрэгтэй. Өнөөдөр хууль тогтоох үйл ажиллагааны үе шатанд судалгааны аргыг буруу хэрэглэсэнээс олон орны хууль тогтоомжийг харьцуулан дүгнэхэд алдаа гарах магадлал их байна. Тийм учраас ялангуяа срөнхий танин мэдэхүйн үүднээс дүгнэлт хийхэд алдаа гардаг хэдэн тохиоддол байдгийг Б.Чимид багш иэгтийн томъёолсноор ". . . объектыг буруу сонгон авах; улс орныхоо бодит нөхцөл байдалыг зөв харгалзан үзэлгүй хуулбарлах; эрх зүйн шинжлэх ухааны тодорхой үзэл баримтлалыг оорийн орны нөхцөл байдалд тохиорох эсэхийг үл харгалзах; эрх зүйн бүл, аймаг, салбар, дэд салбар, төрөл хэсэг (институт) гэх зэргийн "ойлголт", оорөөр хэлбэл эрх зүйн тогтолцооны оөр оөр бүтцийг харгалзахгүй, өөрийн болгох; хууль, эрх зүйн шинжлэх ухаан, мэргэжлийн хэвшсэн нийтлэг ойлголт, зарчим, нэр томъёо, загварыг тоомсорлохгүй буюу буруу дутуу ухаарах; эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд, түүний дотор хууль тогтоомжийн болон хууль зүйн бусад арга хэрэглүүрийн хоорондын уядцаа, тэнцлийг үл харгалзах"<sup>4</sup> гэсэн асуудлуудал юун түрүүнд анхаарлаа хууль тогтоогч нар хийгээд төсөл боловсруулагчид хандуулах ёстой юм. Ийм алдаа гаргахгүйн тулд **харьцуулсан эрх зүйн онол сургаалд үндэслэн шинжлэх ухааны арга зүй, аргачлалаар нарийн нягт судлах хэрэгтэй байна.**<sup>5</sup>

<sup>4</sup> Н.Лүндиндорж. Төр, эрх зүйн сангиээсний хөгжлийн хандлага. УБ., 2002. 252 дэх таз.

<sup>5</sup> Мон нам. 253 дэх таз.

Эрх зүйн шинжлэх ухаан нь аль иэг улсын эрх зүйн системийн зарчмууд, журам заалтууд болон стандартуудыг тайлбарлах техникийг агуулаад зогсохгүй нийгмийн элдэв зорчилдлоонийг саатуулах буюу зохицуулах арга замыг иэж олохыг мөн оортоо багтаадаг гэж үзвэл эрх зүйн харьцуулалтын арга барил аль иэг ганц улсын дотоод эрх зүйн өгч чадахаас хамаагүй илүү баялаг зохицуулах арга замуудын хувилбар, сонгох боломж өгч чадах нь тодорхой. Учир нь гагицуү өөрийн орны эрх зүйн тогтолцооны дотор бүгсэн ямар ч сэтгэлгээ сайтай хуульчийн бүх насаараа бодож олж чадах бүх арга замуудаас дэлхийн олон янзын эрх зүйн системүүд нь зохицуулах арга замуудыг хавьгүй илүүтэй олон хувилбараар өгч чадна. Эрх зүйн харьцуулалтын практик ач холбогдол бүхий 4 гол үүргийн иэг нь эрх зүйн харьцуулалт бөгөөд энэ арга нь хууль тогтоогчдод тусламж болох явдал юм<sup>6</sup>. Учир нь өөрийн орны хууль, эрх зүйг илүүд үзэж, дотроо асуудлыг шийдвэхийг чармайх нь түгээмэл боловч илүү оргон хүрээгээр тухайн асуудлыг харах боломжкоор хангадаг тул өнөө үеийн хууль тогтоогч (Улсын Их Хурлын гишүүн) нар оортоо хэрэгтэй шийдлийг "Эрх зүйн харьцуулалт"-аар тодруулбал, оор орны хууль тогтоомжийг анхаарч судлах замаар олж авах нь зов юм.

Харьцуулалт бол аливаа юмс үзэгдлийн адил тосвөтгэй ба ялгаатай тал, шинжүүдийг тогтоодог. Шинжлэх ухааны харьцуулалтыг үр дүнтэй болгоход хоёр үндсэн шаардлага тавигдаж байдаг байна. Эхний гол шаардлага бол харьцуулах гэж буй хоёр буюу түүнээс дээш олон объектод ямар иэг илэрхий бодит нийтлэг шинж байх явдал юм. Хэрэв иэг объектын гол шинжийг оөр иэг объектын гол биш шинжтэй харьцуулбал түүний танин мэдэхүйн үр дүн худал буюу хоосон байх болно. Тодруулбал, эрх зүйн харьцуулалтын бүрэлдэхүүнд:

- харьцуулалтанд хамруулсан зүйл (comparatum)

<sup>6</sup> Б.Чижигд. Үндсэн хувьшиг үзэж баримталаз: нийтэх асуудал. УБ., 250-253 дарьжат

- харьцуулах зүйл (comparandum)
- холбогч (ter ium comarationis) Энэ нь дээрх хоёр зүйлийн дундаж онцлог, хоёуланд нь байх шинж чанар богоөд энэ шинж чанар дэр уг хоёр зүйл тохирч, үүний дунд харьцуулалт хийх боломж огогддог.

**Нэгдүгээрт:** Хууль тогтоогч (хуулийн төсөл боловсруулагч) нь хамгийн түрүүн ямар эрх зүйн бүлийг өөрийн хийх гэж буй харьцуулалтад хамруулах вэ гэдгийг шийдэх хэрэгтэй. Бүх эрх зүйн тогтолцоог "Эх" болон түүнд нэгдсэн "гишүүн" гэсэн хоёр том бүлэгт хувааж болно. "Эх" эрх зүйн систем нарийн бодож боловсрогжсон байдаг богоөд бусад системүүд тогтмол түүнийг хуулбарлан авах буюу дуурайdag.

**Хоёрдугаарт:** судалгааныхаа хүрээг хaa хүргэл тэлж болох тухай асуудал юм. Энэ талаар срөнхий чиглэл огоход хэцүү байдаг ба энэ нь тухайн судалгааны тодорхой сэдвээс хамаарна. Хэрэв, олон янзын эрх зүйн систем түүний хэв маяг, загварыг харьцуулж байгаа бол судалгааныхаа хүрээг срөнхийдөө эрх зүйн бүлүүдийн эх системүүдээр хязгаарлаж болно. Харин тодорхой ямар нэгэн асуудлаар дагнан харьцуулалт хийж байгаа бол дараах журмыг мөрдөж болно. Иргэний эрх зүйд, ялангуяа гэрээний, омчийн эрх зүйд "сонгодог" асуудлууд байдаг. Эдгээр болон Америкийн эрх зүйг, Ромын бүлээс Франц, Италийн эрх зүйг, Германы эрх зүйн бүлээс Герман, Швейцарийн эрх зүйг судлахад хангалттай. Мөн онолын шинэчлэл ховорхон хийгддэг тул Скандинав системүүдээс Швед, Данийн эрх зүйг судалгаанд хамруулбал зохицжтой. Эдгээр эрх зүйн асуудлуудаас гадна бүх орны хууль тогтоогчид адилхан зууралдааж буй чухал асуудлууд байдаг. Ийм үед бүр жижиг системийн бодож боловсруулсан шийдлийг ч анхааралдаа авах шаардлагатай болох нь олонтоо. Жишээ нь, Израйль гэрээний стандарт-хэлбэртэй холбоотой асуудлыг шийдэх тал дээр илүү амжилттай байна. Ослын нийгмийн даатгалын арга замаар автозамын ослоос үүдэлгэй хохирлыг барагдуулах талаар Канадын Саскатчеван муж, Польш, Финляндын хамт дэлхийг тэргүүлж

байна. Мөн гэр бүлийн салбарт Скандинавын улсуудын системээс суралцах зүйт илтээд их. Тухайн орны эрх зүйн системд шинчилгэ, оорчлоулт хийхэд уг системд хамгийн их нолоөтэй системийг эрх зүйн харьцуулалтад хамруулах шаардлагатай байдаг байна.

**Гуравдугаарт:** Хууль тогтоогч (хуулийн төсөл боловсруулагч) харьцуулахаар сонгосон гадаад орны хууль тогтоомжийг өөрийн орны системд дассан нүдээр хардаг, өөреөр хэлбэл, хэрэгтэй шийдэл, арга замыг харийн эрх зүй дотор хайхдаа өөрийн системд олж сурсан газраа эрдэг тохиолдол олон. Ингэж буруу газар хайснаас гадаадын эрх зүйн систем тухайн асуудлыг зохицуулаагүй, гадаадын системээс авах юм байхгүй гэсэн дүгнэлтэд хүрнэ. Гэтэл эрх зүйн системүүдийн өөр хоорондоо ялгагдах гол ялгаа нь тухайн асуудлыг өөр өөр замаар шийддэгт байх богоод үүний улмаас уг асуудалц өгсөн шийдэл тухайн эрх зүйн системийн хaa ч, мөн системээс гадуур ч одож болно гэдгийг санах хэрэгтэй юм.

**Доровдүгээрт:** Эрх зүйн нэр томъёоны сан бүрдүүлэх хэрэгтэй. Судалгааны явцад судалгаа, харьцуулалт хийж байгаа изгээнийг хэрхэн нэрлэх, юу гэж ойлгох талаар хундрэл гардаг. Ямар нэгэн уг буюу хэлтэг харьцуулалтад хамруулсан бүх системийн хувьд яг тэр утгыг илэрхийлж адилхан асуудлыг хамрах тохиолдол бараг угүй. Иймд эрх зүйн харьцуулалтын үйл явцын дараагийн алхам болох "эрх зүйн нэр томъёоны сан" байх шаардлагатай. Үүний тулд тусгай өгүүлбэр зүй болон үгсийн сан боловсруулах хэрэгтэй. Энэ нэр томъёоны сан нь маш уян хатан байх шаардлагатай богоод өөр хоорондоо зорүүтэй боловч гүйцэтгэх үүргээрээ харьцуулж болох институциудыг өөртөө багтаахын тулд ойлголтуудыг хангалигтай өргөн хүрээгээр авсан байвал зохино. Сүүлийн жилүүдэд хууль зүйн нэр томъёоны толь хэд хэд гарсан нь олзуурхууштай юм.

Хууль бүтэх (тогтоох) үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг дээшилүүлэхэд шууд нолоо үзүүлэх эрх зүйн гол хоёр эх сурвалж бол **Хууль тогтоомжийн тухай хууль, Улсын Их**

**Хурлын хуралдааны дэгийн тухай хууль хоёр юм.** Энгэрсэн онд баталсан, ирэх оноос хэрэгжиж эхлэх Хууль тогтоомжийн тухай хууль нь хуулийн төсөл боловсруулах, санаачлах ажилд ахиц давшил авчирна гэж найдаж байгаа юм. Аих 1993 онд Улсын Их Хурлын даргын захирамжаар “хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалт”-ыг баталсан байдаг богоод энэ аргачлалын дагуу 1997 он хүртэл хууль тогтоомжийн төслийг боловсруулж хэлэлцэн баталдаг байсан. Хууль тогтоомжийн тухай хууль нь улс орны бодлогыг тодорхойлох, хууль тогтоомжийг санаачлахаас эхлээд хэрэгжилтийг хангах хүртэлх бүхий л асуудлыг нэг дор, цогц байдлаар зохицуулж, агуулгыг тодорхойлсон нь одоогийн эрх зүйн орчиниг илүү давшилтгэй болгож, сайжруулсан гэж үзэхээр байгаа юм. Тухайлбал хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дараах зохицуулалтууд иэмзгэсэн.

1. Хуулийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүднээс Засгийн газар б 6 аргачлалыг баталж, мөрдүүлэх;
2. Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийх;
3. Хуулийн төсөл боловсруулахын өмнө түүний хэрэгцээ шаардлагыг холбогдох аргачлалын дагуу урьдчилан таандан судлах;
4. Хэрэгцээ шаардлагыг судалсны үндсэн дээр хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулах;
5. Хуулийн төслийн үзэл баримтлалд тулгуурлаж хуулийн төслийг холбогдох аргачлалын дагуу боловсруулах;
6. Хууль санаачлагч хуулийн төслийн үр нелоөг холбогдох аргачлалын дагуу үнэлэх;
7. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг аргачлалын дагуу тооцоолох;
8. Хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авсан байх;

9. Хууль тогтоомжийн төсөлд санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлгүүлэх;
  - a. Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах
  - b. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах
10. Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангагдаг байхаар шинэ тогтолцоог бий болгосон;
11. Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлсэн тохиолдолд эрх зүйн дүгнэлт гаргуулж хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тогтолцоог бий болгосон;
12. Парламент, УИХ өөрийнхөө баталсан хуулиа олон нийтэд хүргэх үүргийнхээ дагуу яаж ажиллахыг тодорхой болгосон зохицуулалтыг оруулсан;
13. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах нийтлэг журмыг хуульчилсан;
14. УИХ ЗГ хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үзэлгээ хийх ажлыг хийхээс гадна хөндлонгийн байгууллагаар үзэлгээ хийлгэх зэргээр хамтарч ажилаж болохоор зохицуулсан.

1) Хуулийн тосол боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах үүднээс Засгийн газар б 6 аргачлалыг баталж, мөрдүүлэх Хуулийн тосол боловсруулах арга зүйн асуудлаар зовломж, аргачлал гаргах, хууль зүйн нэр томьёог нэг мөр болгон жигдлэх арга хэмжээ авах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал”, “Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд үзэлгээ хийх аргачлал”, “Хуулийн төслийн зардлыг тооцох аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал” гэсэн 5 аргачлалыг 2009-2011 онд баталсан байдал бэгээд энэ нь зовломж, арга зүйн шинжлэлийн байсан

тул хуулийн төсөл боловсруулахад төдийлон хэрэглэгддэгтүй байсан. Үүнийг сайн дагаж мордсон бол тослийн шинжлэх ухааны үндэслэл нэмэгдэх байсныг хэлэх хэрэгтэй.

**2) Хууль санаачлагч хууль тогтоомжийн тослийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийх;**

Хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг тодорхой үе шат бүхий дарааллаар хийхийг хуульчилж өгсөн. Үүнд:

- > хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;
- > хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;
- > хууль тогтоомжийн төслийг боловсруулах;
- > хууль тогтоомжийн тослийн үр нолооний үнэлгээ, зардлын тоошоог хийх;
- > эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдох иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн тослийг хэлэлцүүлж, санал авах;
- > хууль тогтоомжийн төсөлд холбогдох торийн болон төрийн бус байгууллага, мэргжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;
- > хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авах;
- > хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
- > хууль тогтоомжийн теслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд оргон мэдүүлэх.

**3) Хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах**

Хууль тогтоомжийн төслийн үр нолоог урьдчилан тандаж судлах нь аливаа асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлон, тухайн асуудлыг шийдвэрлэх

зохицуулалтын хувилбаруудыг илрүүлж, тэдгээрийн зергэ болон серег талуудыг харьцуулан судалж, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлоог урьдчилан тооцсоны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг шийдвэр гаргагчид санал болгоход оршино.

#### **4) Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;**

Хууль тогтоомжийн тосол боловсруулахын омни тухайн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах нь хуулийн чанар, үр нөлоог дээшилүүлэх, хэрэгжих баталгааг хангах чухал иехцэл болох ба энэ нь ирээдүйд батлагдан гарах хуулийн гол агуулга, үзэл санааг тодорхойлж байгаа хэрэг юм.

Хууль санаачлагч /Ероихийлогч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар/ хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох ба хууль санаачлагчийн огсон удирдамж, чиглэлийн дагуу тухайн төслийг хариуцан боловсруулах мэргэшсэн хуульч, шинжээч, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг ажиллах нь илүү тохиромжтой.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулах богоед хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагага, хууль тогтоомжийн зорилго, ероихий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал болон хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд ижмэлт, верчилгээр оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал зэргийг тусган үзэл баримтлалын төслиө боловсруулна.

## **5) Хууль тогтоомжийн тосол боловсруулах**

Хууль тогтоомжийн тослийг боловсруулахдаа холбогдох аргачлалын дагуу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тухайн харилцааг хуулиар зохицуулахаар шууд заасан, эсхүл хууль тогтоомжийн тослийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.

Хууль тогтоомжийн тосол боловсруулахад тухайн хуулийн хэрэгцээг тодорхойлох нь чухал богоод хэрэгцээг тодорхойлоход хэд хэдэн асуудлыг судлан үзжээ тогтооно. Үүнд:

- Нийгмийн тодорхой харилцааг үүсгэх, өөрчлох, дуусгавар болгоход чиглэх эсэх;
- Тухайн зохицуулалт нь Монгол Улсын газар нутгийг бүхэлд нь хамрах эсэх;
- Иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад эрх олгох буюу үүрэг хүлээнгэх эсэх;
- Тухайн харилцааг зохицуулах оор бусад арга зам байгаа эсэх;
  - ✓ Цаашид үүсж болох сөрөг үр дагавар болон нийгэм тухайн зохицуулалтыг хүлээн авахад бэлэн эсэх, тодорхой хэмжээний хүлээлт бий эсэх;
  - ✓ Тухайн асуудлаар хууль батлах ажлыг хүлээнгэх боломжгүй байгаа нохцол шаардлага, түүнчлэн тухайн асуудлыг хэсэгчлэн, эсхүл цогцоор нь зохицуулах шаардлагатай байгаа эсэх.
- Тухайн харилцааг хуулиар зохицуулснаар бий болох үр дагавар нь түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зөвтгож байгаа эсэх;
  - ✓ Тухайн зохицуулалт нь нийгэм, здийн засаг, шинжлэх ухаан, техник, хууль зүйн хувьд бий болох үр дагавар, ач холбогдол нь зерэг талыг бий болгох бол;
  - ✓ Тухайн зохицуулалт бий болсноор нийгэмд үзүүлэх здийн засгийн зардал нь нийгэмд эргээд илүү сайнаар нөлоюу бол.

Хуулийн төсөл боловсруулахад төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна:

- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд ийцээн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзл баримтлалтай уялсан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;
- Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зорчилгүй байх;
- Хэм хэмжээ тогтоогоогүй, тухагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;
- Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, эз тохиолдолд эшигээнийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;
- Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нохцол байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;
- Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зорчсон этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин тоголдор болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдох журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;
- Шаардлагатай тохиолдолд бусад хуульд измэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагаддах хуулийн төслийг боловсруулсан байх;
- Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлгэй байж болох

бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана. Эдгэр шаардлагуудаас гадна хуулийн тосол боловсруулахад нэр томьёо, хуулийн төслийн хэл зүй, найруулга зүй, товчлол, ишлэл зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

Эрх зүй, хууль тогтоомжийн системчлэлийг шинэ түвшинд гаргах шаардлага буй болоод удахж байна. Хууль тогтоомжийн системчлэлийн үндсэн гурван аргын аль алийг нь хэрэглэж ирсэн туршилага бидэнд бий. Гэхдээ төрөлжүүлэн хуульчлах (Кодификаци) үйл явц удаашралтай, ийнгмийн харилцааг зохицуулагч хуулийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч тэдгээр хуулиудын давхардал бий болж иэг төрөл харилцаанд олон жижиг хуультай болсон нь кодификаци хийн төрөлжүүлэн хуульчлах хэрэгтэйг харуулж байна.

2002 онд Иргэний хуулийг шинэчлэн баталсныг эс тооцвол манайд төрөлжсен хууль гарч чадахгүй явж ирсэн. Харин 2015 онд Зорчлийн тухай хууль батлагдан гарч 2017 оны 7 дугаар сарын 1 ийсээхэлэн дагаж мerdeхеөр болсон нь том ахиц дэвшил болсон гэж үзэж байна. Нийт 224 хууль тогтоомжуудад байсан захиргааны зөрчил, хариуцлагын арга хэмжээнүүдийг иягтгэн улмаар эрүүтийн хуультай ийнцүүлэн хуульчилснаар зорчлийн тухай хууль гарч байгаа юм.

Байгаль орчны тухай хуулиуд, ийнгмийн халамж, даатгалын тухай хууль тогтоомж, газрын тухай хууль тогтоомж гэх мэтээр төрөлжүүлэн хуульчлах шаардлагатай салбарууд байна. Манай улс онгорсон онц ОХУ-ыг дууриаж сонгуулийн кодекс хуультай болох оролцлого хийлээ. Гэхдээ энэ нь зохицуулж буй харилцааны онцлогоос хамаарч үр нөлөөтэй байх эсхийг цаг хугацаа харуулна.

Хууль олиоор төрж байгаатай холбоотойгоор Хууль зүйн яамнаас оргөтгөсөн ажлын хэсэг гарч хуулиудын давхардыг арилгах кампанит ажлыг хийснээр 2009-2011 оны хооронд 298 хуульд эрх зүйн цэвэрлэгээ хийсэн байна. Үүзэс хойш 5, 6 шахам

жил өнгөрөхөд дээрх цэвэрлэгээг дахин хийх шаардлага мөн л гарч ирж байна.

Багц хууль гэдэг ухагдахуун бий болоод удаж байна. 1990 эд оны эхийд Татварын тухай багц хууль, Боловсролын тухай хууль гээд л эхэлсэн түүхтэй. Ямарч л байсан **Багц хуулийн** хувьд оор хоорондын уялдаа холбоо (булг, зүйл заалтууд төдийгүй зохицуулж буй асуудал хүрээний хувьд тухайлбал, батлан хамгаалах салбарын хууль тогтоомж шүүхийн багц хууль гм) -той байхыг хууль тогтоомжийн тухай хуульд бэхжүүлж өгөх шаардлага тавигдсан юм.

Багц хуулийн тосол гэсэн зүйлийг бий болгож Хууль тогтоомжийн тухай хуулийн 26 -р зүйлд заахдаа:

26.1 Засгийн газар тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн тослийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багц хуулийн тослийг боловсруулж, өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд хууль тус бүрийн үзэл баримтлалыг тодорхойлно гэсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг Улсын Дээд Шүүх тайлбарлах эрх, үүрэгтэй. Энэ эрх, үүргийг яаж хэрэгжүүлэх вэ? гэдэг асуудал нийтэн маргаан дагуулж буй юм. Шинэ Үндсэн хууль мөрдөгдсөнөөс хойшхи нийтээд хугацаанд (2012 он хүргэлх) Улсын Дээд Шүүх норматив тайлбар буюу хуулийн зүйл заалтыг тогтоолын хэлбэрээр тайлбарлаж ирсэн. Улсын Дээд Шүүхийн тайлбар нь Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэл рүү халдсан шинжтэй гэсэн шүүмжлэл удаа дараа гарсантай холбогдуулан шүүхийн тухай хуулиар казуальний буюу шүүх хэрэг маргааныг шийдвэрлэсэн жишиг нь тайлбар болох агуулга бүхий заалт орсон. Энэ нь бас л хяналтын шатны шүүхийн шүүгчийн шийдвэр Улсын Дээд Шүүхийн тайлбар болж чадах уу гэдэг асуулт тавигдаад хүрч байна. Гэсэн ч урдах тогтоолууд ч, хэрэг маргаан таслан шийдвэрлэх практик ч аль аль нь албан ёсны тайлбарт багтана. Энд нэг зүйл тэмдэглэхэд сүүлийн жилүүдэд

Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарлах үйл ажиллагаа зогсонги байдалд орсныг хэлэх байна.

Шүүхийн тухай багц хуульд энэ мэгт үзэл баримтлалын шинжтэй маргааны асуудлууд байгаа нь хууль бүтээх (тогтоох) -д нарийн бодож тооцсон, шинжлэх ухаач хандлага үгүйлэгдсээр байгааг харуулж байна.

## **АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ**

1. Б.Чимид. Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэлгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болох нь (Олон улсын симпозиумд тавьсан илтгэл). Төрийн захиргаа сэтгүүл. УБ., 2002. 252 дахь тал.
2. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлог асуудал. УБ., 250-253 дахь тал
3. Д.Лундээжанцан. Л.Өлзийсайхан. Парламенттат ёс. УБ., 2005.
4. Кашанина Т.В. Юридическая техника М., 2011.
5. Н.Лундээвдорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 252 дахь тал.
6. С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001. 74 дэх тал.
7. Chritopher. E. Legal technique NSW., 2002.

## THESIS: ISSUES OF IMPROVEMENT OF THE SCIENTIFIC BASIS FOR LAW MAKING PROCESS

Law making process is in intersection of many humanitarian disciplines and it is a relation inherited from the nation's social life patterns, which should be viewed from a different perspective of each discipline. Also, it is an independent issue of the science mixed with legislative values among the human history.

This comprehensive activity which can be similar to creation of a queen's crown includes: *First*, legislative tradition of the nation mixed with modern classic theories considering worldwide standards; *Second*, study of the nature and evolution of the relations that require legislative regulations; *Third*, to study social mind and academic organizations' proposals; *Fourth*, improve the capabilities of the Parliament which is the main subject to law making process; *Fifth*, the main requirement to rationally apply the scientific cognition methods in a rational basis.

The above requirements are the main conditions to improve scientific justifications of the legislation the following activities in all levels of legislation:

- Initiate law drafts and submit to the State Great Khural;
- Discuss and approve the laws (Standing Committees and Plenary Sessions);
- Verify and publish the laws.

Therefore, the presentation highlights that the above main requirements must be as important as the investigation of the real needs of the legal regulation, development of the concepts of the draft laws, and implementation of the draft laws likewise the development of the draft laws.

We consider that the presentation has new and practical significance by mentioning all the methods to create laws, using the comparative study in it, and aiming to determine the improvement methods.

# ХУУЛИЙН АМИН СҮНСИЙГ ЧИНГИС ХААНЫ ӨВД ТУЛГУУРЛАН СУДАЛСАН НЬ

С.Наранчэрэл

Академич, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтийн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, Шихихутуг Их сургуулний хүндэт доктор

Монгол улс 1990-ээд оны эхиээс эхлэн асар их ортогтэй хууль тогтоох байнгын байгууллагыг буй болгон “хуулиудыг үйлдвэрлэх” үйл ажиллагааг маш эрчимтэй явуулж ирсэн билээ. Өнгөрсөн 25 жилийн туршид нийтдээ 500 гаруй хууль баталж, бараг байгууллага бүр хуультай болсон. Гэвч эдгээр хуулиуд бидний хүсэн хүлээсэн хөгжил цэцэглэлтийг эх оронд маань авчирч чадсангүй.<sup>1</sup> Ийм учраас эл илтгээд хуулийн амин сүнс чухам юу болохыг шинжлэх ухааны үүдиэс шинжлэхийг оролдов.

## Хуулийн амин сүнсийн талаарх тэргүүлэх үзэл баримтлал

Хуулийн амин сүнсийн талаар дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлалыг суут сэтгэгч, францын соён гэгээрүүлэгч Ш.Монтесъко одоогоос 250 гаруй жилийн өмнө “Хуулийн амин сүнс” (1748 он) хэмээх алдарт бүтээлдээ бичсэн хэмээн судлаачид үздэг. Суут сэтгэгч Ш.Монтесъко хэдийгээр хорвоогийн бүх улс оронд ёс суртахууныг өргөн дээдэлдэг<sup>2</sup>,

<sup>1</sup> Илтгэлч магий бил бүр одоогоос 15 жилийн анио 2001 онд “Форсажт нийтийн үед магий бил бий болсон хуулийн үер буулт сайн, ухаалаг хуулийн зүйн тогтолцоог тайвчжиг бүхий з хийд бэрх, түрү исцүүдлүүд шийдвэрлэлдэх юм шаар бодлыг аюул хийд төрүүлж байна. “Баату хууль байвалад оршиж чиньдрэж ч сайнтархи даа” эхийн бодлас байсан. Гэвч мийн нийд бил бий баясанчийр Хуулийн гаралд з байсан бэхжүүлж аюул хэрэг байрандаа байсандр з байна. Үүний дараа хуулийн шигэл алдарт, эрэлээж шинжлэлээх лөдөг газар авах болжээ” гэж бичсэн байсан билээ. - С.Наранчэрэл Монголын ба дэлхийн эдгээрийн тохижуулж... Улаанбаатар, 2001, 210-211 дэх мал.

<sup>2</sup> Шарын Монтесъко Хуулийн амьт сүрье..., францаас монголчжсон Т.Тамирчын..., Монгудор, Улаанбаатар, 2009, их дэх татыг үзүүлж юу.

хууль хүний оюун ухаан,<sup>3</sup> хууль ард олны тулд бүтээгддэг<sup>4</sup> хэмээн бичсэн боловч хуулийн амин сүнсийг тэрбээр засгийн газар бурийн мөн чанар, зарчмаас эрэлхийлж, учир нь гэвэл, энэ зарчим хуульд дээд зэргийн нөлөө үзүүлдэг. Үүнийг таныж мэдэх гэж илээд мэрийсэн. Хэрэв тэр зарчмыг тогтоож дөнгөх юм бол хууль тэрийс угтан гардаг гэдэг нь харагдах учиртай юм<sup>5</sup> гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүгээрээ Ш.Монтесъко хууль бол зарчим гэсэн санааг гаргаж тавьсан. Энэ бүхэнд үндэслэн суут Монтесъко хуулийн амин сүнс нь хууль тогтоогчийн тусгайлсан, нарийвчлан тодорхойлсон байгууламж<sup>6</sup> гэсэн гол дүгнэлтээ гаргасан байна. Ш.Монтесъкогийн энэ дүгнэлтэн тэргүүнд хуулийг хууль тогтоогч тогтооно гэсэн санааг илэрхийлсэн. Тэрээр цааш нь хууль нь хууль тогтоогчийн тодорхойлсон тусгай байгууламж гэж үзсэнээрээ хуулийг хууль тогтоогчдын үзүүлэхүй эрх мэдлийн асуудал болгон хувиргажээ. Ш.Монтесъко энэ санаандaa тулгуурлан хуулийн амин сүнс нь эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн турван хэсэгт тэнцвэржүүлэхэд оршино гэсэн дүгнэлт хийсэн юм.

Ш.Монтесъкогийн хууль ёс суртахуунаас ангид байх тухай үзэл баримтлалыг дараах үсийн сэгтэячид түүштэй үргэлжлүүлсэн билээ. ХХ зуунд Монтесъкогийн үзэл баримтлалыг орчин үсийн эрх зүйн онолын шилдэг төлөөлөгч Ханс Кельзин түүштэй үргэлжлүүлэн “Ёс суртахууны хэм хэмжээ... нь эрх зүйгээс ангид мөн чанараа хадгалж, эрх зүй болж хувирдагтүй билээ”<sup>7</sup> хэмээн бичсэн нь эдүгээгийн эрин цагийн эрх зүйг тодорхойлж байгаа билээ. Орчин үсийн бараг бүх улс гүриүүдийн Үндсэн хууль, түүний дотор 1992 оны

<sup>3</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 5 дахь тагын үзүүлүү.

<sup>4</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 6 дахь тагын үзүүлүү.

<sup>5</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 6 дахь тагын үзүүлүү.

<sup>6</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 273 дахь тагын үзүүлүү.

<sup>7</sup> Ханс Кельзин Хэм хэмжээний тухай срэгийн оног..., герман хэлээс өргүүлсэн М.Хатшабатар., Уланбаатар., 2013, 37 дахь тагын үзүүлүү.

Монгол улсын Үндэсний хуулийн үзэл баримтлал Ш.Монтесъекийн дэвшүүлсэн, омно огүүлсэн үзэл санаанд тулгуурласан.

Ш.Монтесъко хуулийн амин сүнсийн талаарх үзэл баримтлалаа дэвшүүлжээ “Хуулийн амин сүнс” хэмээх алдарт бүтээлдээ монголчуудыг “манай дэлхийн хамгийн этгээд сонин улс”<sup>8</sup> хэмээн ирлэжээ. Энэ талаар Америкийн эрдэмтэн Жак Утерфорд “Сөргэн мандалтын үеийн зохиогчид, аялагч нар Чингис хаан болон монголчуудаар илт бахархлаг байсан бол 18 дугаар зууны соён гэгэрүүлэх үеийнхэн монголчуудыг асар уудам Ази тивийн муу муухай, соготой бүхний билэгдэл болгон Азийн эсрэг үзэл суртлыг дэвэргэв. 1748 онд Францын гүн ухаанч Монтесъко “Хуулийн амин сүнс” зохиолдоо Азийнхыг дорд үзэх эхлэлийг тавьсан бөгөөд тэдний муу муухай бүхнийг дэлхий дээрх хамгийн хачин хүмүүс гэж ирлэсэн монголчуудад хамааруулав”<sup>9</sup> хэмээн бичижээ.

Ш.Монтесъко бичихдээ “Азид томоохон эзэнт гүрэн удаа дараа байгуулагдаж байсан. Европод бол хэзээ ч тийм эзэнт гүрэн оршин тогтнож байсангүй. Юу вэ гэвэл, бидний мэдэх Ази тив илүү их тал хээр нутагтай, тэнгис далайгаар томоохон томоохон хэсэг болон таслагдсан аж. Урагшлах тусам булаг шанд нь амархан ширгэдэг, уул нурууд нь асар их цасгүй, гол мөрөн нь төдий л оргон биш тул учрах саад тогтор бага. Ингэхдээр Азид засаг төр нь ямагт эзэрхэг түрэмгий байж таарна”<sup>10</sup> гэсэн байна. Үүгээр Ш.Монтесъко монголчуудыг газар зүйн байрлал, цаг уур нь залын түрэмгийлэгчид болгон хувиргасан гэсэн санааг дэвшүүлжээ.

Тэрбээр Европ тивд чөлөөт ард түмэн харин Ази тивд зэрлэг ба бүдүүлэг ард түмэн бий гээд “Зэрлэг улс түмэн, бүдүүлэг улс түмний хооронд ялгаа бий. Зэрлэг улс түмэн нь тарж саринсан

<sup>8</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 256 дахь тал.

<sup>9</sup> Жак Утерфорд Отоогийн Ертөнцийг удээслэж эсэн Чингис хаан... орчуулсан Г.Гамбаод., Улаанбаатар., 2009, 224-225 дахь тал.

<sup>10</sup> Ш.Монтесъко, дүрдсан бүтээл, 246 дахь тал.

жижиг үндэстнүүд бегоод аль нэгэн онцгой учир шалтгаанаар хуран цугларч чаддагтуй, тэгэхэд бүдүүлгүүд нь бол нийлж нэгдэж чаддаг жижиг үндэстнүүд юм. Зэрлэгүүд нь ав хомрогоор хөөцөлддөг, бүдүүлгүүд нь бол малын ажил эрхэлдэг улс түмэн юм. Үүнийг Умард Азид тодорхой харж болно. Сибирийн улс түмэн хүйгээрээ амьдарч чадахгүй, учир нь гэвэл оорсднийгөө тэжээх амь зуулгагүй. Татарууд<sup>11</sup> бол цаг улирлын аясаар хүйгээрээ амьдарч чадна. Юу вэ гэвэл мал сүрэг нь тодорхой хугацаанд хуран нийлж болно. Тэгэхэр бүхий л бүдүүлэг овог аймаг нэгдэн нийлж болно. Яаж нийлж вэ гэвэл нэг удирдагч нь бусад олон овог аймгийг өөртөө нэгтгэсний дүнд болой. Ингэсний дараа хоёр юмнаас нэгийг л сонгох ажилтай тулгарна. Үүнд, нэг бол тарцаах, эзвол Өмнөдийн аль нэг ээзэнт улсыг байдлан дагуулахаар аян дайнд мордох ажил<sup>12</sup> гэж бичсэн байна.

XIII зууны үед Чингис хаан тархай бутархай монгол овог аймгуудыг нэгтгэх үед хүн ам нь 600-700 мянга орчим,<sup>13</sup> цэрэг дайчинд нь 100 000<sup>14</sup> хүрэхтэй үгүйтэй байжээ. Гэтэл эн үед монголчуудад үесэс үед дайсагнасан зурчидийн Алтан улс 60 сая, Хорезм 20 сая гаруй хүн амтай, аль ч талаасаа монголчуудаас илүү хөгжилтэй, асар их хүчирхэг байжээ. Оросын иэрт эрдэмтэн Лев Гумилёв “монголчуудад суурин иргэдийг эзэмдэн эрхшээх оролдхийлэл байсангүй, гагцхүү хил хязгаараа бат найдвартай тогтоож, хүчтэй бегоод хэрэгий дайсан этгээдээс унасан газар, угаасан усаа хамгаалж, хел хөсөр

<sup>11</sup> Тартар (*Tartar*) гэж II-X зууны үед одоогийн монгол хэлтэй улс түүнийг ишгэж сронхижелж изгрээх байжээ.

<sup>12</sup> Ш.Моитеевско, дүрдсан бүтээг, 253 дарь тал.

<sup>13</sup> Н.С.Турбецкий Чингис хааны өв: Оросын түүхийг орчноос бус, дорноос сохион узхай (Наследие Чингизхана. Взгляд на русскую историю не с запада, а с востока). Орос хэлээс орчуулсан Д.Цогцэлхийн... Улаанбаатар., 2015, 69 дэх талыг үзүүлүү.

<sup>14</sup> Лев Гумилев Улаанд урсасан эзэнт түрний эрэг буюу “Гэээн Ноаниы улсын тухай” домог... Орчуулсан О.Бүрээнжаргал... Улаанбаатар., 2014, 235 дарь талыг үзүүлүү.

газар аж төрөхийг л эрмэлзэн хүсч ажгуу"<sup>15</sup> гэсэн дүгнэлтээ "...монголчуудын дайсан Мэргэдийг Половчууд өмгөөлж байсан аж. Онон морноос Днепр хүрэх хийгээд Днепрээс Онон хүрэх тал хээрийн зам нэг богоод хил хязгаараа дайсан этгээдэд нээж үлдээх нь учир утгагүй хэрэг байв. Монголчууд Половецчуултгай дайсан шалтгаан чухам үүнд орших бөгөөд тэднийг Карпатын чанад руу хөөн гаргах зорилгоор монголчууд Русийн гүн рүү довтолсон юм"<sup>16</sup> гэж баталсан байдаг. Оросууд половец гуж Каспийн тэнгис, Кавказ, Хар тэнгисийн хойд хэсгийн бүс нутаг, баруун тийш Дунай морний эхэнд тулах асар уудам баруун хойд Евразийн их талд эртиээс амьдарч ирсэн түрэг угсааны иүүдэлчдийн олон аймгуудыг кипчак гэж нэрлэдэг байжээ. Европт болохлоор куман буюу коман<sup>17</sup> гэж нэрлэдэг ажээ. Энэ үед Русь нь олон тооны вант улсад хуваагдан задран бутарч, өөр хоорондоо дайсагналцаж байв. Ийм байдал нь Русийг монголын эзэнт гүрэнд дагаар ороход хүргэсэн гэдэг. Монголчуудын иөлөөнд байх үедээ Руссийн олон хот суурин ямар ч хохирол амсаагүй бөгөөд хүчирхэг Алтан орд улсын үед хөгжил цэцэглэлт зогсолтгүй явагдсаныг Оросын түүхчид өөрсдөо баталсан байна.

Хятадын түүхчдийн өөрсдийнх нь иотолсноор Хятад гүрэн Монголчуудын эрхшээлд байхдаа тархай бутархай нэгдмэл бус байдал нь эцэслэгдэж, нэгэн цаг үеийн турш чинээлтэг хангалиун амьдарч, ср бусын хөгжил цэцэглэлигэд хүрч, худалдаа үйлдвэрлэл оргожин хөгжжээ. Ойрхи дорнод, дундад Ази монголчуудын ачаар худалдаа арилжаанд иөлөө бүхий үүрэг гүйцэтгэх болжээ.

Монголчууд Евразийн их худалдааны бүсийг хөгжүүлж, Газрын дунлад тэнгисийн Венеци, Генуягаас Монголын эзэнт гүрний дундуур дайрч, Хятад хүрэх замын нутаг давсгэрийн

<sup>15</sup> Н.С. Түрбээрхийн, дүрдсан бүтээл, 69 дэх тал.

<sup>16</sup> Лев Гумилев, дүрдсан бүтээл, 69 дэх тал.

<sup>17</sup> Сүнчинаа Масалын эзэнт үүрний мандал бүүрэл, Узаанбаатар, 2015, 69 дэх таллас тодруулж үзүү.

аюулгүй, найдвартай байцлыг хангаж өгчээ. Үүний үр шимийг Европчууд, төв Азийн лалынхан, Еврейчүүд, Хятадууд, Азийн бусад улс түмэн хүртэж байжээ.

140 жилийн туршид монголчууд нэгэн үеийн амар амгалан буюу Pax Mongolica-г дэлхий дахинд авчирсан билээ. Ингэхлээр Ш.Монгесъекийн Монголчууд түүний дотор Чингис хааныг Энэтхэгээс Газар дундын тэнгис хүртэл Азийг түйвээн сүйтгэж, Персээс дориод зүгт орших бүх улсыг устган элсэн цол болгосон гэсэн үндэслэгээ түүхэн бодит үнэнд огт нийцэхгүй байна.

### **Ш.Монгесъекогоос 450 жилийн өмнөх тэсөөр үзэл баримтлал**

Чингис хаан багшдаа бичсэн захидалдаа “Өдгөө миний бис эрдэмтэн мэргэдийг залж, авьяастан чадвартныг түшихийг хүсэж буй нь дэлхий дахиньг амарлиулахын төлөө болой”<sup>18</sup> гэсэн байdag. Чингис хааны энэ эрхэм чанарыг түүний хүүхдүүд, ач гуч нар нь нэр тортэй үргэлжлүүлжээ. Түүний нэг жишээ нь их эзний отгон хөвүүн Толуйгийн гуравдугаар хөвүүн Хүлэгү Ил хаант улсыг цогцлоож, түүнийг залгамжлагчдын санаачилгаар 1301-1311 оны хооронд СУДАРЫН ЧУУЛГАН хэмээх Монгол төрийн албан ёсны түүхийг Персийн язгууртан Рашид-ад-данийн удирдлагаар Монгол төрийн нэрт зүтгэлтэн Болод чинсан, хятад эрдэмтэд, энэтхэг санваартан нарыг оролцуулсан баг бүтээсэн. Эл бүтээл Персийн Рашид-ад-Данийн нэрээр алдаршсан бөгөөд Ш.Монгесъекогоос 450 жилийн өмнө бичигдээ. Тэр бүтээл “Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч нарт хорвоод торж, хаан тор барих удмынхан минь аль ч улс түмэнд хэрэглэж болохуйц Чингис хааны ёс суртахуун, засаг хуулийг өөрчлөхгүйгээр сахивал Монх тэнгэр хишигээ хүртэж, тэд маань өнө мөнхөд гэр хотлоороо энх амар,

<sup>18</sup> Ли Жичан Чапчунь болбын орно энэхүүдээд горчсон шамдэлэг..., орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар., Улаанбаатар., 2010, 18 дэхь тал.

жаргалтай байх болмуй заа”<sup>19</sup> хэмээсэн байдал билээ. Энэ бүтээлд эхлээд ёс суртахуун, дараа нь Засаг хууль гэсэн байна. Чухам яагаад хуулийн омно ёс суртахууныг оруулах болов?

Өнөөдөр Монгол улсад дээр дооргүй ёс суртахуун ярьж, ёс суртахуунгүй байгаа учраас ийм байдалд орчихлоо гэж халаглах болжээ.

Тэгвэл ёс суртахуун гэж юу юм бол? Аливаа юутай ч зүйрлэшгүй хамгийн үнэ цэнэтэй зүйл нь менго, эд хөрөнгө, албан тушаалд бус харин түүний ёс суртахуунд<sup>20</sup> байдал ажээ. Үүнийг дэлхийн суут ухаантнууд нэгэнт иотолж чадсан байна<sup>21</sup>.

Агуу Аристотель одоогоос 2500 жилийн омно “Хууль тогтоогчид болбоос дадал зурсныхсаа дунд сайн тал руу нэгжит хэлбийн одчихсон хүмүүс дагана хэмээн ойлгосны үндсэн дээр үзүүлж сайни нэрийн омниөөс тэднийг сайн үйл рүү уриалан шахах хэрэгтэй, харин дуулгаваргүй бөгөөд нуруу муутай хүмүүсийг залхааж, цэргүүлж байвал зохино”<sup>22</sup> гэсэн санааг дэвшүүлж байжээ. Аристотель ийнхүү хуулийн амин сүнсийг “сайн үйлтэй”, ёс суртахуунтай шууд холбон үзэж байжээ.

Ёс суртахуун бол аливаа хүмүүнийг хүмүүн хэвээр байлгах дотоод сэтгэл, хүний уураг тархинд мөнхөд орших оддмол бус төрөлх огогдол буюу энерги юм. Хүмүүн гээч бодгаль оортөө ямагт сэтгэлийн сайн инстиктийг тээж явдаг. Шударга ёс, ичих ба эмээх сэтгэл, эр зориг, үүрэг ба хариуцлага, жудаг, нинжин оровч сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, найрсаг элдэг зан, тэсвэр тэвчээр, өгөөмөр сэтгэл, үл хомхойрох, ос хонзон, атая жөтөө з

<sup>19</sup> Рашид-ад-дин Сүфрын чуулган.... I боть..., орос хэлээс эх латын хөрвүүлэсэн Ц.Сүрэхорлоо., Улаанбаатар., 2002, 404 дэх тал; Рашидаддин Шандирим чуулган хэмээх монголчуудын түүх оршинд...., дэд боть..., Англи хэлээс орчуулж, уяла уг бичиж, тайлбар түүлт уйлдсэн Г.Аким., хөөрдөх хэмээ..., Улаанбаатар., 2015, 448 дэх талыг үзэж үз.

<sup>20</sup> Ёс суртахууныг англи хэлээ moral, орос хэлээ мораль хэмээн ишигэж байдал.

<sup>21</sup> Альберти Эймиштейн..., Улаанбаатар., 2015, 79 дэх таласын тодруулж үзэж үз.

<sup>22</sup> Аристотель Никомахын ёс түү..., орос хэлээс орчуулсан Б.Даш-Эндон., Улаанбаатар., 2007, 319 дэх тал.

өвөрлөх зэрэг хүмүүний эрхэм нандин зан чанарын цогц угтаа ёс суртахуун юм.

Аливаа хүний уураг тархи, мэдрэлийн систем нь 80 мянган тэрбум эсэс бүрддэг байна. Эрлэмтэд 80 их наяд (80 000 000 000) цахилгаан элементийг хүний уураг тархи агуулдаг болохыг тогтоожээ<sup>23</sup>. Хүний уураг тархинд 10 тэрбум гаруй үүр байдгийг мөн изэжээ<sup>24</sup>. Тэдгээр үүр ёс суртахууны энерги үйлдвэрлэж, хүлээн авч, бүртгэн тэмдэглэж, дамжуулдаг аж. Эдгээрийн үр дүнд хүний оюун ухаан хэвийн ажилладаг байна. Тэрхүү ёс суртахууны энерги нь бусад хүмүүнд үйлчлэн харилцан татаалцах хүчин чадлыг өөртөө агуулдаг. Ийм болохлоор кванттын физикчид дэлхий өртонц бүхэлдээ оюун бодлоос үүсэлтэй хэмээн үзжээ<sup>25</sup>.

Хүний оюун ухааны нэг хэсгийг ердийн ухамсар, ногөө хэсгийг нь дотоод ухамсар бүрдүүлж, эдгээр нь бие биетгэйгээ шууд хамааралтай харилцан ажилладаг байна. Хүний дотоод ухамсырын үл мэдэгдэх орон зайг орчин үеийн шинжлэх ухаан судалж эхэлсэнээс хойши хүн төрөлхтөн ердоо 100-ад жилийн нүүр үзэж байна. Дотоод ухамсырын оргөн уудам талбарт хүний ёс суртахууны өгөгдлийн орон зай байдаг. Энэ учраас ёс суртахууныг хэн нэгэн тогтоодогтуй, харин төрөлх эсэс бүрдэнэ.

Хүн эхийнхээ умайгаас тасрахад түүний уураг тархинд ёс суртахууны эс энерги унтаа байдалтай байх боловч цаашдын осолт бойжилтын явцад удам судар, гэр бүлийн болон өөрийн хүмүүжил, боловсрол ба орчны олон талт иөлөөлөл зэргээс шалтгаалан ёс суртахуулаг буюу эсхүл ёс суртахуулаг алдах телөвшлэө олно. Суут Кант ёс суртахууны зүй тогтол хүний сэтгэл дотор байдгийг нотлоод хүн сайн явахыг хичээж чадах тул сайн байх учиртай гэж үзжээ. Германы гүн ухаанч Прехт

<sup>23</sup> Наполемон Хилз, Клемент Стоун Эрээг смийгээнд түүхээрэлан амжисинаад түрхэх нь..., орчуулсан Д.Донгийн, Улаанбаатар, 2014, 55 дахь талыг үзүүлүү.

<sup>24</sup> Мон тэнд, 56 дахь тал.

<sup>25</sup> Ронда Берн Нууц..., Монголдадар, Улаанбаатар, 2011, 15 дахь талыг үзүүлүү.

хүний ёс суртахууны чадвар төрөлхийн. Бидний приматаас гаралтай тархи бусдын сэргэлийг ойлгох боломж олгосон ба мөн “сайн үйл” хийснийхээ толоо нейро химийн урамшуулал авахаа ч мэддэг. Иймд ёс зүйтэй зан төрх бол маш нарийн төвөгтэй альруизм бөгөөд сэргэл болон эргэцүүлэн бодохоос бүтиз... Ёс суртахуунаа ямар түвшинд хэрэглэх нь хүн өөрийгөө хүндлэх хүндлэл болон хүмүүжлээс хамаардаг<sup>26</sup> хэмээн бичсэн.

Хүмүүс жигд ёс суртахуунлаг байх үед тэдэнд хуулийн хэрэг огт байхгүй байжээ. Гэтэл нэг хэсэг нь мөнгө, эд хоронго, албан тушаал, тансаглалт улайран, ёс суртахуунаасаа дээгүүр тавих болсон нь хүн төрөлхтөнд их гай зовлон авчиржээ. Чингис хааны багш хутагт ариш Чанчунь бомбо “Ёсыг (ёс суртахууныг) чин сэргэлээр үзүүлж бясалгахуйд хад чулууг туулан ондөр уулнаа авирах мэт болох агаад дээшилэх тутам бэрх болох тул хэрэв алхамын төдийд алдваас урьдын бүх зүтгэл талаар болох бий. Иймийн тул ёсыг (ёс суртахууныг) туйлын чандаар сахиж чадах нь үзүүлж бэрх агаад өртөнцийн эгэл хүмүүс тийн явж үл чадах нь даанч их ажтуу. Ёсноос “(ёс суртахуунаас) тэрслэгсэд, шунагсад болбоос уулнаас онхрох чулуу лугаа адил хоромхон зуурт үлдэх мөргүй талиймуй”<sup>27</sup> хэмээсэн сургаал айлдаж байжээ. Их Монгол улсын үед түгэн дэлгэрээн “Эрдэний эрхи Субашид”-д “муу юм өртөнцөд олон бий боловч, муу хүнтэй адил аюулт юм ер үгүй”<sup>28</sup> хэмээн бичсэн байdag.

Хүчирхийлэл, ёс хонзон, атаархал, хорон муу санаа, луйвар, дур зоргын авирлалазас ёс суртахуунлаг хүмүүсийг хамгаалах нь ганц нэг хүний хувьд бараг боломжгүй зүйл юм. Иймд ёс суртахуунлаг хүмүүсийг хамгаалахын тулд эзэн хаан дангаараа

<sup>26</sup> Мон тэмд.

<sup>27</sup> Ли Жичан Чанчунь болбын орно энгээдэд зорчсон тэмдэлээ..., орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар, 2010, 98-99 дэх тал.

<sup>28</sup> Сажса Бандид Гүнгэлжсанлан Эрдэнийн сан Субашид..., Монгудар..., Улаанбаатар, 2009, 52 дахь тал.

эсхүл иргэдийн дундаас сонгогдсон төлөөлогчид хуран чуулж, ёс суртахуулаг бус хүмүүсийн хорон мую үйлийг гэсгэх, тэдний учруулсан хохирлыг арилгахын тулд албадлага хэрэглэх зайлшгүй шаардлагага үүссэн. Энэ шаардлагага хууль, түүний биелэлтийг туслай зохион байгуулалт-төрт ёсыг буй болгов. Ёс суртахуулаг иргэд татвар гувчуур сайн дураараа толж, түүгээрээ төрийн түшмэдүүдийн цалин пүүлүүг тавьж олгон, хариуд нь өөрсдийгөө ивэол хамгаалалтдаа байлгахыг шаардах болов. Төр, түүний нүсэр аппаратыг ёс суртахууныг хамгаалагч байх ёстой хэмээн үзэж иржээ. Монголчууд төрийн сүлдэндээ залбирч ирсний учир ийм юм.

### **Харийн сурвалж бичижт хийсэн эрэлхийлэл**

XIII зууны үед ёс суртахууныг амин сүнс болгосон хууль нь Монголчуудыг дэлхийн эзэнт гүрэн болгосныг юуны өмнө гадаадын элч, эрдэмтэн мэргэд, санваартан, худалдаачин, аялагчдын бичиж үлдээсэн сурвалжуудаас эрэлхийж мэдэж авсан юм. Энэ талын буюу өөрөөр хэлбэл, Чингис хааныг эих тунх байх үеийн хоёр аян замын тэмдэглэл нь эдүгээ үлдсэн байна. Эхнийх нь Чингис хааны багш, хутагт<sup>29</sup> арш<sup>30</sup> Чанчунь бомбын<sup>31</sup> орно этгээдэд зорчсон тэмдэглэл юм. Чингис хаан хутагт аршийг олон удаа урин залж, түүнд бүр хувийн захидал хэдэнтээ бичиж байжээ.<sup>32</sup> Захидлыг хүлээж аваад нас сүүдэр 70

<sup>29</sup> Хутагт гэдэг бод хувцасаадаа алходог цэл.

<sup>30</sup> Ариш бол хүний хол хөдөлжбоноос зайдуу, бүйдлан газар яом бяслагалт үйзээж буй даяланч хүн.

<sup>31</sup> Бомбо бол манай зорилт хэм үед Энэтхэг. Түүн үзмаар Хятад дэлгэрэн долонын шатмын.

<sup>32</sup> Чингис Хаан захидалдаа "Одгоо миний бие эрдэмтэн мэргэдийг захж, аялгастан чадвартныг түүчинийг хүснэг буй нь дэлхий дахьтасаа амирхулзахын толоо болой. Гэх миний хан сууринд сууринд сүүсэн цагасаас яланыг чит смыгтээр төр засагт түүхээс онох хургадээ үүрийн шийцэх хүнийг хараахан эг охигт анам. Харин одгоо сонсохут багийтан Та бомбын үзэн биешиг олоод ёсмыг журамзан шийбэг үзэж, үзэмжийг мэдэн дээдэх үхийнд ёс зүйд иштэрэн эрдэм чадаг төгс бүрдмээ хамгийн улс даяараан алдаршиж, эртний босод

гарсан ч их хааны урилгаа заллагаас цааргальж чадсангүй. Чингис хаан Хорхэм руу хөдөлчихсөн байсан учир арш Чанчунь бомбо түүнтэй уулзахын тулд хойноос нь иэн их бартаат замыг 2 жилийн туршид туулж, Самарканд орчимд их хаанд бараалжээ. Чингис хаан түүнийг гүн хүндлилтэй хүлээн авч, багшаа гэж дээдлэн, дэргэдээ 2 жил орчим байгаж, хутагт аршийн ном сургаалыг хичээнгүйлэн сонижээ.<sup>33</sup>

Ногоо нь Хятадын элч Мэ-да Бэй-лутгийн “Полное описание монголо-татар” /Монгол-татарын бүрэн тэмдэглэл/ юм. Хятадын энэ элч 1221 онд Чингис хаантай уулзахыг зорьсон боловч тэрбээр алсад дайлаар мордсон учир Яныцзинд (Эдүгээгийн Бээжин хот) Монголын цэргийн их жанжны

---

*мэдрэдийн сургаалыг оворлон, эрдэмт хүмүүний сайн ёсоор аглаг уулцаа бяасалж хийн үднээс сууж буй генээ. Овог дээдийнхээс үзээксэн эрдэмт үүндаасыг олон узамжтайсан, үзүүлж эрдэмт ария балсон эрхэм таныг Болибын ёсны замд орсон сүсэгэнэ олон уулзын мөт дуран хүрээлж гэдгийг махос би саянтардан олж лэдэвэй. Хаан мянган бие алсын аянд мордсон хойноо сай, эрхэн Таныг хязгаар нутагтанаа бүйс сонсоод таныг исэд битирэн санагахын сэргэг минь ер үз дараагдах болон. Бас таны тухай үзээр доломг болсон яриа хөөрөөг сонсон нэм исээр баатарт боловч уул гол хэмнэхийн хол тул энэ үдийн хүрч учраан залдоожээс эс чадавай. Ниймийн тул махос би алс газраас боловч сүүдэлласаа босч, бие мэхийн Танд ёсолж, шадар түшмэцээс шалжэн. Таныг мянган газрын чатадаас үрүн залж байтам. Эрхэм ария бишиг түр түүрээн, эзэн цэлийг эзчилжүй алс хэмжээн эс төвөгжинөөж, эргэж буцалжүйсээр морилсон ирэх, түүэн оны зөвхөн түүдүүрүүрийг ариглаж, дэхийн дахиньг эзслэх үйл эрдэмийг махос надад зөвлөн хэлж, энэч бас мянган биед насыг уртасгаж, алзийн хүтигийг баттагахаа үүндаас эрдэмийг заваж хийрэх болон уу? Тэр цагт махос би баси Таныг бөршийн биенэр хүндэтэн асрангах мэргэн үг, шидэм сургаалыг сонсох хэмжээн ишд мичээнгүйгэн хүснэг. Эрхэм баси Таны эрдэм сургаалыг түр ч атугай хүртвээс надад буян завшанаа болох буй заа” - Ли Жичан Чанчунь болибын орно энгээдэд зорчсон тэмдэгээ... оруулж тайвбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар.. Улаанбаатар., 2010, 19-20 дахь тал.*

<sup>33</sup> Ли Жичан Чанчунь болибын орно энгээдэд зорчсон тэмдэгээ..., оруулж тайвбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар.. Улаанбаатар., 2010, 18 дахь талыг үзнүү.

өргөөнд зочилж, нэлээд хугацаагаар Их Монгол улсад байж, монголчуудын ёс суртахууныг судалжээ.

Плано Карпини,<sup>34</sup> Жувейни,<sup>35</sup> Рубрук,<sup>36</sup> Рональд Лейтхэм,<sup>37</sup> Рашид-ад-Дин<sup>38</sup> нарын XIII-XIV зууны үед бичсэн ном, аян замын тэмдэглэл нь онөө үед хадгалагдан үлдсэн нь Чингис хааны үеийн ёс суртахууныг судлахад баттай, ходлошгүй эх сурвалж болсон юм. Дорно дахинь судлаач, эрдэмтэн П.Рачиневский “Монголчуудын ёс суртахуунд Чингис хааны хууль тогтоомжийн авчирсан гайхалтай өөрчлөлтийг сударчид болон аялалчдын баримтууд тогтоох боломжийг бидэнд олгож байгаа билээ”<sup>39</sup> хэмээн бичсэн нь эдгээр болон гадаадын эрдэмтэд, судлаачдын бусад бүтээлийг хэлсэн хэрэг юм. Персийн түүхч Жувейни “Чингис хаан ноёрхсоныхоо эхээр аймгуудын дотор зөвшиоорөгдсөн буюу явагдаж байсан болхи

<sup>34</sup> Ромын панын эхээр томилогдон 1245-1247 онд Их Монгол улсад амьдарсан итали ундаанын Плано Карпини цутгасва буцаж очоод, аян замын тэмдэглэлээ Монголчуудын түүх (*Historia Mongalorum quos post Tartaros appellatim*) хэмээн нэрээр эмчигж гаргажээ.

<sup>35</sup> Ил хийнт үзүүн нээж бүхий сурвалжыг түүнчэлж, персийн түүхч Жувейни Хархорумд хөйр ч удаа хүрээнд ирсэн багаад 1252-1253 онд “Дэхийг байвалдан дасгалзагчийн түүх” номоо бичсэн.

<sup>36</sup> Францын IX Людовик хааны эхээр 1253-1254 онд Их Монгол улсад түрэлжэн ирж, аян замын тэмдэглэлээ Дорно эхээрээд зорчсон тэмдэглэл (*Itinerarium fratris Willielmi de Rubruquis de ordine fratrum Minorum*) хэмээх нэрээр гаргасан юм.

<sup>37</sup> Итальян алдарт аялагч, худалдаачит Марко Поло ворийн худалдаачин зүрх, агаа алын хамт 15 настай байхдаа 1260-аад оны үед Хубилай хааны барагдаж танищаад улмаар түүний ишгэлийг ажээ. Тэрбээр 1272-1289 оны хооронд Хубилай хааны дээрээд 17 жилийн алба хаяж, түүний эхээр олон газар заралдаж байжээ. Их Монгол улсад алба хаяж байхдаа угзэж харсан ба сочссон зүйлээ Рустикээд хэмжих хүнд хайлж бичүүлжээ нь Орчлонгийн элдэж сохиц (*Livres des merveilles du monde*) хэмээн ном болон гарчээ.

<sup>38</sup> Персийн Рашид-ад-Диний удирдлагын түүрүүсэн “Сударын чуулган” нь дундад зууны үеийн Ази, Европын аль ч улс түүэнд байхгүй түүхийн лосгуй ижмээрхий толийн хэмжээнд бутгээлд үзүүлдээ.

<sup>39</sup> Пауль Рачиневский Чингис хаан түүний амьдралт ба ов..., англи хэмжээ орчуулсан Л.Монх-Эрдэмэ., Уланбаатар., 2006, 142 дахь тал.

бүдүүлэг заншлыг эвдэж, онолын талаар үзсэн ч сайгууштай хууль тогтоомжийг тогтоожээ”<sup>40</sup> гэж бичсэн байна.

Чингис хаан “Хуучин угийг хууль болго”<sup>41</sup> хэмээн айлдсан нь олон түмний өдөр тутмын амьдралаар бичигдээгүй хууль болсон ёс суртахууны хэм хэмжээнд тулгуурлан хууль гарга гэсэн иэн гайхамшигт санааг дэвшүүлсэн байна. Ийихүү тэрбээр ёс суртахууныхаа ачаар Жувейний бичсэнчлэн “тэр бараг ганцаархнаа, зэр зэвсэгтүй гэмээр цоон цөргтэй байж одий төдий хүчирхэг дайснууд дундаас, тэр үеийнхээ сайтар зэвсэглэсэн фахтур (богд хаад) мэтийн хүчирхэг хаадын дундаас цойлон гараад дорноос өриө хязгаар хүртлэх эрх мэдэлгийг бараг тулалдалгүйгээр эрхэндээ оруулж чадсан”<sup>42</sup> юм. Марко Поро “Чингис хааны засаглал шулувун шударга, хүн арддаа зэлтэй энэрзүүг үзсэн бусад орны хүн ард ч түүнтэй өөрсдөө ирж ийилэн иэгдсөэр байв. Нэг мэдэжэд түүнийг дагалдагсад, дэмжин талархагсад газар дэлхийг хучин бүрхсэн үй түмэн болсон”<sup>43</sup> гэж бичсэн байдал билээ.

Ес суртахууныг амин сүнс болгосон Чингис хааны хууль олон үеийн туршид монголчуудын оюун санааны ой санамжид хадгалагдаж ирснийг Оросын алдарт аялагч, байгаль судлаач, газар зүйч Н.М.Приживальский,<sup>44</sup> Монголд 1893-1938 он хүртэл 35 жил амьдарсан, швед Ф.А.Ларсон,<sup>45</sup> Орос-зовлолтийн иэрт

<sup>40</sup> Жувейни Дээлийг байздан дагуулагчийн түүх.... тэргүүн боть..., Мизра Мухаммед Казашийн эмчтэгэсн номыгperc хэмээс англи хэлээр орчуулсан Ж.Э.Бойг, орос хэлийн орчуулсан М.Бадсаням., Улаанбаатар., 2006, 28 дахь тал.

<sup>41</sup> Монголын нууц товчоо..., Ц.Дамдинсүрэн/, Улаанбаатар., 2009, 181 дахь тал.

<sup>42</sup> Жувейни, дүрдсан бүтэээл, 18 дахь тал.

<sup>43</sup> Рональд Лейтекэм Марко Поро аялагч.., англи хэлийн орчуулсан О.Бүрэнжаргал, Улаанбаатар., 2012, 147 дахь тал.

<sup>44</sup> Н.М.Приживальский Монгол, Тангад нутгаар.., Орос хэлийн орчуулсан Ж.Нэрэгий, Улаанбаатар, 2011.

<sup>45</sup> уз. Ф.А. Ларсон Монгол орон, Монголчуудын дунд онгоруулжсан он жил..., Герман хэлийн орчуулсан А.Цэрэнгүүтүүн.., шинчлэлийн орчуулсан хөгжлийн удаагийн хэсээ, Улаанбаатар, 2015.

эрдэмтэн И.И.Майский,<sup>46</sup> Монголын Данийн иэрт аялагч, угсаатан судлаач Хеннинг Хаслунд-Кристенсен,<sup>47</sup> Швейцарийн иргэн, гэрэл зургийн сурвалжлагч Вальтер Боссхард<sup>48</sup>, Унгарын иргэн, Монголд 9 жил амьдарсан Гелета Иосеф,<sup>49</sup> монгол судлаач, орос-германний Николас Поппе<sup>50</sup> нарын зэрэг хүмүүсийн омних зуунд бичсэн судалгаа шинжилгээний бүтээд, аян замын тэмдэглэлд өгүүлсэн байна. Тухайлбал, Шведийн Ф.А.Ларсон Чингис хааныг ямар их ухаалаг хууль дэлхийд бий болгосныг мартсан байна<sup>51</sup> гэж бичжээ.

Гадаадынхны хийсн сүүлийн үеийн судалгааны дүгнэлт сонирхол ихээхэн татах боллоо. Оросын судлаач, Еврази сургаалыг үндэслэгч Н.С.Трубецкой одоогоос 100 шахам жилийн омно Чингис хааны төр ёсон иэн ёс суртахуунлаг<sup>52</sup> байсан гэсэн дүгнэлт хийжээ. Германы Монгол судлаач эрдэмтэн Удо Баркмани “Чингис хаан судлал, Монголын их эзэнт гүрний түүхийн судалгаа Баруунд хол урагшилжээ. Эдгээр судалгааны дүнд Барууны ертөнцөд Чингис хааны талаар олж авсан бидний ойлголт төсөөлөл бүрмесөн оорчлогдсөн юм. Бид Чингис хааныг “харгис хэрцгий”, “яргачин” гэхээ болив. Бид түүний суу билиг, гэрээс бошгын<sup>53</sup> талаар мэдэж авахыг хичээх болов”<sup>54</sup> гэсэн дүгнэлтэд хүрсэн

<sup>46</sup> уз. И.И.Майский *Современная Монголия.. Иркутское отделение., 1921* (Орчин үеийн Монгол, Улаанбаатар, орчуулга)

<sup>47</sup> уз. Хеннинг Хаслунд Монгол хүн, Монгол бурхад., Битпресс хэвлэхийн газар, Улаанбаатар, 2011; Хеннинг Хаслунд-Кристенсен Яана ав!, Герман хэлээс орчуулсан Б.Баярсайхан., Улаанбаатар, 2014.

<sup>48</sup> уз. Вальтер Боссхард Сэргээ булаам Монгол орон мину., Герман хэлээс орчуулсан Б.Баярсайхан., Улаанбаатар, 2014.

<sup>49</sup> уз. Лагслу Фурбант Монгол сэргээ заргодсон есөн жил., Унгар хэлээс орчуулсан Д.Бат., Улаанбаатар, 2015.

<sup>50</sup> уз. Поппе Дуртгал., NERKO publishing, Улаанбаатар, 2007.

<sup>51</sup> Ф.А. Ларсон, дурдсан бүтээл, 50 дахь тал.

<sup>52</sup> Трубецкий Н.С. дурдсан бүтээл, 64 дахь талын үзүүлүү.

<sup>53</sup> Бониц گەزىن ئەن مونگول خەلەق زەرلىق، سەئىخەن، آيدىڭ، سۇرىماڭ، سۇرتەن گەزىن ىتىھاتىي اەمىز.

<sup>54</sup> Удо Б.Баркмани *Монголын түүх, уз төрийн асуудлын тухай* өгүүлэхүүд.. Улаанбаатар., 2013, 229 дахь тал.

байна. Эдгээр дүгнэлт бас Чингис хааны хуулийн амин сүнс ёс суртахуун байсныг нотолно.

## Харийн элдэв бусын үзэл баримтлалын туршилтын талбар байхаа хэээ болих юм вэ?

Их эзэн Чингис хааны "... бус сэтгэлгийн үгэнд орж, мохосдуулэн сэтгэвээс, мөн зарлиг засаг<sup>55</sup> мохосдоло шүү"<sup>56</sup> хэмээсэн захиас байдаг. Үүгээрээ Чингис хаан үндэсний ов уламжлаа умартаж, бусдыг хуулбарлан дууриах сэтгэлгээнд автагдвал хүчирхэг торт ёс, хууль цааз чинь мөхнө шүү гэсн санааг илэрхийлжээ. Тэрбээр бас "Миний сургаалыг мянган оц хувиргалгүй, түмн үедээ бөрчлөлгүй ургийн ургаараа мөрден журамлатугай"<sup>57</sup> хэмээн захьсан гэдэг.

Монголын хүчирхэг эзэнт гүрний хойч үсийн удирдагчид өвөг дээдсийнхээ гэрээс захиасыг умартаж, эв зээ алдсаны улмаас XVI зууны үед сарнин бутарч, доройтлын хар ангал руу гулсан орсон билээ. Хоёр том гүриэр хүрээлгэдэх болж, тэдний хэн нэгний нь дэмжлэг туслалцааг авахаас өөр аргагүйд хүрэв. Энэ удаад Манжийн хаанд хандаж, түүний дэмжлэгээр цус асгаруулсан аймшигт талцаа арайхийж зогсоов. Өөрт нь аяндаа орж ирсэн монголыг монхийн хараат байлгахын тулд Манжийн хаан хуулиа тулган хүлээлгэх бодлогыг туштай, чадамгай явуулав. 200 гаруй жилийн туршид Монгол улсын нутаг дэвсгэрт ийнхүү Манжийн хууль хүчтэй нөлөөлев. Газар нутгаа харийнханд улам бүр алдсаар байв. Улс тор, хууль зүй,

<sup>55</sup> "Засаг" гэсэн үг эртний монгол хэзэн ээ "цэргэ", ардыг избэн төхөнүүзах хуулийн нэр" хэмээн ойзгогддог байжээ. – Монгол хэзний дээгэрэжүй тайлбар төв (таван боть)... И.Бонь., Д.-Л. Улаанбаатар., 2008, 989 дах шамыг үзүүлүү.

<sup>56</sup> Мэргэн гээжин Лүнсандамбийжсэцэн Алтан төвч – Монгол түүхэн эх сурвалжийн цуврал.., 12 дугаар боть., Улаанбаатар., 2006, 165 дахь тал.

<sup>57</sup> Сайншалт Чингис хааны тоноочоон.., тэргүүн дэвнэр., кирилл үсжилт хөрөүүстэн Ш.Чойнгаа, М.Баярсийхан, С.Батхүүшиг.., Улаанбаатар., 2003, 397-398 тал.

эдийн засаг, үндэсний тусгаар тогтиол зугуухандаа бүдгэрсээр. Ийм нохцолд умард гүрний дэмжлэг туслалцааг авахад хүрэв.

Тусалсан хэдий ч коминтери Марксист-Ленинист онолыг Монголд тулган хүлээнгэв. Энэ онол ёсоор өмнөх тогтолцооны оюуны тэргүүлэх хүч болсон засаг ноёд, хутагт хувилгаад тэдний ойр дотнын хүмүүсийг ангийн эвлэришгүй дайсан мэтээр үзэн ядаж, тэднийг хүйс тэмтрэх бодлогыг баримтлав. Монголд 35 жил амьдарсан шведийн А.Ф.Ларсон “Би ороос дорно, өмнөөс умардыг хүртэл аялж, газар бүрийн эрхэм дээдсээр зочлуулж үзсэн. Олон аймаг хошууг авыных нь үеэс эхлээд хүүгийних нь ноён суух үеийг хүргэл мэдэх билээ. Бас ирээдүйд ноён суух жаал хүүг нь ч танина. Бүх орон, аймаг хошуугаар явах зуураа би амин хувийнхаа сонирхлыг ард түмнийхээс дээгүүрт тавьсан гуравхан ноёнтой дайралдаж байлаа. Засаглахаар заясан тоотой хэдхэн жилийнхээ хугацаанд ухаалаг, сайн ажиллах явдал Монголын ноёдын гэр бүлийн мах цусанд шингэсэн чанар”<sup>58</sup> байлаа гэж бичжээ. Ингэхлээр монголын нийгмийн хамгийн ёс суртахуунлаг, оюулаг хэсэг устгагджээ. Үндэснийхээ өвөрмөц онцлогийг огт хайхрахаа болж, зөвхөн зөвлөлтийн гэсэн болгоныг зов хэмээн дууриан хуулбарласан. Ардын хувьсгалын өмнө Монгол улс мөхөж зүйл дууссан мэт “домог” зохион. Гэвч тэр нь болохоор изг анги ногөөгөө дарангуйлах зэвсэг, хууль нь болохоор ажилчин, малчин ангийн хүсэл зоригийн илэрхийлэл хэмээсэн үзэл баримтлал монголын хөрсөнд нутагшиж чадсангүй.

1990-ээд оны үеэс хуулийн тухай барууны онолыг шууд хуулбарлан хэрэглэв. Энэ нь юуны өмнө эрх зүйт торийн тухай үзэл баримтлал юм. Энэ онол ёсоор хуулиар хориглоогүй бүхийг зөвшөөрч, хүний эрхийг дээд зэргийн өндөрт гаргаж, үүрэгт нь ач холбогдол өгөлгүй, дур зоргын авирлал газар авснаар монголын уламжлалт ёс суртахууныг хоцрогдол хэмээн хосор хаяж, монголчуудын соёл иргэншлийн өлтий болсон

<sup>58</sup> Ларсон Ф.А. дүрдсан бүтээл, 17 дахь тал.

бэлчээрийн газар руутгаа улангасан дайрч, онгичон байгаль орчиоо сүйтгэв. Ашигт малтмалаар улс орноо өөд татах хүсэл эрмэлзлэл Монгол улсад дааж давахын аргагүй өр ширийг авчрав. Ийнхүү Монгол улс XVI зуунаас хойш харийн эндэв бусын онол, үзэл баримтлалыг туршсаар өдий хүрэв. Гэтэл монголчууд бидэнд хууль, торт ёсны өөрийн гэсэн дэлхий дахинд шагшин гайхагдаж ирсн хосгүй уламжлал байсан байна.

### ТӨГСГӨЛИЙН ОРОНД

Өмнө дурдсаныг нэйтгэн дүгнэвэл хуулийн амин сүнс нь аливаа хүмүүний уураг тархины төрмөл өгөгдөл болох ёс суртахуун ажээ.

Чингис хаан “Хөвүүн нь эцгийн сургаалыг үл авагсад, дүү нар нь ахмадын ятгалыг үл сонсогсад, эр нь гэргийгээ сэжиглэж, гэргий нь эрээ эсэргүүцгэсд, эрс нь гэрлэсэн гэргийгээ доромжилж, охин нь ураглаагүй эрээ гадуурхагсад, ахас захас нь багачууд хүүхэд үл хамааран, хүүхэд багачууд нь ахас захсынхаа хамаарлыг үл дагагсад, эрхэм ноёд ураг төрлөө дотночилж, үл таних хүмүүсийг гадуурхагсад, баян эрхэм хувийн хөрөнгөө нарийлж, албаны эдийг хонжигсод эрх биш худал хуурмагын замд орж, хулгай дээрöm болох бөгөөд өрх гэр доройтож, тор улс мөхөн, дайсны өмнө ялагдах болмуй. Эдгэр муу зүйлийг хориглотугай хэмээн би чанга сээрэмжлүүлсүгэй”<sup>59</sup> хэмээсэн хууль зарлиг буулгасан байдал. Үүнээс үзүүхэд тэрбээр ёс суртахууилаг бус үйлийг хуулиар хориглож, албадлага тогтоож байсныг харуулна. “Өөрийн бие шударгуу байваас зарлиг эс буулгасан хэрэг бүтүюү, өөрийн бие шударгуу бус байваас зарлиг хэдий буулгавч эгэл ард эс дагаюу”<sup>60</sup> гэсэн гүн ухаанд Чингис хаан сүсэглэж байжээ. Жувейни “...тэр мэргэн ухаан, сүр хүчээрээ дэлхийн хамаг хаадын орой нь байж,

<sup>59</sup> Уз. “Юань түрүүний наадмор орчуулцаа.. I боть; Сайханал Чингис хааны төвчөөн..., дээд дэктэр..., Улаанбаатар., 2010, 397-398 дэх тал.

<sup>60</sup> Күнц Шүүмжээгээс огуулж, хамаад хамисг орчуулсан М.Чимэднээс., Улаанбаатар., 2013, 124 дэх тал.

хүчирхэг Хосровчуудын тухай бичигдсэн болгоныг, Фараонууд, Кесариудын тухай он дарааллын бичиг, эртний сурвалж бичгүүдийг судлах гэж зүдрэлгүй оорийн хар толгойгоор хууль дүрэм тогтоосон болгоо”<sup>61</sup> гэж бичсэн нь үүнийг нотолж байна.

Чингис хааны хуулийг эх бичвэрээр нь олох гэсэн судлаачдын эрэл олон зууны туршид үргэлжилсээр өнөөдрийг хүрэв. Дийлэнхи судлаачид Чингис хааны хуулийг орчин цагийн бичмэл нэгдмэл хууль шиг байсан мэтээр төсөөлж байна.

“Засаг” буюу “Yassa; Yasa; Yasaq; Jazag; Zasag” хэмээсэн нэр томъёо Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн. Тухайлбал, Чингис хаан зарлиг болгон “Засаг хондвоос”<sup>62</sup> надад хэзэгтүн гэсэн гэж Монголын нууц товчооны 227 дугаар зүйлд бичигджээ. “Засаг” гэсэн нэр томъёо нь монгол хэлийн “хууль цааз”<sup>63</sup> гэсэн уттыг агуулдаг. Түүнчлэн ихэвчлэн перс, араб хэлийн эх сурвалжид энэ нэр томъёог хэрэглжээ. Тухайлбал, Жувейнийн бичсэн “Дэлхийг байдан дагуулагчийн түүх” (1260 оны орчим), Рашид-ад-динийн “Судрын чуулган” (1306 он) зэрэг бүтээлийг нэрлэж болно. Эдгээрээс үзэхэд Чингис хааны хууль энэ хорвоо ертөнцөд байсан нь одоо нэгэнт хүлээн зөвшөөрөгджээ. Надтай зөвлөж, Шихихутугийн шийтгээд цагаан цаасанд хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн ураг хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүүгий<sup>64</sup> хэмээсэн Чингис хааны зарлигийг Монголын нууц товчоонд тэмдэглэн үлдээсэн юм. Эдгэр нь ёс суртахууныг ноцтой гажуудуулсан тохиолдолд тогтоосон хориг, албадлагын арга хэмжээ байв. Ийм учраас хуулийн амин сүнс нь ёс суртахуун богоод энэ онцгоеес авч үзвэл хууль тогтоогчид ёс суртахуулаг бус, үүний улмаас

<sup>61</sup> Жувейни, дурдсан бүтээл, 18-19 дахь тал.

<sup>62</sup> Монголын нууц товчоо...., эртний уг хэлэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрөүүлэх...., шинээр хөрөүүлж, тайлбар үйлдсэн Ш. Чоймав..., Улаанбаатар, 2011, 187 дахь тал.

<sup>63</sup> Монгол хэлний дэлжэргэнгүй тайлбар талын, 989 дахь тал.

<sup>64</sup> МНТ-ны 203 дугаар түүлэйг үзнэ уу.

хууль нь ёс суртахуунлаг бус, хуулийг хэрэглэгчид (хуульчид) нь ёс суртахуунлаг бус, хүн ард нь ёс суртахуунлаг бус болсон байвал “судрын чуулган”-д бичсэнчлэн “өнө монхөд гэр хотлоороо энх амар, жаргалтай байх”<sup>65</sup> иохцол хангагдахгүй юм байна.

Чингис хаанаас багшдаа бичсэн захидалын “Хаан миний бис умар зүгийн их хээр талд аж торон сууж, чин сэтгэлээр чигч шударгыг эрхэмлэн тогтоогоод, сүйтгэн бүрэлгэхийг хориглон зогсоож, өмсөх хувцас, идэх хоолоон адуучин үхэрчинтэй хуваалсан, ард иргэдийг хүүхэдтэйгээн адил үзэж, цэрэг дайчид, эрдэмтэн мэргэдийг ах дүүгэн мэт хүндэлж, эв зэйиг эрхэмлэн, энэрэл хишигийг түгээмүй”<sup>66</sup> хэмээсн ганцхан өгүүлбэр хуулийн амин сүнс ёс суртахуун болохыг хэн ч маргахын аргагүй харуулж байгаа юм биш үү?

Хаана ёс суртахуун ба хуулиас мөнгө, эд хөрөнгө, албан тушаал, тансаглалыг дээгүүр тавина, тэнд юу болдгийг 800 жилийн өмнө персийн түүхч Жувейни хэрхэн бичсэнээр эзэхүү илтгэлээ өндөрлөө. Тэрбээр эндэв үл бүтэх амьтдаас болж, дэлхий дахин далайн шуурга мэт оволzon бүхийд, ойр дотийн хаад ноёдны бисээ тоосон ихэмсэг зан хэрээс хэтрээд ирэх цагт оройн дээд Бурхан Чингис хааны сур хүчийг соёрхон олгож, ялалтын эзэн болгосон юм<sup>67</sup> хэмээжсс.

<sup>65</sup> Рашид-ад-дин Судрын чуулган..., I боть..., орос ханжээс эх хэмээ хориуулсан Ц.Сүрээнхоргоо..., Улаанбаатар., 2002, 404 дэх таз; Рашидаддин Шандирин чуулган хэмээх монголчуудын түүх орчиний..., дэд боть..., Англи хэмээж орчуулж, уялага уг бичиж, тайлбар зуулж үзүүлж Г.Аким..., хөөрдах хэлээ..., Улаанбаатар., 2015, 448 дэх талыг үзэж үү.

<sup>66</sup> Ли Жичан Чанчуны бамбын ариа эхээдээ гарчсон тэмдээгээ..., орчуулж тайлбарласан Я.Ганбаатар, Ц.Ганбаатар..., Улаанбаатар., 2010, 18 дэх талыг үзэж үү.

<sup>67</sup> Жүсэйти, дурдсан бүтээл, 18-19 дэх талыг үзэж үү.

## **STUDYING ESSENTIALS OF THE LAW BASED ON HERITAGES OF GENGHIS KHAN**

Mongolia has been adopting many laws intensively from the beginning of 1990's while having established a legislative body which cost higher. In the last 25 years, Mongolia has adopted over 500 laws and almost every state organization has its own law at the moment. However, these laws did not bring the development and growth we have been expecting to our country. Therefore, this presentation analyzed what are the essentials for the laws from a scientific perspective. The presentation has been developed based on the past decade studies done by Academician S. Narangerel and comprises of over 60 quotes and 5 main parts. His 13-page presentation is briefed in 3-page document.

### **Leading concepts regarding essentials of the laws**

The researchers consider that worldwide-accepted concepts regarding the essentials of the laws were mentioned by Ch. Montesquieu, prominent thinker and the French enlightener, in his book titled *The Spirit of Laws* (1748) 250 years ago. He concluded that the essentials of the laws lie in the balancing of the power in legislative, executive and judiciary sections. Ch. Montesquieu's concept on independence of the laws from the ethics had been inherited by the post-period thinkers. Hans Kelsen, the best delegate of the modern lawyers maintaining Montesquieu's concepts, wrote that "measures of the ethics is independent from the laws, maintain its nature and cannot convert into laws". This quote determines the modern-day laws.

Ch. Montesquieu described Mongols as "strangest nation in the world" in his famous book titled *the Spirit of the Laws* while he proposed concepts on essentials of the laws. He continued that the geographical location and climate have converted Mongols invaders. However, Lev Gumilev confirmed his facts which stated that "Mongols did not have an attempt to invade settled nations but they wanted to strengthen their border areas and protect their native land

from strong external invaders in order to live peacefully" by historical documents. Historians also proved that Russia and Chia did not have any losses during the Mongol empire era. There is a proof that there was development and flourishing for Golden Horde era. Also, Mongols developed trading zones to a greater extent and ensured their security. In doing so, many nations benefited from that. Therefore, Ch. Montesquieu's conclusion that "Mongols or Genghis Khan destroyed Asian nations extending from India to Mediterranean, and conquered all the nations located in the east of Persian Empire" is baseless in comparison with historical facts.

### **Completely different concept 450 years ago before ch.**

#### **Montesquieu era**

Genghis Khan stated in his letter to his master "Currently, the fact that I invited all the scientists and academicians in order to rely on the talents is to make the world peaceful". This important value of Genghis Khan was inherited by his children and grandchildren with honor. For example, COLLECTION OF SUTRAS was created by the initiative of Khulegu, the third son of Tolui, youngest son of Genghis Khan between 1301 and 1311. The book states that "if the nations and empires that will be created along with his latter generations follow and do not change the Genghis Khan's ethics and laws in 500 hundred or a thousand, or ten thousand years later, eternal sky will give them endowment and they will live altogether peacefully ever after." The book prioritizes first ethics then laws. Why the ethics come before the laws?

Most important things for any man are not money, properties or titles, but his ethics. Great Aristotle considered the essentials of the laws as good deed and ethics directly 2500 years ago.

Ethics can help any person to stay as a human and is a native data or energy which exists forever in their internal mind or brains. Mankind keeps good instincts in his body all the time. Fairness, shame and fear, braveness, obligation and responsibilities, individuality, benevolent compassion, fame, reality, trust, friendly

and polite behavior, patience, generosity, not having greedy heart, malice and envy are complexity of the most important characters of the mankind. Ethics cannot be decided by anybody but it comprises of the native characters according to the many thinkers, scientists and nature science disciplines.

When people have similar ethics, they did not need any laws at all. However, some people wanted to flush for money, properties or titles and preferred them over the ethics. This caused a trouble to the mankind. Therefore, the kings or representatives chosen from the people convened a meeting and considered there needed to be punishment or compulsion for people without ethics in order to protect people with ethics and repair the losses. And the people considered the state as a "protector of ethics". The reason why Mongolians pray for the symbol of the state is the reason.

### **Findings from the foreign literature**

Mongols' law with ethical spirit in the 13<sup>th</sup> century made Mongols as the world's strongest empire according to the facts written by foreign messengers, scientists, pastors, traders and tourists. Books and travel notes written by Plano Carpini, Juvaini, Rubruk, Ronald Latham and Rashid-Ad-Din during the 13-14<sup>th</sup> centuries are conserved until now which allows us to study the ethics of Genghis Khan on a firm and unmovable basis. Oriental scholar and scientist P.Rachnevsky wrote that "sutra writers and travelers' evidence gave us an opportunity to study the wonderful changes that the Genghis Khan ethics brought to the Mongols" which meant the above and other books created by foreign scientists and researchers.

Recent studies conducted by foreigners have a lot of interests from our side and if we mention one of them, N. S. Trubetskoi, Russian researcher and founder of Eurasian Study, concluded that the Genghis khan state was very ethical about 100 years ago. German Mongolist Udo Barkmann concluded that "Genghis Khan study and historical study of the Great Mongol Empire have advanced well in the west. As a result of these studies, our understanding regarding

the Genghis Khan changed substantially. We will no longer call Genghis Khan as "cruel" and "butcher". We would like to know more about his smartness and testament". This conclusion proves that the essentials of the Genghis Khan laws were based on the ethics.

### **When are we going to stop to be a test field for various foreign concepts?**

Great Genghis Khan said to us that "if you think in a limited way following others then our laws and state will be destroyed". Genghis Khan showed by this word that not to forget own traditions and follow other traditions then the strong state and laws will be destroyed. Also, he said "Please follow my words in a thousand years or a ten thousand years without any changes by generation by generation".

However, the peace between the kingdoms of Mongol empire was destroyed and Mongols went to bad times during 16<sup>th</sup> century. After that, Mongolian laws followed Manchu or Komintern political, legislation and economic policies. Then, pastors and higher state people are ignored or killed thus vanishing the most ethical and smart parts of the Mongolian society. The law theory was following the western theories during 1990's which is about the legislative state. According to the theory, everything that are not prohibited by the laws will be permitted and human rights are considered as vital. But we did not highlight the obligations then freedom became limitless causing the traditional ethics of Mongolia was considered as old, pasture land was exploited and environment was polluted.. Therefore, Mongolia has been undergone in a different foreign theories and concepts since 16<sup>th</sup> century. However, we have had a unique tradition of laws and state which is considered very good in the worldwide.

## **ENDING**

If we conclude the above, the spirit of the laws lies in ethics of anybody which is given from his birth. Genghis Khan prohibited unethical things by laws and used punishment. He prays for the philosophy which states that "if you are fair then your order will be implemented or if you are not fair, then your order will not be followed by the people" and he punished any acts against ethics. Therefore, the spirit of the laws is ethics and the law makers should not follow unethical actions then the laws will be unethical and law users will become unethical causing whole population as unethical according to the Collection of Sutras.

Genghis Khan's letter to his master stated that "I, King, lives in the north steppe and prefers the fairness, stops the destroying acts, shares food and clothing with my people, considers my people as my children, adores soldiers and academicians as my brothers, prefers peaceful and benefits the poor". This one sentence shows where the spirit of the law lies in.

Where the ethics is appreciated over money, properties and titles you will see what happens there from the Juvaini's book written 800 years ago. He said that because of bad people, wars are abundant over the world and kings prefer bad habits then Genghis Khan got all the victories over them.

## ХУУЛЬ ТОГТООХ АЖИЛЛАГАА: ТҮҮХЭН СУРГАМЖ

Ч.Энхбаатар

Удирдлагын академийн эрх зүйн тэснээсийн эрхтэгч,  
хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор

Монголын нийгмийг бүхээд нь ардчилах, төрийн тогтолцоог шинэчлэх, төрийн эрх мэдлийг тэнцвэртэйгээр хуваарилах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үндсэн хуулийн хяналтыг нэвтрүүлэх эрх зүйн үндснийг бүрдүүлсэн шинэ Ундсан хуулийг дагаж мөрслөн он жилүүдэд Монгол Улс ардчилсан хөгжлийн замаар тууштай замнаж, нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд зарчмын шинээтгэл хийсэн билээ. 1992 оны Ундсан хуулиар тус улсын төрийн тогтолцоог төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмын үндсэн дээр тогтоосон нь дэлхий нийтийн жишигт нийцсэн шийдвэл болсон юм. Үүний үр дүнд Монгол Улсад хууль тогтоох эрх мэдлийг дангаараа хэрэгжүүлэх бүрэн эрхтэй орчин цагийн парламент- Улсын Их Хурал- 1992 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн.

Төрийн шинэ тогтолцоо төлөвшин бэхжих явц үргэлж дардан замаар яваагүй бөгөөд ололт амжилтын зэрэгцээ эрх зүйн орчин төгс бүрдээгүй, тогтолцооны дархлаа гүйцэд суугаагүй зэрэгээс үүдсэн зарим бэрхшээл, зэрээтэй асуудал оршисоор байгаа. Энэ талаар манай бусад илтгэгчид тодорхой баримттай ярих байх гэж бодож байна. Харин энэ илтгээд гарцааны цэг буюу Монгол Улсад парламенттэй ёс хэрхэн нэвтэрзэн, улмаар хууль тогтоох институциүүд хэрхэн хөгжиж ирснийг авч үзэхийг чухалчилсан юм. Учир нь онгөрснөө дэйслэж, түүнээс түүхэн сургамж авч байх нь одоогийн хурсан ондорлоигтоө бодит үнэлгээ өгөхөд тустай байх болов уу.

Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллаганы практикт түүхийн үүдиэс дүн шинжилгээ хийхээс омно тухайн үсийн Монгол Улсын удирдлагын хэлбэр болон төрийн тогтолцооны онцлог, үндсэн шинж, төрийн тогтолцоонд хууль тогтоох

субъектын эзлэх байр суурийг тодруулах нь зүйтэй болов уу. Үүнийг иш үндэс болгож, торийн эрх барих байгууллагуудын хууль тогтоох бүрэн эрхийн эрх зүйн зохицуулалтыг тоймлюж, эцэст нь хууль тогтоох ажиллагааны практикийг шинжлэн судалж, зохих дүгнэлт хийх болно.

### Нэг. Монгол Улсын удирдлагын хэлбэр

Ардын хувьсгал ялсны үр дунд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар торийн удирдлагын хаант хэлбэрийг халж, илүү дэвшилттэй бүгд найрамдах ёсыг тогтоон бэхжүүлсэн боловч түүгээр тогтоосон удирдлагын хэлбэр нь дэлхийд зонхиидог парламентын, ерөнхийлөгчийн буюу холимог бүгд найрамдах улсын хэлбэрийн аль нь ч биш, зөвлөгүүдийн бүгд найрамдах улс гэж томъёологддог удирдлагын овормоц хэлбэр байв.<sup>1</sup> Үүний үндсэн шинжүүд нь: торийн эрх мэдрэл хуваарилах зарчмыг үүгүйсгэж, засгийн бүх эрх нэгдмэл байх зарчимд суурилдаг, төлөөлох байгууллагууд нь захирах, захирагдах зарчмын дагуу зохион байгууллагдсан нэгдмэл тогтолцоог бүрдүүлдэг, орон нутагт өөрөө удирдах ёс хэрэгждэгтүй, торийн бүх байгууллага тухайн түвшний Хурлуудаас байгуулдаж, тэдэнд ажлаа хариуцан тайлagnадаг, бүх шатны төлөөллийн байгууллагууд нь жинхэнэ ажиллагч байгууллага биш, зөвхөн гүйцэтгэн захирамжлах байгууллагаас гаргасан шийдвэрийг батламжлах үүрэг хүлээдэг, төлөөллийн дээд байгууллагын бүрэн эрхийг үзүүн хэрэгтэй түүнээс сонгогдсон цөөн хүнтэй тэргүүлэгчид түүний нэрийн өмнөөс

<sup>1</sup> 1917 оны 4 дүгээр сард эх ороондоо буцаж ирсний дараа бичсэн "Доровдүгээр сарын схемүүд" бүтээгдээ В.И.Ленин: ажисчны депутатуудын Зөвлөгүүд нь хувьсгалийн тасгийн цор ганц байж болох хэлбэр мөн..., үзүүлсээс парламентын бүгд найрамдах эзслын хэлбэр лүү эрээн орох нь уларсан алхам болно..., ниймд эзслын хэмжээнд дорсодоо байгуулнаадан ажисчны, тарничны Зөвлөгүүдийн бүгд найрамдах улс байх ёстой гэсэн санаачуудын дэмшигүүлэгээ В.И.Ленин. Поли. Собр.соч., 5 изд., Т.31, с.113-118-аас үзүүлж үү.

гүйцэтгэдэг байсан юм.<sup>2</sup> Түүнчлэн засаглалыг үнэн хэрэгтээ намын шат шатны удирдах аппарат хэрэгжүүлдэг намын засаглалын хэлбэр буюу *партиократии* тогтсон байв. Өөрөөр хэлбэл тэр үеийн төрийн байгуулалтын гол шинж нь төрийн бүх байгууллага МАХН-ын удирдлагага, хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг байсандаа оршино.<sup>3</sup>

Энэхүү тогтолцоо нь 1960 оны Үндсэн хуульд 1990 оны 3 дугаар сарын 23-нд томоохон иймэлт, өөрчлөлт оруулж, МАХН-ын онц эрхтэй холбогдсон заалтуудыг хассанаар улс төрийн хариуцааг шинчилэн, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг эрс өөрчлох хүртэл 70 шахам жил хадгалагдсан юм.

### Хоёр. Хууль тогтоох субъект (парламент)

Нийтийн жишгээр хууль тогтоох байгууллага буюу парламент нь хэд хэдэн үндсэн шинжийг агуулдаг. Иягдүгээрт, парламент нь тооолдлийн байгууллагын хувьд бүх ард түмнээс сонгогдож, тэдний хүсэл зориг, ашиг сонирхлыг бүрэн илэрхийлдэг. Хоёрдугаарт, парламент нь хууль тогтоох бүрэн эрхийг төрийн өөр ямар ч байгууллагатай хуваалцахгүйгээр, дангаар хэрэгжүүлдэг юм. Гуравдугаарт, байнгын үйл ажиллагаа явуулах учиртай. Эдгээр шинжүүдийг цогцоор агуулж гэмээнэ жинихэнэ утгаар парламентгад тооцогдоно.

<sup>2</sup> Г.Н. Андреева. Конституционное право зарубежных стран. М., "Эксмо", 2004. с. 177; А.М. Осавелов. Конституционное право зарубежных стран. М., "Юнитизакон и право", 2010. с.122-123.

<sup>3</sup> БНМАУ-ын омнох үндсэн хуумиудад МАХН-ын удирдан чиглүүлж үргэнд тухай тодорхой заадаг байжээ. Тусайбал, 1940 оны үндсэн хуульд "БНМАУ-ын хөдөлгөөрччин (зажигачин, магачин, оюутан) ардын дотроос аль шалдэг иджсэнэй болгоод учраа мэдэсээд нь узс нийгмийг хөгжүүлжийн таловоа тэмдээд хөдөлгөөрччин ардын тэрэгүүнд явах хэсэг болгоод узс нийгмийг байгуулжмыг удирдах хүчин болох МАХН-д эзэлдэн нээгдээ" (82 дугаар зүйл). 1960 оны Үндсэн хууzy: бүрнийде яланчуу марксизм-ленинизмын онцлог эмчилжсан МАХН нь узс нийгмийг удирдан чиглүүлжээг мөн гэж тус тус заасан байдал.

Монгол Улсад эрт үеэс төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхгээ хэмээн томъёолж болох Их хуралдай, "Хорин дөрвийн зөвлөл", мянганы ноёдын хуралдай, аймгийн ноёдын чуулган, хожмоо Богд хаант Монгол Улсын Одоо өргөгдсөний 3 дугаар онд (1914) байгуулагдсан Улсын Дээд, Доод Хурал хэмээх олон байгууллагыг үйл ажиллагаа явуулдаг байсан боловч бүгд төлөөллийн бус байгууллагыг байсны дээр гагихуу хаанд зөвлөх эрхтэй байжээ. Тухайлбал, Улсын Доод хурал нь засгийн олон яамдаас оруулсан аливаа асуудлыг хянан хэгэлцэж Улсын Дээд хурал уг асуудлаар Богд эзэнд айлтгаж эцсийн шийдвэрийг гаргуулдаг байсан.<sup>4</sup> Түүнчлэн 1921 оны 9 дүгээр сард байгуулагдсан Улсын түр цагийн Хурал ч Ардын Засгийн газарт зөвлөх эрхтэй байснаараа өмнөхтэй тостай байв.<sup>5</sup> Иймд анхдугаар Үндэсн хууль батлагдах хүртэл Монгол Улсад төрийн дээд эрх барих, үүнийг дотор хууль, дүрэм батлах, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах бүх эрхийг үнэн

<sup>4</sup> Монгол Улс дахь парламенттат ёсны түүхийг судлаачид Монгол улсад парламенттад ёс хөдийнээс хэрэгжсэж эхэлж талаар өөр өөр үзүүлж бодолтой байдгийг тэдний бүтэээгүүдээс гарж байсан. Судалгааны нээлд бүтээгд "парламенттат ёс" нь Хамаг Монголын хамт төрийн үзэс гэхэлтийг гэж үзэж үргүйгээ тухайн үе дэх "Ноёдын хуралдай"-тай холбон тайзбарладаг бол өөр хэсэг судлаачид Чингэх хамны байгуулсан Их Монгол Улсын үе дэх "Их хуралдай" нь төрийн дээд байгууллагын ишнийг илүү алхиж байсан гэж түүхийг парламенттат ёсны овог гэж үзжээ байна. (Ж.Бодбаяатар нар, Монгол Улсын түүх, УБ, 1999, 422 дахь тал) Ногоо хэсэг судлаачид Монгол Улс дахь парламенттат ёсны таловшиг нь Богд хамт Монгол Улсын төгрөөн эхэлтийг хамжин үзжээ, 1914 онд байгуулагдсан Улсын Дээд, Доод хурлыг парламенттат ёсны үзэс таловшигийг холбон тайзбарладаг байна. (Ж.Зашкуу, Г.Азтанцээн, Монголын түүхийн лекциүүд, УБ, 1999, 225 дахь тал) Монгол Улс дахь парламенттат ёсны таловшигийг бүрээжин тогтосон гэж зарим бүтэээд дурдэжээ. (Р.Гончигдорж, Монгол Улс дахь парламенттат ёсны үзэс, таловшиг, цахиадын зандаага, Шинэ толь, 2000, №30, 41 дахь тал).

<sup>5</sup> Улсын түр цагийн хурдан дүрмийн 19-р түйл: "Энэхүү хураат энэхүүмээс улсын хурал биш тут таслан шийтгэх бүрэг эзгүй болгоод хэзээн тогтоосон зүйний засгийн газар мэдүүжин хянан байцаалж гүйцэтгэн шийтгүүзбэлэг зөхливо". Бүгд Нийтийн Монгол Ард Улсын Үндэсн хууль, түүрийн холбоодох зарши ажлын зүйтгэл (1921-1940), Нэгдүгээр дэвтэр, Улаанбаатар, 1972 он, 36 дахь тал.

хэрэгтээ 1921 оны 3 дугаар сарын 13-нд байгуулагдсан Ардын түр Засгийн газар<sup>6</sup> гартаа төвлөрүүлж байсан. Энэ бүхнээс узвол Монгол Улсад хувьсгалын өмнө ч, ардын засгийн эхний жилүүдэд ч төрийн эрх барих төлоөллийн байгууллага байгаагүй юм.

Анхдугаар Үндсэн хуулиар Монгол Улсад төрийн эрх барих дээд эрхийг хэд хэдэн байгууллага дундаа хадгалааг тогтолцоог бий болгосон юм. Үндсэн хууль ёсоор төрийн эрх барих дээд байгууллага (тэр үеийн хэллэгээр улсын дээд эрхийг барих газар) нь Улсын Их Хурал байсан бол түүний зарим үүргийг 30 гишүүн бүхий Бага Хурал чуулганы журмаар гүйцэтгэж, улмаар Бага Хурлын чуулганы чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид хэмээх 5 гишүүнтэй байнгын байгууллага ажиллуулахаар зохион байгуулжээ. Үүнийг зарим судлаачид төрийн эрх мэдэл хуваарилсан явдал гэж тайлбарладаг<sup>7</sup> боловч үнэн хэрэгтээ төрийн эрх мэдлийг хуваарилах бус, харин дээд байгууллага нь эрх мэдлээ доод байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрсөн зохицуулалт байсан юм.

Өөреөр хэлбэл, тус улсад хэрэг дээрээ төрийн дээд эрхийг барьdag хэд хэдэн байгууллага зэрэгцэн оршиж байсан богоед хууль тогтоох байгууллага нь цаана үндсэн ажилтай жирийн ардуудаас бүрдээн, жилд нэг удаа цөөн хоногоор хураалдаг Улсын Их Хурал ч биш, мөн жилд хоёрөс доошигүй удаа цөөн хоногоор хураалдаг Улсын Бага Хурал ч биш, харин байнгын ажиллагаатай Бага Хурлын Тэргүүлэгчид байсан гэж үзэх үндэстэй.<sup>8</sup>

Ногоотгайгүүр, хууль тогтоох ба гүйцэтгэх байгууллагуудын ўл ажиллагаа ногдмэл байх зарчим дээр зохион байгуулагдаж, тухайлбал Улсын Их Хурал нь хууль тогтоох төдийгүй хууль

<sup>6</sup> 1921 оны 7 дугаар сарын 16-ныас Ардын Засгийн газар гэж иорзээдэх болсон.

<sup>7</sup> Л.Однайхан. Парламент. УБ, 2001 он, 36 дахь тал.

<sup>8</sup> Энэ нь марксизм-ленинизмын оногчид парламентад түүзлийн таагүй хандаж, түүнийг жирийн ардуудыг хурам махтай, тоорогдуулж, мунхруулжас зарынгоор байгуулагдсан газар гэж үзэх байсан Монгол дахь тусгасан юм.

биелүүлэх, захирамжлан гүйцэтгэх дээд үүргийг Үндсэн хуульд заасан хэмжээ, хязгаарын дотор гүйцэтгэж байсны зэрэгцээ, гүйцэтгэн захирамжлах дээд газар-Засгийн газар ажилаж байсан нь дээд эрх барих байгууллагуудын эрх хэмжээ, чиг үүрэг нь хоорондоо холилдсоныг гэрчилнэ. Тэр биттий хэл, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд: “Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн Эрхт Ард Улс хэмжэж, улсын дээд эрхийг жинхэнэ арлад эзлүүлэн, улсын албанаа хэргийг Улсын Их Хурал ба мөн Хурлаар сонгогдсон Засгийн Газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино”; 4 дүгээр зүйлд: “БНМАУ-ын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалах бөгөөд мөн Хурлын чөлөө цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, ба бас мөн Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино” гэж тус тус зохицуулсан нь төрийн дээд эрхийг хэрэгжүүлэхэд Засгийн газар хүссэн цагтаа шууд оролцох боломж иzzлтэй байсныг гэрчилнэ.

Анхдугаар Үндсэн хуулиар тогтоосон энхүү тогтолцоо иzzэд удаан ургэлжилсэн билээ. Тухайлбал, 1940 оны Үндсэн хуульд: “БНМАУ-ын төрийн дээд эрх барих байгууллага нь Улсын Их Хурал мөн. Улсын Их Хурлыг 3 жилийн ижтэй удаа хуралдуулна. Улсын Их Хурлын чөлөө цагт төрийн эрх барих дээд байгууллага нь Их Хурлаас сонгон байгуулах Улсын Бага Хурал болно. Улсын Бага Хурлын чуулганыг жилийн ижтэй удаа хийнэ. Улсын Бага Хурлын чөлөө цагт төрийн дээд эрхийг барих газар нь Бага Хурлаас дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга ба дөрвөн гишүүнтэйгээр сонгон байгуулах Бага Хурлын Тэргүүлэгчид болно” гэж заасан бол 1960 оны Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал мөн” гэж заасан бөгөөд 33 дугаар зүйлд: “Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт төрийн эрхийг барих дээд байгууллага мөн” гэж заасан байна. Эдгээр бүх байгууллага тухайн үед хэрэгжүүлж байсан сонгуулийн журмаас шалтгаалж жинхэнэ толоолийн байгууллага болж

чадахгүй байсны дээр Улсын Их Хурал (хожим Ардын Их Хурал) нь бус харин түүнээс байгуулагдсан Тэргүүлэгчид л байнгын үйл ажиллагаа явуулж, Их Хурлынхаа изрийн өмнөөс хууль баталдаг байсан нь тус улсад нийтийн жишгээс гажсан өвөрмөц тогтолцоо үйлчилж байсныг илтгэнэ.

## Гурав. Хууль тогтоох үйл ажиллагааны Үндсэн хуулийн зохицуулалт

### 3.1. Үндсэн хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсурмын эрх зүйн зохицуулалт

Монгол Улс түүхэндээ дөрвөн Үндсэн хууль баталж, дагаж мордсон боловч Үндсэн хуулийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах журмыг бусад орнууд шиг нарийвчлан тогтоож байгаагүй. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиар төрийн эрх барих дээд байгууллагад улсынхаа гол хуулийг батлах, өөрчлөх үүргийг ногдуулсан байдаг. Тухайлбал, 1924,<sup>9</sup> 1940<sup>10</sup> оны Үндсэн хууль ёсоор эн үүргийг Улсын Их Хуралд, 1960 оны Үндсэн хуулиар Ардын Их Хуралд<sup>11</sup> тус тус харицуулжээ. 1924 онд энэхүү үүргийг хэрхэн хэрэгжүүлэх тухай тодорхой заагаагүй бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг анх БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн "БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлох журам" хэмээх Арван хоёрдугаар бүлгээр тогтоожээ. Уг бүлгийн 95 дугаар зүйлд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг өөрчлох явдлыг Улсын Их Хурлаар гүйцэтгэх богоод Их Хурлын тэргүүлэгчдийн гуравны хоёроос доош бус хувийн гар

<sup>9</sup> 1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 6-р зүйл: "Улсын Үндсэн хуулийг өөрчлох батлах явдлыг гагццуу Улсын Их Хурлаас эрхэм шийтгээээс тохино".

<sup>10</sup> 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 16-р зүйл: "Улсын Их Хурлаас дамгаар эрхэх хүргүүд тъ: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг батлах ба өөрчлох; ...".

<sup>11</sup> 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл: "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурал төрийн бүх эрхийн барих багасганд үзүүлж тушаийбаз: а) БНМАУ-ын Үндсэн хуулийг батлах, өөрчлох; ...".

өргөж баталснаар өөрчилнэ” гэж заасан байв.<sup>12</sup> Улмаар БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн “БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлох ба халах тухай” Аравдугаар бүлэгт Үндсэн хуульд иżмэлт, өөрчлөлт оруулах журмыг илүү дэлгэрэнгүй тогтоожээ. Уг бүлэг нь хоёр зүйлээс бүрдэж байсан богоод 93-р зүйлд: “БНМАУ-ын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг тагцуу Ардын Их Хурлаар хэлэлцэж, түүнийг депутатуудын гуравны хоёроос доошигүй нь баталснаар оруулна”, 94-р зүйлд: “Коммунизмын үед төрийн зарим үүрэг мөхөх тутам тэр үүргийн тухай Үндсэн хуульд бичигдсэн зүйлс хүчнүүдийг болж байна. Социализм, коммунизм байгуулах гол зөвсөг болсон төр байх хэрэгцээгүй болж, түүнийг хөдөлмөрчдийн коммунист эвлиязор сольсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана” гэж тус тус заажээ.

### *3.2. Ердийн хууль батлах, түүнд иżмэлт, өөрчлөлт оруулах эсурмын эрх зүйн зохицуулалт*

#### *3.2.1. 1924 оны Үндсэн хууль*

1924 оны Үндсэн хуулийн 11-р зүйлээр улсын дээд эрхийг хадгалах газруудын (Улсын Их Хурал, Улсын Бага Хурал, Бага Хурлын Тэргүүлэгчид, Засгийн газар) эрхлэн шийтгэвэл зохих зүйлүүдийг тогтоохдоо улсын шүүх таслах газруудын хэргийг явуулах дүрэм хэмжээ, мөн иргэний ба эрүүгийн хууль зүйлийг тогтоох бүрэн эрхийг тэдгээр байгууллагуудад хамааруулжээ. Харин бусад заалтай харьцуулбал, хууль дүрэм, тогтоол, тушаал гаргах бүрэн эрхийг Улсын Бага Хуралд (12 дугаар зүйл), харин аливаа хууль дүрмийн эхийг зохиож Бага Хурлаар хэлэлцүүлэх

<sup>12</sup> Үндсэн хуулийн энэ залгат нь хөöрдмэл уншгатай гэж үзэж байна. Улсын Их Хурал нь эхэлж 3 эхийд нь залгаа, ложим эхийд нь залга цөнхөн хомогсоор чулдаг байсан бол түүний чуулганы чөлөө цэсийн Их Хурлын Тэргүүлэгчид байна ажиглагдаагаа тус тусдаа явуулж байгууллага байсан юм. Ниймд Үндсэн хуулийг өөрчилж бүрэн залгийг Улсын Их Хурал сүүчинчээс гэж зассан морталго Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн олонийн саналцаар уг өөрчлөлийнг баталжина гэж зассан нь чухамдаа Үндсэн хуульд аливаа налгээн, өөрчлөлийн оруулах бүрэн залгийг Улсын Их Хуралд бичи, Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн олонийн байжээ гэж үзэхээс өөр аргагүй.

бүрэн эрхийг Бага Хурлын Тэргүүлэгчдэд (20-р зүйл) тус тус олгосон нь харагдаж байна.

### 3.2.2. 1940 оны Үндсэн хууль

1940 оны Үндсэн хуулийн “Засаг торийн байгууламж” хэмээх Хоёрдугаар бүлгийн Иэгдүгээр зүйлийн 25 дахь хэсэгт: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын өмнөөс засгийн дээд эрх ба улсын захиргааны дээд газруудын эрхлэх хэрэг нь: ...25.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэний тухай хууль гаргах” гэж заажээ. Мөн хуулийн деревдүгээр бүлгийн 19-р зүйлд: “Бага Хурлын эрхлэх хэргүүл нь: ...4. Бага Хурлын чөлөө цагт Бага Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан хууль дүрмүүдийг батлах”, 22-р зүйлд: “Бага Хурлын Тэргүүлэгчид нь: ...4. Бага Хурлаас батлах хүртэл шинэ хуулийг гаргах ба дагаж шийтгүүлэн байгаа хуулиудад тайлбар огох” гэж тус тус зохицуулжээ. Үүнээс үзвэл Бага Хурал нь хууль тогтоох бүрэн эрхтэй байсан боловч уг эрхээ Бага Хурлын Тэргүүлэгчдээс батлан гаргасан хууль дүрмүүдийг батлах хүрээнд хэрэгжүүлэхээр хязгаарласан нь тодорхой байна.

БНМАУ-ын 9-р Их Хурлын 1949 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн тогтоолоор Үндсэн хуульд оруулсан томоохон ижмэлт, өөрчлөлтөөр дээр дурьдсан зүйл, заалтуудыг дараах байдлаар шинэчлэн найруулжээ. Үүнд:

-Гол өөрчлөлт нь Улсын Бага Хурлыг татаан буулгаж, Бага Хурлын Тэргүүлэгчдийг Улсын Их Хурлын Тэргүүлэгчид гэж цаашид изрэхээр тогтоожээ. Өөроор хэлбээ, зэрэгцээн олон төрийн дээл эрх барих байгууллагаас нэг байгууллага хасагджээ.

-Мөн тус хуулийн 22, 24-р зүйлүүд нь ихээхэн ач холбогдолтой юм. 22-р зүйлд заснаар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хууль тогтоох эрх гагихүү Улсын Их Хуралд байх бөгөөд, 24-р зүйлд зааснаар, аливаа хуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын толоологчийн олонхийн саналаар зөвшөөрөн баталсан байвал баталсанц тооцохоор болжээ. 23-р зүйлийн дагуу Улсын Их Хурал нь түүний чөлөөт цагт Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан бөгөөд батлуулбал зохих зарлигүүдиг

батлах болсон юм. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоох бүрэн эрхийг гагцхүү Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр заасан нь ихээхэн дэвшилтгэй алхам болжээ.

-Харин Улсын Хурлын Тэргүүлэгчид нь дагаж шийтгүүлэн байгаа хуулиудад тайлбар огох, зарлигуудыг гаргах, тэдгээрийн хэрэгтэй нь Улсын Их Хуралд дараагаар оруулах бүрэн эрхтэй болжээ (29-р зүйлийн “г” хэсэг).

### *3.2.3. 1960 оны Үндсэн хууль*

1960 оны Үндсэн хуулийг боловсруулж батлахдаа омнох Үндсэн хуулийн зохицуулалтыг хэвээр хадгалан үзүүлэсэн билээ. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрхийг барих дээд газар нь Ардын Их Хурал байсан богоод тус улсад гагцхүү Ардын Их Хурал хууль тогтоох эрхтэй байв (18,19-р зүйл). 20-р зүйлд заасны дагуу Ардын Их хурал төрийн бүх эрхийг барих богоод үүнээс тухайлбал: "...1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг батлах ба өөрчлөх, 2.Хууль гаргах, ...9. Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс гаргасан Ардын Их Хурлаар батлуулбал зохих зарлигуудыг батлах..." бүрэн эрхтэй байсан. Харин Ардын Их Хурлын Тэргүүлэгчид нь Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт засаг төрийн эрхийг барих дээд байгууллага мөн богоод дагаж шийтгүүлэн байгаа хуулиудад тайлбар огох, зарлиг гаргах эрхтэй байв (33-р зүйл).

**4. Монгол Улс дахь хууль тогтоох үйл ажиллагааны практик**  
Хууль тогтоох бүрэн эрх гэдэг нь Үндсэн хууль, бусад хуулийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох цогц үйл ажиллагаа юм. Эдгээрийн хэрэгжилтийг тус тусад нь авч үзлээ.

**4.1. Үндсэн хууль баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулжс ирсэн практик ажиллагаа**

Анхдугаар Үндсэн хуулийг Улсын Анхдугаар Их Хурлаар, 1940 оны Үндсэн хуулийг Улсын наймдугаар Их Хурлаар, 1960 оны

Үндсэн хуулнийг БНМАУ-ын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганаар тус тус баталсан байдал. Тухайн, тухайн хуралдааны тэмдэглэлийүүдтэй танилцвал төслийг толоо лөгчдөд танилцуулах, тэд нараас гарсан асуултанд хариулах зэрээр үндсэн хууль батлах үйл явц журам горимын дагуу явагджээ.

Оргох магадлал өндөр гэмт хэрэгтнүүд онц аюултай ялтан байна. Тиймээс тус хорих анги нь өндөржүүлсэн хяналттай байна. Ердийн хорих анигууд энэ хэсгийг тусгаарласан байх бөгөөд хараа хяналтыг өндөржүүлсэн байх бөгөөд ажиллах амьдрах байр нь бүгд тусгаарлагдсан байна. Гадна хэсгийн харуул хамгаалалт: орчны талбайг албан хаагч хугацаатай эргэж тойрно. Торон болон хэрмэн хананд тулах хяналтыг телекамер мөн гэрэлтүүлг болон нохойтой албан хаагч хийнз.

### **Дүгнэлт**

1. 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилтээс харахад Монгол улсын эрүүгийн хариншлагын тогтолцоонд хорих ял дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал шүүхийн шүүн таслах ажиллагааны иэгдсэн мэдээгээр нийт яланы дотор хорих яланы эзлэх хувь 60-70%, давтан гэмт хэрэгтэн 49%-тай байна. Энэ нь хорих, баривчлах, цаазаар авах ялыг хавтгайруулан оногдуулж байгааг харуулж байна. Иймээс эрүүгийн хуулийг эргэн харах, шинэчилж, өөрчлөх нь тулгамдсан шаардлага байгааг харуулж байна. Хорих яланы осолтийг бууруулах, шорон дүүргэлтийг багасгах нь тулгамдсан асуудал болсоор байна.
2. Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлсизээр ялтны ял залж хугцаанд нь ялтныг гэр бүл, наиз нөхөд, хамт олныхоо дунд хөдөлморлох, нийгэмтэйгээ харьцах, үр хүүхдээ ёсгох, гэм буруугаа ухааран хүмүүжих, шоронжих сэтгэлгээнээс хол байх нохцол бүрдэнэ. Хорих ял оногдуулсан ялтаанд тороос зарцуулж буй хоронго, нийгэмшүүлэх зардал багасна.
3. 2015 онд шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд хорих яланы дэглэмнийг иээлттэй хаалттай дэглэмтэй байна гэж хуульчилсан. Шинэ хуулийг мөрдох хугацаа хойшилсон ч 2002 оны эрүүгийн хууль хэвээр үйлчилж байгаа оноө үед хорих

ялны жир, чанга, онцгой, гэсэн дэглэмүүдийг зайлшгүй  
өөрчлох шаардлагатай байна. Учир нь:

Нэгдүгээр оноогийн жир, чанга, онцгой дэглэмүүдийн  
хаорондын ялгаа багассан. Хоёрдугаарт дэлхийн бусад ихэнх  
улс хорих ялны иzzлтэй хаалттай дэглэмд шилжсэн.

4. 2002 онд баталсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль  
хоригдлыг бусадтай уулзах, харицах эрх зүйн байдлыг  
дээрдүүлсэн. Ялангуяа жирийн дэглэмийн ялган бусадтай  
уулзах захидал илгээмж авах эрх нь хязгаарлалтгүй болсон.  
Чанга ноцгой дэглэмийн түр ба удаан хугацааны уулзалтын  
тоо иzzмэгдсэн. Энэ бүхэнтэй холбоотойгоор илгээмж авах,  
захидал бичих, шаардлага байхгүй болсон.
5. Мөн хорих ангийн хамгаалалтын бүсүүдийн хоорондын ялгаа  
тун бага болсон. Бүх дэглэмүүдэд хамгаалалтын хэрэгслэл,  
тоног тохеоромж, гадна талын харуул хамгаалалт, хяналт зэрэг  
үзүүлэлтүүд бүгд адил болж байна.
6. Сүүлийн жилүүдэд төвлөрсөн хорих ангиудын гадна  
хамгаалалтын хэрмэн хашааг дэглэмийн ялгаа  
харгалзахгүйгээр барьж байгуулсан. Энэ нь хорих ангиуд ял  
зdlүүлэх дэглэмийн ялгааг харгалzan тогтоосон хамгаалалтын  
олон бус байх шаардлага багассаныг харуулж байна. Эндээс  
хорих ялны дэглэмүүдийн хоорондын зааг ялгаа багассан  
боловхыг харуулж байна.
7. Орчин үед ялангуяа жирийн дэглэмд хорих здлжж байгаа  
засрал хүмүүжил сайтай зарим хоригдлыг олон нийтээс  
тусгаарлаж байна гэж үзэхэд эргээжээгэй болж байна.  
Зарим ноццолд жирийн дэглэмтэй ялтнууд харуул  
хамгаалттайгаар олон нийтийн дунд хөдөлмөрлөж байгаа  
практик байна.

# **AMENDED CRIMINAL CODE OF MONGOLIA AND ITS CHALLENGES OF IMPLEMENTATION IN CONTEMPORARY CONFLICTS**

The purpose of this speech is to underlie an overview of revised criminal code of Mongolia on issues in regarding to punishment principle, circumstances of incarceration and imprisonment punishment, overview of newly introduced punishment of home detention, process of punishment imposition, authorized legal bodies and prisoner security category classification.

## **1. Issue on amendment of punishment purpose**

Current Criminal Code of Mongolia (2002) defines the purpose of penalty and criminal liability as follows: "to protect citizens and society from criminal interference, restore the infringed rights, punish and educate (upraise) the offenders, and prevent from committing crimes". whereas this article is modified in Criminal Code in 2016 as "Purposes of criminal liability shall be protection of the citizen and society from criminal encroachments, restoration of the rights violated in result of a crime, deterring the persons who committed crime, prevention of crimes and helping inmates back into society ". It can be analyzed it brought up issues prisoner's life after imprisonment. Rehabilitation has been played a big role in the history of imposition of criminal punishment.

In scope of legislation reform of Mongolian government policy on rehabilitations can be emphasized by following distinguishes:

1. Reduce the imprisonment share and duration as raising the duty of non-imprisoning penalty policies.
2. Policy of prison's activity should be guided by "socialize" but "punish", transfer prison institution into open - close regime, to bring prison environment close to international level, to create practical field to let different types of penalties to take place, to bring the activity of convict's socialization into professional level, to encourage prisoners and to focus on effectiveness on punishment system.

Correction facility and decision enforcement service's social work is a professional work to implement social reintegration programs to inmates, develop inmate's ability to participate in social relations, keep them sustainable in social psychology and to develop their behaviors. In

practice, correction facility and decision enforcement service's work is differentiated by the crime committed by the convict's personality, age and gender.

In scope of this speech I have obtained information on other countries of practice imposition of criminal punishment procedures. Even though it is different from country to country but there are significant amount of similarities in imposition of punishment.

## **2. Issue 'Limitation on the right to travel':**

The detention /imprisonment/ is being overwhelming majority of The Criminal liability system since Criminal Law of Mongolia implemented in 2002. According to the unified information data of the court decisions, around 75% of were detention sentences, 10-15 % of were arrest, and 1-5% of were other penalties of all sentences. Totally there is 90% of detention sentences. This evidences that the issuance of sentences to detain, arrest and capital punishment is too common in court practice. Therefore revised criminal code includes the home detention as a criminal punishment. Home detention provides an alternative to imprisonment and aims to reduce re-offending while also coping with expanding prison numbers and increasing costs. It allows eligible offenders maintain family relationships and responsibilities and attend rehabilitative programs that contribute towards addressing the causes of their offending.

## **3. Issue 'Detention regime':**

Following that, I quoted the 193rd act of Government in 2012 approved the program "Transferring prison type and regime into open - close regime system" in my speech. Developed countries such as Germany, in Colorado State of the US, the UK and Switzerland have implemented the practice of open, closed and half-open regimes of the detention. If we take a look from legal regulations and practical acts side: the formulation which has made on the basic attributes of prison sentences necessarily leads to changes and it set purpose to bring the type and regime of imprisonment into the international standard.

**МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТМООЖООС  
ЯЛГАМЖТАЙ МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ  
ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМД ҮНДЭСЛЭН  
ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ**

*Ц.Мандах, /LL.D/*

*Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын  
хурээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор*

**Товч агуулга**

Энэхүү өгүүлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийс ялгамжтай тохиолдолд хэрэглэх хэмжээгүй, тухайн олон улсын гэрээний үйлчилэл болон шүүхэд шууд хэрэглэгдэх боломжтой эсэх зэргийг хэрхэн тодорхойлох талаар онолын түвшинд товч дун шинжилгээ хийх замаар Монгол Улс аливаа олон улсын гэрээнд нэгдэн орох буюу соёрхон батлахдаа дотоодын хууль тогтоомжийг түүнд ишүүцүүлэх арга хэмжээ аваагүйгээ үүсэх бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар жишээнд тулгуурлан тайлбарлав. Тодруулбал, хууль тогтоогч олон улсын гэрээнд нэгдэн орохдоо дотоодын хуулийг түүнд ишүүцүүлэгүйгээ болж зарим тохиолдолд Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хуультай зорчилтэй хэрэгжих боломжтой байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурал "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протокол"-д нэгдэн орох тухай хуулийг 2012 оны 1 дугаар сарын 5-ны өдөр баталсан. Ингэнээр Монгол Улс цаазаар авах ялагүй орон болсон бөгөөд тус нэмэлт II Протоколд нэгдэн орсноор Монгол Улс олон улсын ёмно цаазын ялыг бүрмосон халах үүрэг хулээсэн боловч тухайн үед хууль тогтоогч Монгол Улсын Эрүүгийн хуульд бөрчлөлт оруулаагүй тул өнөөг хүртэл энэ торлийн ял Монгол Улсын Эрүүгийн хуульд хүчин тогтолцор хэвээр байна. Иймд тус олон улсын гэрээ болон Эрүүгийн хууль хоорондоо зорчилтэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжтой зорчилтэй

тохиолдолд тухайн олон улсын гэрэг шүүхэд хэрэглэхээ олон улсын эрх зүйн "Pacta sunt servanda" буюу "гэрэг заавал биелүүлэх зарчим", Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд тулгуурлан тайлбарлан хэрэглэх замаар залруулах боломжийн талаар энэхүү огүүлээр хөндөв.<sup>1</sup>

**Түлхүүр үг:** олон улсын гэрээ, гэрэг заавал биелүүлэх зарчим, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, олон улсын гэрэг тайлбарлан хэрэглэх

### **1. Олон улсын гэрээний үйлчлэл, түүнийг соёрхон батлах нь**

Олон улсын эрх зүйн болон үндэсний эрх зүйн систем нь харилцан адилгүй боловч нягт уяддаа холбоотой. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлооний талаарх хэм хэмжээ нь хүний эрхийн талаарх олон улсын баривт бичгийн заалтуудад үндэслэгдсэн байдал. Олон улсын эрх зүйн нэг онцлог нь эрх зүйн тухай тогтолцоон дахь субъектүүдийн эрх үүргийг тодорхойлдог. Нөгөөтэйгүүр улс орнууд олон улсын эрх зүйн дагуу үүрэг хүлээхийн сацуу түүнийг үндэсний хэмжээнд буюу дотоодлоо мөрдөх, нутаг дэвсгэрийнхээ хүрээнд биелзлийг нь хангах үүрэгтэй. Үүнийг олон улсын эрх зүйн хэмжээний хэрэгжилт буюу имплементаци гэнэ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн З-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилэл" гэж заасныг Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венеийн конвенцтэй уялцаатай, цопц байдлаар, хамтатган хэрэглэх учиртай. Монгол Улсын хувьд олон улсын гарээний эрх зүйн хэм хэмжээ, олон улсын нийтээр дагаж

<sup>1</sup> Энэхүү огүүлээт нь золигчийн 2015 оны Шүүх эрх мэдээ залжсан №1 дугаарт нийтэгээсн "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын Цагаанаар авах языг халхагд чиглэсэн Имээлийн II протоколын олон улсын эрх зүйн растыг *sunt servanda* зарчмын үндэслэл нь "огүүлэгийн гол саналын түүхээрлийн холбоодох нэмээтийн судалгаа хийж он министрийн бозовсруулагдсан болно.

мордох зэрчим, хэм хэмжээ, НҮБ-ын дурэмд заасан зорилго, зарчим заавал биелгэдэх хэм хэмжээ юм.<sup>2</sup> Түүнчлэн БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мордоход шилжих тухай Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд харшилаагүй БНМАУ-ын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зорчилдсон тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална” гэж зааснаас харахад Монгол Улсад олон улсын гэрээ давуу хүчин чадалтай болохыг харуулж байна.

Олон улсын хоёр болон олон талт гэрээ байгуулах, биелүүлх, хяналт тавих, цушах, иэгдэн орох, гарахтай холбогдсон харищааг зохицуулдаг 1993 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заавал соёрхон батлах олон улсын гэрээг тусгасан ба 10 дугаар зүйлийн 10.2-т Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас оор журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батлахаар заасан байдаг.

Соёрхон батлах гэж олон улсын гэрээг төрийн эрх барих дээд байгууллагаар батламжлахыг хэлнэ. Соёрхон батлах нь төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэр учраас тухайн улсын төрийн бүх шатны байгууллагын хувьд гэрээг заавал биелүүлж зоншоорлийг илэрхийлж байгаа хамгийн нэр хүнд бүхий хэлбэр мөн юм.<sup>3</sup> Түүнчлэн Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 15-д “Улсын Их Хурал Засгийн газрын оргон мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг оорийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх”-ээр заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 болон Хорин тавдугаар зүйлийн 15-ын заалт нь соёрхон баталсан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн иэгэн адил хүчингэй болохыг

<sup>2</sup> Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн фэлээрэнгүй тайлбар, Улаанбаатар хот, 2011 он, 7 дэхь тал

<sup>3</sup> Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн фэлээрэнгүй тайлбар, Улаанбаатар хот, 2011 он, 16 дэхь тал

нотолсон, тэдгээрийг төрийн бүх шатны байгууллага дагаж мордох үүрэгтэй болохыг хуульчилсан заалт юм.

Харин олон улсын гэрээний томъёоллын хувьд, Олон улсын гэрээний тухай хуулийн З дугаар зүйлийн 1-д “Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдтэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ” гэж тодорхойлжээ. Олон улсын гэрээ нь гэрээ, хэлэлцэр, тунхаглал, пакт, контракт, конвенц, протокол зэрэг нэр, хэлбэртэй байж болно.<sup>4</sup>

## 2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос ялгамжтай тохиолдод хэрэглэх хэмжээг тодорхойлох нь

Олон улсын нийтийн эрх зүйн хэмжээг хэрэгжүүлэх 2 торлийн арга зам байдаг. Энэ нь олон улсын гэрээнд нэгдэж орсноор түүнийг шууд дагаж мөрдэх эсхүл олон улсын гэрээнд нэгдэж орсноор түүний заалтуудыг дотоодынхоо хууль тогтоомжид тусгах явдал юм. Олон улсын эрх зүй болон дотоодын хууль тогтоомжийн талаар хоёр онол байцааг. Эдгэр нь монист онол буюу дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь бие даасан шинжтэй богоод тус тусдаа хогжин. Монгол Улсын хувьд Үндэсн хуулийн заалтын үзүүл санаа нь монист онолд илүү нийцж байгаа богоод дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь нэгдмэл шинжтэй юм. Хэдийгээр Монгол Улсын хувьд дотоодын хууль тогтоомж болон олон улсын эрх зүй нь нэгдмэл шинжтэй хэдий ч олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй

<sup>4</sup> Монгол Улсын Хууль зүйн нам, “Монгол Улсын Үндэсн хуулийн нэр төмөйнүүд дагалдаа”, Улаанбаатар хот, 1993 он, 25 дахь тал.

байсаар байна. Энэ тохиол байцлыг харгалзан, 2008 оны 2 дугаар сарын 28-ны одер Монгол Улсын дээд шүүх олон улсын гэрээний заалтыг дотоодод хэрэгжүүлэхтэй холбоотой шүүхийн ўйл ажиллагааг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор "Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай" 09 дүгээр тогтоол гарсан.

Тус тогтоолд, "шүүх эрүүгийн хэрэг, иргэний болон захирагааны эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ хучин төгөлдөр болсноор заавал даган мөрдох шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн, дотоодын хууль тогтоомжид измэлт, оорчлолт оруулахыг шаардсан заалттай, Үндсэн хуульд харшилаагүй, үндэсний эрх зүйн хариулцаны оролюгч этгээдүүдэд шууд эрх, үүрэг үүсгэх чадалтай Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ" гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хучин төгөлдор болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилээ" гэж заасан нь олон улсын гэрээ, конвенци олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болох хэдий ч Монгол Улсын шүүхийн практикт олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцыг хэрэглэдэг жишиг тогтоогүй ба шүүхийн практикт дотоодын эрх зүйг оргоноөр хэрэглэдэг тул, дотоодын эрх зүй нь хүний эрхийн гол гэрээ, конвенцуудын үзэл санаатай уялдахгүй, зөрчилдөх зэрэг асуудал нь эрх зүйн захирагдах ёсны гол асуудал болоод байна. Иймээс Монгол Улс нь эрх зүйд захирагдах ёсыг Монгол Улсад төловшүүлэх, мөрдүүлэхийн тулд иэн тэргүүнд хийх чухал алхам бол одоогийн мөрдөж буй хууль тогтоомжуудаа олон улсын гэрээ конвенци, тэр дундажаа олон улсын хүний эрхийн гол гэрээ конвенцуудын

зарчмуудтай хэр нийцэж байгааг нь дүгнэн шинжилж, шүүгч шийдвэр гаргах ажиллагаанд заасандаа здгэр гэрээ конвенцуудыг хэрэглэдэг, үзэл санаанд нь тулгуурлан хэргийг шийдвэрлэдэг шүүхийн практик тогтоох, улмаар аль ч шатандаа эрх зүйд захирагдах ёсны гол амин сүнс болсон хүний эрхийг дээдэлж, хамгаалдаг болох явдал юм.<sup>5</sup>

### 3. Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалтын дагуу олон улсын гэрээг хэрэглэх боломж

Монгол Улсад одоо мордогдож байгаа ихэих хуульд Монгол Улсын олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос давуу хүчин чадалтай гэж тусгагдсан байдаг. Тухайлбал, Иргэний хуулийн 539 дүгээр зүйлийн 539.2.-т Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын Иргэний хуульд зааснаас өөрөөр заасан бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтад харшилаагүй бол олон улсын гэрээний заалтыг дагаж мордено гэж заасан. Харин Эрүүгийн хууль нь өөрөө онцлогтой бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд Эрүүгийн хуульд зааснаас өөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг бусад Монгол Улсын ихэих хуулийн адил шууд хэрэглэх боломжгүй юм.

Монгол Улсын одоо үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 2.2-т “Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ” гэж заасан ба мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдээн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээнгэнэ” гэж заасан. Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 болон 13 дугаар зүйлийн 13.1-ээс харахад эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, ял онооход зөвхөн Эрүүгийн хуулиг хэрэглэхээр заасан байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдээн этгээдэд зөвхөн Эрүүгийн хуулиар эрүүгийн хариуцлага хүлээнгэнэ гэсэн гол ойлголт тодорхойлгож байна. Гэсэн хэдий

<sup>5</sup> Ц.Мандах, “Эрх зүйд захирагдах ёс ба шүүх эрх мэдэл”, Шүүх эрх мэдэл замжигээ, 2014 №2, 115 дарь тал.

ч Монгол Улсын Эрүүгийн хуулийн Эрүүгийн хууль тогтоомжийг тодорхойлсон ундсан хэсэг нь 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг юм. Энэ зүйд эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэмжээнд үндэслэн гэж заасан нь Монгол Улсын бусад ихнэх хуульд<sup>6</sup> тусгагдсан олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжарос давуу түйлчлэх тухай<sup>7</sup> зүйл, хэсгээс өөрөөр тусгагдсан юм. Тэгвэл Монгол Улсын иэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протокол /цаашид нэмэлт II Протокол гэх/-ыг хэрхэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжтой талаар дараах хэсэгт дун шинжилгээ хийж тайлбарлав.

**1) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протоколыг хэрэглэх асуудал, үүссэн бэрхшээ<sup>8</sup>**

<sup>6</sup> Олон улсын сэргэжийн тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэмжүй тайлбар, Улаанбаатар хот, 2011 он, 97-147 дэх таз

<sup>7</sup> Олон улсын эрх зүйг үндэстний хууль тогтоомжкоос давамгайж чанар нь олон улсын эрх зүйн үр өсөөжүүлж үзэчжээ чухал мөнцөл юм. Түүтийн энэ тъе улс сүргүй хөөрөөндөн хувь ёсны хариуцаа, энэ тайван, агуулж байдлыг сагтан хамгаалах дүүзээ зүйн баталгаа болж байна. (М.Дүгээрсүрэн, О.Хоссияр, "Олон улсын эрх зүй," Улаанбаатар хот, 1999 он, 4 дэх таз)

<sup>8</sup> Монгол Улсын Ерөнхийзүйч цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх өөрчийн байр суурин 2010 оны 1 дүгээр сарын 14-ний одор УИХ-ын чуулган дээр иясралжээ. Үүгээр Монгол Улс практикит цаазаар авах ялыг гүйцэтгэхээс үндэжнээс түрдээжин ба Ерөнхийзүйчин энхийүү байр суурин: эрх зүйн хувь баталгаажуулж, 2012 оны иядуулжээр сарын 5-нд Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгуулалтын Ерөнхий Ассемблейгээс 1989 оны 12 дугаар сарын 15-ны одор баталсан Иргэний бэзэн улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг давжад чиглэсэн нэмэлт II Протоколд иядээ орох тухай хуулийн тохиийн хэвлэлийг баталсан. Хэдийгээр тус олон улсын сэргээнд иядэн орсон хэдий ч олон улсын сэргээ хүчин тогтолцор болж эхэсэн одровс лойн шүүржээ хэд хэдэн удаа цаазаар авах ялыг ииноосон туз тус олон улсын сэргээ хэрэгжээд үүссэн бэрхшээг хэмжин тодорхойтож.

## **Гэрээгээр хүлээсэн үүрэг:**

Монгол Улсын Их Хурал НэгдсэнҮндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейгаас 1989 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II Протокол /цаашид нэмэлт II Протокол гэж/-д 2012 оны нэгдүгээр сарын 5-нд нэгдэн орох тухай хуулийн төслийг хэлэлцэж баталсан. Тус протоколд нэгдэн орсон буюу түүнийг соёрхон баталсан улс орон өөрийн шүүхийн харьяалын хүрээнд хамарагдах хэний ч хувьд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх, түүнчлэн өөрийн эрх хэмжээний хүрээнд цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах гэсэн үндээн 2 үүргийг хүлээдэг.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тодорхой заалтуудаар цаазаар авах ял оногдуулах гэмт хэргийг тодорхойлж өгсөн бага од дээрх олон улсын гэрээнд нэгдэн орохдоо Эрүүгийн хуулийн цаазаар авах ялыг хүчингүй болгох Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт хуулийг өргөн барьж, батлаагүй юм. Өөроор хэлбэл, Монгол Улс тус нэмэлт II Протоколд нэгдэн орох үед дотоодын хууль тогтоомжийг түүнд ишүүчүүлэх арга хэмжээ аваагүй тул Монгол Улсын олон улсын гэрээ ба Эрүүгийн хууль хоорондоо зөрчилтэйгээр хэрэгжиж байна.

Нэмэлт II Протоколын оршил хэсэгт дурдсанчлан, Монгол Улс нь тус протоколд нэгдэн орсноор Монгол Улс цаазаар авах ялыг халах нь хүний нэр төрийг бэхжүүлж, хүний эрхийг хөгжүүлиэ гэдэгт итгэж, Пактын 6 дугаар зүйлд цаазаар авах ялыг халах нь зохицой гэснийг онцлон тэмдэглэж, цаазаар авах ялыг халахад чиглэсэн бүхий л арга хэмжээ нь хүний амьд явах эрхийг хангах баталгаа болох ёстойг ухамсарлаж, цаазаар авах ялыг халах үүргийг олон улсын омно хүлээхийг хүсч нэгдэн орсон гэж ойлгох нь зов юм.

Иймд Монгол Улсад одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд хууль тогтоогч нэмэлт өөрчлөлт оруулж, цаазаар авах ялыг

хүчингүй болгоогүй тул энэхүү ял нь хүчин төгөлдөр хэвээр байна. Энэ нь зүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цазын ялыг оногдуулах эсэх дээр эргэлзээтэй байдлыг үүсгэж байна.

### Гэрээний хүчин чадал, хэрэглэх боломжийг тодорхойлох нь:

Өмнөх хэсэгт хийсэн дун шинжилгээнээс харахад, Монгол Улсын Эрүүтийн хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа нэмэлт II Протоколыг 2012 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улс төрийн эрх барих дээд байгууллагын тогтоонийг тодорхойлох нийтийн төгөлдөр Монгол Улсын хууль юм.

Энэ хүрээнд авч үзвэл Монгол Улс нэмэлт II Протоколц нэгдсэнээр оорийн үндэсний хууль тогтоомжид холбогдох нэмэлт, оорчлолт оруулах шаардлагатай гэж үзсэн эсэх талаар түүхчилжин тайлбар хийх нь зөв юм. Түүхчилжин тайлбарыг хийхдээ эрх зүйн актыг баталж хэлэлчж байх уед ямар санаа бодлоор хууль тогтоооч баталсан бэ гэдгийг эргэж харах нь зүйтгэй. Өөрөөр хэлбэл, тухайн хэм хэмжээг тогтоож байх цаг үеийн нөхцөл байдал, хүчин зүйлсийг тооюх арга юм. Энэ үүднээс УИХ-ын холбогдох байнгын хороодын санал, дүгнэлт, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, протоколыг судлан үзвэл, хууль тогтоогч холбогдох дотоодын хууль тогтоомжид нэмэлт, оорчлолт оруулах шаардлагатай гэж үзэгүй байна.<sup>9</sup>

<sup>9</sup> Ирээний болон улс төрийн зүтгэлийн тухай олон улсын Пактын цагаанаар авах язгууламжад чильтээн Ихэвчлийн II Протоколыг соёрхон башлах тухай хуулийн тохиолд Монгол Улсын Засгийн газар 2010 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд орсон мэдүүлэсэн. Тус нэмэлт II Протоколд нэхэмжилжээгээ зөвлөхөө тухай асуудлыг Аюулжүйг бийдэл, гадаад бодлогын байнгын хороо 2010 оны 10 дугаар сарын 12-ны одийн хуралдаанаараа хэвлэлтээс горимын саналын дэдүү Хууль зүйн баймын хорооны хуралдаанаар хэвлэлчүүзээсээр шийдвэрлэсэн ба дээрх асуудлыг Хууль зүйн баймын хорооны 2010 оны 10 дугаар сарын 19, 26-ны өдөр тус тус хэвлэсэн. Хууль зүйн баймын хорооны гишүүд дээрх асуудлыг хэвлэхээд яваад цагаанаар авах язгуулжтэгэсний дараа тухайн эхийн гэлийн бурууцгүй нь тогтолцоогдох тохиолд байдлыг бичсан тогтолцох боломжгүй болно, дээрх яз нь гэвтэй хөгжлийн спрагзмын багасгасанд тухай оровсогт

Түүчинчлэн тус олон улсын гэрээнд оролцогч улс дотоодын хууль тоогоомжид нэмэлт, өөрчилгэлт оруулах шаардлагатай талаар тусгайлан заагаагүй ба гэрээний дагуу оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд цаазын ялыг зовхон дайны цагт хэрэглэхийг л зөвшөөрдөг байна. Иймээс нэмэлт II Протокол нь Монгол Улсын нутаг давсгэрт шууд үйлчлэх буюу оороо биелгэдэх шинжийг агуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус нэмэлт II Протоколыг шууд хэрэглэж болох эсэх талаар дүн шинжилгээ хийж үзвэл, 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдөр “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүдээн зөвшөөрсөн хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” Монгол Улсын Дэд шүүхийн 09 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэгт, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Үйлдэл, эс үйлчүүг гэмт хэрэгт тооююх, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжэг зовхон энэ хуулиар тодорхойлно” гэж заасан тул Эрүүгийн хуулыд тусгайлан заасан

---

ойшолтод цэв тавих, улс орны шийгэм, эдийн засгийн интегрировтой уе дуучч байгаа цаг үед хүмүүрээ, энэргийг ёсны зарчмын үүднээс хандаж цаазаар авах ялыг халахамж тайлбарын тийтийн хамдаалчилж эзэрчжин манай улс эхэхүү Нэмэлт II Протоколд нэгдэн орах нь цаг үед олсон томоохон шийдэл болго, уг асуудлыг шийдвэрээс омно холбоодх төрийн байгууллагасар Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн бодлога, эрүүгийн танхцэл байдаг, цаанын чиг хандлага тэрх ясуудалд бодитай судалгаа хийгэх, шийт цэгээдээ энд тазаарт зөрхөн ойлголтыг сурталчилж шаардлагатай зэрхэг санаалыг тус тус гаргасан байна. Түүрэчин хуралдаанд ороцсон гишүүд Ирээний болон улс төрийн зэхийн түүхий олон улсын Пактын цаазаар авах ялыг халхад чиглэсэн Ихэгээт II Протоколд нэгдэн оролыг зөвшилцөвт асуудал нь Монгол Улсад хувьн төсөлдөр мордогдаж буй хувь тогтолцожстой тогтолцожгүй гэж үзсэн байна. Ирээний болон улс төрийн зэхийн түүхий олон улсын Пактын цаазаар авах ялыг халхад чиглэсэн Нэмэлт II Протоколыг соёрхон батлах түүхий хуулийн төсийн Улсын Их Хурал 2011 оны 5 дугаар сарын 05-ны одрийн чуулганы нэгдэстн хуралдаашар хэлэлцэх үед УИХ дээль МАН-ын бүлэг зөвсэргэлж авсан ба улшиар 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр үргэлжлэхгүй хэлэлцэж Улсын Их Хурээн чуулганы хуралдаамын дэсийн түүхий хуулийн 29.1.1-д заасны дагуу хуралдаанд ороцсон гишүүдийн албаныт санаалыг соёрхон бийтгэсэн.

тохиолдолд л эрүүгийн гэмт хэргийн шинжийг тодорхойлсон олон улсын эрх зүйн хэм хэмжээг шүүхэд хэрэглэж болно гэж тус тогтооолд онцолжон байна. Үүнээс харахад Монгол Улсын Эрүүгийн хуулыд тусгагдсан цаазаар авах ялыг хүчингүй болгосон талаар тусгайлан заагаагүй учир тус нэмэлт II Протоколыг эрүүгийн хэрэг хянан шийцвэрлэх ажиллагаанд шууд хэрэглэх боломжгүй мэт харагдаж байна. Гэхдээ дээр дурдсанчлан Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг бүр нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд шийцүүлэн иждэн орсон олон улсын гэрээ, конвенцийн зарчим, үзэл баримтлалд үндэслэж байх ёстой юм.

## 2) Олон улсын гэрээг *Pacta sunt servanda* зарчмыг тулгуурлан хэрэглэх нь

Хуулийг зорилго, чиг үүрэгт нь тулгуурлан тайлбарлах арга нь аливаа хэм хэмжээг хууль тогтоогчийн зорилпод тулгуурлан тайлбарлах явдал юм. Үүгээр ямар харилцааг зохицуулах, ямар зорчигдсон эрх зүйгийг хамгаалах гэснийг тайлж уншина. Энэ байдал тодорхойгүй буюу бүрхэг тохиолдолд түүнийг системчих байдлаар хайна. Тодруулбал, хуулийг зорилгоос нь эхэлж уншаад тухайн хуулийн хамаарах бусад систем төдийгүй Үндсэн хуулийн суурь зохицуулалт хүртэл шалгаж үзэх юм.<sup>10</sup> Энэ хүрээнд, хуулийн зорилго, зохицуулалт нь тодорхой богоод нэмэлт II Протоколын дагуу оролцогч улс нь цаазаар авах ялыг халах үүрэгийг олон улсын өмнө хулээж, баарийн шүүхийн харьяаллын хүрээнд хамарагдах хэний ч хувьд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй буюу оролюгч улс бүр баарийн шүүхийн харьяаллын хүрээнд цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах юм.

<sup>10</sup> Н.Лумдэндорж. "Хууль тайлбарлан хэрэглэх омол арга зүй (Лекцийн тэндээлэл)", Шүүх эрх нийтийн эмчилгээ, 2015 он №1, Уламбаяатар хот, II дахь мал.

Дээр дурдсанынлан, тус нэмэлт II Протоколд иэгдэн орсноор Монгол Улс хоёр үүргийг олон улсын омни хүлээж байгаа богоод здгээр нь Монгол Улсад цазын ялыг түйцэтгэхгүй, цаазаар авах ялыг халахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авах юм.

“Аливaa хүчин төгөлдөр гэрээг түүнд оролцогч улсууд заавал биелүүлэх үүрэгтэй богоод түүнийг үнэнч шударгаар хэрэгжүүлнэ” гэж Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн Конвенцид заасан байдал.<sup>11</sup> Энэ нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон *Pacta sunt servanda* буюу гэрээг заавал биелүүлэх зарчим юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг богоод Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “Гэрээгээр хүлээсэн үүрээ шударгаар сахин биелүүлэх” зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын II нэмэлт Протоколын зургадугаар зүйлийн 1-д “Энэхүү Протоколын заалтууд нь Пактын хувьд нэмэлт заалт болон хэрэглэгдэнэ” гэж заасан тул нэмэлт II Протокол нь Пактын нэг хэсэг боливо.

НҮБ-ын Хүний Эрхийн хорооны 80 дугаар чуулганас “Пактын гишүүн улсуудад хүлээгэснэй нийтлэг үүргийн тухай” 31 дүгээр зөвлөмжийг гаргасан байна. Тус зөвлөмжийн 4 дэх хэсэгт “Пактын дагуу оролцогч улсын хүлээсэн срдийн үүрэг болон Пактын 2 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг нь Пактын оролцогч улс бүрт бүхэлдээ үйлчилнэ” гэж заасан. Түүничийн “бүх шатны төрийн байгууллага (үүнд: хууль тогтоох, түйцэтгэх болон шүүх эрх

<sup>11</sup> Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенци, 1969 оны 5 дугаар сарын 23-ны одор баталж, 1980 оны 1 дүгээр сарын 27-ны одор хүчин тогтолцор болсон. (Монгол Улс 1988 оны 4 дүгээр сарын 11-ний одор иэсэн орсон. Төрийн лэдээхээ тусгай дугаар, II боть, 459 дэх тайл.)

мэдлийн байгууллага хамаарна) болон бүх шатны буюу улсын, бүс нутгийн эсхүл орон нутгийн олон нийтийн байгууллага, төрийн байгууллага оролцогч улсын хүлээсэн үүргийг хүлээнэ. Олон улсын, тэр дундаа Хорооны эмне тухайн оролцогч улсыг ихэвчлэн толооцдог гүйцэтгэх засаглал нь хариушлагыг хүлээхэс хэлтрэх болон үр даавраас зайлсхийх зорилгоор аль нэг засаглалын салбарын Пактын зүйл заалттай тохирохгүй буюу харшилсан үйлдлийг буруутгаж болохгүй юм. Энэхүү ойлголт нь Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйлд тусгагдсан зарчимгай шууд хамааралтай ба тус зүйлийн дагуу Оролцогч нь гэрээг биелүүлэхгүй байгаанаа зөвтгөхийн тулд дотоодынхао эрх зүйн заалпаас иш татах ёсгүй юм.<sup>12</sup>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр Үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй” гэж заасан. Гэхдээ энэхүү зарчмыг Үндсэн хууль болон бусад дотоодын хуулийн зүйл заалпаас иш татах биелүүлэгүй үүрэг эсхүл гэрээний дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэгүйгээ зөвтгэж болохгүй юм.<sup>13</sup>

Хуулийг тайлбарлан хэрэглэхдээ хууль тогтоогчийн санаа бодол, зорилгыг аллагдуулж хэрхэн болохгүй тул шүүгч шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ хууль бол улс төрийн бодлого,

<sup>12</sup> НҮБ-ын Хурийн Эрээний хороомын 80 дүгээр чуулганын гарсан “Пактын гишүүн улсуудад хүлээгжсэн тиймтэй үүргийн тухай” 31 дүгээр тохиомжийн 4 дахь зүйл (*The Nature of the General Legal Obligation Imposed on States Parties to the Covenant CCPR/C/21/Rev.1/Add. 1326 May 2004*) Цахим хэзбоос <http://doxis2.oicohcr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=6QkG/dPPRiCAqhkKb7yhsjYoiCMKo/Rv2FVa1%RLMiTniRO+fnf3cPVrcM9YR0/W6Txaxgr3f9kUFpWoghB/TpKj2pPhZsbEJw/GcZRASidFunJORub,IEaUhby3IWOPt2mfFDc6ZSwM/MmOGV/H>

<sup>13</sup> Мөн тэнд

шийдвэр гэдгийг ямагт анхаарч байх ёстой бөгөөд бодлогыг ойлгоогүй цагт хуулийг зов тайлбарлан хэрэглэх боломжтүй юм.<sup>14</sup> Энэ үүдлийс нь хараад измэлт II Протоколд нэгдэн орж, хууль тогтоогч цаашид Монгол Улсад цаазын ялыг халж, түйцэтгэхгүй гэж Монгол Улсын хуулийг гаргасан бөгөөд энэ улс төрийн шийдвэр нь цаг хугацааны хувьд цаазын ялыг хэрэгжүүлж бодлого гарсан тул сүүлц батлагдсан хууль нь хүчин тоголдер байх онолоор<sup>15</sup> үйлчилж ёстой юм.

Дээр дурдсанчлан *Pacta sunt servanda* буюу гэрээг заавал биелүүлэх зарчим нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим бөгөөд түүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлий” гэж заасан тул Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасан “Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийгээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ” гэж заасныг үндэслэн шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тайлбарлан хэрэглэх нь оновчтой санаадаж байна. Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 нь тус зүйлийн 2.2-оос илүү хүчин чадалгай буюу Эрүүгийн хууль тогтоомжийг тодорхойлсон үндсэн заалт юм. Өөрөөр хэлбэл “Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэнэн” гэж заасан тул Монгол Улсын Эрүүгийн хууль нь бороо Монгол Улсын Үндсэн хуулиас салбарлаж гарсан органик хуулийн хувьд тус хуулийн зүйл заалт бүр нь Монгол Улсын Үндсэн хуульд үндэслэх ёстой билээ.

<sup>14</sup> Н.Лүндиндорж: “Хууль тайлбарлан хэрэгзэх онол, арга зүй (Лекцийн тэмдэгэлээр)”, Шүүх эрх мэдээ эмчилгээ, 2015 он №1, Улаанбаатар хот, 9 дэх тал.

<sup>15</sup> *Leges posteriores priores contrarias abrogant*

*Subsequent laws repeal those before enacted to the contrary.*

*2 Rol. R. 410; 11Co. 626, 630. Law Dictionary. Adapted to the Constitution and Laws of the United States. John Bouvier. Published 1856.*

### **3) Эрүүгийн хуулийн шинэчилсэн нариуулга дахь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээ**

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 3-ны одор баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн нариуулгад 2002 оны Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д заасантай адил Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэн гэж тусгагдаагүй байна. Тус хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг, ял, албадлагын арга хэмжээг энэ хуулиар тодорхойлно”, мөн зүйлийн 3-т “Үйлдэл, эс үйлдвүүг шинээр гэмт хэрэгт тооцсон, шинээр ялын төрөл, хэмжээг тогтоосон Эрүүгийн хуулыг нэмэлт, оорчилж оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно” гэж Эрүүгийн хууль тогтоомжийн бүрдэл болон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнгэх хуулийг тус тус тодорхойлсон байна. Шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4-т “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлж, хэм хэмжээг баримталаха” гэж заасан нь зөвхөн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад олон улсын гэрээг харгалзан үзэх асуудал тусгагдсан байна. Харин олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээний тухайд тус хуульд тусгагдаагүй бөгөөд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэх тухай тусгагдаагүй байна.

#### **Дүгнэлт**

Монгол Улс төрийн эрх барих дээд байгууллагадаар батгламжилж соёрхон баталсан аливаа олон улсын гэрээгээр хүлээн үргүгийг завал биелүүлэх ёстой бөгөөд энэ нь европе олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн *Pacta sunt servanda*

буоу гэрээг заавал биелүүлэх зарчим юм. Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 1-т "Монгол Улс олон улсын эрх зүйн шийтгээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна", мөн зүйлийн 2-т "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж заасан тул Монгол Улсын бүх шатны төрийн байгууллага олон улсын хамтын нийгэмлэгийн омно болон гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажиллах ёстой нь харагдаж байна. Нэгэnt гэрээгээр хүлээсэн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн олон улсын гэрээнд нэгдэн орох үед цаг тухайд нь дотоодын эрх зүйн хууль тогтоомжийг тухайн гэрээтийг уялдуулж, шаардлагатай оөрчлөлтүүдийг хууль тогтоогчийн зүгээс хийж байх ёстой байна.

Монгол Улс одоогийн мөрдөж буй хууль тогтоомжуудаа олон улсын хүний эрхийн гол гэрээ юнвениуудын зарчмуудтай хэр нийцэж байгааг нь дүнэн шинжилж, шүүгч шийдвэр гаргах ажиллагаанд даа здгээр гэрээ конвенциуудыг хэрэглэдэг, узл санаанд нь тулгуурлан хэргийг шийдвэрлэдэг шуухийн практик тогтоох, улмаар аль ч шатаандaa эрх зүйд захирагдах ёсны гол амин сүнс болсон хүний эрхийг дээдэлж, хамгаалдаг болох нь чухал байна.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин тогтолцээр болмопц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилэг гэж заасан хэдий ч энэхүү нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилгээний байсан хэдий ч Эрүүгийн хууль зэрэг зарим онцлог бүхий хуулийн дагуу энэхүү дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил бүхий олон улсын гэрээг шууд хэрэглэх боломж нь хязгаарлагдмал байна. Иймд тухайн эрх зүйн хэм хэмжээний уялцаа холбоо, үр дүн, зорилгыг анхаарч судлан хэрэгжүүлж, бүх шатны төрийн байгууллага Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн омно болон гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаагийн хувьд шүүгч шуухийн шийтгэх тогтоолын үндслэлж

хэсэгт дээрх байдлаар Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтыг тайлбарлан хэрэглэж байх нь зүйтэй нь харагдаж байна. Оюроор хэлбэл, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжгий зорчилгэй тохиолдолд болон хууль тогтоогч дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй уялдуулан баарчлалт хийгэгүй тохиолдолд тухайн олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх үед шүүгч түүнийг гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нь уялдуулан тайлбарлан хэрэглэх замаар залруулж байх нь зөв байна.

Түүничлэн шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээний тухай отгхон ч тусгагдаагүй бэгээд Эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэх тухай от тусгагдаагүй нь учир дутагдалтай байна. Энэ нь цаашил шүүхээс эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэх ажиллагаанд эрүүгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсон зарчим, хэм хэмжээнд үндэслэсэн эсэхэд тайлбар хийх боломжийг нь хязгаарласан байна. Иймд шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд энэ торлийн зүйл заалтыг нэмж оруулах зайлшигүй шаардлагатай нь харагдаж байна.

# SOME ISSUES WITH THE INTERPRETATION AND THE APPLICATION OF INTERNATIONAL TREATIES RATIFIED BY MONGOLIA WHICH ARE INCOMPATIBLE WITH MONGOLIA'S DOMESTIC LAWS, BASED ON COMMONLY RECOGNIZED INTERNATIONAL LAW PRINCIPLES

This article provides a brief analysis on how to define whether the international treaties which Mongolia is a party to are incompatible with its domestic legislation, and what power Mongolian courts have to apply international law which is inconsistent with domestic legislation. It provides examples of how international law principles apply where Mongolia's legislators have not taken measures to adapt domestic legislation by ratifying the international treaty.

Specifically, when legislators ratify international treaties which are incompatible with the domestic laws and do not take any action to adapt the domestic law, Mongolian domestic laws remain in force although they are incompatible with the ratified international treaties.

For example, Mongolian State Great Hural adopted the law of ratification of "The Second Optional Protocol to the *International Covenant on Civil and Political Rights*, aiming at the abolition of the *death penalty*" on January 5th 2012, and it is already in force and effective as domestic legislation. Since the ratification, Mongolia is obliged to abolish the death penalty in accordance with Article 1(2) of the Second Optional Protocol, however the death penalty remains an available sentence under the Criminal Code of Mongolia.

This article identifies possible ways to interpret and apply international treaties which are incompatible with domestic laws, based on the Constitution of Mongolia and commonly recognized principles and norms of international law.

**Keywords:** international treaty, *pacta sunt servanda* principle, commonly recognized principles of international law, interpretation and the application of the international treaties

# **ХУУЛЬ ХЭРЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС, ХУУЛЬ ЗҮЙН ПОЗИТИВИЗМЫН ХОЦРОГДОЛ**

*/Эрүүгийн эрх зүйн хүрээнд/*

*П.Баянбаатар*

*Шихижүүц их сургуулзийн*

*Эрүүгийн эрх зүйн тэжэлтийн ахлах багш, докторант*

*Б.Гантуурэв*

*Төр, захиргааны эрх зүйн тэжэлтийн ахлах багш, докторант*

## **АГУУЛГА**

1. Хууль хэрэглэх ойлголт, үйл ажиллагааны онцлог /хууль зүйн позитивизмд дүн шинжилгээ хийх нь /
2. Хууль хэрэглэх аргачлалд хуулийн тайлбарын үзүүлэх нолоо
3. Дүгнэлт
4. Хавсралт

## **Оришийн оронд**

Хуулийн хэм хэмжээ судлан үзэх явц болон практик дээр хуулийг хэрэглэх нэг мөр ойлгоход бэрхшээлтэй, хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгоход эргээвээтэй, тодорхой бус нэг асуудлыг хуулийн хэд хэдэн зүйл заалгаар оруулсан хэм хэмжжээчилсэн, тайлбарласан зүйлс байна.

Тиймээс тухайн эрх зүйн хэм хэмээг хэрхэн тайлбарлах, хэрэглэх тал дээр арга зүйн хувьд судалгаа явуулж, гарах арга замыг тодорхойлох шаардлага байгаа гэдэг нь харагдаж байна.

Судлаачийн зүгээс энхүү сэдвийн хүрээнд хууль хэрэглэх ойлголт, үйл ажиллагааны онцлог хийгээд хууль хэрэглэх аргачлалд хуулийн тайлбарын үзүүлэх нолоог тодорхойлох, хууль зүйн позитивизмын хоцрогдолыг даван туулах арга замыг эрэлхийлэхийг зорьсон болно.

Судалгааны ажлыг шинжлэх ухааны судалгааны макро харьцуулалтын / macro comparison / аргыг сронхийлон ашигласан болно.

### 1. Хууль хэрэглэх ойлголт, Үйл ажиллагааны онцлог

/хууль зүйн позитивизмын үүдлийс дун шинжилгээ хийх нь /

Харьцангуй хийсвэр системээс<sup>1</sup> тодорхой шийдвэр гаргадаг системрүү шилжих асуудал эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах тухай мөн эрх зүйн хийдлийг даван туулах тухай асуудалтай холбогддог. Тийм учраас эрх зүйг хэрэглэх үйл ажиллагаа эрх зүйг тайлбарлах, эрх зүйн хийдлийг даван туулах зэрэг асуудлыг онолын үүдлийс холбон авч үзэх шаардлагатай болдог.

Эрх зүйг хэрэглэх уламжлалт сургаалмын онолын үндэслэл, хууль зүйн позитивизм асуудлыг авч үзэх нь:

19 зууны эхэн үеээс эхэн эрх зүйд хандах хандлага социологийн, түүхэн, жам ёсны эрх зүйн зэрэг чиг хандлагатай болж эхэлсэн бөгөөд энэхүү байдал нь эрх зүйн бүтэц, хууль хэрэглэх механизмыг илүү их нарийвчлан авч үзэхэд шууд хүргэсэн. Эрх зүйн тодорхой бус байдал нь тухайн үеийн нийгэм здийн застийн нохцол байдалтай тохиорохгүй байсан учраас нийгэмд гарсан тодорхой маргаантай асуудлыг шийдэх арга замуудыг илүү их логик дэс дараалалтай болгох, түүний тусламжтайгаар зан үйлийн горимуудыг нарийвчлан тодорхойлсон, аксиомуудыг гаргаж иржээд хүрсэн байна. Эрх зүйн ойлголт хэм хэмжээг тодорхой системд хэлбэржүүлэн авч үзэх боломжийг хулээн зөвшөөрөх явдал 1804 оны Францийн Иргэний кодиксоор дамжин илрсэн. Уг кодикс нь хэл найруулга, нэр томъёо бүтцийн хувьд харьцангуй ондөр түвшинд хийгдсэн байна. XVIII зууны сүүлийн XIX зууны эхээр бий болсон кодиксууд нь

<sup>1</sup> Эрх зүйг хэрэглэх болох хэрэгжүүлэх рүз ажиллагааны түүхий сургалт нь социалист системийн уснуудад хот их хийсгэр, алжин шийнгээд хуршилжээс баатай язже ирсэн байна.

нийгийн амьдралд үссэн нохцол байдлуудыг бүхийл боломжит хүрээнд зохицуулж байжээ.<sup>2</sup>

Дээрх үзэл санаа, үнэт зүйлийн тархалт нь эрх зүйд хууль зүйн позитивизмыг улам бүр баталгаажуулах үндсэн шалтгаан нь болсон байна. Тухайн үеийн үзэл баримтлалаар бол төгс хууль гэдэгт кодикс<sup>3</sup>-ийг тооцдог байжээ. Энэхүү үзэл хандлагын логик үр дагавар кодификаци бөгөөд шүүх кодификацийг хэрэглэх явдал нь кодикст сорөг тайлбар хийх хандлага ажиглагдаж байсан.

Позитивизмыг авч үзэхийн өмнө эрх зүйд хацаах хандлагыг авч үзэх шаардлагатай байдаг. Тухайлбал: ёс суртахуун хэмээх ойлголтын дор нэгдэж байгаа нийгмийн олон хүчин зүйлс эрх зүйн агуулгад нилээдгүй нелөө үзүүлдэг байна.

Эрх зүйн шинжлэй зан үйлийн горим журмыг авч үзэх өөр өөр үзэл хандлагын гол шалгуур нь судлаачдын үзсэнээр дараах хэд хэдэн зүйлд төвлөрон илэрдэг.

1. Эрх зүйн хэм хэмжээг түүний хууль зүйн хүчин чадалтай адилтган авч үзэх хандлага. Энэ хандлага нь: хууль зүйн хүчин чадал нь торийн засаглалын дээд байгууллагын хүснэгтийн үр дагавараар тодорхойлогдоно гэж үздэг. /Дж.Остин/
2. Хүлээн зөвшөөрөгдсөн зан үйлийн горим журам. /Г.Л.А.Харт/
3. Торийн байгууллагын эрх хэмжээний дагуу батлагдсан үндсэн хэм хэмжээн дээр тулгуурлан гарсан зан үйлийн горим журам<sup>4</sup> /Х.Кельзен/ хэмээн тайлбарлан авч үзсэн байдаг.

Эрх зүйг ойлгох ойнголтой эрх зүйн эх сурвалжийн ойлголтыг давхар авч үзэж болдог. Эрх зүйн эх сурвалж хэмээх ойлголтыг нийгмийн харилцааг зохицуулагч хүчин зүйлс тэдгээрт хууль зүйн ач холбогдол бий болгох процессийн холбон тайлбарлах хандлага байдаг байна. Энэхүү хандлагыг Й.Эссер дараах байдлаар тайлбарласан байдаг.

<sup>2</sup> Kantorowicz H. Op. cit. S. 30

<sup>3</sup> Кодикс гэдэг нь торийн буюу ойролцоо шинжлэй нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүдийг нэгтгэн системчилсэн лууучилсан акт юм.

<sup>4</sup> Kelsen H. Das Naturrecht in der politischen Theorie . Ed. F. M. Salzburg. 1963, s.148

Эрх зүйн эх сурвалжийг булгийн усны эхтэй адилтган үзсэн байна. Чулуу бол булгийн усны эх сурвалж биш, ус чулууни дороос урсан гардаг. Яг энэ үесээ хэлээд усыг хүн ашиглах боломжтой. Эндээс эх сурвалж гэдэг ойлголтыг эрх зүйн хэлбэрт хүчин чадал олгож байгаа нийгмийн харилцааг зохицуулагч эрх зүйн арга хэрэгсэл механизм гэж үзсэн байна.

Хууль зүйн позитивизмын гол зорилго балогик нь эрх зүйн хэм хэмжээг тодорхой хэлбэрийн шаардлагад нийцүүлэх явдал юм. Үүнтэй холбоотойгоор эрх зүйг нийгмийн нэг үзэгдэл болгон, нийгмийн бусад үзэгдээс зааглах эрх зүйд ямар нэг илөвөлөх байдлаар авч үзсэн байдаг. Энэ утгаараа хууль зүйн позитивизм нь эрх зүй, эрх зүйг бүтээх, эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааг зааглах гол үндэс суурь болсон юм.

#### **Хууль зүйн позитивизмд гарсан хүндрэлтэй асуудлууд**

Хууль зүйн позитивизмын хүрээнд гарч ирсэн хүндрэлтэй асуудлууд нь дараах хэд хэдэн хүчин зүйлтэй холбогдуулж тайлбарладаг байна.<sup>5</sup>

1. *Нийтлэг хэм хэмжээний хийсвэр шинж ба шүүхээр хянан шийдвэрлэгдээж байгаа тохиолдол хоорондын харилцаан хамааралгүй байдлаас бий болсон хууль тогтоомжийн агуулгын тодорхой бус байдал нь хууль хэрэглэхэд хүндрэл учруулдаг.*

Энэ нь эрх зүйн хийдлийг бий болгодог ба үүнийг арилгахын тулд шуугч хуулийг төсөөтэй хэрэглэх, эрх зүйн зарчим, шударга ёсыг удирдлага болгох, харилцаанд оролцогчдын ухаалаг оновичтой шийдлийг тус тус харгалзан үзэж болно.

2. *Хуулийн олон салаа утгатай байдал нь хууль хэрэглэхэд хүндрэл учруулдаг.*

Энэ нь хуулийн агуулгыг тодорхой бус болож хүн бур хуулийг оорийн мэдлэг боломжийн хүрээнд ойлгох, бичих хандлагыг бий болгодог. Хууль тогтоогч оновичтой бус томъёолол хэрэглэсэн,

<sup>5</sup> Правоприменение: Теория и практика. Отв. Ред. Ю.А. Гакомиров. М., 2009. С. 39

хуулийн үйлчээ оновчтой бус хүрээнд үйлчилсэн дутагдалтай байдалд оруулсан байдал.

3. Эрх зүйн хэт их системчлэл нь хууль тогтоогчид тодорхой нэг хязгаарлалт тогтоож огоход хүрээдэг. Хэрэв хууль тогтоогч системт чанарыг ул харгалзан үзсн бол хуулийг хэрэглэгч субъект хууль тогтоомжийг алдаатай хэрэглэгчээд шууд хүрээдэг.

4. Хууль тогтоох ба хууль хэрэглэх уйл ажиллагаанд нолоолдог оор нэг хүчин зүйл бол эрх зүйн тогтолцоо хэт хаалттай байдал явдал юм. Оөрөөр хэлбэл, эрх зүйн тогтолцоог хэт явцуу байдлаар авч үздэг. Эн нь хууль тогтоогч болон эсвэл хууль хэрэглэгч субъектын гаргаж байгаа шийдвэрт шууд нолоо үзүүлдэг. Эрх зүйн тогтолцоог нээлттэй авч үзэх нь эрх зүйн гарал үүслийг судлах, түүнийг зөв тодорхойлоход нийтээдгүй ач холбогдол үзүүлээ гэсэн уг юм. Гэхдээ анхаарах гол зүйл нь рецепци хийх явдал юм. Үүний тод жинээ бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн үзүйл болох мэтийн зарчмыд дүгнэлт хийж болно.

Эрх зүйн хэм хэмжээний актын агуулга ба эрх зүйн тодорхой шийдвэрийн агууллыг тодорхойлж байгаа нийгмийн хүчин зүйлийн дотроос хамгийн их нелөө үзүүлж байгаа хүчин зүйлийг олж тодорхойлоход Х.Кельзений эрх зүйн цэвэр онол чухал ач холбогдолтой.

Х.Кельзен эрх зүйн шинжлэх ухааны судлах зүйлийг албадлагын журмаар хэрэгжүүлж байгаа хэм хэмжээний нийлбэр болох эрх зүйг судлах явдлаар хязгаарлаж болно. Үүнтэй холбоотойгоор торийн эрх бүхий байгуулагын эрх хэмжээ нь үндсэн хэм хэмжээг бий болгох гол үндэс богоод эрх зүйг нийгмийн харищааны бусад зохицуулж байгаа арга хэрэгслээс ялгах шалгуур нь болно гэж үздэг.

*Эрх зүйн цэвэр онол нь хууль зүйн позитивизмийн логик хөгжлийн дэс дарааллыг шуу их хөгжүүлээн богоод эрх зүйг*

*хэрэглэх үйл ажиллагааг судлах явдал нь хууль зүйн уламжлал  
позитивизмын хурээнд судлах боломжгүй гэж үздэг.<sup>6</sup>*

Хууль хэрэглэх судалгаа нь: эмпирек түвшинд байх ёстой ба  
мен онолын бусад ойлголтыг ажиглах ёстой. С.С.Алексеев "эрх  
зүйг хэрэглэх гэдэг нэр томъёо оороо хэм хэмжээ тогтоосон хууль  
тогтоомжийн тогтолцоон дээр үндэслэн гэсн үг юм"<sup>7</sup> хэмжээн  
тайлбарласан байдаг.

Харин орнодийн судлаачид болох Г.Канторович, Р.Эрлих,  
Д.Фрэнк, О.Холмс нарын үзснээр эрх зүйн тодорхой шийдвэрлийг  
гаргахад нийгмийн хүчин зүйл оргон хүрээнд нөлоолдог гэж үздэг.  
Тиймээс тэдгээр хүчин зүйлийг эрх зүйн бүрэлдэхүүнд орно гэж  
үзсэн байна.<sup>8</sup> Тодорхой маргааныг шийдвэрлэхэд эрх зүй ба эрх  
зүйг хэрэглэх гэсн хоёр ойлголтыг зааглах гол үндэслэл бол:  
маргааныг шийдвэрлэн шийдвэр гаргах үед эрх зүйг бүтээдэг. Эрх  
зүйг хэрэглэх үйл ажиллагаа нь эрх зүйг бүтээх үйл ажиллагаатай  
зэрэг явагдана гэж үздэг байна.

Орчин үсийн позитивист хандлага эрх зүйг төроос бүтээдэг: эрх  
зүй өөрөө хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээчлэгдсэн гэсн  
хандлагад төвлөрч байгаа ба нэг талаас эрх зүйн агууллыг  
харгалзан үзэхгүй байгаа эрх зүйн тогтолцоог иээлттэй гэдгийг  
хүлээн зөвшөөрөх хандлага ажиглагдах байгаа, эрх зүйг нийгмийн  
үзэгдэл гэж үзэж байгаа, эрх зүй ба эрх зүйг хэрэглэх гэсн  
ойлголтонд нийгмийн хүчин зүйлүүд нөлөөлж байгаа тиймээс эрх  
зүйн чиг үүрэг үр нөлөөний асуудлыг илүү их харгалзан үзэх ёстой  
гэж үздэг. Ногое талаас дээрх хандлага нь эрх зүй төрийн хүснэгт  
зориг гэсн хандлагатай зөрчилддэг, хэм хэмжээний агуулга ба  
хууль зүйн хүчин чадал гэсн ойлголт хоорондоо ялгаатай гэсн  
хэд хэдэн дүгнэлттэй зөрчилдөхөд хүргэдэг байна.

<sup>6</sup> Kelsen.H. *Das Naturrecht in der politischen Theorie*. Ed. F. M. Salzburg. 1963. S-148

<sup>7</sup> Алексеев. С.С. Указ. Соч. Т.1.С-330

<sup>8</sup> Llewellyn.K. *The Bramble Bush*.1930.S-3

Эрх зүйн талаар орчин үсийн позитивист хандлагын онолын ойлголтын хамгийн гол цом бол эрх зүйг нийгмийн бусад үзэгдлийн зааглах явдал юм. Гэхдээ эрх зүй ба эрх зүйг хэрэглэхэд иполоолж байгаа хүчин зүйлийг эрх зүй гэсэн ойлголтын хүрээнд /эрх зүйн бүтэц бүрэлдэхүүнд/ хамааруулах ёстой гэх үзэл хандлага юм.

Дээрх онолын үзэл баримтлалын үзэл санаанаас үндслэн эрх зүйг хэрэглэх гэсэн асуудлыг нарийвчлан судлан авч үзэх боломж нээгдэж байгаа юм. Үүндээр үндэслэн хууль хэрэглэх ойлголтыг дараах байдлаар судлан авч үзлээ.

**Хууль хэрэглэх гэдэг нь:** хуулиар эрх олгосон эрх зүйн хэм хэмжээний заалт, зарчмыг удирдлага болгон хууль зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн шийдэл гаргахад чиглэгдсэн ажиллагаа юм.

Харин хууль хэрэглэх практик гэдгийг эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах буюу тэдгээрийн хийдэл ба тодорхой бус байдлыг арилгах талаар бүрэлдэн тогтосон шүүх буюу бусад хууль хэрэглэгчийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль зүйн учир холбогдол бүхий зан үйл<sup>9</sup> гэж тодорхойлсон хандлагатай санал нэгдэж байна.

Хууль хэрэглэх ажиллагааны явцад эрх зүйн хэм хэмжээний агуулга, зорилго улам бүр тодорхой болдог. Хууль хэрэглэх үйл явц нь хуулийг хэрэгжүүлэх төрийн эрх мэдлийн изг арга бөгөөд энэ нь төрийн эрх бүхий байгууллага албан тушаалтны үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг онцлогтой.<sup>10</sup>

Дээрх ойлголтоос хуулийг хэрэглэх үйл явц нь субъектын хувьд хязгаарлагдмал шинжлэй гэдэг нь харагдаж байна.

Эрх зүйт ёс, төрийн эрх мэдэл хуваарилах зарчимтай холбоотойгоор зарим судлаачид хууль тогтоох эрх мэдлээс хуулийг зөвхөн тогтооно, гүйцэтгэх эрх мэдлээс хуулийг зөвхөн

<sup>9</sup> С.Нарангэрээ. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2008., 534 дахь таз

<sup>10</sup> Монгол улсын дээд шүүх Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, олон практикийн түзгүйлдэсан асуудал. УБ. 2008., 223-дэхь таз

биелүүлийн, шүүх эрх мэдлээс хуулийг зөвхөн хэрэглэнэ гэсэн байдлаар тайлбарлажээ.<sup>11</sup> Мөн шүүхийн тухай хуульд шүүхээс тусгайлан хууль хэрэглэхтэй холбоотой заалтыг нарийвчлан оруулсан байдал.<sup>12</sup> Үүнээс бяцхан дүгнэлт хийвэл хуулийг зөвхөн шүүх хэрэглэдэг гэж дүгнэж болохоор байна.

Гэсэн хэдий боловч хууль хэрэглэх хэлбэр нь нэг талаас зохион байгуулах ногоо талаас засаглах шинжтэй байдал.

Хуулийг хэрэглэх зохион байгуулах хэлбэр нь: тодорхой албан тушаалтан нэг бүрчилсэн зохицуулалтын актын тусламжтайгаар тодорхой асуудлыг шийдвэрлэж байгаа удирдах зохион байгуулах ажиллагаа юм. Үүнд тодорхой эрх зүйн хариулсааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох, тодорхой үйл ажиллагааг удирдах, нэг бүрчилсэн зохион байгуулах шинжтэй хариулцаа багтдаг.

Хуулийг хэрэглэх ажиллагааны засаглах хэлбэр нь эрх зүйн зорчлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрх сэргээх мөн төрийн албадлагын бүх төрлийн арга хэмжээг авах, хариуцлага хүлээнгэх асуудлыг зохицуулах, хамгаалах шинжтэй засаглан захирамжлах ажиллагаа юм. Шүүх бол хууль хэрэглэх засаглах хэлбэрийн субъект ба харин зохион байгуулах хэлбэрийн субъектэд тодорхой нэг бүрчилсэн акт гаргаж буй албан тушаалтан<sup>13</sup> байх боломжтой юм.

<sup>11</sup> Мон тэнд

<sup>12</sup> Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Эрх зүйн наядсан мэдээлэлийн системийн язгуулалт –ээс иштээв.

12.1.Шүүх хэрэг, маргааны хянан шийдвэрлэгээд Үндэснэхэд зүйл шийцүүзэн гаргасан бусад хүчиний хэрэглээнгээ.

12.2.Шүүх Үндэснэхэд шийцэхүй, хэрэг, маргаан гарах үед хүчин төгөлдөр болоогүй, албан ёсвор тийтгээхээгүй хүчиний хэрэглэхгүй.

12.3.Тодорхой хэрэг, маргааны хянан шийдвэрлэгээд хэрээхүү хүчин нь Үндэснэхэд шийцэхүй байна гэж үзжэл шүүх тухайн хэрэг, маргааны хянан шийдвэрлэх ажиллагааны түүдээгүүжэж, самаалаа Улсын Дээд Шүүхээд оруулна.

<sup>13</sup> Затиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухайн хууль. УБ. 2002., 3 дугаар түйл, 3.1-дэх залгат, 3.1.2. "затиргааны албан тушаалтат" гэж эс хүчиний 3.1.1-д залгасан байгуулалтын тийтийн эрх түйн хэрээмжийн зорилтуудыг бүрдэх.

Зарим судлаачид "хуулийг зөвхөн шүүх хэрэглэдэгтүй, төрийн бусад байгууллага, албан тушаалтан, иргэн бусад этгээд шийдвэр шийдэл гаргахдаа хэрэглэдэг" гэж тайлбарласан байдал.<sup>14</sup>

Шүүхийн тухай хуулийн 23 зүйлийн 23.2 дахь зүйлд иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Монгол Улсын Дээд Шүүхэд ирүүлийн гэмж.

Үүнээс үзэхэд хууль хэрэглэх субъектэд иргэн ч адил хамаарах байдлаар тайлбарлаж заасан байна. Хууль хэрэглэх зохион байгуулах, засаглах хэлбэрийн аль нэг чиг үүргийг хэдийгээр хувь хүн хэрэгжүүлдэг боловч тухайн этгээд зөвхөн нэг бүрчилсэн актын үндсэн дээр шийдвэр гаргах албан тушаалтан байх ёстой гэдэгт тал өгч хандах ёстой юм.

## 2. Хууль хэрэглэх аргачланда хуулийн тайлбарын үзүүлэх нюанс

Хууль тайлбарлах үйл ажиллагаа эрх зүйг хэрэгжүүлэх процессын зайлшгүй, чухал элемент юм. Ямар нэг эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхийн омно уг хэм хэмжээний утга агуулыг сайн ухаж ойлгох, зарим тохиоддолд уг хэм хэмжээг тайлбарлах шаардлага гардаг. Хууль тайлбарлах үйл ажиллагаа бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, таниулахад чиглэгдсэн оор оор субъектээс хэрэгжүүлдэг олон талт, нарийн үйл ажиллагаа юм.<sup>15</sup>

VI зууны үед ээзи хаан Юстиниан оорийн Дегистийг тэгс боловсорсон хэмээн үзэж тайлбарлахыг хатуу хориглосон байна. Хоронгот ёсны хөгжлийн эхний үед зарим сэтгэгчид /Ш.Л.

Эрхийг бие даан хэрэгжүүлэхэдээ торийн жинхэнэ албан хаагч, түүчинчлэгийн тийштэй эрх зүйн холбоогийн асуудлаар бусдыг татварамжинэсэн шийдвэр гаргасдаа торийн бус албан тушаалтынг ойлгого. Харшиг хувийн эрх зүйн хурээнд ашигийн толоо болон ашигийн толоо бус үйл ажиллагаа явуулдаг хүүхийн энгээдийн шийдвэр гаргах албан тушаалтанд ойлгож болто.

<sup>14</sup> Монгол Улсын Дээд Шүүх. "Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, оюут практикийн түзэгжинэсэн асуудал". УБ., 2008. 224-дэх тал

<sup>15</sup> В.И. Храпанюк. Теория государства и права. М. 1997.. С. 29

Монгескье. Ч.Беккари зэрэг эрдэмтэд /хамжлагатнуудын шүүхээс хуулийг тайлбарлахыг эсэргүүцэж хуулийн үзэл санаа үг үсгийг нарийн чанд мөрдохийг шаардаж байв. Хөрөнгөтнүүд засгийн эрхэнд гарсны дараагаар шүүхээс хуулийн үзэл санааг тайлбарлах эрхийг олгосон юм.<sup>16</sup>

Энэ үзэл санаа нь анх Наполеоны Кодекст зөвхөн хуулийн хүрээнд тайлбарлах агуулгаар илрч байжээ.

Нийгмийн харилцаа аажимдаа нарийн төвөгтэй болохын хэрээр хуулийг тайлбарлах үзэл санаа улам дэлгэрч хуулийг тайлбарлах нь эрх зүйн хийдлийг даван туулах томоохон арга хэмсэн үзэх болов.

Харин Социалист эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад хууль тайлбарлах ажиллагаа нь ямагт хувьсгалч, ангич, намчирхсан үзэл сурталт автагдаж хүний эрх, эрх чөлөөг хясан боогдуулж байсан юм.

“Тайлбарлах” (interpretatio-зуучлах гэсэн латин гаралтай үг.) гэсэн нэр томъёо нь олон утга илэрхийлийн. Хүмүүнлэгийн шинжлэх ухаанд хүн төрөлхтоний соёлын объектуудыг (урлагийн бүтээлүүдийг тайлбарлах зэрэг) танин мэдэхүйн арга буюу яиз бүрийн хэл зүйн бичвэрүүдийг (бичгийн эх сурвалжуудыг) ойлгох гэсэн агуулгатай.<sup>17</sup> Эрх зүйн шинжлэх ухаанд тайлбарлах гэсэн нэр томъёо нь эрх зүйн хэм хэмжээг илэрхийлсэн бичвэрүүдийг ойлгох утгаар хэрэглэгдэнэ.

Хуулийг тайлбарлах үйл ажиллагааны талаар харилцаан адилгүй оөр санал байдаг.<sup>18</sup> Тухайлбал, зарим судлаачид “хуулийг тайлбарлах үйл ажиллагааг зөвхөн эрх зүйн агуулгыг нь ухаж ойлгох үйл ажиллагаа” гэж үздэг бол бусад судлаачид “хуулийг тайлбарлах үйл ажиллагаа бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж таниулах үйл ажиллагаа” хэмээн тодорхойлдог байхад гуравдах

<sup>16</sup> В.В.Лазарев. *Общая теория государства и права. Т.2. М., 1998. С-324*

<sup>17</sup> Ч.Ингисүрэн. Эрх зүй төрийн сронхий онол. УБ, 2004., 209-дэх таз

<sup>18</sup> В.Н.Храпанюк. *Теория государства и права. М.,1997. С- 30*

хэсэг нь “эрх зүйг тайлбарлах ажиллагаа нь дээрх хоёр үйл ажиллагааны нэгдлээс бүрдэнэ” гэж үздэг байна. Үүнээ үзвэл:

Хуулийг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжэний утга санаа, агуулга, иэр томъёог тодруулах, иээн харуулах үйл ажиллагаа юм.<sup>19</sup>

Онөө үсийн хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах талаар хоёр гол үзэл санаа ноёрхж байгаа юм.

Нэг талаас Оросын эрдэмтэд...” эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах ажиллагааг нь эрх зүйн хэм хэмжээ хэрэглэх үйл явцтай хамт хэрэгждэг учраас ямар ч хуулийг тайлбарлаж болно<sup>20</sup> гэж үзэж байгаа бол, ногоо талаас барууны зарим эрдэмтэд: тайлбарыг зөвхөн тодорхой тохиолдолц буюу хууль бүрхэг байх, зорчилтэй байх үед хийн гэж үзэж байгаа юм.

Эдгээр үзэл санаа нь эрх зүйг бүтээх, танин мэдүүлэх, хэрэгжүүлэх үе шатанд байвал зохих үзэгдэл, эсвэл эрх зүйн хийдлийг шийдвэрлэх арга хэрэгсэя гэж үзэхтэй холбоотой юм.

*A. Оросын Холбооны Улсын эрдэмтэд эрх зүйг тайлбарлах арга, төрлийг дараах байдлаар авч үзсэн байдал.*<sup>21</sup> Эрх зүйг тайлбарлах аргад:

- Хэл зүйн арга
- Логикийн арга
- Системчлэн тайлбарлах арга

<sup>19</sup> Судлаачид эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах гэхэг сониний ойлголтынг олон ялангаар тодорхойлсан байдал. Үүний дараах бүтээлүүдээс дэлгэрүүлж үзүүлж болно. В.Н. Храпанюк. Теория государства и права. М., 1997. С- 30. В.В.Лазарев. Общая теория государства и права. Т.2. М., 1998. С-440. Н.И.Матузов, А.В. Мазыко. Теория государства и права курс лекций. М., С- 417. А. Алексеев. “Источники права”, М.,1998 . Ч.Нямсүрэн. Эрх зүй төрлийн сониний омол. УБ. 2004., 209-дэх тал, Монгол Улсын Дээд Шүүх. “Шүүхээс хүзүү тайлбарлах хэрэгжээс омол практикийн түүхэдсан асуудал”. УБ., 2008. 22-23-дэх тал эзрээс тодорхойлазонуудыг үзэж болно.

<sup>20</sup> В.В.Лазарев. Общая теория государства и права. Т.2. М., 1998., С- 324

<sup>21</sup> Дээрх ангилалтын ланчай орны эрх зүйн омол судланчдын бүтээлүүдээс шийтгэх байдлаар ширж болно.

- Түүхчлэх арга зэргийг хамааруулдаг

Харин эрх зүйн хэм хэмжээний тайлбар, түүний төрлийг дараах байдлаар авч үзсэн байдаг.<sup>22</sup>

Эрх зүйн хэм хэмжээний тайлбарыг тайлбарлаж байгаа субъект, хууль зүйн үр дагавраас нь хамааруулан:

- Албан ёсны тайлбар
- Албан бус тайлбар гэж хоёр ангилдаг.

Албан ёсны тайлбарыг *норматив, казуаль тайлбар* гэсн хоёр терелд хуваадаг.<sup>23</sup>

*Норматив тайлбар нь:* шинэ эрх зүйн хэм хэмжэог бий болгодогтүй, зөвхөн батлагдан гарсан хэм хэмжээний агууллыг хүрээнд тайлбарладаг ба эрх зүйн хэм хэмжээ нь хүчингүй болох эсвэл өөрчлөгдох зэрэг тохиолдолд мөн адил хүчингүй болох эсвэл өөрчлөгддог.

Норматив тайлбарыг *аутент буюу эх тайлбар, легаль буюу зөвшиорогдсон тайлбар* гэж хоёр ангилдаг.<sup>24</sup>

*Казуаль тайлбар нь:* заавал биелгдэх шинжгүй ч албан ёсны тайлбар болдог. Уг тайлбарыг тухайн эрх зүйн хэм хэмжэог тодорхой тохиолдолд хэрэглэгдэж, тухайн байдлыг нь харгалзан хэрэгжүүлдэг тайлбар юм. Норматив тайлбар нь эрх зүйн тухайн хэм хэмжээтэй салшгүй холбоотой байдаг ба түүнээс салангид

<sup>22</sup> Эрх зүйн хэм хэмжээний тайлбар түүний төрөл нь: эрх зүйн хэм хэмжээг тайзбарлагчас мухайн хэм хэмжээний агуулга уяла санвааг төвөрхий арга хэрэгслийн тусгамжтайгаар ижн гардуулсан үйл ажиллагааны үр дүг юм. Н.И.Матузов, А.В. Мазько, Теория государства и права курс лекций. М., С- 417

<sup>23</sup> Н.И.Матузов, А.В. Мазько, Теория государства и права курс лекций. М., С- 419

<sup>24</sup> Аутент тайлбар бол эрх зүйн хэм хэмжээтэй агуулыг тухайн эрх зүйн хэм хэмжээг башлан гаргасан байгууллагас тайлбарлаж буй тайлбар юм. Тухайлбал дүүрэг тохиох байгууллагас хэрэгжүүлж буй тайлбар. Тухайлбат: Узсмы Их Хурал Эрүүгийн хуулийн башлагдахаас уг хуулийн тусгай ангийн 79, 82, 89, 108, 113, 177, 185, 231, 215, 263, 265, 270, 301-дүгээр зүйлүүдэд тайлбар хийсэн байна.

Легаль /зөвшиорогдсон/ тайлбар бол эрх зүйг тайлбарлах эрх олгогдсон, зөвшиорогдсон байгууллагас хэрэгжүүлж буй тайлбар юм. Тухайлбат дээр шүрх хууль тохиох байгууллагас башлан гаргасан хэм хэмжээтэй актыг башлан гарах эрхийн.

хэрэглэх боломжгүй байдаг бол казуаль тайлбар нь тухайн тохиолдод буюу хэрэг маргаантай салшгүй холбоотой бөгөөд нийтээр дагаж мөрдөх шинжийг агуулдаггүй. Тухайлбал: давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоол, магадлалд тухайн хэрэглэгдэж байгаа хэм хэмжээний агуулгыг тайлбарласан байдаг. Казуаль тайлбарын зорилго бол тодорхой тохиолдлыг зөв хянан шийдвэрлэхэд тус дөхөм узүүлэх явдал юм.

#### **Б. АНУ-ын хуульчдын судалгаанаас утсхэд:**

Тэд хууль зүйн тайлбарын хамрах хүрээ, шинжийн талаарх судалгаанд анхаарахаасаа илүү тухайн тайлбарыг хийх арга зүйн ямар чиглэлийг баримтлах талаар анхаарч байна. Энэ утгаар нь зарим эрдэмтэд<sup>25</sup> хуулийн тайлбарыг хуулийн зорилтын тайлбар ба уг зүйн тайлбар гэж хоёр хуваажээ<sup>26</sup>.

Мөн тэд энэ хоёр ангиллын дагуу intentionalist<sup>27</sup> буюу хууль тогтоогчийн сонирхлыг дэлгэрүүлэх нь хуулийн тайлбарын гол зорилго гэж үзэгчид ба textualist<sup>28</sup> буюу хуулийн тайлбарын хамгийн гол зорилго нь уг зүйн тайлбар хийх явдал бөгөөд уг зүйн тайлбар хийснөр хууль тогтоогчийн зорилтыг тодорхойлж болно гэж үзэгчид гэсэн хоёр төрлийн үзлийг баримтлагчдад хуваагдсан

<sup>25</sup> Walter Sinnott-Armstrong, *Word Meaning in Legal Interpretation*, *San Diego Law Review*, May-June 2005, Vol 42, number two, P 465.

<sup>26</sup> Зарчмын нам золцоход (*Түзэлбэл N.S. Bindra, The interpretation of statutes and General Clauses Acts (Central and States) with WORDS AND PHRASES Fourth Edition, 1965. P.7*) grammatical буюу хэд зүйн ба logical буюу логикийн гэж хууль зүйн тайлбарыг ангилсан байдал болон нь энэхүү ангилалтай агуулжмын хувьд нээж.

<sup>27</sup> Larry Alexander Sai Prakash, Stanley Fish, Steven Knapp, Walter Benn Michaels эзэрхэг эрдэмтэд энэ хэсэгт багтана. *San Diego Law Review What is Legal Interpretation Vol 42. Pp461-462* Тэдний бичснийг мөн энэ тохиолдоос ушинж болно.

<sup>28</sup> Walter Sinnott-Armstrong, Jeffery Goldsworthy, эзэрхэг эрдэмтэд энэ хэсэгт багтана. *San Diego Law Review What is Legal Interpretation? Vol 42. Pp461-462* Тэдний бичснийг мөн энэ тохиолдоос ушинж болно.

байна. Гуравдахь хэсг нь аль алиныг нь хүлэн зөвшөөрсон Pluralist<sup>29</sup> буюу дундыг баримтлагчид эрдэмтдийн хэсг юм.

Хууль тогтоогчдын зорилгыг тодорхойлогчдын хувьд хууль тогтоогч тухайн хуулийг баталж байсан үедээ чухам ямар зорилго тавьсныг хууль тогтоогчийн хуралдаан дээр хэлсэн үг, ишлэсн баримтыг тэмдэглээс олж унших боломжтой тул тэр бүтгийг шинжилж байж, ямар утга санаа гарсаныг тогтоож болно. Ингэхдээ хууль тогтоогчийн саналыг асууж ч болно гэж үздэг бол үг зүйн тайлбар хийгчид хууль тогтоогч ямар санаатай байсныг асууж болох хэдий ч энэ нь улс төрийн нохцол байдал зэргээс шалтгаалж дэндуу эрсдэлтгэй. Тухайн үед хууль тогтоогч ямар үг хэрэглэсэн тэр утгаар нь я хуулийг тайлбарлах нь зөв. Ийм учраас хууль тогтоогч хууль батлахдаа зөв үг сонгож байх хэрэгтэй гэж үздэг.

Хуулинд байгаа тухайн үгээд хэдэн ч янзын утгатай байж болох учир уг үгийг чухам ямар утгаар нь хууль тогтоогч хэрэглэснийг тайлбарлах шаардлага гардаг байна.<sup>30</sup> Харин үг зүйн тайлбар хийгчид үг зүйн хувьд тайлбарлахад хүнд заалт гарвал тухайн хуулийн зорилт, бусад зүйлийг уншаад хууль тогтоогч уг заалтаар ямар утга илэрхийлэхийг зорьсоныг мэдэж болно гэж үздэг байна.

Үүнээс үзвээс “хуулийн тайлбарт тодорхой утга, агуулга илэрхийлэгүү сүл үгийг хэрэглэхгүй байх хэрэгтэй”. Эрх зүйн ямар ч торлийн баримт бичигт хоёрдмол утгатай нэр томьёог хэрэглэхээс зайлсхийх нь чухал. Эрх зүйн бичилтийг ач холбогдлын хувьд үндсэн, туслах гэж хуваан ангилж болохгүй юм. Тухайлбал, нийгмийн суурь харилцааг зохицуулдаг шинж чанараар нь Үндсэн хуулийг маш няхуур бичих ёстой, харин бусад хууль ба тэдгээрийн тайлбарыг анхаарал бага хандуулж бичиж болно гэсэн хандлага срөөс байж болохгүй. Үндсэн хууль, хууль,

<sup>29</sup> Sam Rickless, Kent Greenawalt, ээээээ эрдэмтээд энэ хэсэгт багтана. *San Diego Law Review. Review What is Legal Interpretation?* Vol 42. Pp461-462 Төдий бичснийг蒙古с зэс төхтимлоос ушииж байно

<sup>30</sup> Walter Simnot-Armstrong, *Word meaning in Legal Interpretation. San Diego Law Review. Review What is Legal Interpretation?* Vol 42. Pp 472.

хуулийн тайлбар бүгд нийгмийн харилцааг зохицуулж, иргэдний эрхийг хэрэгжүүлж зохицуулагч байдаг тул тэднийг нэгэн тувшинд няхуур бичилгээр бичих ёстой юм.

Хуулийг тайлбарласан тухайн тайлбарыг хууль хэрэглэхэд хэрэглэж байгаа учир тайлбар нь хуулийн нэгэн адил хүчин чадалтай болж, хуулийн салшгүй нэг хэсэг буюу тухайн тайлбаргүйгээр тухайн зохицуулалт бүрэн хүчин чадлаа хэрэгжүүлж чадахгүйд хүрдэг байна.

Тухайн улс нь нийтлэг эрх зүйн тогтолцоотой, хувийн эрх зүйн тогтолцоотойгоос шалтгаалан хуулийг тайлбарлах арга зүй түвшин оор оор хэлбэртэй байна.

Нийтлэг эрх зүйн тогтолцоот орнуудад бичмэл хуулиас гадна, шүүхийн жишиг тайлбарлах хэрэг гардаг. Учир нь шүүхийн жишиг нь нийгмийн харилцааг зохицуулах байдлаараа бичмэл хуулиас хэрэглээний түвшиний хувьд ижил, эсвэл бараг илүү байх тохиолдол байдаг.

Тиймээс шүүхийн шийдвэрийн тайлбар хэрэгтэй болно. Гэвч нийтлэг эрх зүйн бүл бүхий орнуудын шүүхийн шийдвэр нь дэлгэрэнгүй байдаг учраас тухайн шийдвэрийг гаргасан шүүгчийн итгэл үзүүмшилийг төвөгтүй ойлгох боломжтой. Нэн ялангуяа шүүхийн жишгийн ratio decidendi, obiter dictum-ийн бүтцийг баримтлан гаргасан шүүхийн шийдвэр нь бичмэл хууль, түүний тайлбар хоёрыг зэрэг нэг дор орлох боломжтой байдгаараа давуу талтай байдаг байна.

Хуулийн тайлбар, жишгийн тайлбар хоёр бие биенээ нохцөлдүүлж байж нийгмийн харилцааг бүхлээр нь зохистойгоор зохицуулж чаддаг.

Хуулийн тайлбарыг хийхдээ бүх хуулийн бүх хэсэг, зүйл заалтыг нэг адил аргаар тайлбарлах огт болохгүй. Тухайн хуулийн хамрах хүрээ, хүчин чадал, нийгмийн сэтгэл зүйд хэр нолоо үзүүлэх, онцлог, шинж чанар, хэсэг, зүйл заалтын хэлбэрээс хамааран түүнийг тайлбарлах арга (техник) оор оор байх ёстой юм. Салбар эрх зүй бүрээс шалтгаалан хуулийг тайлбарлах арга зүй оор байна гэснүүд болно. Тухайлбал: Эрүүгийн хуулийг төсөөтэй

хэрэглэдэгтүй гэдэг үндэслэлээс үүдэн тайлбарыг агуулга, цаг хугацааны хувьд нэг мөр хэрэглэх байдлаар тайлбарласан байна. Эрүүгийн хуулинд хууль тогтоогчийн зүгээс тайлбаруудыг /Аутент тайлбар/ хийсэн байдал. Энэхүү тайлбарыг дараах байдлаар торолжуулж авч үзж болно.

### 1. Хэл зүйн тайлбар<sup>31</sup>

Эрүүгийн хуулийн тусгай ангид дараах нэр томъёог тайлбарласан байдал. Үүнд: Молжих, жолооч, тээврийн хэрэгсэл, торийн албан хаагч, торийн албан тушаалтан, торийн бус байгууллага, аж ахуйн ижжийн албан тушаалтан гэсэн нэр томъёог тайлбарласан байна.

### 2. Системчилсэн тайлбар:<sup>32</sup>

Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой зүйл заалтыг сронхий ангийн ялаас чөлөөлөх үндэслэл журмын холбогдох заалттай уялдуулан тайлбар өгсон байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн дээрх тайлбарууд нь эрүүгийн хуулийг төсөөтэй үл хэрэглэх, мөн зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангид гэм буруутай үйцэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг хэмжээн заасан тохиолдолд Эрүүгийн хариушлага ногдуулах тул туйлын тодорхой байдлаар тайлбарласан байдал.

Гэтэл Иргэний хуулинд Эрүүгийн хуулттай ижил байдлаар тайлбарласан заалт байдалгүй ч тухайн хэм хэмжээний агуулга, үзэл санаанд дүгнэлт хийхэд хууль тогтоогчийн зүгээс тайлбар хийсэн явдал байна.<sup>33</sup>

Монгол Улсын Дээд Шүүх нь Үндэсн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах талаар Үндэсн хуулийн 50 дугаар зүйл 50.1.5- д заасан байдал.

<sup>31</sup> Дэлгэрэнгүйг хавсралт № 1-ээс үзүүлж.

<sup>32</sup> Дэлгэрэнгүйг хавсралт № 2-ээс үзүүлж.

<sup>33</sup> Монгол улсын иргэний дүүлэг, 251 дүгээр зүйл, 252 дүгээр зүйл. Эрийн зүйн мэдээллийн изгэсэн систем [legisinfo.mn](http://legisinfo.mn) -ээс иштамж.

Улсын Их Хурал хууль тайлбарлах тухай заалт Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулинд байдагтүй боловч "аутент" тайлбарыг Улсын Их Хурлын зүгээс хууль батлах үйл ажиллагаатай давхар хийсэн байгааг дээрх жишээ харуулж байна.

Магадгүй энэ тохиолдолд тухайн хуультай хамт батлагдсан тайлбарыг хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлах эрхийн дагуу Монгол Улсын Дээд Шүүхээс тайлбарыг тайлбарлаж болох эсэх нь эргэлзээтэй байна.

## ДҮГНЭЛТ

Эх газрын эрх зүйн тогтолцоо XII-XII зууны дунд үед бүрэлдэн тогтсон гэж судлаачид үзэг богоод түүний улбаа ХрТӨ VI-1 зууны үед бүрэлдэн ба эртний Ромын эрх зүйн үзэл санаа нөлөөлсөн. Өнөө үед Европын болон Латин-Америкийн ихэнх улсуудад энэ тогтолцоо үйлчилж байна. Энэхүү тогтолцооны гол онцлог нь эрх зүйн хэм хээжүүний акт эрх зүйн зохицуулалтын үндсэн эх сурвалж болон хэрэглэгдэг ба тэдгээрийг нилээд хийсвэр шинжтэйгээр бүтээдгээс үүдэн эрх бүхий субъектээс тайлбарлагдан, үйлчилжийн шир хүрээгээ тодорхойдог байна.

Манай орны эрх зүйн тогтолцоо нь агуулга, хууль зүйн техник, эрх зүйн эх сурвалж, арга зүй талаас нь авч үзвэл эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах ба энэ утгаараа нийгмийн бүхий л харилцааг хуулиар зохицуулалтанд оруулах шаардлага тавигдаж байдаг.

Тухайн хуулийг хэрхэн зөв хэрэглэх, тайлбарлах асуудал нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой юм.

Тиймээс судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна.

1. Монгол улсын хууль тогтоомжийн системчилгийг эрх зүйн философиийн үүднээс авч үзвэл позитив шинжтэй гэж судлаачид дүгнэсэн байдаг. Өдгөө хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн позитивизмд гарсан хүндэрлэгтэй асуудлыг онолын үүднээс зайлшгүй тайлбарлах шаардлага гарч байна.

Бид нэгдүгээр дэд хэсэгт хууль зүйн позитивизмд гарсан хүндрэлтэй асуудлуудыг дурьласан. Үүнийг оорийн орны хууль тогтоомжтой харьцуулсан дүгнэвэл:

А. Хуулийн олон салаа утгатай байдал нь хууль хэрэглэх үйл ажиллагаанд хүндрэл бий болгодог гэсэн хандлага нь Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйл 50.1 дэх хэсэгт “энэ хуульд заасан хугацаагаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт ийнгэмд ашигтай ажлыг цалин холс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэнэ” гэж заасан байтал шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлд 96.6 дугаар зүйлд заасан нь цалин холс олгох тухай заасан нь шүүхийн зүгээс аль хуулийг баримтлан шийдвэрлэхэд эргэлзээ торүүлж байдаг.

Мөн Захиргааны хариуцлагын тухай хуульд захиргааны зорчил гэж зүйлчилсэн заалтууд нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 37-р зүйл заалтуудтай хэл зүйн болон агуулгын хувьд шууд давхцаж байна. Хэдийгээр эрүүгийн хуулийн шинэчилсэн наиргуулыг хийж, зорчлийн тухай хуулийг батласан боловч хүчин төгөлдөр иййтээр дагаж мордеөгүй байна.

Тиймээс энэхүү давхацсан, олон салаа утгатай байдал нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээний үн цинийг бууруулах мон хууль хэрэглэхэд хүндрэл учруулдаг тул хуулинд ишмэлт өөрчилт оруулах хэрэгцээ шаардлага өндөр байна.

В. Хууль тогтоох, хууль хэрэглэх үйл ажиллагаанд иөлөөлох эрх зүйн тогтолцоог хэт хаалттай байдлаар үзэх явдал юм.

Хэдийгээр манай улсын хувьд тодорхой түвшинд эрх зүйн тогтолцоог изолтгэй авч үзэн хуульчилсан боловч хууль тогтоомжийн системчлэлийг хийгээд агуулга, үнэт зүйлсийн түвшинд хийдэлтгэй учраас хууль хэрэглэгч субъект тухайн хуулийг хэрэглэхэд хүндрэл учирч байна.

Тухайлбал: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд мэтгэлийх

зарчмыг хуульчилж огсөн боловч үнэтэй зүйлсийг нь үнэтэй чигэр нь рецепци хийгээгүй байдаг. Учир нь Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны мэтгээш зарчмын үнэтэй зүйлс нь мэтгээшгэч талуудын эдлэх эрх хууль зүйн хувьд ижил түвшинц байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд өөрийн гэм буруутай үйлдлийг үл хүлээн зөвшиорсон тохиолдолд мэтгээшгэч гэх мэт. Гэтэл манай улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулианд дээрх үнэт зүйлсийн агуулга үзэл санаа суугаагүй байдаг. Одоогийн эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх хуулийн төсөлд мөн адил үнэт зүйлийн хувьд тусгалаа олоогүй.

Тиймээс хууль тогтоогч өөрийн хууль тогтоох субъектив үйл ажиллагаанд ийгмийн амьдралын объектив хэрэгцэ шаардлагыг харгалzan үзэх ёстой байна. Оороор хэвлэл орчин үсний позитив онолын хамгийн гол цом болох эрх зүй, эрх зүйг хэрэглэхэд нолоолж байгаа хүчин зүйлсийг эрх зүй гэсэн ойлголтын хүрээнд хамааруулж авч үзэх явдал юм.

Мөн эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн харилсан хамаарлыг тогтоохдоо рецепцийг зөв хэрэглэх нь онолын болон практик ач холбогдолтой.

2. Эрүүгийн хуулинд тайлбар гаргахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгцэ шаардлагага ондор байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн өөрийнх нь үзэл санаа, агуулгыг өөрчлох буюу алдагдуулахгүй байх.
- Эрүүгийн хуулийн заалтыг хүндрүүлэн тайлбарлахгүй байх.
- Эрүүгийн хуулийг тесеетэй хэрэглэдэгтүй хууль ёсны зарчмыг баримтлан тайлбарлах.
- Эрүүгийн хуулийг тайлбарлахдаа уг хуулийн хэм хэмжээг өөр хооронд нь логик зорчилгүйгээр болит хуульчлагдсан байдлыг нь баримтлан тайлбарлах зэрэг болно.

Ийнхүү олон шаардлагага тавих нь Эрүүгийн хууль өөрео ийгмийн амин чухал харилцаануудыг гэмт хаддлагас хамгаалдаг, зорчигдсөн эрхийг сэргээж, гэм буруутай этгээдэд эрүүгийн

хариуцлага тооцдог, бүтэх, тайлбарлахад нарийн мэргэжлийн ур чадвар шаардагдах хууль юм.

3. Онолын ойлголт хийгээд хууль тогтоомжийн хоорондын зааг ялгааг багасгах нь хууль хэрэглэх үйл ажиллагаанд ач холбогдолтой юм.

Онолын ойлголтын хувьд хууль хэрэглэх хэлбэр нь нэг талаас зохион байгуулах ногоо талаас засаглах шинжтэй байдаг гэж бид нэгдүгээр бүлгээр авч үзсэн. Шүүх бол хууль хэрэглэх засаглах хэлбэрийн субъект ба харин зохион байгуулах хэлбэрийн субъектэд тодорхой нэг бүрчилсэн акт гаргаж буй албан тушаалтан байх боломжтой юм. Харин шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мордох, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салсаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Монгол Улсын Дээд Шүүхэд ирүүлнэ гэжээ. Үүнээс үзэхэд хууль хэрэглэх субъектэд иргэн ч адил хамаарах байдлаар тайлбарлаж заасан байдаг.

Хувийн эрх зүй тэр дундаа ямар салбар эрх зүй гэдгээс шалтгаалан хууль хэрэглэх субъектыг өөр өөр агуулгаар тайлбарлах шаардлага байгаа гэх Оросын холбооны улсын судлаачдын үзлийг дэмжигж байна. Тухайлбал: Хувийн эрх зүй тусгайлан Иргэний эрх зүй, Хөдөлмерийн эрх зүйд тодорхой иргэн хууль хэрэглэх тохиолдол байхад, шийтийн эрх зүй тусгайлан эрүүгийн эрх зүйд иргэн хууль хэрэглэх онолын үндэслэл байхгүй юм.

Онолын хувьд эрх зүйн хэм хэмжээний агуултыг тухайн эрх зүйн хэм хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарлаж буй тайлбарыг аутент тайлбар гэдэг. Гэхдээ манай орны хувьд тухайн үзэл баримтлал эрх зүйн тодорхой хэм хэмжээнд орсон тохиолдолд албан ёсны эрх зүйн эх сурвалжийд тооцогддог.

Монгол Улсын Дээд Шүүх нь Үндэсн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах талаар Үндэсн хуулийн 50 дугаар зүйл 50.1.5- д заасан болно. Гэтэл Улсын Их Хурал

хууль тайлбарлах тухай заалт Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуулийн байдагтүй боловч “аутент” тайлбарыг Улсын Их Хурлын зүгээс хууль батлах үйл ажиллагаатай давхар хийсэн байгааг бил өмнө дурьдсан.

Өрнөдийн судлаачид эрх зүйн хэм хэмжэг батласан субъект оороо тайлбарлах ажиллагааг угүйсгэх болсон ба учир нь тухайн тайлбарт улс торийн ашиг сонирхол, хүсэл зориг тодорхой нөлоолох магадлалтай хэмээн тайлбарласан байна.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлд гэм буруутгыйд тооцох гээд 13.1 дах хэсэгт шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутгайд тоонохгүй хэмээн сронхий хэм хэмжэг хуульчилсан байдал. Харин 13 дугаар зүйл 13.2 дах хэсэгт эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутгай эсэхэд түүчинэн Эрүүгийн хууль<sup>39</sup> болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэж нэг дах хэсэгт заасан зарчмыг дэлгэрүүлэн хуульчилсан. Энхүү агуулга нь үндсэн хуулинд заасан хуулийг тайлбарлах агуулгатай шууд зорчилдож байгаа ба шаталсан зорчилдоон бий болж байгаа учир хууль тогтоох, ижмэлт өөрчлөлт оруулах замаар шинэчлэх шаардлагатай байна.

<sup>39</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль – “Торийн мэдээлэл” эзэлжсэндээ 2002 оны 5 дусдарт нийтийнэдэснэ

**Улсын их хурлаас эргүгийн хуулинд дараах байдлаар  
хэл зүйн тайлбар хийсэн байна**

**113 дугаар зүйл. Хүн худалдаалах**

Тайлбар: 1. Энэ хуулийн 113.1-д заасан “молжих” гэдгийг худалдагдсан хүний бисийг нь үнэлүүлэх зэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлагах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсн утгаар ойлгоно.

**215 дугаар зүйл. Тээврийн хэрэгслэйн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зорчих**

Тайлбар: Энэ зүйлд заасан “жолооч” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд, “тээврийн хэрэгсэл” гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, оөрөө явагч бусад машин, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүничлэн бусад механикссан тээврийн хэрэгслийг тус тус ойлгоно

**230 дугаар зүйл. Торийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсргүүцэх**

**231 дүгээр зүйл. Торийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох**

Тайлбар: Энэ хуулийн 230, 231 дүгээр зүйлд заасан **Торийн албан хаагч гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мордон байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.**

**263 дугаар зүйл. Торийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалтын байдлаа урвуулах**

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан **торийн албан тушаалтан гэдэгт торийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхээж байгаа этгээдийг хамааруулна.**

**265 дугаар зүйл. Торийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах**

Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн изгжийн албан тушаалтai гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн изгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.

301 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг, хүмүүст халдан довтлох

Тайлбар: Энэ зүйлд дурдсан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс гэдэгт гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын ажилтнууд, дипломат элч, түүничлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айтчлаалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад оорийн улсын төрийн изрийн омниөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хамаарна. Дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан ёрөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна

**Улсын их хурлаас эрүүгийн хуулинд дараах байдлаар  
системчилсэн тайлбар хийсэн байна**

**79 дүгээр зүйл. Эх орноосоо урвах**

Тайлбар: Гадаад улсын тагнуулын албанад элссэн боловч авсан даалгавраа биселүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын албатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн Монгол Улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлооолно.

**82 дугаар зүйл. Торийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах**

Тайлбар: Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулахад оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс омни эн тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлооолно.

**89 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх**

Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мошгогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогоо эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэсэн бол энэ зүйл хамаарахгүй.

**108 дугаар зүйл. Хүн хулгайлах**

Тайлбар: Хүн хулгайлсан үйлдэл нь бие даасан оор гэмт хэргийн шинжгүй бөгөөд хулгайлагдсан хүнийг сайн дураараа сүллэсан этгээдэл эрүүгийн хариуцлага хүлээнгэхгүй.

**113 дугаар зүйл. Хүн худалдаалах**

Тайлбар: 2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээнгээнэ.

*177 дугаар зүйл. Зандалчлах*

Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэлтгэхэд идэвхтэй оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс омно эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсхүл эн үйлдвийг таслан зогсооход идэвхтэй оролцсон бөгөөд түүний үйлдээд **өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.**

*185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх*

Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодисыг зохих зовшооролгүй хадгалж байгаад зохих байгууллагад сайн дураараа авчирч огсон этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

*270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах*

Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

## **НОМ ЗҮЙ**

1. Монгол улсын дээд шүүх. Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх, онол практикийн тулгамдсан асуудал. УБ. 2008
2. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ.2008
3. Ч.Нямсүрэн. Эрх зүйн онол, УБ.2010
4. Б.Баярсайхан, Эрх зүйн онол, УБ.2010
5. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ.2012
6. А.К. Романов, Их Британий эрх зүй болон эрх зүйн тоогтолцоо, УБ, 2016
7. Kantorowicz H. Op. cit.
8. Kelsen.H. Das Naturrecht in der politischen Theorie . Ed. F. M. Salzburg, 1963,
9. Правоприменение: Теория и практика. Отв. Ред. Ю.А.Тихомиров. М., 2009.
10. Kelsen.H. Das Naturrecht in der politischen Theorie . Ed. F. M. Salzburg, 1963
11. Алексеев, С.С. Указ. Соч. Т.1
12. Llewellyn.K. The Bramble Bush
13. В.Н. Храпанюк. Теория государства и права. М. 1997
14. В.В.Лазарев. Общая теория государства и права. Т.2. М., 1998
15. Н.И.Матузов, А.В. Малько. Теория государства и права курс лекций. М
16. Walter Sinnott-Armstrong. Word Meaning in Legal Interpretation. San Diego Law Review, May-June 2005, Vol 42, number two
17. N.S. Bindra, The interpretation of statutes and General Clauses Acts (Central and States) with WORDS AND PHRASES Fourth Edition, 1965
18. San Diego Law Review What is Legal Interpretation Vol 42
19. Walter Sinnott-Armstrong, Word meaning in Legal Interpretation. San Diego Law Review. Review What is Legal Interpretation? Vol 42

## **THEORETICAL BASIS OF APPLYING LAW AND LAG OF LEGAL POSITIVISM**

/ Criminal law framework /

Studying legal norms and applying law in the practice are difficult to understand, and doubt. So it is demanded to, define ways to apply law and how to explain legal norms.

Researchers to study way to go through lag of legal positivism, to define influence of legal interpretation in applying law and concept of applying law. In framework of legal positivism there are some problems related some factors. Including;

1. Common standards abstract nature and shall be settled in certain mutual legislation Court of content created in unrelated cases caused is difficult to apply the law. It threw the law, which must be taken into account by the use of similar law judge to remove it, the legal principle of justice, management and relations participants intelligent solutions.
2. Patchwork essence of the law that they can understand and write trends within your own knowledge, even as uncertainty laws contents of the law complicity. It is difficult to apply the law. Legal use of appropriate terminology and being served into state failure within the legal service assists.
3. Legal excessive systematic leads to give a clear restriction on the legislature. If not what is the law, taking into account the quality of user-setter systematic law subject to other factors that affect the process of determining the direct and teach applicable law. Law erroneous application of the law is that the legal system is too closed. Researchers, studied to go through ways some problematic issues in framework of legal science

# БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

М.Сувд

Онгонтэнээр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багас,  
Хууль зүйн доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** Бэлчээрийн тухай хуулийн тослийн үзэл баримтлал, бэлчээрийн тухай хуулийн төсөл, Ирээдүй хойч үсийн хүрээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах

**Хураангуй:** Монгол улс бэлчээрийн тухай тусгай хуультай байх, уг хуулийн тослийн үзэл баримтлал ямар байх талаар эрдэмтэд, судлаачид, мэргэжилтийүүд, хуулийн төсөл санаачлагчид сүүлийн жилүүдэд ихэохэн анхаарал тавьж санал бодлоо илэрхийлсээр байгаа нь хууль тогтоох үйл ажиллагаан дахь ардчилалын нэг илрэл мөн. Энэ сэдвээр хөдөө аж ахуйн болон эдийн засгийн ухааны эрдэмтэд, судлаачид, мэргэжилтийүүд илүү санаачлагатай ажилаж, харин хууль зүйн шинжлэх ухааны салбарынхан тодийлон ишэвхи, зүтгэл гаргахгүй байгаа сүл тал ажиглагддаг.

Монгол Улсад бэлчээрийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүдсэн хоёр чиглэлийн үзэл баримтлал байна. Энэ нь:

1. Бэлчээрийн харилцааг тусгай хуулиар зохицуулах,
2. Бэлчээрийн харилцааг газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан зохицуулах гэсэн байдаар илрэч байгаа юм.

Сүүлийн жилүүдээ хууль санаачлагчид газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар бэлчээрийн харилцааг зохицуулах чиглэлийг түлхүү баримтлах хандлагатай<sup>1</sup> байв. Харин тусгай хуультай байх үзэл баримтлал изгdsэн тодорхой шийдвэр

<sup>1</sup> 2014 онд Газарын тухай хуулийн төсөлд бэлчээрийн харилцааг зохицуулахтар тусгагдсан байв.

хүрэлгүй 20 орчим жилийг ардаа орхиод байгаа ч төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд болчээрийн тухай хуулийн тослийг хэд хэдэн удаа боловсруулсан нь бэлчээрийн харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах нийгмийн хэрэгцаа шаардлага байгааг тод харуулах болов.

**Key words:** Draft law on pastureland, concept of draft law on pastureland, Protecting the rights and Environment interests for future Generation<sup>2</sup>

**Abstract:** Presently effective Land Law of Mongolia has some regulations on pasture relations; however, it could not involve all the issues related to the pasture protection and exploitation as it has had many vulnerable issues of legal relations according to the research results. For instance:

- Uncertain tendency and general reflection of state policy on pasture and national laws and rules regulations on pasture issues
- Conflicts between legal norms on pasture relations and unclear statements,
- Uncertain statements on pasture planning and organized exploitation,
- Uncertain boundary of pasture reserves,
- Creation conditions to use sorted pastures free of charge,
- Un optional management system for pasture relations,
- Unguaranteed decision making mechanism on pasture issues,
- Loose responsibilities on herders and other relevant subjects for pasture issues and problems, and failure to reflect joint organizational rights and responsibilities of herders into relevant laws and rules.

Enhancement of legal regulations and coordination for proper usage, protection, and restoration of pasture is directly related to the independence, national safety, and sustainable development of

<sup>2</sup> [http://www.sehn.org/pdf/Models\\_for\\_Protecting\\_the\\_Environment\\_for\\_Future\\_Generations.pdf](http://www.sehn.org/pdf/Models_for_Protecting_the_Environment_for_Future_Generations.pdf)

Mongolia. In connection with mining production development, constitutional rights of herders to live in healthy and safe environment, to be protected from natural imbalance and environmental pollution, to enjoy a comfortable working environment<sup>3</sup>, to travel through the territory of Mongolia freely, to choose a place of temporary and permanent residence have been limited and breached for recent years; therefore, the society has been suffered from the serious danger to lose traditional way of livelihood.

**Conclusion:** It is urgent to make major amendments and changes into legal regulations of pasture relations in Mongolia immediately. It is can't be solved only through amendments and changes into Land Law of Mongolia. Instead, it is clear that Mongolia needs a special law on pastureland; therefore, lawmakers are urgent to update and enhance previously discussed draft pasture law for adoption.

Бэлчээрийн тухай хуулийн төсөл санаачилсан торийн байгууллага - Хүнс, хөдөө аж ахуйн яам (цаашид яам гэх)-ас гадна иргэний нийгмийн байгууллага - Швейцарийн Хөгжлийн Агентлагийн "Ногоон алт" төсөл, Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо (цаашид МБМХ гэх) бэлчээрийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүнц тулгуурлан бэлчээрийн тухай хуулийн төслийн хувилбарыг хэд хэдэн удаа боловсруулсан байна. Судалгаагаар:

1. 1996 оны 5 дугаар сарын 17-нд ХХААХҮЯ (тухайн үеийн нэрээр)-ны боловсруулсан "Байгалийн бэлчээр ашиглалтыг зохицуулах тухай хууль" изртэй төсөл,
2. 1997 оны 3 дугаар сарын 3-нд мөн яам боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,
3. 2007 оны 1 дүгээр сарын 11, мөн оны 5 дугаар сарын 10-нд яам боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,
4. 2009 оны 7 дугаар сарын 20-нд яам боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,

<sup>3</sup> Article 16.4 of the Constitution of Mongolia

5. 2009 оны 11 дугаар сарын 2-нд МБМХ-ны боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,

6. 2010 оны 3 дугаар сарын 17, мөн оны 7 дугаар сарын 8-нд яам боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,

7. 2010 оны 3 дугаар сарын 22, мөн оны 10 дугаар сарын 15-нд МБМХ-ны боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл,

8. 2016 оны 3 дугаар сарын 28-нд яам боловсруулсан Бэлчээр ашиглалтын тухай хуулийн төслийг тус тус боловсруулжээ.

Эдгэр төслийдээс торийн эрх бүхий байгууллагад хэлэлцүүлсэн ажил үндсэндээ үгүй гэж болно.

2009 оны 7 дугаар сарын 20-нд яамины боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төслийг Засгийн газарт оргон мэдүүлсэн, мөн төслийг Улсын Их Хуралд 2010 оны 7 дугаар сарын 8-нд оргон барьсан хэдий ч аль алиныг нь хэлэлцсэнгүй.

МБМХ-ны боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалын асуудлаар 2010 оны 10 дугаар сарын 15-нд тус байгууллага Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Швейцарын Хөгжлийн Агентлагийн “Ногоон алт” төсөл, Дэлхийн банкны “Тогтвортой амьжираа - II” төсөл, Монголын Мянганы Сорилтын сангийн “Хот орчмын бэлчээрийн” төсөл зэрэг байгууллагатай хамтран “Бэлчээрийн эрх зүйн орчиниг боловсронгуй болох асуудалы” сэдэвт бага хурлыг зохион байгуулсан хэлэлцүүлэг хийж хурлын эмхэтгэл<sup>4</sup>, сонинд<sup>5</sup> хэд хэдэн удаа хэвлэн ийнтийн эзэрзээр бэлчээрийн хуулытай болох ажилд ихээхэн хүч гаргажээ. Мөн эдгэр байгууллага хамтран ажиллаж бэлчээрийн тухай хуулийн төслийн талаар малидаас судалгаа авч тэдний санал бодлыг тусгах ажлыг зохион байгуулсан байна.

<sup>4</sup> “Бэлчээрийн эрх зүйн орчине боловсронгуй болгох асуудал” хурлын ижтэлжийн энхийгээ, УБ, Торийн ордон, 2010

<sup>5</sup> Бэлчээр-Ногоон алт саны №02 (03), (05), 2009, 2010, “Зүйн мэдээ” саны № 258 (3330), 2009

Дээр дурдсан бэлчээрийн тухай хуулийн төслийдээс 2016 оны 3 дугаар сард яам эцэслэн боловсруулсан хувилбарыг сонгон хууль зүйн дун шинжилгээ хийхэд:

- Төреөс бэлчээрийн талаар баримтлах зарчмтай байх,
- Бэлчээрийн ангилал тогтоох,
- Бэлчээрийг зохицой ашиглалтын арга замыг тодорхой болгох,
- Бэлчээр ашиглаж ирсэн малчдын уламжлалт эрхийг хамгаалах,
- Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах,
- Бэлчээр ашиглагчийн эрх, үүргийг хуульчлах,
- Бэлчээрийн даацаад малын тоог тохируулах,
- Малчдын хамтын зохион байгуулалтыг дэмжих,
- Бэлчээрийн удирдлага, санхүүжилтийн асуудлыг зохицуулах,
- Бэлчээрт учирсан хохирлыг нохон толгот эсвэл асуудлыг шийдвэрлэх,
- Хууль тогтоомж зөрчигчид хариулага тооцох гэх мэт бэлчээрийн харилцааны нийтлэг асуудлыг тусгайлан зохицуулах үзэл санааг хөндсөн байна.

Хуулийн төсолд бэлчээрийг здийн засгийн зргэлтэл оруулах, бэлчээрийг нохон сэргээхээрэг ишлэд дэвшилтгэй, тавигдаж буй шаардлагад тохирохуйц хэм хэмжээ тусгагдсан, иргэл, байгууллагас авах зорилгоор бэлчээрийн тухай хуулийн төслийг цахим хэлбэрээр байршуулж төслийг иргэл, байгууллагаар хэлээндүүлэх, амьдралд хэрэгжиж болох хэм хэмжээг түлхүү тусгасан гэх мэт давуу талыг дэмжиж байна.

Харин хуулийн төслийн зарим зохицуулалт төслийн үзэл баримтлалтай зорчилтэй, хуулийг бэлчээр хамгаалах тухай хууль хэмжээн явцуу хүрээнд авч үзсэн зэрэг суд тал ажиглагдаж байгаа нь хууль батлах үйл ажиллагаа үр дунд хүрэлгүй өдий хүрсэн үндсэн шалтгаан болж байгааг угүйсгэхгүй.

Монголын бэлчээрийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болтох чиглэлээр боловсруулсан бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, түүнд нийцсэн хуулийн төсол боловсруулах нь цаашц хууль саначлагчид

бэлчээрийн тухай хуулийн төслийг сайжруулан хэлэлцэхэд онол, практикний чухалач холбогдолтой.

Бэлчээрийн тухай хуулийн төслийг цашид сайжруулан боловсруулдаа дор дурласан үзэл баримтлал төслийн иши тэргүүний шийдл байх нь зүйтэй юм.

- Олон улсын практикт давамгайлах хандлагатай болж буй ишитийн эмгэнэл - Tragedy of the commons<sup>6</sup>, газрын түрэмгийлэн эзлэх - Land grabbing<sup>7</sup>, нутгийн иргэдээд тушиглэсэн байгалийн наецийн менежмент - Community based natural resources management<sup>8</sup>, ирээдүй хойч үсийн хурээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах - Protecting the rights and Environment interests for future Generation<sup>9</sup> зэрэг бэлчээр,

<sup>6</sup> Hardin, G., (1968). "Tragedy of the Commons", *Science*, Vol. 162.

<sup>7</sup> On this phenomenon see the special issues *Journal of Peasant Studies (JPS Forum on Global Land Grabbing Part 2: on methods*, Vol. 40 (3), 2013, pp. 469-609) and of *Globalizations (Land Grabbing and Global Governance*, Vol. 10 (1), 2013, pp. 1-209).

Sassen, Saskia, *Land Grabs Today: Feeding the Disassembling of National Territory*, 10 *Globalizations* 2013, pp. 25-46 (43).

On the concept see Pahuja, Sandhya, *Decolonising International law: Development Economic Growth and the Politics of Universality*, 2011, pp. 95-171; Schrijver, Nico J., *Sovereignty over natural resources: Balancing rights and duties*, 1997, pp. 36-113.

On complex forms of interaction from a Global Governance-perspective: Margulies, Matias E./ McKeon, Noral/ Borras Jr., Saturnino M., *Land Grabbing and Global Governance: Critical Perspectives*, 10 *Globalizations* 2013, pp. 1-23.

On land-grabbing and human rights see De Schutter, Olivier, *The Green Rush: The Global Race for Farmland and the Rights of Lands Users*, in 52 *Harvard International Law Journal* 2011, pp. 503-559 эх сурвалжсуудаас дэлгэрүүдэж танилцана уу.

<sup>8</sup> Ostrom, E. 1990. *Governing the Commons: The Evolution of Institutions for Collective Action*. Cambridge: Cambridge University Press.

Ostrom, E. 1998. *The Institutional Analysis and Development Approach*. In *Designing Institutions for Environmental and Resource Management*, eds. E. T.

Ostrom, E. 1999. *Private and Common Property Rights*. In *Encyclopaedia of Law and Economics*, eds. B. Bouckaert and G. De Geest, 332-379. <http://encyclo.findlaw.com/index.html>.

Ostrom, E. 2009a. *Design Principles of Robust Property Rights Institutions: What Have We Learned?* In *Property Rights and Land Policies*, eds. G. K. Ingram and Y.-H. Hong, 25-51. Cambridge, MA: Lincoln Institute of Land Policy эх сурвалжсуудаас дэлгэрүүдэж танилцана уу.

<sup>9</sup> [http://www.sehn.org/pdf/Models\\_for\\_Protecting\\_the\\_Environment\\_for\\_Future\\_Generation.pdf](http://www.sehn.org/pdf/Models_for_Protecting_the_Environment_for_Future_Generation.pdf)

байгалийн иеоц баялгийн зохистой ашиглалтын талаарх үзэл баримтлалд тус тус зохицуулалттай болох;

- Бэлчээрийн (өвөлжээ, хаваржаа, зуслан, намаржаа, отрын иеоц нутаг) болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бус нутаг тогтоох,
- Бэлчээрийн харилцаанд оролцооч субъект, тэдгээрийн эрх зүйн байдлыг тогтоох гэсэн үндсэн турван чиглэлийг зарчмын төвшинд авч үзэх нь зохистой.

Бэлчээрийг даанцад нь нийтийн төслийн төслийн талдаа ашиглах, бэлчээр ашиглах эрхийг хууль зүйн хувьд тодорхой болгон зохицуулах, тороос бэлчээрийн толов байдалд хяналт тавих, малыдын хамтын байгууллагад бэлчээрийн талаар эрх хэмжээ олгох зэрэг гол гол асуудал хуульчлагдаш шаардлагатай байна.

Бэлчээрийн хил зааг тогтоох асуудал хуульчлагдах нь төслийн үзэл баримтлалд чухал байр суурь зэлэх ёстой гэж үзэж байна. Үүний тулд отор, уламжлалт мал аж ахуй эрхлэх бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бус нутгийн хил заагийг тогтоох эрхийг төрийн захиргааны зохих байгууллага, нутгийн оөрөө удирдах байгууллагад хуулиар олгох, аль ч бэлчээрийн хил заагийг тогтооход ажлын хэсэг байгуулах замаар харгалзах шалнуур, арга, аргачлалыг хуулиар нарийвчлан зохицуулах нь зохистой байна.

Өөр нэгэн анхаарал татсан асуудал бол хуулийн төсөлд бэлчээр зохион байгуулалтын асуудал шийдвэрлэх зүйлийн нэг байх ёстой. Энэ асуудалд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалтыг баталгаажуулах шаардлагатай. Үүний тулд суманд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бус нутгийн байршилыг тогтоож түүний хэмжээ, хил заагийг монголчуудын бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, иүүдэл хийх боломжтой байдлаар тогтоон хуульчлах нь зүйтэй байна. Бэлчээрийн хил заагийг үндэслэж сумын иргэдийн Төлөвлөгчдийн Хурлаас тухайн бус нутгийн онцлогт тохируулан сумын бэлчээр ашиглалт, хамгаалалтын журам баталж, бэлчээрийг малыдын хамтын

байгууллагад тэрэгээр ашиглуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь чухал.

Бэлчээр ашиглагч субъект, түүний эрх зүйн статусыг тодорхой хуульчлах хэрэгцээ амьдралаас урган гарсаар байна. Хуулийн төсөлд бэлчээр ашиглагч субъект нь зөвхөн иргэн, хуулийн этгээд байхаар тусгах нь учир дутагдалтай болно. Бэлчээр ашиглагч субъектийг малчдын хамтын байгууллага, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч субъектийг иргэн, хуулийн этгээд байхаар шинэчлэн оөрчлөхөөр тосолд тусгавал бэлчээрийг дундаа хамтран ашиглаж болох хууль зүйн үндэслэл бүхий хувилбар бий болох сайн талтай. Учир нь тухайн газар нутгат тулгуурлаж мал аж ахуй эрхлэгчид малчдын хамтын байгууллагын зохион байгуулалтад орох, бэлчээрийг малчин, малчин орх дангаараа бус дундаа хамтран ашиглах, бэлчээрийн хэвийн толов байдлыг хангахад чиглэсн үйл ажиллагаа явуулах, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг төлөвлөж зохион байгуулах нохцел бүрдж зэрэг эрх зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Малчдын хамтын зохион байгуулалтын эрх зүйн үүдсний Монгол Улсын иргэний хуулиар тогтоосныг үндэслэн гэж болно. Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд “Хамтран ажиллах тэрээр үндэсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нахорлогийн хэзээр зохион байгуулгадаж үйл ажиллагаа явуулж болах богоод шийн байгууллагыг улсын буртгэлд буртгүүлэхгүй, бутыг, зохион байгуулалтыг лишиуд харилцан тодорхойлох тодорхойлийн<sup>10</sup>”, гэж заасан. Малчдын хамтын зохион байгуулалтын хэлбэр нь хэдийгээр хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ч гэсн иргэний хуулын заасан өронхий үндэслэлээр эрх зүйн харилцааны субъект байж, тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх хууль зүйн нохцел бүрдэнэ.

Бэлчээрийн харилцааны талаар төрийн болон нутгийн оороо удирдах байгууллага, малчдын хамтын байгууллагын эрх хэмжээг тодорхой хуваарилан зааглах асуудал хуулийн

<sup>10</sup> Иргэний хууль, 2002, 481.1

төслийн бас нэг чухал үзэл баримтлал байх ёстой гэж үзж байна. Гээля энэ асуудал төдийлон нарийвчлагдаагүйн гадна шаардлагатай зарим хэмжээ ор тас орхигдсон байдал ажиглагдав. Бэлчээрийн харилцааны зохицуулалт дан ганц төрийн байгууллагад бус малчдын хамтын байгууллагын эрх хэмжээнд ямар нэг байдлаар хадгалагдах нь иргэний нийгмийн орчин үеийн үзэл хандлага, гадаадын зарим орны дэвшилтгэтийн турилагаас харагдаж байна. Төслийн 17 дугаар зүйлцбэлчээр ашиглагчийн эрх, үүргийг зохицуулахаар тусгасан нь дэвшилтгэй ч бэлчээр омчилгэч төр, түүний төлоөллийн байгууллага, албан тушаалтан бэлчээрийн талаарх эрх хэмжээ, бэлчээрт тавих хяналт, хариуцлага хүлээх гэх мэт асуудлыг орхигдуулсан нь бэлчээрийн харилцааны субъектүүдийн нэгдмэл ашиг сонирхлыг хуулиар хангахад дутагдалтай гэх үндэслэлтэй байна.

Тосолд бэлчээрийг ашиглалтын зориулалтаар нь ангилаал тоогоо<sup>11</sup> шинэлэг зохицуулалтыг бий болгохоор тусгасан нь сайшаалтай.

Ер нь уламжлалт мал аж ахуй эрхлэх бэлчээрийг малын хамтын байгууллага дунцаа хамтран гэрээгээр ашиглах зохицуулалт бий болгож баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зохистой.

Бэлчээрийн хуулийн төслийн нэг үзэл баримтлалд ирээдүй хойч үеийн хүрээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг хуульчлан зохицуулах нь зохистой.

Үндсэн хуулийн оршил хэсгийн агуулга, эрх зүйн үр дагавар нь хууль зүйн шинжлэх ухаанд онол, арга зүйн ихээхэн ач холбогдолтой. Үүнийг байгалийн неоц баялаг ашиглалт, тэр дунцаа бэлчээрийн газар ашиглалт, хамгаалалттай холбогдуулан авч үзвэл, "... торт ёс, түүх, соёлынхоо уламжлалтыг наандижин авлож ... иргэний ардчилсан нийгэм цогцоулган хөгжүүлэхийг эрхэм зорилго балгоно" хэмээн монголчуудын уламжлалыг хойч

<sup>11</sup> Бэлчээр ашиглалтын тухай хуулийн төсөл, 2016, 5-10

Үедээ овлуулэн үдээх оргон агуулга бүхий асуудлыг хуульчилжээ гэж болно. Харин Үндсэн хуульд Монгол Улсын тогтвортой хөгжлийн нэг чухал үзэл баримтлал болох ирээдүй хойч үеийн хүрээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг зохицуулаагүй. Энэ нь бидний судалгаанаас ангид байх боломжгүй нь тодорхой. Хүн төрөлхтний энхүү эрхийг дэлхийн олон орон Үндсэн хуульдаа тунхаглан баталгаажуулдаг байна. Тухайлбал, Эстони<sup>12</sup>, Андорра<sup>13</sup>, Армени<sup>14</sup>, Швейцари<sup>15</sup> зэрэг улсад Үндсэн хуулийнхаа оршил хэсэгт, Эквадор<sup>16</sup>, Аргентин<sup>17</sup>, Өмнөд Африк<sup>18</sup>, Бельги<sup>19</sup>, Боливи<sup>20</sup>, Бурунди<sup>21</sup>, Куба<sup>22</sup>, Швед<sup>23</sup>, Бутан<sup>24</sup> зэрэг улсад Үндсэн хуулийнхаа үндсэн зохицуулалт хэсэгт, Польшид<sup>25</sup> Үндсэн хуулийнхаа оршил хэсэг болон үндсэн зохицуулалт аль алийд нь давхар тунхаглан зохицуулдаг байна. Улс орны хойч үеийн экологийн эрх ашиг, сонирхлыг хангаж хамгаалах асуудлыг хуульчлан бэхжүүлсэн.

Эдгэр орны Үндсэн хуулийн үзэл баримтлал бол тааламжтай хүрээлэн буй орчинд амьдрах хойч үеийнхийн эрхийг хүлээн зөвшилцөрч, хуульчлан хамгаалах асуудлыг тунхаглан баталгаажуулсан давшилтэт хэм хэмжээг тусгасан явдал мөн.

Тогтвортой хөгжлийн бодлогыг эрэмблэх шаардлагатай үндсэн 3 элемент бүхий онолд<sup>26</sup> ирээдүй хойч үеийн хүрээлэн буй

<sup>12</sup> *The Constitution of the Republic of Estonia 1992, preamble*

<sup>13</sup> *Andorra's Constitution of 1993, preamble*

<sup>14</sup> *Constitution of Armenia, 1995, preamble*

<sup>15</sup> *Federal Constitution of the Swiss Confederation 1999, preamble*

<sup>16</sup> *Constitution of Ecuador 2008, art 395*

<sup>17</sup> *Constitution of the Argentine nation, 1994, art.41*

<sup>18</sup> *The Constitution of the Republic of South Africa, 1996, art.24*

<sup>19</sup> *Constitution of Belgium, 1993, art.7*

<sup>20</sup> *Bolivia (Plurinational State of)’s Constitution of 2009, art.9.6*

<sup>21</sup> *Burundi’s Constitution of 2005, art.35*

<sup>22</sup> *Constitution of Cuba, 1976, art.27*

<sup>23</sup> *Constitution of Sweden, 1991, art.2*

<sup>24</sup> *The Constitution of The Kingdom of Bhutan, 2008, art.5*

<sup>25</sup> *The constitution of the republic of Poland, 1997, preamble and art.74.1*

<sup>26</sup> Weiss, Edith Brown, "In Fairness To Future Generations and Sustainable

орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал зүй ёсоор багтдаг байна. Үүнд:

1. Хойч үеийнхний эрхийг хамгаалах, энэ нь хойч үеийнхэнд зайлшгүй хадгалагдах,
2. Хойч үеийнхэнд хүрээлэн буй орчны хэвийн толев байдлыг зайлшгүй хадгалж үлдээх,
3. Хойч үеийнхний байгалийн баялаг ашиглах боломжийг хамгаалах шаардлага гэсэн элементүүд орно.

Судалж үзсн орнуудад зэгзор эрхийг Үндсэн хуулиараа хуульчлан хамгаалахын зэрэгцээ хуулийн хэрэгжүүлийг зохион байгуулах тусгай байгууллага байгуулж, тодорхой эрх, үүрэгтэй (хүрээмж буй орчны асуудлаар иргэдийн санал, хүснэгт, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх, торийн байгууллагатай харилцах, санал хүснэгтээ уламжлах гэх мэт) байх асуудлыг мөн хуульчилдаг байна.

Монгол Улсын Үндсэн хуульд бицний ирээдүй хойч үеийн хүрээлэн буй орчны эрх, ашиг сонирхлыг хамгаалах хэм хэмжээг тунхаглан тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийг боловсронгуй болговол зохих нэгэн чиглэл болох нь тодорхой бөгөөд эл асуудлыг бэлчээрийн тухай хуульд давхар баталгаажуулах асуудал онол, практикийн ач холбогдолтой.

Бэлчээрийн харилцааг зохицуулах тусгай хуультай байхаар боловсруулсан төслийдийг сүүлийн 4 жилд Улсын Их Хурлаар хэлэлчээгүй, хэлэлчээх асуудлын жагсаалтад ч багтаагүй одий хүрсн нь бэлчээрийн харилцааны асуудлаар териийн болдого дутагдаж байгаагийн нэг баримт мөн. Ийм боллогогүйгээс бэлчээрийн доройтол ихэсч, бэлчээр ашиглагчдын эрх хязгаарлагдаж буй болит байдал сүүлийн үед илрээд ажиглагдах болов. Ул уурхайн үйл ажиллагаа болон хууль бус үйлдлүүд хүрээлэн буй орчин, ялангуяа бэлчээр, усны нөөц, хүн, мадл олон тооны эрдэл учруулж байна. Эдгээрээс гарах нэг гарц бол бэлчээрийн харилцааны овормоц олон талт асуудлыг иж бүрэн

хамарсан тусгай хуулийн төслийг байгалийн баялгийн зохицой ашиглалтын талаар баримталж буй үзэл баримтлал, олон улсын эрх зүйн жишигт тулгуурлан боловсруулж батлах нь Монгол Улсын онцгийн амьдралын хэрэгцээ, шаардлага болсоор байна. Үүнийг судалгаанц үндэслэвэл, 21 аймгийн бүс нутгийн төлөөлөл бүхий 15060 оролцогч (мадчин -13301, мэргэжилтэн -1197, удирдах ажилтан -562)-оос бэлчээрийн асуудлыг тусгай хуулиар хуульчлах шаардлагатай эсэх талаар судалгаа авахад оролцогчдын 67.3 хувь нь бэлчээрийн тухай хууль шаардлагатай гэсэн үр дүн гарсан.

*Хүснэгт 1. Бэлчээрийн харилцааг тохицуулсан хууль гаргах шаардлагатай эсэх? санал асуултын судалгыны үр дүн*

	Бар- уун бүс	Зүүн бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Улаан- баатар хот	Дүн	Хувь
Шаардлаг а-тай	3017	1313	2872	2803	135	1014 0	67.3
Шаардлаг а-гүй	720	469	780	841	4	2814	18.7
Мэдэхгүй	567	338	552	644	5	2106	14

2015 онд мөн дээрх санал асуулгаар 6 аймгийн 362 оролцогчоос чанарын судалгаа авахад 85.08 хувь буюу 308 нь тийм, 10.7 хувь буюу 39 нь угүй, 4.1 хувь буюу 15 нь мэдэхгүй гэжээ.

*Хүснэгт 2. Таны бодлоор бэлчээрийн асуудлыг тусгай хуулиар зохицуулах  
хэрэгжээ, шаардлага байна уу? санал асуулжын судалгааны үр дүн*

	Тийм	Үгүй	Мэдхгүй	Нийт
Архангай	47	8	0	55
Баянхонгор	37	3	3	43
Говь - Алтай	48	8	6	62
Ховд	45	7	3	55
Увс	62	7	0	69
Завхан	69	6	3	78
<b>Нийт</b>	<b>308</b>	<b>39</b>	<b>15</b>	<b>362</b>

2011, 2015 оны дээрх судалгаагзар бэлчээрийн харилцааг бэлчээрийн тухай тусгайлсан хуулиар зохицуулан журамлах зайлшгүй шаардлага байгаа нь илтг байна.

Төгсгөлд нь газрын тухай хуульд ишмэлт, оорчлолт оруулснаар бэлчээрийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн дүгнэлтийг хүрэв.

# ХУУЛЬ БҮТЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭС ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

/үзэл сэтгэлгээний хөгжил/

ЦАмарсанаа

*Шихихутуг Их сургуулийн Тор, захиргааны  
тэснэхмийн баси, Хууль зүйн ухааны магистр*

Эрх зүйн хөгжил нь нийгмийн бүхий л үед хувьсан оорчлогдож ирсэн байна. Эрх зүйг тодорхойлохдоо В.И.Алеексев "Эрх зүй хэээ ч одохгүй" хэмээсэн байдал. Энэ нь эрх зүйг тодорхойгүй зүйл гэсэн үг биш харин тогтмол оорчлогдож хувьсаж байна гэсн санаа байх юм.

Нийгмийг хэрхэн зөв зохицой байгаа эсэхийг ямагт хяналтанд байлгах шаардлагатай юм. Эрх үүргийн тэнцвэрт байдал алдагдвал нийгмийн гажуудал буюу дарангуйлал бий болох юм. 1950 онд болсон Английн нийгмийн хуулийг эсрэгүүцсэн билгийн чиг хандлагаар гэмт хэрэг гэх үзлийн эсрэгүүцэл 1967 онд хуулинд оорчлолт орсон нь нийгэм оороо торийн байгууллагын эсрэг хяналт тавьж байх нь иэн чухал гэдгийг харуулсаар байгаа юм.

Судалгааны ажлын зорилго: эрх зүйн онолын сэтгэлгээ хандлага тогтоох болон захиргааны байгууллагат зүй ёсны хэвшмэл сэтгэлгээг бий болгох.

Судалгааны зорилтын хувьд:

1. Эрх зүйн түүхэн хөгжлийн талаарх товч.
2. Захиргааны хууль, тогтоомжинд дун шинжилгээ хийх нь.

## Эрх зүйн түүхэн хөгжлийн талаарх товч.

Орчин үеийн эрх зүйн үзэл баримтлал, философиийн хөгжил нь дундад зууны үеийн схоластик эрх зүйн филюсофитой салшгүй холбоотой. Эрх зүйн хэм хэмжээнүүд нь хоорондоо зорчилдоонд орж, бие бистэйгээ зорчилдсон тохиолдолд хууль, эрх зүйн

шударга ёсны шүүлт болгох<sup>1</sup> үзлээс энэ хандлага үүсэлтэй. Тиймээс энэ үсийн сэтгэгчдийн дунд эрх зүйн төрөлх эхэнд чанарыг танин мэдэхүйгээс ахуйд буюу хэт бурханлаг узэл философиос эрэх хайгуул улам бүр хүчтэй байсан. Профессор Ж.Робертсын тэмдэглэснээр: “Бурхан байх бөгөөд, хүмүүний амьдралыг толовлон зохицуулж, хэн бурхны толовлогеөнд зааснаар амьдрах аваас сайн, хэн бурхны толовлеснөөс гажвал буруу номтон гэсэн сонгодог жам ёсны эрх зүйн онолд тулгуурлж байсан<sup>2</sup>”. Тиймээс хүний хууль нь дээд бурхан хийгээд байгалийн хуульд нийцэж байх ёстой гэсэн сургаалиас үүдэж<sup>3</sup>, түүнд нийцэгүй хуулийг Августин /Augustine/ “Lex injusta non Lex” буюу “шударга бус хууль нь угаас хууль биш” хэмээн зарчим болгон тунхагласан. “Хүчин тоголцор хууль бүр ямар нэгэн шалтгааны хууль байдаг. Шалтгааны хуулийг хүчин тоголцор хуулиас ялгаж салгах нь тун төвөгтэй” хэмээн XVI зууны английн хуульч Кристофер Жерман хэлсэн<sup>4</sup> нь эл үсийн эрх зүйн сэтгэгээний тод илрэл мөн.

Харин XVIII-XIX зуунд байгалийн шинжлэх ухаанд гарсан нээлтүүд нь нийгэм хийгээд хүмүүнлэгийн ухааны асуудлуудыг шинээр авч үзэхэд хүргээн бөгөөд энэ нь эрх зүйн судалыг ч мөн тойрсонгүй. Тухайн үед шинжлэх ухааны хүрээнд гарсан гэгэрэл нь хүнийг мистицизм буюу домог, сүсэг бинирэл, байгал хийгээд дээд ухамсарт захирагдах байдалыг түүний өөрийнх нь оюун ухаанаар чөлөөлөхийг эрмэлзэв. Ингэнээр бидний өөрсдийн амьдралын ирээдүй гагцхүү бидний оюун ухаанаас үүдэлгэй гэх рационал узэл улам бүр хүчтэй дэлгэрэх болжээ. Үүнд тулгуурлан

<sup>1</sup> И.Лүндиндорж. “Төр, эрх зүйн сэтгэгээний хөгжлийн чиг хандлага”, УБ, 2002.38 дат мал.

<sup>2</sup> J.M.Roberts. *History of the World*. 1993 New York: Oxford University press, p.42.

<sup>3</sup> Т.Аквина монхийн жам ёсны бурхны, хүн төрөлжтийн гэсэн дараан тортмын хүстийг заагласан болговд эдээр тээвэрхэдээр фарааглаар бие биедээ захирагдах ёстой ажгуу. *Thomas Aquinas Summa Theologica. Part II. Question XCIV.4 th article*. Дам шилж.

<sup>4</sup> St.Augustine. *The Libero Arbitrio. I.vII.* дам шилж.

орчин үсийн буюу модери гэх нийгмийн үндэс нь гагцуү оюун ухаанд итгэх итгэл дээр суурилж гарч ирсэн<sup>5</sup>.

Бурханаас юм уу, түүний хүслээр тогтоосон ямар ч дээд эрх зүй гэж байхгүй. Мөн байгаанс буюу жам ёсны ямар нэг хатуу тогтоосон зарлиг, хэм хэмжээ гэж үгүй богоод түүнд дулдуйдсан ямар ч нийгмийн бүтэц, давхраа гэж байхгүй. Бүгд л оюуны хэрэглүүр, хүний өөрийнх нь бүтээл учраас хүнийг хүнээс өөр хэн ч аврахгүй. “Тиймээс хүмүүсийн нийгмийн хяналтын хэрэглүүр болох эрх зүйн тогтолцоог тэд оорсдоо бүтээж чадах богоод чадах ч ёстой” гэсэн үзэл санааг рационалистиүүд давшүүлсэн<sup>6</sup>. Үүнд үндэслэж ёс суртахууны үнэт зүйлээс эрх зүйг зааглах ёстой эсэх дээр хуваагддагаас үл хамааран орчин үсийн жам ёсны эрх зүйчид хийгээд позитивистүүд бүгд байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглан салгах шаардлагыг хүлээн зөвшөөрдөг.

Байгалийн хуулиас хүн төрөлхтний хуулийг зааглах оролдлогыг хамгийн аих английн эрх зүй судлаачид болох Ж.Остин, Ж.Бентам нар хийсэн. Тухайлбал: Ж.Бентам: “Эрх зүй нь өөрт тавигдах шаардлагын дагуу бүтээгдсэн бол эрх зүй богоод дээд тэнгэр хийгээд бурханд нийцэх албагүй”<sup>7</sup> хэмээн тэмдэглэсэн богоод цааш нь өөрийн онулыг тодотгон “хуулийг позитив хэмээн нэрлэх шалтгаан нь хүнээс эхнээг гэдгийг тодотгож буйн зэрэгцээ бурхны хийгээд байгалийн хуультай оор оор ойлголтыг хооронд нь хольж хутгахаас сэргэжлэв” хэмээн тодорхойлсон. Энэ үндэсн дээр тэрэр, хууль гэдэг бол бүрэн эрхтийн захирамж<sup>8</sup> хэмээн тодорхойлсон.

Харин Ж.Бентам “Эрх зүйн тогтолцооны хамгийн чухал үүрэг, зорилтыг нэг бол оорийнхоо хэм хэмжээ, зарчмуудын тусламжтайгаар хүмүүсийн хоорондын аливаа ижсн харилцааг нийгмийн ба хууль зүйн мэргэжлийн ухамсар ба практик эрх зүйн

<sup>5</sup> М.Батсуурь. “Эрх зүйн хөгжлийн: Модери ба постмодери ба ландшаага”. УБ., 2006. Шалжтууг сэргүүл.

<sup>6</sup> Stewart Henry. *Dragan Milovanovic's A Constitutive Theory of Justice*. 1991.

<sup>7</sup> Freeman M.D.M Lloyd's *Introduction to Jurisprudence*. London. 2001. p. 63

<sup>8</sup> Law is command of Sovereign

харилцаа болгон хэвшүүлэхэд оршино<sup>9</sup>. Тиймээс аливаа хуулийг шалгах шалгуур нь дээрхтэй уядаж практик зорилгыг хангах чадвартай байна уу гэсэн үндэслэл болохоос биш дээд хуульд харшлах тухай биш<sup>10</sup> хэмээн үзсэн. Мөн тэрээр “жам ёсны эрх”-ийн талаарх ямар нэг ойлголтоос үргэлж татталзаж, цааргалж ирсэн бөгөөд түүний судалгаа эрх чөлөө, тгш эрх, омч хөрөнгө зэрэг ойлголтуудыг бүхээд нь үнэ цинэ, үзэлжүүлжийнхээ хүрээнд авч үздэг аж. “Эрх” гэдэг бол хууль зүйн ойлголт бөгөөд бид “эрх”, “үүрэг”-ийн тухай ярихдаа юун түрүүнд хуулиар я сэтгэдэг. Хууль я танд сонгох, сонгогдох, цалин монго авах, цагдаагаар хамгаалуулах эрхийг өгдөг<sup>11</sup>. Харин жам ёсны эрх гэдэг бол модон холтгай хүүхэлдэй<sup>12</sup> хэмээсн байдаг.

Ж.Бентам дэвшүүлсэн нэг чухал санаа бол эрх зүйг ашигт чанарын онол хэмээн иерийдсэн утилитаризмын үүдлийн тайлбарлахыг оролцсонд байдаг. Тодруулбал, ашигт чанарын зарчим нь эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн аз жарталын нэмэгдүүлэх эсхүл хорогдуулах байдлаас нь хамааруулж аливаа үйлдэл бүрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөх зарчмыг хэлнэ. Ашигт чанар гэдэг нь ямар нэгэн объект түүнийг хөндөж буй этгээдэд үр өгөөж, давуу тал, цэngэл, сайн сайхан, аз жартал бий болгох эсхүл гэм хор, овчин шашлал, муу муухай, зовлон зүдгүүр учрахаас сэргийлэх шинж чанарыг хэлнэ. Тиймээс ашигт чанар нь тухайн хүн амын дийлэнх хэсэгт хамаарах ёстой бөгөөд хууль нь хүний амьдралын асуултуудын дийлэнх хэсгийг шийдвэрлэх чадвартай бол уг хуулийг даган мөрдөх ёстой ажс<sup>13</sup>. Тодний үзлийг

<sup>9</sup> С.Наранжирээ. “Монголын ба дэхийн эрх зүйн тоствариоо”. УБ., 2001.60 дахь тал.

<sup>10</sup> Freeman M.D.M Lloyd's *Introduction to Jurisprudence*. London. 2001. р. даан шилжээ

<sup>11</sup> Bentam J. *Anarchical Fallacies*. 1987. р. 73 даан шилжээ. “Эрх зүй”. УБ., 2004. сэргүүл. Ч.Оюнбаев.

<sup>12</sup> Моисеев. Философия права. Новосибирск. 2003. даан шилжээ. “Шинжүүлэг”. УБ., сэргүүл. М.Батсуурь.

<sup>13</sup> Сонгодог позитивистуудын доктриналсаныг талархан философи алмерикийн реалист гарч ирсэн. Гэхээ тэд энэ зүйг бурлан хийсээд хүний шигээ узувчилжээ залгах хандлагатай нэгддэг боломж эрх зүйг тодорхойлох хандлага дээр эрх бөөр байр суурьтай байдаг. Тодруулбат прагматизмын узээл дээр суурьжжээ Оливер Венделл Холмс. Ж.Франк/1889-1957/, К.Левеллини/1893-1962/ нар эрх зүй

Австрийн эрх зүйн онолч Х.Келзен, Английн хуульч Г.Харт<sup>14</sup> нар үргэлжлүүлэн хөгжүүлсэн. Х.Келзен<sup>15</sup> эрх зүйг дээд бурханлаг үзлээс салгах явдлыг бүрэн дэмжээд зогсохгүй мөн объектив мэдлигийн бусад салбараас зааглах оролцлого хийсэн.

Аливаа нийгмийн харилцаа ёөрийн зохицт байдлаар зохицуулагдан өрнөж байгаа нь ид шид биш, тагихүү эрх зүйн гайхамшигт хүч. "Эдүгээ хууль зүйн шинжлэх ухааныхаа хувьд утгаа алдаж дуусчээ. Учир юу гэвэл хуульчид сэтгэл зүй, биологи здийн засаг, улс төр, шашин, суртлын холимог бантан болсон тодийгүй элгэр ухаанаас хэн их хуулсаараа гайхуулах болсон нь дээр өгүүлж буй утгын алдалт болж буй юм"<sup>16</sup> хэмээн эрх зүйг мистицизм тодийгүй нийгмийн баримжаатай судлах хандлагад дайралт хийсэн. Хамгийн гол нь эрх зүйг цэвэр байлгаснаар хэн нэгний хүсэл зориг хийгээд бусад субъектив үзлэлж шингэхийг хаах ажээ. Харин цэвэр эрх зүй бол хэм хэмжээ нь формаль тэгш байдлын зарчмаар харилцааг зохицуулж, хэн юу хийх ёстой үгүйг зааварлагч хэм хэмжээний нийлбэр цогц<sup>17</sup> ажээ.

Английн эрх зүйн онолч Г.Харт "Эрх зүй нь горим журмын цогц бөгөөд эдгээр горим журам ёөрийн онцлоогоос хамааран анхдагч ба хоёрдогч гэсэн үүрэгт хуваарилагдана. Анхдагч горим журам нь хүмүүсийн зан үйлийг тэлгээрийн хүсэл зоригтоос үл хамааруулан дэглэж байдаг"<sup>18</sup>. Тэрээр Ж.Бентамын ашигт чанарын онолын гаргалгаанд сууринтж "Бараг оршин буй бүхий л эрх зүйн

амыдралас хэн тасарсан байдлыг арилгахыг оролцсон. Тэдний үзүүлээр эрх зүйн мөн чанарыг танин мэдлийн түүд хийсвэр онолуудад анхиласан хандуулжасан штуутыгээр шүүхийн практик анхилас нь чухал. Эрх зүй нь уг гаралгаараа тэмгээрээс бүг, газар давхийнх бөгөөд хэрэглэхэдэхүүн шинжээстэй, энд түү бэл "тэмгээрт замхрах хоссон бодол биш" бөгөөд төвчир "ээс нь шургуул шийдвэр яи" гээс тодорхойлсон.

<sup>14</sup> H.L.A.Hart. *The Concept of Law*. Clarendon Law Series. Second edition. Oxford University press. 1994 дээр үзүүлэн үзэх.

<sup>15</sup> Х.Келзен. "Just farst буюу Есн үз". УБ., 2004. 24 дэх мал.

<sup>16</sup> Kelsen H.L. *The Concept of Law*. Clarendon Law Series. Second edition 1989 дээр иштээв.

<sup>17</sup> Hart H.L. *The Concept of Law*. Clarendon Law Series. Second edition . Oxford University press. 1989 дам шийтэв.

тогтолцоо нь хоёр нийгмийн зорилгыг хангахад чиглэгддэг буюу эхнийх нь хүмүүсийн амьдралын зайлшигүй хүрээг горим журмуудаар дэглэх. Ингэснээр амьдралын тохиолдол бүрт эрх бүхий этгээдээс тухайн үед хэрхэх тухай шийдвэр гаргуулахаар хандах шаардлагагүй болдог. Харин бүрхэг ойлголтой тулгарахад сергэлдэх хоёр ашиг сонирхолуудын дундаас тухайн горим журмын бүрхэг хэсгийг тодотгох замаар анхныхаа зорилгыг илүү нээдэг... харин иээлтэй эрх зүйн бүтэц нь тохиолдлоос тохиолдол бүрт хувьсаж байдаг сергэлдэх хоёр талын ашиг сонирхолыг заримдаа баланслах эрх бүхий этгээд /шүүх/-эр тогтоолгох явдал байдгийг угуйсгэх арагүй. Гээн хэдий ч дийлэнх үед амьд эрх зүй нь эрх бүхий этгээдэд тохиолдол бүрт шинэ эрэл хайлт хийх шаардлагатгүйгээр асуудлуудыг тогтоосон горим журмын дагуу шийдвэрлэх гарц болж чаддаг<sup>19</sup> гэж номолж, эрх зүйн чиг үүрпийг дийлэнх асуудлыг шийдвэрлэх чадвараар хяглаарласан. Хэдийгээр эрх зүйг нийгмийн баримжаатай судлахаас татгалзаг позитивистүүдийн үзлийг дэмждэгтүй ч хэт бурханилаг үзлээс ангид судлах хандлагыг дэмжиж буйгаа профессор Л.Фуллер /Lon Fuller/, Ж.Финниис нар оөрсднийн бүтээлдээ харуулсан. Тухайлбал Л.Фуллер “Эрх зүй нь уг гарвалаараа газар дэлхийнх богоёд хэрэглэгдэхүйц шинжтэй. Эрх зүй бол тэнгэрт замхрах хоосон бодол биш... Үнэхэр дээд эрх зүй гэж байвал миний өгүүлж буй жам ёсны эрх зүйн үзэл доод буюу хүн төрөлхтний эрх зүйд хамаарна” хэмээсэн. Цааш нь “Эрх зүйн иэн чухал чиг үүрэг бол хүмүүсийн зан үйлийг оөрсдөө тэлгээр зан үйлээ хянах нийтлэг горим журамд захируулах замаар нийгмийн дэг тогтоох явдал” богоёд хэрэв зан үйлийг хянах хуулийн энэ чиг үүргэд нийцэгүй хууль бол хууль биш. Харин энэ чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд горим журмуудын тогтолцоо нь дараах зарчмуудыг бүрэн тусгасан байх ёстой. Үүнд:

- Горим журмууд нь нийтлэг нохцлоөр илрэх ёстой
- Горим журмууд нь нийтэд зарлагдсан байх ёстой

<sup>19</sup> Hart H.L. *The Concept of Law*. 129-135

- Горим журмууд нь үйлчлэх ирээдүйтэй байх ёстой
- Горим журмууд нь маш ойлгомжтой нохцлоор илэрхийлэгдсэн байх ёстой
- Горим журмууд нь бие бие малгайлан захирсан байх ёстой
- Горим журмууд нь хамрагдаж буй талуудын бүрэн эрхэд үл хамаарах зан үйлийг шаардах эрхгүй
- Горим журмууд нь субъект түүнд итгэл найдвараа алдтал байнга өөрчлөгдох ёсгүй
- Горим журмууд нь үндэсн хэв маяг бүхий тогтолцоондоо захирагдах ёстой” гэжээ. Үүгээрээ эрх зүй нийтлэг шаардлагыг хангах ёстой гэсэн Ж.Бентамын үзлийг баримталсан.

Дээрх сэтгэгчдийн үзлэс дүгнэвэл, эрх зүйн модерн хандлагын үзүүлж баршигүй ач гавьяа нь эрх зүйг мистицизм хийгээд дээд тэнгэрлэг, бурхны хүсэл зоригтой хутгаж байсан сэтгэлгээнээс хүн төрөлхтнийг салгаац зогсохгүй хууль зүйн хандлагтайгаар судлах гарцыг илссэнд оршино. Гэхдээ эрх зүй, ёс суртахуун хоёрын хооронд хөшиг бий эсэх асуудал дээр дотроо позитивизм ба жам ёсны эрх зүй онол гэсэн томоохон урсгалд хуваагддаг. Харин тэдний зүгээс эрх зүйд тавьдаг нийтлэг шаардлага бол амьдралц тохиолдох асуудлын дийлэнхийг нь хэм хэмжээ буюу горим журамд үндэслэн шийдвэрлэх чадвартай байх явдал<sup>20</sup>.

ХХ зууны суулчид Франкфуртын их сургуулиас гарсан хүчтэй давалгаа нь ганцхан эрх зүй судалалын тодийгүй нийт сэтгэлгээний түвшинд хувьсгал хийв<sup>21</sup>. Тэдний үзлээр объектив бодит байдал гэж байхгүй. Бодит байдал гэдэг бол социал бүтэц бөгөөд энэ нь биднийг мэндлэхээс омни аль хэдийн угтрагдсан байдаг. Тиймээс бидэнд жам ёсны гэх нэрийн дор хүлээн зөвшөөрөгдсөн үнэн чанартаяа зохиомол ертонц юм. Үүнийг мениаратив хэмээдэг. Тухайлбал, марксизм, фрейдын психианализм,

<sup>20</sup> “Шахматын” сэтгэүүл “Эрх зүйн зөвлэлийг: модерн ба постмодерн хандлага” иштээвээс.

<sup>21</sup> Теодор Адорно

либерализм гэсэн иерийн дор хөгжиж буй метанаарравтийүүд биднийг нэг хэвнэд цутган, гагхуу нэг логикт захицуулж, ийгээм даяар өөрийн хяналтыг бүрэн тогтоож чаддаг. Үүний үндсэн дээр жинхэнэ би гэж байхгүй болдог. Амьдарч буй ийгмээ төсөөлох миний онцог омнио нь байсан бөгөөд хэн нэгэн надал үүнийг овлосон юм.

Түүчинчлэн, мэдлэг бол хүч. Хэрэв үнэхээр бодит байдал ийгмийн зохиомол өртонц байх аваас түүнийг зохиосон, сэдээн этгээд агуу их эрх мэдрүүтэй. Учир нь тэр биднийг өөрөө ямар байдлаар өртонцийг харахыг хүсэж байна, тийм байдлаар биднийг харахыг шаардаж байна. Тэгэхээр үүнийг жам ёсны хэмэх нэрийдлээр бидnid ухуулга хийдэг<sup>22</sup>. Десконструкци-зохиогчийн хүсэл зоригоос үл хамааран текстэнд дадал туршилагаас ангид сэтгэлгээний хэв маягийг тодорхойлох үйл явц, арга хэрэгсэл мөн. Энэ үндсэн дээр постмодерн хэлбэр нь бидний илүү гүнзгий бодож олсон өртонц рүү шигдэж, илүү уран сайханы, ийгмийг тайзчилсан, театрчилсан хэв маяг төрхийг нэгэнтэй олох болсонд<sup>23</sup> Ж.Бодрийяр символик өртонц дэх симулякр хэмээн томёолсон биз.

Тэгэхээр дээрхтэй уялдаж постмодери хандлага эрх зүйтгэй ямар хамааралтай гэвэл сэтгэлгээний бөрчлолт оороо ийгмийн бөрчлолтийг дагуулдаг гэсэн өронхий зүй тогтолын онцгөөс ажиглавал эрх зүй нь ийгмийн хяналтын хэрэглүүл болохын хувьд шууд хамааралтай гэсэн үт. Хүний оюуны хөгжил нь амьдралыг цоо шинэ хуудас, хэмнэлээр дүүргэх болж, түүгээр ч үл барам эрх зүйг энэ харилцааг хамгаалах чадвартай, түүнд хүрч үйлчлэх илүү үр иолоотгүй байхыг шаардах болжээ. Үүнд тулгуурлан постмодернистүүд уламжлалт эрх зүйн онолд шүүмжтэй хандах болсон. Уламжлалт сэтгэлгээний хэв маяг, түүнд тулгуурласан эрх зүйн онолд ияцалт хийхийг зорьсон анхны

<sup>22</sup> "Шинжүүчүү", смигүүл.УБ., 2006.М.Батсүр "Эрх зүйн хөгжил: Модерн ба постмодерн хандлага" илръээс.

<sup>23</sup> Моисеев С.В. "Философия права".Новосибирск.2003.с.188.

ородлогын нэг нь Английн засгийн газарт хандсан Вольфендены комиссын илтгэл байлаа<sup>24</sup>.

Эрх зүйн нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах ёстой боловч түүгээр бамбай хийн хувь хүний эрх чөлөө, ашиг сонирхлын сртэнцэд халдах эрхгүй бөгөөд энэ нь түүнд извтрэх виз биш. Түүгээр ч үл барам эрх зүй нь зүй ёсны хувь ашиг сонирхлыг дэмжих хэрэгслэ мон. Тиймээс эрх зүйг хэм хэмжээ, горим журам хэмээн үзэх уламжлалт хандлага нь “тэг эсхүл, үгүй” /all of nothing/<sup>25</sup> ерөнхий туйлд баригддаг учраас түүний дунд орших асар олон хувилбарт сэлтэх боломжийг хааж<sup>26</sup>, дээрх чанар нь эрх зүйг хатуу тогтсон позитив гэхээсээ мөн харьцангуй уян хатан байхыг үгүйсгээд зогсохгүй энэ чадвараар нолоотай эрх зүйн зарчмуудын үүргийг улам бүр өсгөх болжээ. Үүнийг онолын түвшинд боловсруулсан сэтгэгч бол Р.Дворкин /R.Dworkin/<sup>27</sup> юм.

## 2. Захиргааны хууль, тогтоомжинд дун шинжилгээ хийх нь. /Дүгнэлтийн төслийн түүрээ/

Захиргааны эрх зүйн иэрт судлаач Otto Mayer "Германы захиргааны эрх зүй" гэсэн бүтээлдээ "Үндэсн хуулийн эрх зүйн үе онгөрч, захиргааны эрх зүйн үе эхэлж байна" гэж бичсэн нь олны анхаарлыг ихээхэн татсан байдал. Мөн үүний дараа захиргааны эрх зүй судлаач Fritz Werner "Захиргааны эрх зүй бол нарийвчилсан зохицуулалт бүхий Үндэсн хуулийн эрх зүй мон" хэмээсэн байна<sup>28</sup>.

<sup>24</sup> Хансратт үзүүлүү № 1

<sup>25</sup> Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review, 45..

<sup>26</sup> "Ба, бөгөөд, энэ тохиолдоз, магадгүй, жсүү" гэээн нэр асар олон хувилбаруудад хорвон стижээж чадлагчаргаа хүний оюун ухайн гайхамшигтай бөгөөд энэ чадвараар дээрх сронийн нэхэнд л ажиллах чадвартай зохиомол оюун болох компьютерээс эрс ялгарна.

<sup>27</sup> Dworkin R. Law's Empire. Cambridge: Harvard University Press, 1986; Dworkin R. Taking Rights Seriously. Cambridge: Harvard University Press, 1977; Dworkin R. Is Law a System of rules? Harvard Law Review, ээрэг бүтээлд тусгасчидсан, дамшигээ.

<sup>28</sup> П.Одээрээ. "Захиргааны эрх зүйн сронийн амьт". УБ, 2008, 53 дэх тал.

Үндсэн хууль нь нийгмийн хамтын амьдралын үндсийг тодорхойлоод зогсохгүй ялангуяа хууль болон хуулийг дагалдан гарах актын эрх зүйн байдал болон эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг удирдан чиглүүлэх зарчмыг нь агуулдаг. Үндсэн хуулийн түүхэн хөгжлоост тодорхой харж болно. Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн гуравт "Монгол улсын Засгийн газар бол торийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага мөн"<sup>29</sup> хэмэн түүний чит үүргийн үндсэн агуулгыг нь хуульчилж огсон байна. Үндсэн хуулийн эрх зүйгээр хууль тогтоогч болон захиргааг Үндсэн хуулийг зөрчихийг хориглоод зогсоогүй мөн Үндсэн хуулийн эрх зүйн агуулгыг идэвхитэй хэрэгжүүлэх ёстой бөгөөд ингэснээр Үндсэн хуулийн илөөллийг хамгийн дээд хэмжээнд байлгахыг заасан байдал. Үндсэн хуулийн ихэнх хэм хэмжээ нь "захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр нарийвчилсан зохицуулалт бүхий Үндсэн хуулийн эрх зүй мөн" гэсэн дүгнэлтэйд хүргэсэн<sup>30</sup> болох талтай юм.

Орчин үеийн эрх зүйт торийн салшгүй нэгэн шинж нь гүйцэтгэх эрх мэдлийн хуромц хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан эрх зүйн механизмыг бүрдүүлсэн байх явдал юм. Захиргааны эрх зүйн харилцааны нэг тал нь заавал хуулиар олгогдсон захиралжлах эрх бүхий этгээд байх бөгөөд төр ба иргэдийн хоорондох эрх зүйн харилцаанд голчлон илтэрдэг. Хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээд болох захиргааны эрх зүйн давуу байдлаас иргэдийн эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн механизмыг бүрдүүлэх шаардлагага зүй ёсоор тавигддаг. Иймд захиргааны үйл ажиллагааг оөр ямар нэгэн хараат бус байгууллагаас хянаж байх шаардлагатай болдог<sup>31</sup>.

Дээрхээ дүгнэн үзвэл Захиргааны салбарын хувьд хуулиар зохицуулагдаж буйн харилцаанаас гадна захиргааны хэм хэмжээний актаар нийгмийн харилцааг зохицуулж буй нь хуулийн

<sup>29</sup> Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй. 1992

<sup>30</sup> Мон тазэд.

<sup>31</sup> П.Одгэрэл. "Захиргааны эрх зүйн ерөнхий анх-и". УБ., 2008 он. 57 дэх таз.

Үйлчүүл дутагдаж буй илрэл юм. Мөн хуулийн шинжлэх ухааны салбарын эрдэмтдийн үзэл санаа, сургаал дзор цэвэр эрх зүй буй аливаа нэлоөллюос ангид логик баримтад тулгуурлах хуулийн үзэл баримтлалыг дэмжих нь ажиглагдаж байна. Хуулийн санаачлагч болон хууль зүйн шинжлэх ухаанд дараах зүйлсийг тусган аяхаарах нь зүйтэй болов уу. Тухайзбал:

- Хуулийн зорилго нийгмийн хэрэгцээ хоорондын уялдаа холбоо буюу хуулийн анхдагч үзэл санааг зөв тогтоох. Нийгмийн хэрэгцээ шаардлагасэс ургуулан хуулийг санаачлах. Августин /Augustine/ "Lex iusta non Lex" буюу "шударга бус хууль нь угаас хууль биш" гэх зарчим баримтлах
- Аливаа хуулиудад тухайн харилцааг зохицуулахад журмаар зохицуулна гэж тусгаж оруулдаг. Энэ хуулийн зорилго үзэл санааг суурь болох боловч зарим тохиолдоц хуулийн анхдагч үзэл санааг гүйвуулах, утга агуултыг алдагдуулах суд талтай. Иймд хуулийн дагах журамд уламжлалт хайдлага болох "тэг эсхүл, үгүй" гэх хязгаарлалтын үзэл санаанд тулгуурлах. Мөн хууль санаачлагч ямар харилцааг хуулиар зохицуулах гэдгийг нарийвчлан тусгаж тогтоох.
- Захиргааны эрх зүйгээр зохицуулагдаж буй харилцаа нь Үндсэн хуулийн үргэжлти болох олон салбарын харилцааг зохицуулах учир ердийн хуулиар тухайн харилцааг нарийвчилсан зохицуулалтыг хэм хэмжээний актад үлдээж орхих нь хууль зүйн шинжлэх ухааны хувьд хоцрогдолыг бий болгох суд талтай. Манай улсын хувьд Засгийн газарт хууль санаачлах эрхийг Үндсэн хуулиар олгосон нь давуу талтай. Учир нь Засгийн газар бол салбарын хуулиудыг боловсруулах чухал үүрэгтэй субъект юм.
- Захиргааны эрх зүйн хуулиудад хоорондын зорчилдоонийг арилгах хэрэгцээ шаардлагатай богоод иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хуулинд тусгайлсан зохицуулалт оруулах шаардлагатай.

## **НОМ ЗҮЙ**

### **Хууль тогтоомжууд**

1. Үндсэн хууль
2. Засгийн газрын тухай хууль
3. Яамны эрх зүйн байдлын тухай хууль
4. Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хууль
5. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн иэгжийн тухай хууль
6. 320 хууль

### **Ном сурх бичиг**

1. Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review
1. Dworkin R. Law's Empire. Cambridge: Harvard University Press. 1986; Dworkin R. Taking 2. Rights Seriously. Cambridge: Harvard University Press. 1977; Dworkin R. Is Law a System of rules? Harvard Law Review.
2. П.Одгэрэл."Захиргааны эрх зүйн ерөнхий анги".УБ.,2008.
3. Ж.Сүхбаатар."Өриодийн улс орнуудын захиргааны эрх зүй"
4. Ж.Долгорсүрэн."Монгол улсын захиргааны эрх зүйн удиртгал".УБ.,2006
5. Н.Лодой."Философи ба шинжлэх ухааны арга зүй".УБ.,2001
6. Н.Лундэндорж."Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага".УБ.,2003
7. Г.Совд, Ж.Амарсанаа нар."Хууль зүйн тайлбар толь".УБ.,2004
8. Б.Чимид."БНМАУ-и Захиргааны эрх зүй".УБ.,1973
9. Б.Чимид."БНМАУ-и Захиргааны эрх зүй ерөнхий анги"УБ.,1998
10. Б.Чимид."Үндсэн хуулийн үзэл баримтлал".УБ.,1995

11. "Шихихутуг".сэтгүүл.УБ.,2006.М.Батсуурь."Эрх зүйн хөгжил: Модери ба постмодери хандлага" илтгэлээс.
12. Моисев С.В."Философия права".Новосибирск.2003.с.188.
13. Ш.Батсух."Захиргааны шинжлэх ухааны срохийн онолын зарим асуудал".УБ.,1996
14. Д.Ганзориг."Захиргааны эрх зүйн тайлбар толь".УБ.,2001
15. С.Нарангэрэл."Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо".УБ.,2001
16. Administrative justice in the new european democracies-USA.1998
17. Административное право зарубежных стран: Учебное пособие/ подред.Козырина.М.,1996
18. Василенко И.А.Административно-государственное управление в странах Запада: США, Великобритания, Франция, Германия. Учебное пособие.М.,1998

#### Цахим хуудас

1. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn)
3. [www.premier-ministre.gouv.fr](http://www.premier-ministre.gouv.fr)
4. [www.law.cornell.edu/administrative.htm](http://www.law.cornell.edu/administrative.htm)
5. [www.lib.isu.edu/gov/Executive](http://www.lib.isu.edu/gov/Executive)
6. [www.cabinet-office.gov.uk/organisation/introleaflet.html](http://www.cabinet-office.gov.uk/organisation/introleaflet.html)
7. [www.pm.gov.uk](http://www.pm.gov.uk)

# A PERSPECTIVE AND SCIENTIFIC STUDIES OF LAW

## MAKING PROCESS

### /Concept of development/

Legal development has been evolving in all aspects of society. There was classic "natural law" theory that V.I.Aleksey once said that, "Right legalization will never be found", and Professor J.Roberts said that "There is God, and has plan to coordinate the lives of people, who lives under the God's plan, but who departs God's plan is infidel". Therefore, Augustine /Augustine/ "Lex injusta non Lex" declared principle that human law must be consistent with God and natural law, if not that "injustice law is not law". All Existing law is based on any causes. In XVI century, British lawyer Christopher Jerman said that it's very difficult to distinguish the causes law and existing law.

In XVIII-XIX century British legal experts J.Ostin, J.Bentam were first attempt to distinguish natural law and human law. For example: J.Bentam said: "If the law is designed to meet the requirements for itself that law should not consistent with the highest heaven, and God", which further highlight and defined that theory "reason to call positive law begins with a man but beware to mixing together God and the natural law". This notion continue to developed by H.Kelzen, British lawyer G.Hart. L.Fullyer, J.Finnis were didn't support the Positive's idea but shown in their work that all research should be apart from God's conception.

In later XX century the University of Frankfurt made strong revolutionary wave in legal studies as well as the total level of thinking. Postmodern theory shown that the right legal mindset should change itself but also change the structure of society, in general word is that law is directly related to the use of society control. Development of human intelligence opened the whole new page, rhythm but also required to be more effective in legal relation and have ability to protect. But postmodern's became criticize traditional legal theory.

Administrative law eminent scientist Otto Mayer noted in his work that "Constitution the legal period is over but administrative law's period is beginning" and it's attracted the attention of many people. And after that administrative law scholar Fritz Werner said, "administrative law is very detailed regulation of constitutional law".

**Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг хааж  
Шихихутуг Их сургуулийн захирал,  
профессор Д.Оюунцээнгийн хэлсэн уг**

*Эрхэм хүндэт зочид, хатагтай нөёдоо !*

*Энд хуран чуулсан эрдэмтэн багш, судлаачид, оюутан нараа !*

Шихихутуг Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын иэгэн брэнд нь болсон олон улсын эрдэм шинжилгээний уламжлалт хурал амжилттай өндөрлөж байна.

Жил бүр зохион байгуулагддаг энэ хурал Монголын нийгмийн шинэчлэлийн иэн тулгамдсан асуудлыг сонгон гадаадын иэртэй их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаачдыг урин оролцуулдагаараа Монгол улсдаа тодийгүй, гадаадын анд нарын маань хүлээнтгэй арга хэмжээ болдог сайхан уламжлалтай юм.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтад үнэхэр тулгамдсан, онол, арга зүйн шийдэл нь цаг үеэ олсон хууль бүтээх, хууль тогтоох үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах асуудлаар хийж буй энэ хурал бэлтгэл чамбай, зохион байгуулалт сайтай боллоо. Хурлын үйл ажиллагааг удирдах зохион байгуулсан профессор Ч.Даваадаш болон хурлын бэлтгэлийг хангахад идэвхи зүтгэлтэй оролцсон бүх эрдэмтэн багш нартга талархал илэрхийльс.

Хурал агуулгын хувьд онол, арга зүйн ондор түвшинд болсныг онцольё. Хуралд тавигдсан Үндсэн илтгэл болон дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачдын 16 илтгэлийг бид сонслоо. Хуралд хууль тогтоох, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны онолын болон практикийн тулгар нарийн асуудал болох хуулийн зохицуулалтын ийгэм-эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахаас аваад хуулийг баталгаажуулж хэвлэн ийтгэлж хэрэглэгчдэл хүргэх хургэлэх бүх шатанд хууль зүйн техникийг хэрэглэх, хууль тогтоох үйл ажиллагааны ийтлэг болон улс үндэстний еврөмөшийг хослуулах, эрдэм шинжилгээ, судалгааны танийн мэдэхүйн арга зүйг хэрэглэх, олон ийтийн оролцоог хангах зэрэг асуудлаар санал боллоо солицилоо.

Хуралд илтгэл тавьсан, үг хэлсэн академич С.Нарангэрэл болон бусад эрдэмтэн судлаач нартаа гүн талархал илэрхийлье. Нэн ялангуяа алс холоос Монголыг зорин ирж хуралд идэвхитэй оролцон нэн сонирхолтой илтгэл тавьсан ОХУ-ын Эрхүүгийн улсын Их сургуулийн хуулийн сургуулийн болон БНСУ-ын Хандуны олон улсын Их сургуулийн хуулийн сургуулийн эрдэмтэн судлаач нартаа дахин дахин талархлаа илэрхийлье. Хурлын ажиллагаанд та иехдийн идэвхитэй оролцоо нь манай сургуулиудын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглье.

Хуралд тавьсан илтгэлүүдийг тусгайлан ном болгои хэвлүүллээ. Энэхүү материал нь хууль тогтоох, хууль хэрэгжүүлэх уйл ажиллагааны чиглэлээр хийгдэх эрдэм шинжилгээ судалгааны ажил, их, дээд сургуулийн сургалтад судалгааны чухал эх сурвалж болно гэдэгт эргэлзэхгүй байна.

*Эрдэм намын тань ажил алз амгоор  
дүүрэн байхын өрөөл дэшигүүлье.*

*Та бүхэндээ баярлалаа*